

АНТООН МОСТАЭРТ
МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДМИЙН ХЭЛХЭЭ

Эрдэм шинжилгээний бичиг
Боть XIV

Эрхэлсэн: Г. Цэцэгдарь

Улаанбаатар
2025

ННА 74.58

ДАА 378

Э-733

АНТООН МОСТАЭРТ
МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДМИЙН ХЭЛХЭЭ

Эрдэм шинжилгээний бичиг
Боть XIV

Эрхэлсэн: Г. Цэцэгдарь

Сэтгүүлийн зөвлөл:

Г. Гэрэлмаа	ШУА, Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор
Л. Ганбат	ШУА, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Монголын эзэнт гүрэн, дундад үеийн түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D)
Г. Нарантунгалаг	МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш доктор (Ph.D), дэд профессор
Б. Азаяа	МУИС, Ази судлалын тэнхимийн багш доктор (Ph.D), дэд профессор

ISBN: 978-9919-9036-5-7

**ANTOON MOSTAERT
CENTER FOR MONGOLIAN STUDIES**

STRINGS OF KNOWLEDGE

**Research Works
Volume XIV**

Edited by: G. Tsetsegdari

**Ulaanbaatar
2025**

HHА 74.58
ДАА 378
Э-733

**ANTOON MOSTAERT
CENTER FOR MONGOLIAN STUDIES**

STRINGS OF KNOWLEDGE

**Research Works
Volume XIV**

Edited by: G. Tsetsegdari

Editorial Board:

Guruuchin GERELMAA, Doctor (Ph.D), Associate professor, Leading researcher,
Institute of Language and Literature of Mongolian Academy of
Sciences

Lkhundev GANBAT, Doctor (Ph.D), Head of Department of Mongol Empire
and Medieval History, Institute of History and Ethnology of
Mongolian Academy of Sciences

Gansukh NARANTUNGALAG, Doctor (Ph.D), Associate Professor, Department
of Literature and Art Studies, National University of Mongolia

Badam AZZAYA, Doctor (Ph.D), Associate Professor, Department of Asian Studies,
National University of Mongolia

ISBN: 978-9919-9036-5-7

ТАЛАРХАЛ

Монгол дахь SICM байгууллагын харьяа Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв (АМТ)-ийн “Оюутан судлаач” тэтгэлэгт хөтөлбөр нь 2011-2012 оны хичээлийн жилээс эхлэн 14 дэх жилдээ тасралтгүй тогтмол зохион байгуулагдаж байна.

2024-2025 оны хичээлийн жилд тус тэтгэлэгт хөтөлбөрт МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургууль (ШУС)-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар (ХУС)-ын Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, Утга зохиол, Урлаг судлалын тэнхим, Антропологи, археологийн тэнхим, МУБИС-ийн Монгол хэлний тэнхим, Утга зохиолын тэнхимийн 20 орчим оюутан хамрагдаж, судалгааны ажлаа удирдагч багш нарын удирдлага болон АМТ-ийн арга зүйн ерөнхий зөвлөмжийн дагуу амжилттай хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлаа амжилттай гүйцэтгэж, эрдэм шинжилгээний өгүүллээ “Эрдмийн хэлхээ” (Strings of Knowledge) оюутны эрдэм шинжилгээний бичгийн 2025 оны 14 дүгээр ботид хэвлүүлж байгаа Судлаач оюутнууддаа талархаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд сургалт, судалгааны ажилд тань улам их амжилтыг хүсье.

Дээрх оюутнуудын судалгааны ажлыг удирдан чиглүүлсэн МУИС-ийн багш др. Ж. Ганбаатар, др. М. Жавхлан, др. Г. Нандинбилиг, магистр И. Даваадорж, др. С. Дашдэжид, др. М. Эрдэнэ, др. И. Бямбабаатар, Чингис хаан үндэсний музейн Сан хөмрөг, хадгалалт хамгаалалтын хэлтсийн ахлах сэргээн засварлагч магистр Б. Батчимэг, ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу, шавж судлалын лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан магистр Д. Алтанчимэг болон МУБИС-ийн багш др. Р. Сарангэрэл, др. Г. Цэцэгдарь, др. П. Яньдий, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан др. Д. Уртнасан нарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

2024-2025 оны хичээлийн жилд “Оюутан судлаач” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд оюутан судлаач нарт лекц номоо айлдсан МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш др. На. Сүхбаатар, Чингис хаан үндэсний музейн Сан хөмрөг, хадгалалт хамгаалалтын хэлтсийн ахлах сэргээн засварлагч магистр Б. Батчимэг, МУИС-ийн Нүүдэлчдийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний

ажилтан Г. Энхбаяр, МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш И. Даваадорж нартаа талархлаа илэрхийлье.

Тус хөтөлбөрийг хариуцан ажилласан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан др. Т. Батбямба, АМТ-ийн эрдэм шинжилгээний зөвлөх др. Г. Цэцэгдарь нарт талархлаа илэрхийлье.

Оюутан судлаачдад номын үйлчилгээ үзүүлэн ажилласан АМТ-ийн Эрдэм шинжилгээний номын сангийн ажилтан Ц. Рэнцэнбямба танаа талархъя.

“Оюутан судлаач” тэтгэлэгт хөтөлбөрийн үйл ажиллагааг бүрэн дэмжин ажилладаг Монгол дахь SICM байгууллагад талархлаа илэрхийлье.

Антоон Мостаэрт
Монгол Судлалын Төв

2025 он

ГАРЧИГ

ТАЛАРХАЛ	5
Сүхбаатарын ЦЭЛМҮҮН	
Торгууд аман аялгууны [а, а:, ә, ә:]	
эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь	11
Ганболдын ЭНХЖИН	
Орчин цагийн ярианы хэлний авианы өөрчлөлт	22
Зоригтбаатарын ХИШИГБАЯР	
Монгол хэлэнд давтамж өндөр илрэх	
англи, орос хэлний үгийн дуудлагын	
онцлогийг илрүүлэх нь	33
Үнэнбүрэнгийн СОЛОНГО	
“Алчуур” гэх үгийн тархац ба авианы хувьсал	47
Зоригтын АНУЖИН	
Монгол хэлний -γalja дагаврын тухай	57
Цэдэндамбаагийн СУВД-ЭРДЭНЭ	
Монгол хэлний үйл үгийн утгын өргөслийг судлах нь	67
Чимиддоржийн ӨНӨРЗАЯА	
Пүрэв гүнгийн орчуулсан “Хааны бичсэн	
нэмж тогтоосон манж үгний толь бичиг”-ийн	
“Хөгжмийн зүйл”-ийг “Хорин нэгт”-ийн	
тайлбар тольтой харьцуулах нь	85
Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ	
Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээх	
их хөлгөний судар	97
Цогтбаатарын ТӨГСБААТАР	
1990-ээд оны монголын уран зохиол дахь	
хотын уран зохиолын шинж	113

Эрхэмбаярын БУДСҮРЭН

П. Батхуягийн өгүүллэг дэх болзолт дүрслэлийн онцлог	128
---	-----

Батсүхийн ЗОЛБОО

Монгол үлгэр дэх шидэт туслагчийн дүр, өгүүлэмжийг шинжлэх нь	136
--	-----

Мөнхбаярын АДЪЯАСҮРЭН

Дорно дахины ард түмний ертөнцийн үүслийн домог зүйн өгүүлэмжийг харьцуулах нь	162
---	-----

Бямба-Эрдэнийн НОМИН

Монгол аман зохиол дахь ургамлыг оньсоголох тогтмол болон өгүүлэмжийн харилцаа холбоог шинжлэх нь	175
---	-----

Цэрэндоржийн НАМУУН

Шавжийн судалгааг ашиглан хадны оршуулгын зан үйлийг тодруулах нь	186
--	-----

Болорчулууны МӨНХЖИН

Монгол охидын сарын тэмдэг анх ирэх нас менархи ба түүнд нөлөөлөх хүчин зүйл	209
---	-----

Цацралмаагийн МӨНХЗАЯА

Монголын малчдын махны худалдаан дахь ёс суртахууны эдийн засгийн ойлголт	226
--	-----

CONTENT

APPRECIATION	5
Sukhbaatar TSELMUUN	
Experimental phonetic analysis of the vowel [a, a:, æ, æ:] in the Turgut dialect	11
Ganbold ENKHJIN	
Phonetic variation in contemporary spoken mongolian	22
Zorigtbaatar KHISHIGBAYAR	
Identifying the pronunciation features of english and russian high-frequency words in the mongolian language	33
Unenburen SOLONGO	
The distribution of the word ‘Alchuur’ and phonetic variation	47
Zorigt ANUJIN	
About the -yalja suffix in mongolian	57
Tsedendambaa SUVD-ERDENE	
A study on the semantic extension of mongolian motion verbs	67
Chimiddorj UNURZAYA	
Comparison of the ‘Dictionary of twenty-one sections’ with the ‘Musical sections’ in the ‘Manchu dictionary of additional term ordered by the Emperor’ translated by Prince Pürev	85
Sugar CHULUUNCECEG	
The Altan Gerel sutra in Todo bičig	97
Tsogtbaatar TUGSBAATAR	
The characteristics of urban literature in mongolian literature of the 1990s	113

Erkhembayar BUDSUREN

The feature of conditional representation in the
short stories of P. Batkhuyag 128

Batsukh ZOLBOO

An analysis of character and motif of the
donor in mongolian folktale 136

Munkhbayar ADIYASUREN

A comparative study of eastern mythological
narratives on the origin of the world 162

Byamba-Erdene NOMIN

Examining the relationship between plant
riddle invariants and narrative features
in mongolian folklore 175

Tserendorj NAMUUN

Discovering funerary practices cave
burial through the study of insects 186

Bolorchuluun MUNKHJIN

The age of menarche in the mongolian girls
and factors affecting it 209

Tsatsralmaa MUNKHZAYA

Understanding the ethical economy
of mongolian herders' meat trade 226



ТОРГУУД АМАН АЯЛГУУНЫ [a, a:, æ, æ:] ЭГШИГ АВИАГ ТУРШИЛТ АВИА ЗҮЙН АРГААР СУДЛАХ НЬ

Сүхбаатарын ЦЭЛМҮҮН

МУБИС. НХУС. МХУЗ-ын III курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл /Ph.D/

Агуулгын товч: “Торгууд-2024” төслийн хүрээнд Ховд аймгийн Булган сумыг зорин, торгууд аман аялгууг тээж буй угсаатнуудтай уулзсан бөгөөд тэдгээрээс 4 авиалагчийг сонгож судалгааны ажилд зориулан бэлдсэн 250 үгийг авиалуулж, тэр баримтаас [a, a:, æ, æ:] эгшиг авиатай үгсийг түүвэрлэн хөмрөг үүсгэн, уг бүрийн авиаг туршилт авиа зүйн судалгаанд өргөн хэрэглэгддэг “Praat” программаар задлан, өндөр, хүч, урт зэрэг тоон үзүүлэлтийн дунджийг тодорхойлсон бөгөөд [a] авиа F1-798Hz, F2-1479Hz уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу хүчдэлтэй, [æ] авиа F1-639Hz, F2-2166Hz уруулын бус, хэлний урдуурх, агуу дунд хүчдэлтэй, [a:] авиа F1-781Hz, F2-1461Hz уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу хүчдэлтэй, [æ:] авиа F1-697Hz, F2-1803Hz уруулын бус, урагшилсан, хэлний урдуурх, дэд агуу хүчдэлтэй авиа байна гэж энэхүү судалгааны үр дүнд үзэж байна.

Түлхүүр үг: эгшиг авиа, хэлний байдал, хүчдэл, формант, ялгаатай байдал

УДИРТГАЛ

Торгууд аман аялгуу нь монгол угсааны ойрадын нэг салбар аялгуу бөгөөд голчлон Монгол Улсын баруун бус нутаг болох Ховд аймаг, Хятад улсын Шинжаан уйгар мөн Ижил мөрний хэсэгт хэлэлцдэг билээ. Энэхүү салбар аман аялгууг тусгайлан судалж томоохон бүтээл туурвисан эрдэмтэн бол Х. Лувсанбалдан юм. Тэрээр “Торгууд аман аялгууны онцлог” гэсэн бүтээлийг Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “Хэл зохиол судлал” цуврал номыг 1975 оны дугаарт хэвлүүлсэн байна. Энэ бүтээлд торгууд аман аялгууны авиа зүйн онцлогийг нэлээд дэлгэрэнгүй судалсан байх бөгөөд, үг зүй, үгсийн сангийн зарим жишээг дурджээ.

ЗХУ-ын монголч эрдэмтэн Г. И. Рамстедт 1903-1904 онд Ижил мөрний халимаг болон Шинжааны торгууд, өөлдийн аман аялгууг судалсан бол Б. Я. Владимирцов 1908-1909 онд Ховдын дөрвөд, баяд нутгийн аялгуу, аман зохиол угсаатны зүй судлах эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаж тайлан тэмдэглэлээ хэвлүүлснээр Монгол Улс дахь ойрад аялгууны судалгаа эхэлсэн. Тэрбээр Монгол Улсын баруун хойд аймгуудын ойрадуудын хэл яриаг дөрвөд, баяд, өөлд, захчин, торгууд, урианхай, мянгад гэх долоон аялгуунд хувааж, ардын дуу, үлгэр, домог, ерөөл, баатарлагийн туульс зэргийг тус тус аялгуугаар нь ангилан, орос үсгийн галигаар тэмдэглэсэн байдаг. Мөн Монгол Улсад орших торгууд аялгуутныг “Алтайн торгууд” хэмээн нэрлэж, баримт зүйлс дээр тулгуурлан Ховог сайраар нутаглах торгууд, Энэ гол, Хөх нуур орчим оршин суух торгууд, Их бага Юлдусийн сав газар нутаглах Хар-шаарын торгууд, Хүр-хар уснаас баруун урагш Хулц хотын орчим нутаглах торгууд хэмээн тодорхойлж тухайн хэл аялгууг ойрадын бүлэг аялгуунд хамаарна гэж үзсэн билээ.

БНХАУ дахь монгол хэл, аялгуу, үсэг бичиг, авиа судлал ойрад аялгууны авианы талаар авч үзвэл Бямба “Ховог сайрын торгууд аман аялгууны эгшиг зохицох ёс” (1981), Бүрэнбаяр “Хөхнуурын монголчууд ба түүний хэл” (1982), Таяа “Ховог сайрын торгууд аман аялгууны зарим авиалбарын онцлогийн тухай мөчид ойлголт” (1987), Батжав “Ойрад аялгууны өвөрмөц авиаг баримжаа авиатай харьцуулан мөчид шинжлэх нь” (1987), Уртнасан “Баримжаа авиа болон торгууд аман аялгууны авианы харьцуулал” (1988), Гарди “Шинжааны Баянгол торгуудын аман аялгууны гийгүүлэгчийн тогтолцоо” (1988), В. Сэцэн “Баримжаа авиа хийгээд ойрад аялгууны авиалбарын харьцуулал” (1989) зэрэг өгүүлэл нийтлэгдэж ойрад аялгуу, ялангуяа торгууд аман аялгууны авиа зүй, авиалбар зүйн судалгааг ахиулжээ.

Олон улсад торгууд аман аялгууны авиа зүйн онцлог, дуудлага, үгийн сан, торгууд аялгууны фонологийн системийн талаар судлагдсан байдлыг жишээ татан авч үзвэл Hasibagen “新疆蒙古族土尔扈特方言语音系统研究” (Study on the Phonological System of the Torgut Dialect of Xinjiang Mongols), (2019) диссертаци, Wang Fang “土尔扈特蒙古语口语语音初探” (Preliminary Study on the Phonetics of Torgut Mongolian Spoken Language), (2018) өгүүлэл, Aikebaier Tuersun “土尔扈特蒙古语语音与词汇研究” (Study on the Phonetics and Vocabulary of Torgut Mongolian) (2020) докторын диссертаци зэргийг дурдаж болох бол торгууд аман аялгууг туршилт авиа зүйн аргаар судалсан нь Li Na “新疆土尔扈特蒙古语口语语音的实验研究” (Experimental Study on the Phonetics of Torgut Mongolian Spoken Language in Xinjiang), (2017) өгүүлэл, Zhao Li : “土尔扈特蒙古语口语的实验语音学分析” (Experimental Phonetic Analysis of Torgut Mongolian Spoken Language)

(2019) өгүүлэл, Elena Parina, Sechenbaatar “Acoustic Analysis of Oirat Dialects: A Case Study of Torgut Mongolian”, (2018) өгүүлэл, Иванов А.В. : “Акустические особенности ойратских диалектов: торгутский диалект” (Acoustic Features of Oirat Dialects: Torgut Dialect), (2016) зэрэг өгүүлэл хэвлэгджээ.

Дээр дурдсан эрдэмтдийн бүтээлүүдэд халимаг ойрад болон шинжаан уйгарын дотор буй торгууд аялгууг тодорхой хэмжээгээр судалсан боловч чухамхүү БНМАУ-ын Ховд аймгийн Булган сум дахь торгууд аман аялгууг онцгойлон судлаагүй билээ. Торгууд аман аялгууг хэл шинжлэл, аман зохиол, угсаатан судлалын хүрээнд (нутгийн хэл, аман зохиол, тууль, дууны онцлог зэрэг) судалсан байдал арвин хэдий ч туршилт авиа зүйн аргаар тусгайлан судалсан тохиолдол ховор байна.

ТУРШИЛТ АВИА ЗҮЙ

Туршилт авиа зүй (экспериментальная фонетика) нь хэлний авиаг шинжлэх ухааны арга, технологи ашиглан судалдаг хэл шинжлэлийн салбар бөгөөд ярианы авианы үйлдвэрлэл, дамжуулалт, хүлээн авалтын физик, физиологийн болон сэтгэл зүйн талуудыг нарийвчлан шинжилдэг. Энэ нь хэлний авианы шинж чанарыг лабораторийн нөхцөлд хэмжилт, туршилт, анализын тусламжтайгаар судалдаг тул “туршилт” хэмээн нэрлэдэг.

Физиологийн авиа зүйд аливаа авианы эсрэгцэх шинжийг нь зөвхөн бүтэх арга байдлаар нь тайлбарлахаар хязгаарлаж байсан бол энэ бэрхшээлийг давахын тулд XIX зууны сүүлчээр авиаг тэмдэглэж задлан шинжилдэг багаж хэрэгсэл бүхий туршилт авиа зүй үүссэн байдаг билээ.

Хэлний өгүүлэгч сонсогчоос бүрдсэн хамгийн энгийн харилцаагаар жишээлэн авч үзэхэд, сэтгэц-физиологи, өгүүлэхүй болон акустик гэсэн харилцан нягт уялдаатай үзэгдэл юм. Өгүүлүүрийн эрхтний үйл ажиллагааны үр дүнд бий болсон хэлэхүйн дохио сонсголын эрхтэнд хүртэхэд бие биедээ харилцан нөлөө бүхий шаталсан хэд хэдэн үе шатыг дамждаг ажээ. Эдгээр үе шатаас өгүүлэх, сонсохын дунд орших акустик авиа зүй нь хэлний бодит илрэл, агаарын хэлбэлзлийн долгион буюу баялаг хувирамтгай дохиог судалдаг.

Авианы физик хэмжигдэхүүнийг задлан шинжилж үүргийн хувьд ач холбогдол бүхий үзүүлэлтийг олж тогтоон, дүн шинжилгээ хийх нь туршилт буюу акустик авиа зүйн гол судлагдахуун юм.¹

¹ Батзаяа, Г, Уртнасан, Д. (2023). Монгол хэлний нутгийн аялгууны авиа зүйн харьцуулсан судалгаа. Улаанбаатар: Арвай Бархан ХХК

Сэдвийн үндэслэл

Удиртгал хэсэгт буй гадаад эх сурвалжуудад энэхүү сэдэвтэй холбогдохуйц судалгааны бүтээлүүдийг цөөнгүй дурдсан билээ. Гэвч Монгол Улсад монгол хэлний авиа зүйн судалгаа шинжилгээ хийсэн бүтээл арвин байгаа хэдий ч аман аялгууны авиа зүйн ялгаатай байдлыг туршилт авиа зүйн аргаар судалсан нь харьцангуй цөөн тул энэ талын судалгаа шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага үүсэж байна гэх үндэслэл дор тус сэдвийг сонгон судлав. Түүнчлэн Ховд аймгийн Булган суманд суурьшиж буй торгууд угсаатны хэл аялгуунд халх аялгууны нөлөө шингэн бэсрэг аялгуу болж байгаа улмаас бид ахмад өв тээгчдийн аман ярилцлагаас тухайн аялгууны эгшиг авианы онцлог, ялгаатай шинжийг тодруулахыг зорив.

Судалгааны ажлын зорилго

Торгууд аман аялгууны [a, a:, æ, æ:] эгшиг авианы формант (F1, F2)-ыг хэмжин задалж эгшиг авианы онцлог, ялгаатай шинжийг тодорхойлох.

Судалгааны ажлын зорилт

- Сэдэвтэй холбоотой өмнө нь судлагдсан байдлыг тоймлох
- Авиалагчдын хурааж авсан бичлэгээс [a, a:, æ, æ:] эгшиг авиа орсон үгсийг түүвэрлэн кодлох.
- “Excel” программ дээр хөмрөг үүсгэх.
- “Praat” программыг ашиглан кодолсон үгсийн формантыг тодорхойлох.
- Үгсийг олон улсын галигаар галиглах.
- Задлан шинжлэх, харьцуулах, дүгнэлт хийх.

Судалгааны арга ба аргачлал

Тус судалгаанд торгууд аман аялгууны [a, a:, æ, æ:] эгшиг авиаг судлахдаа хэлний авианы өгүүлүүрийн шинжийг авианы физик шинжтэй холбон тайлбарладаг хэл яриа бүтэх акустик онол (Acoustic theory of speech production)-ыг баримтлан туршилт авиа зүйн аргууд болон тоон арга, ажиглалтын арга, тодорхойлох тайлбарлах арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг ашиглав.

Туршилт авиа зүйн аргаар авианы шингээлт хийж, үр дүнг боловсруулахдаа Cool Edit pro 2.0, Praat 5.2, программуудыг ашигласан.

Туршилт судалгааны аргазүй

Тус судалгаанд монгол хэлний халх аялгууны хөмрөгөөс 1-3 үет өргөн хэрэглээний 250 үгийг түүвэрлэн 1 эрэгтэй, 3 эмэгтэй авиалагчаар диктафон дээр тус тус уншуулж бичлэг хийсэн билээ. Эдгээр үгээс үгийн тэргүүн үед орсон [a, a:, æ, æ:] эгшиг авиаг задалж, формант давтамжийн 1, 2-р (F1, F2) бүрэлдэхүүн (F1, F2)-ийг тоо баримтаар гарган зууч тооны хөмрөгт оруулав.

Энэ туршилт судалгааны үр дүнг уламжлалт авиа зүйн аргаар тодорхойлсон эрдэмтдийн судалгаанд түшиглэн уламжлал арга болон туршилтын аргаар судалсан байдал хоорондоо хэр зөрүүтэй байгааг нягталж, мөн халх аялгууны туршилтын аргаар хийсэн судалгааны [a, a:, æ, æ:] авиатай харьцуулан үзэв.

Судалгааны явцад тооцоолон гаргасан хэмжигдэхүүнийг дуун ухааны үүднээс шинжлэхдээ туршилт авиазүйн судалгаанд өргөн хэрэглэгддэг дараах ангиллыг баримталлаа. Үүнд:

Формантын 1-р бүрэлдэхүүн буюу F1-ийн хэмжигдэхүүн амны хөндийн зайнаас хамааран өөрчлөгдөнө.

200-350 Гц	уйтан
350-400 Гц	дэд уйтан
400-500 Гц	уйтан дунд
500-550 Гц	дунд
550-650 Гц	агуу дунд
650-800 Гц	дэд агуу
800+ Гц	агуу

Формантын 2-р бүрэлдэхүүн буюу F2 нь хэлний урдуурх, дундуурх, хойгуурх хэлэгдэхтэй холбоотой.

1600+ Гц	хэлний урдуурх
1200-1600 Гц	хэлний дундуурх
-1200 Гц	хэлний хойгуурх

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол

Торгуудын аман аялгууг туршилт авиа зүйн аргаар судалснаар хэлний онцлогийг шинжлэх ухааны үндэслэлтэй баримтжуулах, соёлын өвийг хадгалах зэрэг ач холбогдолтой. Шинэлэг талаас энэ нь монгол хэл шинжлэлд технологийн хандлага нэвтрүүлж, уламжлалт авиа зүйн хүрээнд тогтоосон онолыг туршилтын аргаар баримтжуулах, нягтлах, мөн ялгаатай байдлыг тодруулах зэрэг практик ач холбогдолтой.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Энэхүү судалгааны хэрэглэгдэхүүн нь “Торгууд аман аялгууны [a, a:, æ, æ:] эгшиг авианы дууны ухааны зууч тооны дата хөмрөг” болон тус хөмрөгийг байгуулахад зориулан бэлтгэсэн торгууд аман аялгуутай авиалагчдаар авиалуулан шингээсэн “WAV” хэлбэрийн дуу бичлэгийн хөмрөг болно.

Авиалагчдын мэдээлэл:

Ховд аймгийн Булган сумын Торгууд-2024 төслийн хүрээн дэх авиа зүйн судалгаанд оролцсон авиалагчдаас дөрвийг сонгов.

№	Асуулт	Авиалагч 1	Авиалагч 2	Авиалагч 3	Авиалагч 4
1.	Код	trg001	trg002	trg003	trg004
2.	Нас	69	82	25	75
3.	Хүйс	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эмэгтэй
4.	Угсаа	торгууд	торгууд	торгууд	торгууд
5.	Төрсөн газар	Ховд, Булган	Ховд, Булган	Ховд, Булган	Ховд, Булган
6.	Ажил мэргэжлийн байдал	Эмийн санч	Багш	Багш	Малчин

ҮНДСЭН ХЭСЭГ

Ойрад аялгуунд *a, ä, o, u, e, ö, ü, i, ī* гэсэн 9 богино эгшиг, *ā, ā̄, ō, ū, ē, ō̄, ī, ī̄* гэсэн 9 урт эгшиг байх ба монголын ойрад аялгуунд *ā̄, ō̄, ū, ī̄* гэсэн хос эгшиг авиа, *ūā, ōā, ōā̄, ūā̄, ōā̄, ēā̄, ōē, ōī, īā* гэх мэт хосорхог урт эгшгийн хувилбар тохиолдоно.

Богино эгшиг

a- хэлний хойгуурх, уруулын биш, амны хөндийн зай уужим, эр чанга, богино эгшиг. Эр үгийн эхэн, дунд орох ба үеийн эцэст маш балархай сонсогдоно. *цалам* (бугуйл), *алантрах* (алмайрах, гайхах), *ujläg^ä* уялга (өлзий хээ)

ä - хэлний дундуурх, урагшилсан, амны хөндийн зай ууживтар, эр, богино эгшиг. *ä* нь эр үгийн *a*, эм үгийн *e* эгшгийн шинжийг хадгалах боловч *a*-ийн шинж нь давамгай байдаг. Эр, эм үгийн эхэн, дунд тохиолдох ба адагт маш балархайшна. *āwā̄l айвал* (мануухай), *xälāx халиах* (харах), *āgā̄ айга* (аяга)

Урт эгшиг

Ойрад аялгууны урт эгшиг нь бусад монгол хэл аялгуунд урт эгшиг үүссэн түгээмэл үзэгдлийн нэгэн адилаар бий болжээ.

Монгол бичгийн хэлний ЭГЭ бүтцэд орсон түрэлтэт *γ, g, y, b(w)* гийгүүлэгч нь аль тод сонсогдох эгшгийн нөлөөгөөр уусан шингэж захын эгшгүүд ижилсэн урт эгшиг үүсжээ.

ā̄- хэлний хойгуурх, уруулын биш, амны хөндийн зай уужим, эр чанга, урт эгшиг. Үгийн аль ч үед тохиолдоно. *qāqt^ä каагт* (сүх), *dzalāt залаат* (богт чөмөг), *batsā бачаа* (бөөн, их)

$\bar{a}$ - хэлний дундуурх, урагшилсан, амны хөндийн дунд зэрэг, урт эгшиг. Эр, эм үгийн эхэн, дунд, адагт тохиолдоно. *āḍāṁ айдам* (айзам, ая дуу), *bār байр* (ам дөрвөлжин), *džirwā- жирвээ-* (жирий-, гүй-)²

Нэг. Торгууд аман аялгууны [a] авиа

Ойрад аялгууг судалсан Ю. Цэндээ ойрадын [a] авиаг хэлний хойгуурх, уруулын биш, амны хөндийн зай уужим, эр чанга”, О. Самбуудорж “хэлний хойгуурх, уруулын бус, уужим, үгийн тэргүүн үед тохиолдох, ерийн чанга” гэж тодорхойлсон байдаг бол торгууд аман аялгууны үндсэн [a] авиаг Х. Лувсанбалдан “эс уруулисан, хэлний хойгуурх, агуу, хүчдэлтэй эгшиг” гэж үзжээ. Харин бидний судалгааны үр дүнд 4 авиалагчийн авиалсан үгсийн формантын задрал нь дунджаар [a] авиа $\bar{X} F_1$ -798Hz, $\bar{X} F_2$ -1479Hz уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу хүчдэлтэй байна.

[a] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Код	Б/дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg002	5	авдар	awtər	a	1218	708.2
trg002	7	агуй	akoï	a	1298	788.7
trg002	21	арвай	arwæ:	a	1432	627.8
trg002	22	аргал	arqəɭ	a	1405	842.3
trg002	20	араг	arək	a	1405	681.4
trg002	14	ажил	aɣʰəɭ	a	1459	761.9

Хоёр. Торгууд аман аялгууны [æ] авиа

Ойрад аялгууны [æ] авиаг Чойжинжав “хэлний язгуурын, уужим, уруулын бус”, Ю. Цэндээ “хэлний хойгуурх, уруулын биш, амны хөндийн зай уужим, эр чанга, урт эгшиг. Үгийн аль ч үед тохиолдоно” гэж тодорхойлсон байдаг бол О. Самбуудорж “хэлний хойгуурх, уруулын бус, уужим, үгийн аль ч үед тохиолдох, ерийн чанга урт эгшиг фонем” хэмээн тодорхойлсон. Харин бидний судалгааны үр дүнд 4 авиалагчийн авиалсан үгсийн формантын задрал нь дунджаар [æ] авиа $\bar{X} F_1$ -639Hz, $\bar{X} F_2$ -2166Hz уруулын бус, хэлний урдуурх, агуу дунд хүчдэлтэй байна.

² Цэндээ. Ю., (2020). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. Улаанбаатар: Хаан үсэг ХК

[æ] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Код	Б/дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg002	10	амьдрал	æmtrəl	æ	1942	681.4
trg002	18	архи	ærkh	æ	1968	547.7
trg002	19	ариун	æry:n	æ	2129	681.4
trg002	44	ханцуй	χæŋtshœ:	æ	1486	761.9
trg002	47	хариу	χæru:	æ	2210	601
trg002	72	тахиа	tʰækhæ:	æ	2236	574.2

Гурав. Торгууд аман аялгууны [a:] авиа

Ю. Цэндээ ойрадын [a:] авиаг “хэлний дундуурх, урагшилсан, амны хөндийн зай ууживтар, эр богино эгишг” гэж тодорхойлсон байдаг бол О. Самбуудорж “хэлний дундуурх, уруулын бус, дунд, үгийн тэргүүн үед тохиолдох, ерийн сул богино эгишг фонем” хэмээн тодорхойлсон байдаг бол торгууд аман аялгууны [a:] авиаг Х. Лувсанбалдан “эс уруулсан, хэлний хойгуурх, дунд, хүчдэлтэй эгишг. Гагцхүү үгийн нэгдүгээр үед тохиолдох бөгөөд ихэнхдээ дараах үедээ сонгодог бичгийн хэлний *i*-тэй үгэнд байна” хэмээн үзсэн. Харин бидний судалгааны үр дүнд [a:] авиа $\bar{X} F_1$ -781Hz, $\bar{X} F_2$ -1461Hz уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу хүчдэлтэй байна.

[a:] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Код	Б/дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg003	2	ангаахай	aŋʷa:χa:	a:	1441	885.9
trg003	4	аав	a:w	a:	1432	945.9
trg003	6	аалз	a:lʰsʰ	a:	1486	1003
trg003	12	ачаа	aʃʰa:	a:	1405	761.9
trg003	14	ажаа	aʃa:	a:	1566	788.7
trg003	25	ялаа	ja:la:	a:	1593	922.7

Дөрөв. Торгууд аман аялгууны [æ:] авиа

Ю. Цэндээ ойрадын [æ:] авиаг “дундуурх, урагшилсан, амны хөндийн дунд зэрэг, урт эгишг. Эр, эм үгийн эхэн, дунд, адагт тохиолдоно” гэж тодорхойлсон байдаг бол О. Самбуудорж “хэлний дундуурх, уруулын бус, дунд, үгийн аль ч үед тохиолдох сул урт эгишг фонем” хэмээн үзсэн. Харин бидний судалгааны үр дүнд [æ:] авиа $\bar{X} F_1$ -697Hz, $\bar{X} F_2$ -1803Hz уруулын бус, урагшилсан, хэлний урдуурх, дэд агуу хүчдэлтэй авиа байна хэмээн тодорхойллоо.

[æ:] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Код	Б/дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg002	1	айл	æ:l	æ:	1838	674.3
trg002	2	ангаахай	аᠩᠭ᠎ᠠ:ᠬᠠᠭᠠᠢ	æ:	1513	735.1
trg002	21	арвай	arwæ:	æ:	1620	627.8
trg002	49	хялайх	khja:la:ᠬ	æ:	1539	735.1
trg002	57	гахай	qaᠬᠠᠭᠠᠢ	æ:	1379	681.4
trg002	62	сайн	sæ:n	æ:	1781	708.2

Халх, торгууд аман аялгууны [a] эгшиг авианы формантын задрал, харьцуулал

Аялгуу	Галиг	F ₁ , F ₂ -ын дундаж	Тодорхойлолт
Халх	a	$\bar{X}F_1=575$ Hz $\bar{X}F_2=1079$ Hz	уруулын бус, хэлний хойгуурх, агуу дунд
Торгууд	a	$\bar{X}F_1=798$ Hz $\bar{X}F_2=1479$ Hz	уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу

Халх, торгууд аман аялгууны [a:] эгшиг авианы формантын задрал, харьцуулал

Аялгуу	Галиг	F ₁ , F ₂ -ын дундаж	Тодорхойлолт
Халх	a:	$\bar{X}F_1=710$ Hz $\bar{X}F_2=1248$ Hz	уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу
Торгууд	a:	$\bar{X}F_1=781$ Hz $\bar{X}F_2=1461$ Hz	уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу

Халх, торгууд аман аялгууны [æ] эгшиг авианы формантын задрал, харьцуулал

Аялгуу	Галиг	F ₁ , F ₂ -ын дундаж	Тодорхойлолт
Халх	æ	$\bar{X}F_1=578$ Hz $\bar{X}F_2=1577$ Hz	уруулын бус, хэлний дундуурх, агуу дунд
Торгууд	æ	$\bar{X}F_1=639$ Hz $\bar{X}F_2=2166$ Hz	уруулын бус, хэлний урдуурх, агуу дунд

Халх, торгууд аман аялгууны [æ:] эгшиг авианы формантын задрал, харьцуулал

Аялгуу	Галиг	F ₁ , F ₂ -ын дундаж	Тодорхойлолт
Халх	æ:	$\bar{X}F_1=710\text{ Hz}$ $\bar{X}F_2=1248\text{ Hz}$	уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу
Торгууд	æ:	$\bar{X}F_1=697\text{ Hz}$ $\bar{X}F_2=1803\text{ Hz}$	уруулын бус, хэлний урдуурх, дэд агуу

ДҮГНЭЛТ

Бид торгууд аман аялгууны өгөгдлийн сан байгуулж [a], [a:], [æ], [æ:] эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлан, акустик хэмжилтүүдийг хийж тэдгээрийн онцлог шинжийг тодорхойлон О. Самбуудорж, Ю. Цэндээ, Х. Лувсанбалдан нарын уламжлалт ангилалтай харьцуулахад хэлний байрлал, хүчдэл, урагшилсан байдалд ялгаа илэрсэн. Ойрад аялгууны болон торгууд аман аялгууны [a, a:, æ, æ:] эгшгийг О. Самбуудорж, Ю. Цэндээ, Х. Лувсанбалдан нар [a] авиаг уруулын бус, хэлний хойгуурх, агуу хүчдэлтэй эгшиг, [æ] авиаг уруулын бус, хэлний дундуурх, урагшилсан, амны хөндийн дунд зэрэг, [a:] авиаг уруулын бус, хэлний хойгуурх, амны хөндийн уужим хүчдэлтэй, [æ:] авиаг уруулын бус, хэлний дундуурх, урагшилсан, амны хөндийн дунд зэргийн хүчдэлтэй гэж үзсэн бол бидний судалгаагаар **[a] авиа** F1-853Hz, F2-1600Hz уруулын бус, хэлний дундуур, агуу хүчдэлтэй, **[æ] авиа** F1-746Hz, F2-2245Hz уруулын бус, хэлний урдуур, дэд агуу хүчдэлтэй, **[a:] авиа** F1-815Hz, F2-1535Hz уруулын бус, хэлний дундуурх, агуу хүчдэлтэй, **[æ:] авиа** F1-849Hz, F2-1868Hz уруулын бус, урагшилсан, хэлний урдуурх, агуу хүчдэлтэй авиа байна гэж үзлээ.

Харин халх болон торгууд аман аялгууны ялгаатай байдлыг авч үзвэл [a] авиалбар нь аялгуу бүрийн тэргүүн үед тохиолдох, үндсэн шинжээрээ адил эгшиг хэдий ч бидний туршилтын үр дүнд хэлний дундуурх, дэд агуу эгшиг гэж тодорхойлогдож байна. Халх, торгууд аман аялгууны [a:] эгшиг авианы формантын задрал, харьцууллын хувьд ялгаатай тал байхгүй хэлний байр болон хүчдэлийн хувьд ижил байна. Харин халх аялгууны **[æ] болон [æ:] авиа** нь уруулын бус, хэлний дундуурх, дэд агуу хүчдэлтэй хэмээн тодорхойлогддог бол бидний судалгааны үр дүнд, **[æ] авиа нь** уруулын бус, хэлний урдуурх, агуу дунд хүчдэлтэй, **[æ:] авиа** нь уруулын бус хэлний урдуурх, дэд агуу хүчдэлтэй байна. Үүнээс дүгнэн үзвэл торгууд аялгуунд эдгээр эгшиг бусад аялгууны урагшилсан хувилбараас дахин урагшилсан байх бөгөөд үүний улмаас бие даасан [æ] авиалбар болон хөгжсөн байна. Мөн энэхүү үр дүнгийн ялгаатай

байдал нь шинжилгээний аргачлалын онцлог шинжээс үүдэлтэй байж болох бөгөөд цаашдын судалгаанд чухал суурь болох юм.

НОМ ЗҮЙ

- Батдорж, Ц., (2014). *Монгол хэлний халах аялгууны авианы дуун ухааны задлалт*. докторын зэрэг горилсон бүтээл. ӨМИС. Хөх хот:
- Батзаяа, Г., Уртнасан, Д., (2023). *Монгол хэлний нутгийн аялгууны авиа зүйн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар
- Лувсанбалдан, Б., (2015). *Сурвалж бичиг нутгийн аялгуу судлал*. Улаанбаатар Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн
- Самбуудорж, О., (2002). *Монгол хэлний ойрд аялгууны фонемын тогтолцоо*. Улаанбаатар
- (1982). *Хэл зохиол судлал*. Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл
- Wangguobin., (2024). *Захчин аялгууны эгшиг, гийгүүлэгч авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь*. докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар
- Wangguobin., (2025). *Захчин аман аялгууны эгшиг, гийгүүлэгч*. Улаанбаатар: Удам соёл ХХК

EXPERIMENTAL PHONETIC ANALYSIS OF THE VOWEL [a, a:, æ, æ:] IN THE TORGUT DIALECT

Keywords: torgut dialect, experimental method, vowel, place of articulation, formant

ABSTRACT

Within the framework of the “Torguud-2024” project, fieldwork was conducted in Bulgan, Khovd province, engaging with ethnic groups preserving the torguud oral dialect. Four speakers were selected, and they were recorded pronouncing a prepared list of 250 words. Words containing the vowels [a], [a:], [æ], and [æ:] were sampled to create a dataset. Using widely adopted software for experimental phonetics, the acoustic properties of these vowels were analyzed, and their average pitch, intensity, and duration were quantified and compared to draw conclusions.



ОРЧИН ЦАГИЙН ЯРИАНЫ ХЭЛНИЙ АВИАНЫ ӨӨРЧЛӨЛТ

Ганболдын ЭНХЖИН

МУБИС. НХУС. МХУЗ-ын багшийн II курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл (Ph.D)

Товч агуулга: Бид энэхүү бүтээлдээ цахим орчин дээрх нийтлэл, сэтгэгдлээс ярианы хэлээр бичсэн үгсийг түүвэрлэн задлан шинжилж, авианы өөрчлөлтийн онцлогийг тодорхойлохыг зорьсон. Энэ судалгаанд i) хэлэхүйн явц дахь авианы хувьсал, ii) монголжсон гадаад үгийн авианы хувьслыг авч үзсэн. Тус судалгаа нь авиа хураах, хэмнэх, гээгдэх, нэмэгдэх, ондооших, ижилсэх, урших үзэгдлийг орчин цагийн монгол хэлний жишээгээр тайлбарлав.

Түлхүүр үг: ярианы хэл, хэлэхийн хурд, авианы өөрчлөлт, хэлний хэрэглээ

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл: Хэлний харилцан нөлөөлөл, хэрэглэгчийн хэрэглээний онцлог болон бусад чадвараас шалтгаалан орчин цагийн монгол хэлний ярианы хэлэнд нэлээд өөрчлөлт ажиглагдаж байна. Үүнээс үүтгэн орчин цагийн монгол хэлний ярианы хэлэнд авианы ямар ямар өөрчлөлт хувьсал гарч буйг судлах шаардлага байна.

Судалгааны ажлын зорилго: Бид энэхүү судалгаагаар орчин цагийн ярианы хэлэн дэх авианы өөрчлөлтийг хэлний хэрэглээнд тулгуурлан судалж, ямар ямар авианы хувьсал гарч буйг авиа зүйн онолын үүднээс тайлбарлан тодорхойлохыг зорьсон.

Судалгааны ажлын ач холбогдол: Орчин цагийн монгол хэлний авианы хувьслыг хэрэглээнд тулгуурлан тодруулах, мөн латин кириллийн холимог хэлбэр, хэт хураасан буюу товчилсон хэлбэр зэрэг хэлний хэрэглээн дэх олон янз байдлыг хэл шинжлэлийн үүднээс тайлбарлан таниулах ач холбогдолтой.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүн утга санааг авиа, үсэг хоёроор илэрхийлдэг. Үсэг нь авиаг тэмдэглэх тэмдэг бөгөөд бичгийн хэлэнд хамаатай. Харин үсгээр тэмдэглэгдэх авиа нь ярианы хэлэнд хамаарах бөгөөд хоорондоо нэгдэж, хувьсаж байдаг хөдлөнгө шинж бүхий амнаас гарах хийн урсгал юм.¹ Ярианд нэг талаас авианы ялгарах шинж, үндсэн өнгө, өгүүлэх онцлогийг хэвээр хадгалах гэсэн, нөгөө талаас авианы ялгарах шинж саармагшиж, үндсэн өнгө нь өөрчлөгдөн зэргэлдээ авиатайгаа зохицон хувьсах гэсэн зөрчилтэй хоёр чиглэл байгааг ажиглаж олно.² Ярианы хэлэнд гарч байгаа авианы хувьслыг эрдэмтэд судлан дараах байдлаар ангилж байна.



Бүдүүвч 1. Д. Уртнасан нарын
2022 оны бүтээлд



Бүдүүвч 2. Ж. Санжаа, Ж. Надмид
нарын 2018 бүтээлд

Нэг. Хэрэглээний явц дахь авианы хувьсал

1. Хураах үзэгдэл

Хэлний хурд болон хэрэглээний орчинтой холбоотой хэмнэх, хураах үзэгдэл ярианы хэлэнд элбэг байна. Гэвч ямар зарчмаар хурааж, хэмнэж байгаа нь тодорхойгүй байгаа тул эдгээр хэлний хэрэглээний өөрчлөлтийг авиа зүйн онолын үүднээс шинжлэн тайлбарлах хэрэгцээ байна. Эрдэмтэн Д.Уртнасан авианы хураагдах хувьслыг “Монгол хэлэнд хэлэхүйн урсгалд балархай эгшгээр төгссөн ү гэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад үгийн эцсийн балархай эгшиг нь хураагдана. Учир нь богино эгшиг, урт эгшгийг нийлүүлж хэт уртаар дуудаж болохгүй.” гэж тодорхойлжээ. Тэгвэл орчин үед цахим орчинд хурдан хариулах, цагаа хэмнэх зэрэг шалтгаанаас үүдэж үгсийг голчлон дараах байдлаар хурааж бичих хандлагатай байна.

¹ Нямжав, Б. (2015). Монгол, Англи хэлний нийлмэл авианы үг. *Acta Mongolica*, 94.

² Санжаа, Ж., Надмид, Ж., (2018). *Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй*. Улаанбаатар, х.245

1.1. Эгшгийг хурааж бичсэн.

- a. Үгийн тэргүүн үед орсон богино эгшиг болон балархайшсан эгшгийг хурааж, урт, хос эгшгийг богино эгшгээр тэмдэглэн бичсэн:

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	hrgdulad	χarə3to:la:t	харагдуулаад
2.	blhor	pəɮχə:r	болохоор
3.	zlu	tsaɮo:	залуу

Хүснэгт 1 Богино эгшгийг хурааж бичсэн

- b. I үеэс хойш орсон аль нэг үеийн урт, хос эгшгийг утга ялгах үүднээс бичээд бусад эгшиг авиаг хураасан:

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	bgrei	pæ:ka:re:	байгаарай
2.	hceegd	χiɮʰe:ke:t	хичээгээд

Хүснэгт 2 Аль нэг үеийн урт, хос эгшгийг үлдээж бичсэн

- c. Үгийн утга ялгахын тулд зөвхөн богино эгшгийг бичээд урт, хос эгшгийг аль үед байгаагаас нь үл хамаарч хураасан:

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	icc	iɮʰe:ɮʰ	ичээч
2.	bnga	pæ:ŋa	байнга
3.	бсан	pæ:səŋ	байсан

Хүснэгт 3 Богино эгшгийг л бичсэн

- d. Бүх эгшгийн хурааж, зөвхөн гийгүүлэгчүүдийг бичсэн:

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	zgr	tsuge:r	зүгээр
	bltl	pəɮtʰəɮ	болтол
2.	bdg shd	pæ:tʰəɮkʃt	байдаг шүү дээ

Хүснэгт 4 Бүх эгшгийг хурааж бичсэн

Латинаар бичсэн зарим үгийг авианы бүрхүүлээр ялгах боломжгүй тохиолдолд өгүүлбэр дэх хам бүтцээс утгаар ойлгох боломжтой байна.

1.2. Тооны нэрийг тоо(цифр)-оор бичсэн.

- a. Үгэнд тооны нэр багтсан:

Кириллээр: хоёртой > 2той

хоёртой > 2той

гуравт > 3т

Латинаар: hoyriin > 2iin

dorvuulee > 4lee

teneg > t1

б. Давтагдсан үгийг цифрээр бичсэн:

Кириллээр: байн байн > байн²

гоё гоё > гоё²

зүрх зүрх > зүрх²

Латинаар: ewii ewii > ewii²

bolj bolj > bolj²

hurдан hurдан >
hurдан²

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	udku	otk ^h o	удахгүй
2.	uzku	utsk ^h u	үзэхгүй
3.	jjkn	ʃiʃək ^h əŋ	жижигхэн

Хүснэгт 5 Авианы хэмнэл I

2. Авиа хэмнэх үзэгдэл

Нэгдүгээрт, дараалан орсон хоёр авианы нэг нь сулрах эсвэл үе сугарах, ижилших аргаар нэг авиа болж болох ба энэ үзэгдлийг хэлэхүйн хэмнэлт гэнэ.

Хүснэгтээс авианы хувьслыг ажиглаад дараах загварт оруулбал: дуугүй шүргэх х [х, ʁ] + зөөлөн тагнайн дуугүй хамжих [k] = зөөлөн тагнайн түрэлттэй дуугүй хамжих [k^h]

Хоёрдугаарт, бүтээврийн бүтэц дэх амьсгалын түрэлтэй ч [ʃ^h] гийгүүлэгч авианы нөлөөгөөр сул шүргэх авиа сулран, бүвээврийн хувилбар үүсгэнэ.

№	Түүврүүд	IPA	Зөв бичих дүрмээр
1.	төрцөн	t ^h ɵrts ^h əŋ	төрчихсөн
2.	үзцэн	utsts ^h əŋ	үзчихсэн
3.	айтсн	æ:ts ^h əŋ	айчихсан

Хүснэгт 6 Авианы хэмнэл II

3. Авиа сулран гээгдэх хувьсал

3.1. “Авианы сулралшлыг эрдэмтэн Ж. Санжаа, Ж. Надмид нарын эрдэмтэд “Уруулын хамжих b гийгүүлэгч, хамжин шүргэх w болоод улмаар сулран гээгдэх ёс бий. Жишээлбэл: Мо. Toytaburi > монгyт.х.тоxt’awɔr > б.х.,го.х.тоxt’ulrt’a2!”³ гэжээ. Цахим орчноос түүвэрлэсэн үгсээс энэ төрлийн хувьсал харагдаж байгаа ч хоёр үг хооронд буюу голчлон “бай-” язгууртай туслах үгийн б /р/ гийгүүлэгч болон туслах үг “юм”-ын гулсах гийгүүлэгч болох ю /j/ сулран гээгдэж, өмнөх үгтэйгээ нэгдэж байгаагаараа онцлог байна. Жишээлбэл:

хаана байна > хаана вайна > хаанайна

суух юм > суухын?

³ Санжаа, Ж., Надмид, Ж., (2018). Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй. Улаанбаатар. х. 255

“Зэргэлдээ авиалбарын хоёр дахь авиалбар нь эхний авиалбараасаа нөлөөтөж байвал дэвших ижилшил гэнэ. Үүнд эгшгийн ижилшил байж болно. Эхний авиалбар нь дараагийн авиалбартайгаа ижил төстэй шинжтэй болж байвал ухрах ижилшил гээд гийгүүлэгчийн уруулших үзэгдлийг жишээ татаж болно” (Д. Уртнасан, 2022) гэжээ. Харин ярианы хэлний авианы өөрчлөлтөд зөвхөн гийгүүлэгч бус эгшигт ухарч ижилших үзэгдэл ажиглагдаж байна. Жишээ нь, үйлийн зэрэгцэн холбох “-ж” нөхцөлийн дараа “байгаад” гэсэн туслах үгийг бичихэд:

- a. *ирж байгаад > ирж вайгаад > иржаагаад* болох буюу туслах үг өмнөх үгтэйгээ нэгдэхэд гийгүүлэгч авиа сулран гээгдсэнээр тэргүүн үеийн хос эгшиг авиа нь II үеийн урт эгшигтэй ижилшин уртаар дуудагдаж байна. Эндээс хоёр үг хэдийгээр нэг болж дуудагдаж байгаа боловч эгшгийн ижилшил явагдахад гол буюу өмнөх үгийн эгшигтэй дэвшиж ижилшихийн оронд өмнөх туслах үгийн эгшигтэй ухран ижилшиж байгааг харж болно. Энэ нь “бай-” язгууртай туслах үгийн II үед орсон уруулын бус, нам [a:] эгшиг авиатай холбоотой байгаа бол үйлийн мөн нөхцөлөөр төгссөн үгтэй “байна” гэдэг үг нэгдэхэд:
- b. *ирж байна > ирж вайна > иржийн(э)/иржээн(э)* гэж дуудагдаж байна. Энэ нь тагнайн дуугүй хамжин шүргэх ж [ʃ] гийгүүлэгч авианы нөлөөгөөр хэлний байрлал намавтар байсан ай [æ:] эгшиг авиа өндөр эгшиг ий [i:] болж ижилшиж байна. Өмнөх жишээнээс ялгаатай нь байгаа гэдэг үгийн аа [a:] авиаг дуудах үед доод эрүү чинээгээрээ доошилж, хэлний нам байрлалд байдаг байхад н [n] авиаг хэлэхэд хэлний үзүүр дээд үүдэн шүд ба түүшинд тулж амны хөндийд битүүмжлэл үүсгэдэг. Иймээс “бай-” язгуурын хос эгшгийг дуудахад хэлний намавтар байрлалд байгаа [æ:] эгшиг авиа тагнайн ж [ʃ] гийгүүлэгчийн нөлөөгөөр ий [i:] эсвэл [e:] болж ижилшиж байна.

3.2. Харин үйлийн тодотгон холбох “-х”, “-даг” нөхцөлүүдийн дараа дагуулж бичсэн “юм” туслах үг өмнөх гол үгтэйгээ нийлж нэг үг болохдоо урт эгшгээр дуудагдаж байна. Тодруулбал, гулсах гийгүүлэгч ю [j] нь тагнайн ойртох авиа бөгөөд улмаар [i:] эгшиг авиа болсон байна. Жишээ нь:

яах юм бэ > яахын яадаг юм > яадын/яадгийн

Мөн байнга үйлдэх одоо цагаар тодотгон холбох “-даг” нөхцөлийн дараа туслах үг “юм” ороход үгийн эцсийн “г” зарим үед гээгдэж (яадын), зарим үед хэвээрээ байгаа нь (яадгийн) хэлэхийн хурдтай холбоотой.

Энд бас асуух сул үг “бэ/вэ” хэлэхийн урсгалд хураагдсан байна.





График 1. Авианы хувьслын статистик

Графикт үзүүлсний дагуу авиаг хураах үзэгдэл нь хамгийн их буюу нийт түүвэрлэсэн 200 үгийн 77-д нь илэрч байна. Үүнээс үзэхэд цахим орчинд үгсийг богиносгож хэрэглэх хандлага түгээмэл байна. Энэ нь цагаа хэмнэх болоод хурдан харилцах соёлоос үүдэлтэй. Харин авиа гээгдэх хувьсалтай 34 үг, авианы хэмнэл явагдсан 67 үг байгаа нь хэлэхийн хурдаас үүдэн авианд гарч байгаа өөрчлөлт элбэг байгааг харуулж байна.



200 үгийг 100% гэж үзвэл латинаар бичигдсэн үг 72%, кириллээр бичигдсэн үг 28% байгаагаас харахад орчин үеийн хүүхэд залуусын гадаад хэл сурах хүсэл сонирхол, хэрэглээ нь төдий чинээ их байгааг харж болохоор байна. Мөн даяаршил эрчимтэй явагдаж буй энэ цаг үед гадны улс орноос орж ирдэг техник технологи дээрх хэл, брэндийн нэрс, цахим орчны хэрэглээ зэргээс болж латинаар бичих хандлага түгээмэл байна.

График 2. Цахим орчны бичвэрийн үсгийн хэрэглээний харьцуулалт

Хоёр. Монголжсон дуудлагатай гадаад үгсийн авианы хувьсал

Гадаад үгсийг дуудахад тухайн хэлний авиа нь монгол хэлний авиа зүйн онцлогоос хамаарч өөрчлөгддөг. Тэдгээр авианд гарсан өөрчлөлтүүдийг ангилж үзвэл:

2.1. Ондооших үзэгдэл

- a. Шүд түүшийн дуугүй хамжих [t] авиа шүд тагнайн дуугүй хамжин шүргэх [ʈ] авиа болж ондоошиж байна. Жишээ нь:
радио > араажав border > боржуур
- b. Мөн дээрх авиануудын түрэлттэй илэрдэг хэлбэр болох шүдний, түрэлттэй, дуугүй хамжих [tʰ] авиа нь шүд тагнайн дуугүй түрэлттэй хамжин шүргэх [ʈʰ] авиа болж ондоошиж байна. Жишээлбэл:
театр > чаатр куртика > күүрчиг

2.2. Гийгүүлэгч авиа гээгдэх үзэгдэл

- a. Уруулын б [p] болон п [pʰ] гийгүүлэгч суларч в [w] гулсах гийгүүлэгч болж улмаар гээгдсэн:
автобус > автобус > автуус паспорт > пасворт > паасуурт
- b. Гулсах гийгүүлэгч в [w] хэлэхийн хурдаас хамаарч хураагдсан:
автуус > атуус

2.3. Уртших үзэгдэл

Гадаад хэлэнд богино эгшгээр тэмдэглэснийг уртаар дуудсан:

куртика > күүрчиг, бургер > бүүргер,
морозное > маруужин, резин > эрзээн

2.4. Эгшиг авиа нэмэгдэх үзэгдэл

- a. Гадаад үгийн тэргүүн үед орсон “p” гийгүүлэгчийн өмнө эгшиг нэмэгдсэн. Жишээлбэл:
радио > араажав резин > эрзээн
рекорд > эркоорд реклам > эрклаам
- b. Тэргүүн үед дараалан орсон гийгүүлэгчийн завсар эгшиг нэмэгдсэн. Жишээ нь:
блок > болоок плитка > нэлээтэг

2.5. Хэлэхүйн орчин, хэлний хэрэглэгчийн онцлогоос хамаарч хувилбарт дуудлага үүссэн:

шоколад > шоклаад > шаклаад > чиглаад
пиво > пийв > пиав

Дараах хүснэгтээс монголжсон гадаад үгсийг харна уу.

№	Түүврүүд	Эх сурвалж	Олон улсын галиг (IPA)	Зөв бичих дүрэм ёсоор
1	АРААЖАВ	https://www.facebook.com/share/v/1E7G9y3MpV/ “MNB.MN” 2024.08.19	ara:ʃa:w	радио
2	БОРЖУУР	https://www.facebook.com/share/p/1E-Jr5iTDxX/ “Medee.mn” 2024.10.16	pɔrʃo:r	боржуур/ border
3	КҮҮРЧИГ	https://www.facebook.com/share/p/1ASg3dBXgt/ “Uyanga Gantumur” 2023.04.20	kʰu:r ʃʰək	куртика
4	Коноо чаатр	https://www.facebook.com/share/p/1BYM-M2Nxls/ “Uyanga Tsoggerel” 2023.01.03	ʃʰa:tʰər	театр
5	БЭНЗЭЭН	https://www.facebook.com/share/p/1Dsx-SZ6vuQ/ “Зугаатай хэл шинжлэл” 2020.04.25	pentse:ŋ	бензин
6	ЭРЗЭЭН	https://www.facebook.com/share/p/1AY-JTSnuZT/ “Самбуугийн Нямсүрэн”	ertse:ŋ	резин
7	ЭРКООРД	https://youtu.be/oB15076M7zc?si=IQ3dX-Ezeg0yeMedr “Ariukaa Ariunsan” 2025.01.26	erkʰo:rt	рекорд
8	ЭРКЛААМ	https://www.facebook.com/share/p/18xUP-pWfZ4/ “Narana Janchiv” 2025.01.13	erkʰla:m	реклам
9	БОЛООК	https://www.facebook.com/share/v/1BXC-6c4AVG/ “Montop” 2020.10.10	pɔlɔ:kʰ	блок
11	ПЭЛЭЭТЭГ	https://www.facebook.com/share/p/1E6y-qeaBQ2/ “Төмөр тунгалаг” 2025.03.01	pʰele:tʰək	плитка
11	ЮҮПЭГ	https://www.facebook.com/share/p/1CT-muCYGGY/ “Duuyaa Duuyaa” 2025.03.30	jupək	юпка

12	автуус	https://www.facebook.com/share/p/1DArftmkuF/ “Бээжин хот, буудал, мэдээлэл, зөвлөгөө” 2025.02.23	awt ^h o:s	автобус
13	паасуурт	https://x.com/Uyanga_ts/status/1656297388951339009 “x.com” “Uyanga Tsoggerel” 2023.05.10	p ^h a:so:rt ^h	паспорт
14	Маруужин	https://www.facebook.com/share/v/12FEqmDPaN7/ “Өмнөговь.мн” 2024.10.28	maro:ʃəŋ	морожное
15	бүүргэр	https://www.facebook.com/share/p/166RpDUQBc/ “Samandariin Tsogtbayar” 2025.02.12	pu:r3ər	бургер
16	шоколад	https://www.facebook.com/share/p/18qP47hA4q/ “RANDOM – Z” 2025.02.02	ʃək ^h əla:t	шоколад
17	Шаклаад	https://www.facebook.com/share/p/18qP47hA4q/ “RANDOM – Z” 2025.02.02	ʃak ^h əla:t	шоколад
18	шиклаад	https://www.facebook.com/share/p/18qP47hA4q/ “RANDOM – Z” 2025.02.02	ʃik ^h əla:t	шоколад
19	чиглаад	https://www.facebook.com/share/p/18qP47hA4q/ “RANDOM – Z” 2025.02.02	ʃ ^h ikəla:t	шоколад
20	пийв	https://www.facebook.com/share/p/1BSQnwX2df/ “RANDOM – Z” 2024.11.30	p ^h i:w	пиво
21	Пиав	https://www.facebook.com/share/p/1E7ZqBp4yo/ “Төмөр Тунгалаг” 2025.04.02	p ^h aw	пиво

ДҮГНЭЛТ

Бид энэхүү өгүүлэлдээ орчин цагийн ярианы хэлэн дэх авианы өөрчлөлтүүдийг авиа зүйн үүднээс хэрэглээн дээр тулгуурлан тодруулахад:

1. Нэгдүгээрт, монгол хэлний хэрэглээний явц дахь 200 үгийг цахим орчноос түүвэрлэж, авианы хувьслыг “авиа хураах”, “хэмнэх”, “сулран гээгдэх” гэсэн гурван үндсэн бүлэгт хуваан ангилсан. Мөн монголжсон дуудлагатай гадаад үгсийн авианы хувьслыг тусад нь ангилж, эдгээр үгс

нь монгол хэлний ярианы авиа зүйн зарчмаар дуудагдаж буйг жишээгээр батлав.

2. Хэлэхийн хурд болон цахим орчинд цагаа хэмнэн хурдан бичих үүднээс авиаг хурааж, хэмнэж бичих зарчмыг нь авиа зүйн онолын үүднээс тайлбарлав.
3. Үүнээс орчин цагийн ярианы хэлний хэрэглээнд байгаа авианы өөрчлөлт нь хэлний буруу гаж үзэгдэл биш, харин авиа зүйн зүй тогтолтой, хэвийн үзэгдэл явагдаж байгааг харж болно. Гэсэн ч зөв бичих дүрэм нь хэлний стандарт, соёлын дархлаа болдог учраас бичгийн хэлэнд зөв бичих зүйн хэм хэмжээг баримтлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр авианы өөрчлөлттэй үг нь бичгийн хэлэнд хамааралгүй байна. Харин хэлэхүйд болоод ярианы хэлээрээ бичдэг цахим орчинд л хэрэглэвэл зохистой.
4. 200 үг түүвэрлэсний 72 хувийг нь латин үсгээр бичсэн нь орчин үеийн хүүхэд залуусын гадаад явах, гадны хэл сурах хүсэл сонирхол, хэрэгцээ төдий чинээ их байгааг харуулж байна. Нөгөө талаас даяаршил эрчимтэй явагдаж буй энэ цаг үед гадны улс орноос орж ирдэг техник технологи дээрх хэл, брэндийн нэрс, цахим орчны хэрэглээ зэргээс болж латинаар бичих хандлага түгээмэл байна. Мөн кирилл, латин үсгийг хослуулан хэрэглэж байгаа нь олон хэлний харилцан нөлөөллийг илэрхийлж болно.

НОМ ЗҮЙ

- Базаррагчаа, М. (1987). *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. Улаанбаатар.
- Цолоо, Ж. (2008). *Орчин цагийн монгол хэлний авиа зүй*. Улаанбаатар.
- Санжаа, Ж., Надмид, Ж., (2018). *Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй*. Улаанбаатар.
- Уртнасан, Д., Ц. Б. (2022). *Авиа зүй. Монгол хэл судлал VIII боть*. Улаанбаатар.

Судалгааны бүтээл

- Нямжав, Б. (2015). *Монгол, Англи хэлний нийлмэл авианы үг*. Acta Mongolica, 94-102.
- Ариунжаргал, Б. (2022). *Цахим орчин дахь үгийн бүтэц, хэрэглээний судалгаа*. Улаанбаатар.

PHONETIC VARIATION IN CONTEMPORARY SPOKEN MONGOLIAN

Keywords: *spoken language, speech rate, phonetic variation, language use*

ABSTRACT

In this article, we analyzed speech-language words collected from online articles and comments to identify phonetic changes in contemporary digital communication. The research examines:

1. The phonetic evolution occurring during usage,
2. The transformation of foreign words into Mongolian pronunciation.

This study explains phonetic phenomena such as reduction, simplification, omission, addition, differentiation, assimilation, and lengthening using modern Mongolian language examples.



МОНГОЛ ХЭЛЭНД ДАВТАМЖ ӨНДӨР ИЛРЭХ АНГЛИ, ОРОС ХЭЛНИЙ ҮГИЙН ДУУДЛАГЫН ОНЦЛОГИЙГ ИЛРҮҮЛЭХ НЬ

Зоригтбаатарын ХИШИГБАЯР

МУБИС. НХУС.

МХУЗ-ын багшийн III курсийн оюутан

Удирдагч багш: Д. Уртнасан

ШУА. ХЗХ. Харьцуулсан хэл шинжлэлийн салбар (Ph.D)

Агуулгын товч: Монголчууд эрт цагаас дэлхийн олон улс оронтой холбоо харилцаатай явж ирсэн учраас тэдгээр улсуудын хэлнээс монгол хэлэнд олон үг орж, үгийн сан нь улам бүр баяжсан. Шинжлэх ухаан – техник хувьсгалын эрин үед салбар бүрт шинэ шинэ зүйл бий болж түргэн хурдацтай хөгжиж байгаа энэ үед харилцааны чухал зэвсэг болох эх хэлний маань үгийн сан шинэ үг хэллэгээр баяжсаар байна. Ингэхдээ тэдгээр гадаад үгийг танихааргүй болтол “монголжуулж” дуудах, эсвэл тухайн гадаад хэл дэх дуудлагаас нь зөрүүтэй дуудах зэрэг үзэгдэл түгээмэл ажиглагддаг. Тиймээс гадаад үгийн дуудлагын онцлогийг илрүүлж авиа зүйн үүднээс тайлбарлах нь олон талын ач холбогдолтой юм.

Тус судалгааны хүрээнд цахим орчинд давтамж өндөр 120 гаруй үгийг түүвэрлэж, дуу бичлэгийн хамт цуглуулж үгийн дата хөмрөг бүрдүүлсэн. Тухайн түүвэрлэсэн гадаад үгсийн давтамжийг тооцоолохдоо цахимаар 160 хүнээс асуулга авсан. Түүвэрлэсэн 120 үгнээс хамгийн өндөр давтамжтай нь фэйсбүүк, карт, банк, мессеж, компьютер, нөүтбүүк, кофе, спорт, такси, видео гэх мэт үгс байсан. Тухайн түүвэрлэсэн үгийн дуудлагыг олон улсын авиа зүйн галиг (IPA)-аар галиглаж, англи хэл болон орос хэлний тогтсон IPA-тэй харьцуулж онцлогийг тодруулав.

Түлхүүр үг: гадаад үг, дан богино эгшиг авиалбар, дуудлагын галиг (IPA), эгшгийн ондоошил

УДИРТГАЛ

Судалгааны зорилго: Өдөр тутамд болон цахим орчинд өндөр давтамжтай илэрч буй англи, орос хэлний үгийг судалж, тухайн хэл дэх эгшиг авиалбар нь монгол хэлэнд илрэхдээ хэрхэн ондоошиж болон хэвээр дуудагдаж байгааг тухайн хэлнүүдийн дуудлагын галигтай харьцуулж, зөрүүтэй дуудлагад дүн шинжилгээ хийх цаашлаад дуудлагын хувьд хэрхэн “монголждог” болохыг тогтоон авиа зүйн үүднээс зохих тайлбарыг хийнэ.

Сэдвийн үндэслэл: Хүн бүр мэдлэг чадвараа дээшлүүлэхийн тулд төрөлх хэлээсээ гадна гадаад хэлийг техник технологийн тусламжтай сурах, цахим орчны хэрэглээний улмаас өдөр тутмын харилцаандаа гадаад үгийг их хэрэглэх болсон. Гэхдээ тэдгээр гадаад үгийг танихааргүй болтол “монголжуулж” дуудах эсвэл тухайн гадаад хэл дэх дуудлагаас зөрүүтэй дуудаж байгаа нь судлах шаардлагатайг илэрхийлж байна.

Сэдвийн судлагдсан байдал: Орчин цагийн монгол хэлэнд европын хэлнээс орсон “курс”, “фунт” зэрэг үгийг “күрс”, “фүнд” гэж өргөлттэй ү эгшгээр дууддаг нь харь гаралтай үг нь эх хэлнийхээ авианы дуудлагыг хадгалдгийг баталж байна. “Клуб” гэх үгийн эхэнд хоёр гийгүүлэгч дараалан орох нь монгол үг, түүний дуудлагад таарахгүй тул монгол хүн уг хоёр гийгүүлэгчийг эгшиг зохицох ёсны дагуу у, ү эгшгээр амилуулж “kulub” гэж дууддаг. (Даваажав, 2013)

Монголжсон үгсийн авианы хувьслыг ажиглавал дараах хэдэн онцлогтой байна. Үүнд:

1. Өргөлтөт үеийн уруулын эгшиг нь уртаар дуудагдвал өмнөх болон дараагийн үеийн эгшиг уруулшина. Жишээ нь: пальто > польтоо, вагон > вогоон [wəʊ:n]
2. Үгийн тэргүүн болон тэргүүн үеэс хойш орсон у [o] нь үү [u:] эгшгээр дуудагдана. Жишээ нь: институт > инстуүт [insu:], клуб > клуүб [ɬu:p]
3. Гадаад хэлний үгийн өргөлтөт үеийн эгшиг нь монгол хэлэнд уртаар дуудагдана. Жишээ нь: масло > масал [ma:səɮ], лампа > лаамп [la:m] (Д. Уртнасан, Ц. Батдорж, С. Батхишиг, 2022)

Орос хэлээр дамжиж монгол хэлэнд орж ирсэн “трактор” гэх үгийг монгол хүн “тараахтар” гэж дуудаж буй нь монгол хэлнийхээ эгшгийг зохицол, гийгүүлэгчийн байр, үеийн бүтцэд захирагдаж байгаа хэрэг юм. Цаашдаа япон, солонгос зэрэг Азийн бусад үндэстнүүдийн нэгэн адил эх хэлэндээ орсон харь гаралтай үгсийн бичлэгийг хэлнийхээ бодит дуудлагад тохируулан, зөв бичих дүрмийн толиор жигдлэн тогтоож, нийтээр дагаж мөрдөх буй заа. Харин тухайн


гадаад хэлээр ярьж, бичихдээ угийн бичлэг, дуудлагыг дагаж мөрдөх нь зүйн хэрэг. Саяхан дахин боловсруулсан кирилл бичгийн зөв бичих дүрмийн тольд гараж {<Fr. garage} гэх мэт европ гаралтай зарим үгийг монгол хэлний бодит дуудлагад нийцүүлэн гарааш гэж бичсэн нь сайшаалтай. (Төмөртоогоо, 2018) гэх мэт монгол хэлэнд орсон гадаад үгсийн авианы дуудлагын талаарх судалгаа байдаг ч арвин биш юм. Иймээс бид энэ удаа дан богино эгшиг авиалбарын хүрээнд монгол хэлэнд орсон англи, орос хэлний үгийн дуудлагын авиа зүйн онцлогийг эгшиг тус бүр дээр тодруулах юм.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: **International Phonetic Alphabet¹** (IPA)-г нийтээр даган хэрэглэх нь хэл бүрийн авианы тэмдэглэгээг нэг болгох зорилготойгоос гадна аливаа хэлийг сурах хийгээд сургах, түүнчлэн судалгаа шинжилгээнд чухал үүрэгтэй юм. Олон улсын авиа зүйн галигийг сурсан хүн ямар ч хэлний дуудлагыг цэвэр тод дуудах боломжтой. Энэхүү судалгаанд монгол, орос, англи хэлэн дэх үгсийг IPA-аар галигласнаар хэл сурч байгаа хүн дараах үгсийн дуудлагыг хооронд харьцуулан судлах боломжтой болох юм.

Судалгааны ажлын арга зүй, хэрэглэгдэхүүн: Энэхүү судалгаанд баримт бичиг шинжлэх, асуулгын, туршилтын арга болон тухайн түүвэрлэсэн үгийн дуудлагыг олон улсын авиа зүйн галиг (IPA)-аар галиглаж, англи хэл болон орос хэлний тогтсон IPA-тай харьцуулах аргуудыг ашиглав.

Судалгааны ажлын хүрээнд 2025 оны 1 сарын 1-ээс 2 сарын 28-ны хооронд цахим орчинд давтамж өндөртэй гадаад үгсийг дуу бичлэгийн хамт түүвэрлэж цуглуулсан. Давтамжийг тооцохгүйгээр нийт 120 үгийн дата хөмрөг бүрдүүлсэн. Давтамжийг тооцохдоо цахимаар 160 хүнээс асуулга авсан. Энэхүү асуулгад хамгийн өндөр давтамжтай үг нь “фэйсбүүк” гэх үг байсан бөгөөд 119 хүн өдөр тутамдаа хэрэглэдэг гэсэн. Дараах графикаар давтамж өндөр 20 үгийг давтамжийн хамт харуулав.

¹ Олон улсын авиа зүйн галиг



Зураг 1. Цахим орчинд илэрсэн гадаад үгсийн давтамж

ОНОЛЫН ХЭСЭГ

Авианы галиг (IPA) нь ямар нэг хэлний авианы өгүүлэх, сонсох зүйн шинжийг нь харгалзан үзэж, авиа бүрийг тэмдэглэж болдог. Энэ галиг нь хэл бүрийн авиаг хамгийн энгийн тэмдгээр илэрхийлдэг бөгөөд тэмдэгтүүдийг ром болон грек үсгээс авч бүтээсэн. Хэл бүрийн авиаг сонсохуйд хүртэх байдлаар галигладаг бөгөөд дөрвөлжин хаалтад [] тэмдэглэдэг уламжлалтай.

Хэлний авиа ба авиалбар: Өгүүлэхүйн эрхтнээр дамжин гарах авиаг утга ялгахад оролцох талаас нь хэлний авиа (speech sound) гэнэ. Хэлний авиа нь физик шинжээрээ бодитой оршиж, хийсвэр шинжээрээ танигддаг. Тиймээс агаарын урсгалд оршдог, физик шинжээрээ бодитой дууг авиа (phone), харин эдгээр дуу хийсвэрлэгдэж, утга илэрхийлж буй дууг авиалбар (phoneme) гэнэ.

Эгшиг нь уушгинаас түрэгдсэн хийн урсгал дууны зам (амьсгалын)-аар дамжихдаа ямар нэгэн саадгүй чөлөөтэй гардаг авиа бөгөөд дууны хөвчийн чичирхийллээс дуу үүсэж, тэрхүү дууг хэлний байрлал, уруулын оролцоогоор өөрчлөхөд өөр өөр эгшиг авиа үүсдэг.

Монгол хэлний эгшгийг дараах байдлаар ангилна. **Хэлний босоо байрлалаар** эгшгийг:

Өндөр: и, ү

Өндрөвтөр: э [e], у [y], ө, у

Намавтар: а [æ], о [œ], о

Нам: а гэж ангилдаг. Хэлний босоо байрлал гэдэг нь хэлний өргөгдсөн хамгийн дээд хэсэг тагнайгаас хэр хол байгааг илэрхийлнэ.

Хэлний хөндлөн байрлалаар эгшгийг:

Хэлний урдуурх: и, э [e], у [y], а [æ], о [œ]

Хэлний дундуурх: а, ө

Хэлний хойгуурх: о, у, ү гэж ангилдаг. Хэлний хөндлөн байрлал гэдэг нь хэлний өргөгдсөн хамгийн дээд хэсэг амны хөндийн хаана байрлаж байгаагаар ялгагдана.

Эгшгийг уруул оролцох байдлаар нь:

Уруулын эгшиг: и, э [e], а [æ], а

Уруулын бус эгшиг: у [y], о [œ], о, у, ө, ү гэж тус тус ангилдаг.²

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол хэлний [æ] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. арми [mon. æ:rəm > eng. a:rmi > rus. 'ar.m'ijə] – англи хэл болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх эгшгийн нөлөөгөөр хэлний дундуурх эгшиг урагшилж ондоошсон.
2. бригад [mon. pærka:t > eng. bri 'geid > rus. br'i'gat] – англи хэл болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний өндөр эгшиг нам эгшиг болон ондоошсон.
3. кабель [mon. æ:pjəl > eng. 'keibl > rus. 'ka.b'il'] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болон ондоошсон. Харин орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
4. карантин [mon. ærəniŋ > eng. 'kwə:rənti:n > rus. kə.rən'tin] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болон ондоошсон. Харин орос хэлний дуудлагад [æ] эгшиг авиалбар нь балархайшсан.

² Монгол хэл судлал VIII боть

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. банк [mon. pæn > eng. bæŋk > rus. bank]
2. бактери [mon. pæxje:r > eng. bæk'tiəriə > rus. bæk't'eriʲə]
3. вакцин [mon. wæxi:ŋ > eng. 'væksi:n > rus. vək'tsinə]
4. макро [mon. mære > eng. mækrəʊ > rus. 'ma.krə]
5. такси [mon. æksi: > eng. tæksi > rus. tək'si]

Монгол хэлний [a] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. радио [mon. ara:tiə > eng. 'reidiəʊ > rus. 'ra.dʲiə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Харин орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
2. академи [mon. aatje:m > eng. ə'kædəmi > rus. ə.kə'd'iem'iʲə] – англи хэл болон орос хэлний дуудлагын галигт [a] эгшиг авиалбар нь балархайшсан.
3. банк [mon. paŋ > eng. bæŋk > rus. bæn] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх эгшиг хэлний дундуурх эгшиг болж ондоошсон. Харин орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
4. танк [mon. a:ŋ > eng. tæŋk > rus. tæn] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх эгшиг хэлний дундуурх эгшиг болж ондоошсон. Харин орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
5. караоке [mon. ara:ə > eng. kəri 'əʊki > rus. kə.rɐ'o.k'iə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх эгшиг хэлний дундуурх эгшиг болж ондоошсон. Харин орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
6. килограмм [mon. iləkra:m (xi:l) > eng. kiləgræm > rus. kʲi.lə'gram] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх эгшиг хэлний дундуурх эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. маркетинг [mon. ma:riŋ > eng. mɑ:rkitiŋ]
2. маск [mon. ma:sə > eng. mɑ:sk]
3. мастер [mon. ma:sər > eng. 'mɑ:stə(r)]
4. карт [mon. a:r > eng. kɑ:rd]
5. парк [mon. a:r > eng. pɑ:rk]
6. гуаш [mon. qwa:f > eng. gwaʃ]

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. банк [mon. pan > rus. bank]
2. радио [mon. ara:tio > rus. 'ra.diə]
3. танк [mon. a:ŋ > rus. tank]
4. караоке [mon. ara:ɔ > rus. kʌ.rɐ'o.kiə]
5. килограмм [mon. iɬekra:m (xi:l) > rus. kʲi.lɐ'gram]
6. маркетинг [mon. ma:riŋ > rus. 'mar.ki.tiŋk]
7. маск [mon. ma:sə > rus. mask]
8. мастер [mon. ma:sər > rus. 'mas.tʲir]
9. карт [mon. a:r > rus. kart]
10. парк [mon. a:r > rus. park]
11. гуаш [mon. qwa:ʃ > rus. gu'aʃ]

Монгол хэлний [i] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. вирус [mon. wi:ru:s > eng. 'vairəs > rus. 'vi.rus] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
2. микрофон [mon. miɐrɔ:ŋ > eng. maikrəfəʊn > rus. mi.krɐ'fon] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
3. шифр [mon. eng. 'saifər > rus. ʃifr] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
4. Вино [mon. wino: > eng. waɪn > rus. vi'no] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
5. Генерал [mon. kinra:l > eng. 'dʒenərəl > rus. gi.nɪ'raɫ] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. виз [mon. wi:ts > eng. vi:zə]
2. индекс [mon. i:ntjes > eng. 'indeks]
3. бизнес [mon. pi:tsəns > eng. biznəs]
4. видео [mon. wi:tio > eng. vidiəʊ]
5. диск [mon. ti:s > eng. disk]

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. вирус [mon. wiru:s > rus. 'vi.rus]
2. микрофон [mon. miəɾɔ:ŋ > rus. mi.krɐ'fon]
3. шифр [mon. > rus. sifr]
4. Вино [mon. winɔ: > rus. vi'no]
5. Генерал [mon. kinra:l > rus. gi.nɪ'ral]
6. виз [mon. wi:ts > rus. vizə]
7. индекс [mon. i:ntjes > rus. 'in.dɪks]
8. бизнес [mon. pi:tsəns > rus. 'biz.nɪs]
9. видео [mon. wi:tɔ > rus. 'vi.dɪə]
10. диск [mon. ti:s > rus. disk]

Монгол хэлний [e] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. цемент [mon. ɛ:mən > eng. si 'ment > rus. tsɪ'mʲent] – англи болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад өндөр эгшиг нам эгшиг болж ондоошсон.
2. менежер [mon. mɛ:ne:ʃɛr > eng. 'mænɪdʒə(r) > rus. 'mʲenʲi.dʒɪr] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
3. менежмент [mon. mɛnəʃmɛ:n > eng. 'mænɪdʒmənt > rus. 'mʲenʲi.dʒmʲent] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
4. Фейсбүүк [mon. ɛ:spu: > eng. 'feɪsbʊk > rus. 'fʲejz.buk] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
5. Ресторан [mon. ɪrɛsəɾa:ŋ > eng. 'rɛstrənt > rus. rʲi.stɐ'ran] – англи хэлний дуудлагын галигт адил илэрсэн. ай харьцуулахад нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон.

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. тендер [mon. ɛ:ntər > eng. tɛndə(r)]
2. лекц [mon. lɛ:x > eng. 'lɛktʃə(r)]
3. мессеж [mon. mɛ:səʃ > eng. 'mɛsɪdʒ]
4. метро [mon. mɛɾɔ: > eng. 'mɛtrəʊ]
5. вебсайт [mon. wɛ:psajə > eng. wɛbsaɪt]

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. Фейсбүүк [mon. ɛ:spu: > rus. 'fʲejz.buk]
2. тендер [mon. ɛ:ntər > rus. 'tʲen.dʲɪr]
3. лекц [mon. lɛ:x > rus. lʲɛkts]
4. мессеж [mon. mɛ:səʃ > rus. 'mʲes.sʲɪdʒ]
5. вебсайт [mon. wɛ:psaja > rus. 'vʲɛp.sajt]

Монгол хэлний [ɔ] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. комплекс [mon. ʊmljəs > eng. 'kɒmpleks > rus. kəm'plʲeks] – англи хэл болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг хойгуурх эгшиг болж ондоошсон.
2. кофе [mon. ʊi: > eng. 'kɒfi > rus. 'ko.fʲə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг хойгуурх эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
3. фокус [mon. ʊ: əs > eng. 'fəʊkəs > rus. 'fo.kus] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
4. лого [mon. ʊ:kə: > eng. 'ləʊgəʊ > rus. 'lo.gə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
5. Компьютер [mon. ʊmju:ər > eng. kəm 'pyutər > rus. kəm'pʲju.tʲɪr] – англи хэлний дуудлагат [ɔ] эгшиг авиалбар балархайшсан. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг хойгуурх эгшиг болж ондоошсон.
6. бокс [mon. pʊ:s > eng. baks > rus. bʊks] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг хойгуурх эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. форум [mon. ʊ:rm > eng. fɔ:rəm]
2. спорт [mon. isɔ:r > eng. spɔ:rt]
3. хлор [mon. xɔlɔ:r > eng. 'klɔ:ri:n]
4. норм [mon. nɔ:rəm > eng. nɔ:rm]
5. паспорт [mon. a:sɔr > eng. 'pæspɔ:rt]

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. бокс [mon. pɔ:s > rus. boks]
2. форум [mon. ɔ:rm > rus. 'fɔ.rum]
3. спорт [mon. isɔ:r > rus. spɔrt]
4. хлор [mon. xɔlɔ:r > rus. xlɔr]
5. норм [mon. nɔ:rəm > rus. nɔrm]

Монгол хэлний [u] эгшиг авиалбар илрэх байдал

Ондоошиж илэрсэн нь:

1. клуб [mon. ulɥ:p > eng. klɒb > rus. klɥp] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад уруулын бус эгшиг уруулиж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
2. курс [mon. ɥ:rs > eng. kɔ:rs > rus. kɥrs] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний өндөр эгшиг нам эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
3. секунд [mon. seɥ:n > eng. 'sekənd > rus. sɪ'kɥndə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний өндөр эгшиг нам эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
4. куб [mon. ɥ:p > eng. kju:b > rus. kɥp] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
5. Сюрприз [mon. surri:tɕ > eng. sɜr'praɪz > rus. sʲɔr'priʲz] – англи хэлний дуудлагат [u] эгшиг авиалбар нь балархайшсан.

Англи хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. жүүс [mon. ʃɥ:s > eng. zɥs]
2. групп [mon. kurɥ: > eng. grɥ:p]
3. дуэт [mon. tɥe: > eng. dɥ'et]
4. рубль [mon. rɥ:peɭ > eng. 'rɥbl]

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. клуб [mon. ulɥ:p > rus. klɥp]
2. курс [mon. ɥ:rs > rus. kɥrs]
3. секунд [mon. seɥ:n > rus. sɪ'kɥndə]
4. куб [mon. ɥ:p > rus. kɥp]
5. групп [mon. kurɥ: > rus. grɥp]
6. дуэт [mon. tɥe: > rus. dɥ'et]
7. рубль [mon. rɥ:peɭ > rus. 'rɥbl]

Монгол хэлний [o] эгшиг авиалбар илрэх байдал*Ондоошиж илэрсэн нь:*

1. журнал [mon. ʃɔrna:l > eng. 'dʒɜ:rnəl > rus. zʊr'nal] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад уруулын биш эгшиг уруулшиж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
2. кактус [mon. > eng. 'kæktəs > rus. 'kak.tʊs] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад уруулын биш эгшиг уруулшиж ондоошсон. Орос хэлний дуудлагат хэвээр илэрсэн.
3. купон [mon. ɔ:ŋ > eng. 'ku:pən > rus. kʊ'pon] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний өндөр эгшиг нам эгшиг болон ондоошсон. Орос хэлний дуудлагат хэвээр илэрсэн.
4. вакуум [mon. waɔ:m > eng. 'vækyum > rus. vɐ'kʊ.um] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.
5. молекул [mon. mɔljeɔ:l > eng. 'maləkyul > rus. mɐ.lɪ'kʊlə] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагат адил илэрсэн.

Орос хэлний дуудлага нь хэвээр илэрсэн нь:

1. журнал [mon. ʃɔrna:l > rus. zʊr'nal]
2. кактус [mon. > rus. 'kak.tʊs]
3. купон [mon. ɔ:ŋ > rus. kʊ'pon]
4. вакуум [mon. waɔ:m > rus. vɐ'kʊ.um]
5. молекул [mon. mɔljeɔ:l > rus. mɐ.lɪ'kʊlə]

Монгол хэлний [œ] эгшиг авиалбар илрэх байдал*Ондоошиж илэрсэн нь:*

1. молекул [mon. mœlje:ɔ:l > eng. 'ma:likju:l > rus. mɐ.lɪ'kʊlə] – англи болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг урагшилж ондоошсон.
2. комисс [mon. œməs > eng. kə'miʃn > rus. kɐ'miʃis] – англи болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг урагшилж ондоошсон.
3. офицер [mon. œfɛ:r > eng. 'a:fisər > rus. ɔ.fɪ'tsɛr] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг урагшилж ондоошсон. Орос хэлний дуудлагад [œ] эгшиг авиалбар балархайшсан.

4. волейбол [mon. wɔɛlɪpɔ:l > eng. 'va:libɔ:l > rus. vɐ.lɪj'bol] – англи хэл болон орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх эгшиг урагшилж ондоошсон.
5. социализм [mon. sɔɛli:tɕm > eng. 'səʊʃəlɪzɪzəm > rus. sɐ.tsi.ə'lɪz.m] – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг дан эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний хойгуурх эгшиг урагшилж ондоошсон.

ДҮГНЭЛТ

Бид энэхүү судалгаандаа өдөр тутамд болон цахим орчинд өндөр давтамжтай илэрч буй англи, орос хэлний үгийг судалж, тухайн хэл дэх дан богино эгшиг авиаалбар нь монгол хэлэнд илрэхдээ хэрхэн ондоошиж мөн хэвээр дуудагдаж байгааг монгол хэлний дуудлагын галигтай харьцуулж, зөрүүтэй дуудлагад дүн шинжилгээ хийхийг зорилго болгон ажилласан билээ. Мэдээний сайтуудаас үгийн датагаа бүрдүүлсэн бөгөөд тухайн түүвэрлэсэн үгийн дуудлагыг олон улсын авиа зүйн галиг (IPA)-аар галиглаж, англи хэл болон орос хэлний тогтсон IPA-тэй харьцуулж дараах үр дүнг ажиглав.

- Хамгийн их давтагдсан фэйсбүүк, карт, банк, мессеж, компьютер, кофе, спорт, такси, видео, волейбол зэрэг үгсийг судалгаанд хамрагдсан хүмүүс өдөр тутамдаа тогтмол хэрэглэдэг гэж бөглөсөн бөгөөд энэ нь 160 хүний 50%-аас дээгүүрх хувийг эзэлж байна.
- Хэлний босоо байрлалаар хэлний өндөр эгшиг нам эгшиг болж ондоошсон бол эсрэгээрээ хэлний нам эгшиг өндөр эгшиг болж ондоошсон.
- Хэлний хөндлөн байрлалаар хэлний урдуурх эгшиг хэлний дундуурх эгшиг болж ондоошсон.
- Уруулын бус эгшиг уруулын эгшиг болон ондоошсон.
- Хос эгшиг дан эгшиг болон ондоошсон.
- Монгол хэлний нийт 10 дан богино эгшиг авиаалбаруудаас [æ] эгшиг авиаалбарын ондоошил хамгийн түгээмэл.
- Нэвтрүүлэгч болон хөтлөгчдийн гадаад үгийн дуудлага илүү цэвэр байсан.
- Англи, орос хэлний дан богино эгшиг авиаалбарын дуудлагаас монгол хэлний дуудлага орос хэлний дуудлагатай илүү ойр.
- Монгол хэлэн дэх гадаад хэлний үгс нь гол төлөв ярианы хэлэнд илүүтэй бөгөөд утга, хэлбэрээсээ холдож ямар үг гэдэг нь танигдахын аргагүй болсон тохиолдлууд цөөнгүй байв.

НОМ ЗҮЙ

- Дамдинсүрэн. Ц, Лувсандэндэв. А. (1982). *Орос монгол толь*. УБ: Улсын хэвлэлийн газар.
- Пулькина. И, Захава-Некрасова. Е. (2001). *Орос хэлний дүрэм*. УБ: ОНГИ хэвлэлийн газар.
- Кручкин. Ю. (2003). *Орос-монгол толь бичиг*. УБ: “T&U printing” компанийн хэвлэх үйлдвэр.
- Балжинням. Н. (2008). *Монгол хэлний гадаад үгийн толь*. УБ: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Самбуудорж. О. (2011). *Монгол хэлний үгийн дуудлагын толь*. УБ: Адмон ХХК.
- Даваажав. Г. (2013). *Монгол хэлний ормол үгийн толь*. УБ: Адмон ХХК.
- Төмөртоогоо. Д. (2018). *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*. УБ: “Адмон принт” ХХК.
- Дуламрагчаа. Т. (2018). *Судалгааны ажлын үндэс*. УБ: Адмон принтинг ХХК.
- Сүхбаатар. О. (2018). *Монгол хэлний харь үгийн толь*. УБ: Мон судар ХХК.
- Уртнасан. Д, Батдорж. Ц, Батхишиг. С. (2022). *Монгол хэл судлал. Авиа зүй*. УБ. Пүрэвжав. Э, Ганболд. Д, Заябаатар. Д, Энхжаргал. С, Эрдэнэтуяа. П, Баттогтох. Г. (2022). *Монгол хэл судлал. Бичгийн хэл*. УБ.
- “Oxford Learner’s Dictionaries” цахим толь
- “Wiki слово” цахим толь

IDENTIFYING THE PRONUNCIATION FEATURES OF ENGLISH AND RUSSIAN HIGH-FREQUENCY WORDS IN THE MONGOLIAN LANGUAGE

Abstract: *The Mongolian language has historically expanded its vocabulary by incorporating many words from other languages due to its long-standing international connections. In today’s fast-paced era of scientific and technological progress, new ideas and innovations are constantly emerging, bringing in even more foreign terms. As a result, the Mongolian lexicon continues to grow. However, these loanwords are often pronounced in a way that significantly differs from their original forms, either through adaptation into Mongolian phonetics or through inaccurate pronunciation. Studying the phonetic characteristics of such words is important for linguistic research, effective translation, and the development of language policy.*

In this research, a collection of over 120 high-frequency foreign words commonly used online was compiled, including corresponding audio recordings to form a

pronunciation dataset. Word frequency was assessed through an online survey involving 160 respondents. The most commonly used words from the list included Facebook, card, bank, message, computer, notebook, coffee, sport, taxi, and video. These words were phonetically transcribed using the International Phonetic Alphabet (IPA), and their pronunciations were analyzed by comparing them to standard IPA representations in English and Russian to highlight distinguishing phonetic features.

Keywords: *loanwords, monophthong vowel segments, IPA transcription, vowel distinction*



“АЛЧУУР” ГЭХ ҮГИЙН ТАРХАЦ БА АВИАНЫ ХУВЬСАЛ

Үнэнбүрэнгийн СОЛОНГО

МУБИС. НХУС.

МХУЗ-ын II курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл, доктор /Ph.D/

Агуулгын товч: Нутгийн аялгууны судалгааг дотор нь байдлыг тодорхойлсон нутгийн аялгууны судалгаа, түүхэн нутгийн аялгууны судалгаа, нутгийн аялгууны газар зүйн судалгаа хэмээн ангилдаг. Нутгийн аялгууг газар зүйн аргаар судлах нь тухайн аялгууны хэлний онцлог (дуудлага, хэлбэр) хэрхэн нутаг нутгаар ялгаатай тархаж буйг илэрхийлэх чухал ач холбогдолтой судалгааны арга юм. Тиймээс энэхүү өгүүлэлд Монгол хэл аялгуун дахь “алчуур” гэх үгийн авианы хувьслыг газар зүйн байрлалд тулгуурлан судалж, үр дүнг гаргасан.

Түлхүүр үг: Халх аялгуу, буриад аялгуу, ойрад аялгуу, өвөрлөгч аялгуу, алчуур, авианы хувьсал, хэлбэрийн ялгаа

УДИРТГАЛ

Сэдвийн үндэслэл: Монгол хэл, аялгууны авианы сэлгэц, зүй тогтлыг судалсан судалгаа олон боловч газар зүйн байрлалын үүднээс үгийн тархац, авианы хувьслыг тусгайлан гаргасан судалгаа ховор байна. 2008 онд Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын төвийнхэн нутгийн аялгууны газар зүйн судалгааг чухалчлан үзэж, “Өвөр монголын монгол хэлний нутгийн аялгууны судалгааг газрын зурагт тулгуурлан “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зураг”-ийн байцаалтын хөтөлбөрийг батлуулан хоёр агуулгаас бүрдэх судалгааг хийсэн. Тус судалгааны нэгдүгээр хэсэг буюу авиа зүйн хэсэгт улсын доторх олон нутгийн аялгууны авианы (үгсийн санг багтаасан) онцлогийг тусгаж чадахуйц 250 дан үгийг сонгон оруулсан.

Хоёрдугаар хэсэг буюу хэл зүйн хэсэгт жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний нэр, үйл үг, дайвар үг, сул үг зэрэг үгсийн аймагт холбогдсон 51 хэл зүйн сэдэв агуулгаар судалгаа хийж үр дүнг хэвлэн гаргасан байна.

Энэ судалгааны үр дүнд тулгуурлан “алчуур” гэх үгийн ӨМ-ын хэл аялгуунуудын тархац болон авианы хувьслын жишээг шууд авч, МУ дахь буриад, халх, ойрад аялгууны “алчуур” гэх үгийн тархац болон авианы хувьсалтай харьцуулах үүднээс энэхүү сэдвийг сонгосон.

Судалгааны ажлын зорилго: Монгол хэл аялгуун дахь “Алчуур” гэх үгийн тархац ба авиа зүйн хувьслыг тайлбарлан тодорхойлох.

Сэдвийн судлагдсан байдал: Монгол хэл, Монголын судлал болон Монгол хэлний нутгийн аялгууг судлахад монголч эрдэмтэн Я. Шмидт, О. Ковалевский, А. Бобровников, Г. И. Рамстедт, А. Д. Руднеев, Б. Я. Владимирцов, С. А. Козин, Г. Д. Санжеев, Т. А. Бертагаев, В. М. Надеяев нар чухал хувь нэмэр оруулсан.

Халх аялгууны материалыг цуглуулж, судалгааны эргэлтэд оруулах ажил ХХ зууны эхэн үеэс эхэлсэн.

- 1908 онд эрдэмтэн Ц. Ж. Жамцарано, А. Д. Руднеев нар халх ардын аман зохиолыг
- 1926 онд Б. Б. Бимбаев халх ардын туулийг
- 1932 онд Н. Н. Поппе умард халхын үлгэр, дуу, ерөөл
- 1940 онд Л. А. Амстердамская дорнод халхын ардын үлгэр зэргийг авиа зүйн галигаар нийтлүүлсэн байна.

Алексей Бобровников 1849 онд “Монгол халимаг хэл зүй” гэдэг том бүтээл бичиж Монгол хэлний авиа зүй болон хэл зүйн үзэгдлийг системтэй харьцуулан авч үзжээ. Эл бүтээлд халимаг хэл аялгууны ярианы үг хэллэгийг монгол бичгийн хэлний дурсгалуудтай харьцуулан судалж монгол хэл судлалын сонгодог зохиол бичсэн юм. Монгол хэлний нутгийн аялгуу судлалын хээрийн шинжилгээний судалгаа 1950-1980-аад оноос хойш ШУА-ХЗХ-ийн нутгийн аялгууны хээрийн судалгаа эхлүүлж өнөөг хүртэл хийсээр байна.

- 1950-аад оноос халхын аман аялгууг нарийвчлан судлах ажил эрчимжсэн бөгөөд Д. Эрдэмбилэг, Н. Шарав-Иш нар нутгийн аялгууны тухай өгүүлэл бичин хэвлүүлсэн.
- Халх аялгууны авиа зүй, хэл зүйн үндсэн онцлогийн талаар Ш. Лувсанвандан, Э. Вандуй, Ж. Цолоо нарын бие даасан бүтээлүүд бий.
- Халх аялгууны авиалбарын бүрэлдэхүүн, авиалбар судлалын тогтолцооны талаар Ш. Лувсанвандан, Т. Пагва, Э. Вандуй, С. Мөөмөө, Ж. Цолоо нар тусгайлан судалсан.

- Салбар аман аялгууг судлах талаар Ц. Шархүү, Д. Төмөртоогоо, Ж. Төмөрцэрэн, Ж. Цолоо, М. Шинэхүү, Ш. Барайшир нар бүтээлүүдээ хэвлүүлсэн байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. “Алчуур” гэх үгийн гарал


Үгийн бодит утгыг хадгалан цөм болсон утгат хэсгийг язгуур морфем гэнэ. Үгийн язгуур морфемд залгаж, түүний бодит утга дээр шинэ нэмэлт утга оруулах буюу эсвэл хэл зүйн хийсвэр утга нэмэх морфемыг залгавар морфем гэнэ. “Алчуур” гэх үгийн язгуур морфем нь арч- [arči] буюу идэвхтэй үйл язгуур байна. Үүнд үйлээс нэр үг бүтээх -уур [yur] дагаврыг залгаж “Арчуур” гэх нэр үг бүтэж, монгол хэлний нэг үгэнд орсон чичрэн шүргэх хоёр [r] гийгүүлэгч бүтэх аргаараа ондоошиж, нэг нь [l] гийгүүлэгч болдог учир орчин цагийн монгол хэлэнд “Алчуур” болжээ.

Үгийн язгуурыг эртний монгол хэлний үүднээс дахин шинжилбэл арч- [arči] гэх үг нь ар- [ar] язгууртай болж байна. Ар- [ar-] язгуураас [ari-] үндэс үүсгэж ариун, ариухан, ариулах, ариулал, ариусгах, ариусах, ариутгах, ариутгуур, ариутгал, ариутах, ариучлах, аригдах, арилал, арилам, арилш, арилах, арилгах, арилгал гэх мэт үгсийн үүр үүсгэсэн байна.

Мөн ар- [ar-] язгуураас арч- [arči] үндэс үүсэж үүнээс арчих, арчуул (арчуур), арчуур, арчилна, арчлам, арчдас (арчих юм), алчуур гэх мэт цэвэрлэх, цэвэр байх утга бүхий үгсийн үүр үүсжээ.¹


¹ Монгол үгсийн язгуурын толь

2. Өвөр монгол дахь “алчуур” гэх үгийн тархац




Зураг 1. Өвөр монголын газрын зураг

№	Байршлын нэр /аймаг, хот/
1	Алшаа аймаг
2	Баяннуур аймаг
4	Их зуу аймаг
5	Бугат хот
6	Хөх хот
7	Улаанцав аймаг
8	Шилийн гол аймаг
9	Зуу Уд аймаг
10	Жирим аймаг
11	Хинган аймаг
12	Хөлөн буйр аймаг




Зураг 2. Хөлөн буйр аймгийн газрын зураг

№	Галиг	Тэмдэглэгээ
1	ᠠᠯᠰᠠᠭ	1, 8
2	ᠪᠠᠶᠠᠨᠨᠠᠭ	1, 7, 10, 13, 19, 21, 23, 31
3	ᠪᠤᠭᠠᠲ	2, 4, 6
4	ᠶᠡᠬᠡᠵᠡᠭᠡ	2, 3, 20, 25, 30
5	ᠪᠤᠭᠠᠲ	7, 9, 11, 18, 21
6	ᠬᠥᠬᠡ	5, 12
7	ᠤᠯᠠᠭᠠᠨᠴᠠᠪ	13
8	ᠰᠢᠯᠢᠶᠢᠨᠭᠣᠣᠯ	14
9	ᠬᠡᠭᠡᠨᠠᠳ	19
10	ᠵᠢᠷᠢᠮ	22, 20
11	ᠬᠢᠩᠭᠠᠨ	27
12	ᠬᠥᠯᠡᠨᠪᠦᠢᠷ	27
13	ᠫᠠᠯᠲᠢᠨᠰ	28
14	ᠫᠠᠯᠲᠢᠨᠰ	29



Зураг 3. Жирим аймгийн газрын зураг


№	Галиг	Тэмдэглэгээ
1	elᠱᠦ:r	22, 23, 85, 104, 106, 108, 110
2	elᠱᠦ:r	5, 13, 97, 103
3	elᠱᠦ:r	12
4	elᠱᠦ:r	10
5	elᠱᠦr	6, 7, 20, 24, 26, 27, 29, 32, 35, 39, 44, 57, 59, 62, 63, 66, 69, 72, 74, 77, 80, 81, 83, 86, 88, 91, 93, 95, 96, 98, 102
6	elᠱᠦr	2, 4, 8, 11, 14, 15, 19, 28, 31, 40, 42, 46, 51, 53, 56, 58, 61, 65, 68, 70, 71, 73, 75, 76, 79, 82
7	elᠱᠦr	16, 17, 30, 33, 34, 45, 60, 67, 78
8	elᠱᠦr	9, 21, 43, 52
9	elᠱᠦr	41
10	elᠱᠦr	1
11	elᠱᠦr	18
12	elᠱᠦr	64
13	elᠱᠦr	25



Зураг 4. Хинган аймгийн газрын зураг

№	Галиг	Тэмдэглэгээ
1	elᠱᠦr	1, 3, 5, 7, 9, 10, 13, 15, 20, 22, 27, 32, 34, 37, 40, 42, 44, 47
2	elᠱᠦ:r	2, 45
3	alᠱᠦ:r	4
4	elᠱᠦ:r	8, 11, 12, 14
5	elᠱᠦr	21, 24, 26, 33, 41, 46
6	elᠱᠦr	23, 38
7	gar elᠱᠦr	39

2.1. Монгол Улс дахь хэл аялгууны “алчуур” гэх үгийн тархац



Зураг 5. Халх аялгуун дахь “алчуур” гэх үгийн тархцын тэмдэглэгээ

№	Галиг	Тэмдэглэгээ
1	alčīúr	
2	altšúr	
3	altšiu:r	
4	altšūr	
5	altšu:r	
6	artšūr	
7	artšül	
8	artšöl	
9	altšör	
10	altšūr	



Зураг 6. Ойрад аялгуун дахь “алчуур” гэх үгийн тархцын тэмдэглэгээ

№		Галиг	Тэмдэг-лэгээ
1	Толгойн гурвалжин алчуур	gimbĕn	



Зураг 7. Буриад аялгуун дахь “алчуур” гэх үгийн тархцын тэмдэглэгээ

№	Дуудлага	Галиг	Тэмдэг-лэгээ
1	алшуур	altšūr	

3. “Алчуур” гэх үгийн авианы хувьсал

3.1. Өвөрлөгч аялгуун дахь “Алчуур” гэх үгийн авианы хувьсал

Авианы сэлгэц

- Хэлний урдуур хэлэгддэг гийгүүлэгч үгийн эхэн, дунд өөр хоорондоо сэлгэнэ. (Цолоо, 2008:112) Энэхүү ёсоор Жирим, Үзэмчин, Хинган аймгуудад үгийн дунд үеийн [ʃ---ʃ, dʒ, s] гийгүүлэгч авианууд өөр хоорондоо сэлгэсэн байна.
- Түүш шүдний гийгүүлэгчүүд хоорондоо сэлгэх ёсоор Хөлөн буйр аймагт [l, ɾ] гийгүүлэгч авианууд сэлгэн хэрэглэгдсэн байна.
- Улаанхад хот, Богд, Цахар, Авга хошуу, Үзэмчин, Баяннуур, Сөнөд аймгуудад үгийн тэргүүн үеийн эгшиг авиа [ɛ---a, æ] авиатай сэлгэн хэрэглэгдсэн байна.
- Жирим, Улаанхад хот, Хинган аймгуудад үгийн дунд үеийн эгшиг авиа [ʊ:--- u:, ʊ, u] авианууд сэлгэн хэрэглэгджээ.

Өвөрлөгч аялгуун дахь “Алчуур” гэх үгийн хэлбэрийн ялгаа

Хөлөн буйр аймагт “Алчуур” гэх үгийг [ɔmbɔrɔ:], [xuŋk] [paltɪ:ns] зэргээр ялгаатай байдлаар өгүүлж, мөн энэхүү хэлбэрийн үгс дээр авиа хувьссан байна.

- Үгийн дунд үеийн [ɔ] эгшиг авиа гээгдэж [ɔmbɔrɔ:]---[ɔmbrɔ:] болжээ.
- Үгийн тэргүүн үеийн сул эгшиг авиа [ɔ]---[ʊ] сул эгшиг авиатай сэлгэж, үгийн дунд үеийн [m] гийгүүлэгч авиа гээгдэж, үгийн сүүл үеийн [ɔ:]—[a:] авиатай сэлгэж [ʊbra:] хэлбэрийг гаргажээ.
- Үгийн сүүл үед [s] гийгүүлэгч авиа нэмэгдэж [ɔmbɔrɔ:s] хэлбэрийг гаргасан байна.
- Мөн үгийн сүүл үеийн [ɔ:]---[æ:] авиатай сэлгэж ɔmbɔræ: хэлбэрийг гаргажээ.

3.2. Халх аялгуун дахь “Алчуур” гэх үгийн авианы хувьсал

Авианы сэлгэц

- Түүш шүдний гийгүүлэгчүүд хоорондоо сэлгэх ёсоор халх аялгуунд [l, ɾ] гийгүүлэгч авианууд сэлгэн хэрэглэгдсэн байна.
- Хэлний урдуур хэлэгддэг гийгүүлэгчүүд үгийн эхэн дунд өөр хоорондоо сэлгэнэ. (Цолоо, 2008:113). Энэхүү ёсоор [č]---[tʃ] авиа сэлгэжээ.
- Өргөлтөт үеийн сул эгшиг авиа, сул эгшиг авиатайгай сэлгэхэд үгийн хэлбэр утгад өөрчлөлт гарахгүй (Цолоо, 2008:105). Энэхүү ёсоор [ú]---[u:], [u:], [ū], [ō] эгшиг авианууд сэлгэсэн байна.
- Монгол хэлний нэг үгэнд орсон чичрэн шүргэх хоёр [ɾ] гийгүүлэгчийн

нэг нь ондоошиж [l] гийгүүлэгч болдог. Өвөрхангайн [Ökha.] аман аялгуунд үгийн сүүл үеийн [r] гийгүүлэгч авиа ондоошиж [l] гийгүүлэгч авиа болсон байна.

ДҮГНЭЛТ

1. Өвөр монголын Жирим, Хинган аймгуудад [ʃ--ʃ, dʒ, s] гийгүүлэгч авианууд, Хөлөн буйр аймагт [l, r] гийгүүлэгч авианууд мөн Улаанхад хот, Богд, Цахар, Авга хошуу, Үзэмчин, Баяннуур, Сөнөд аймгуудад үгийн тэргүүн үеийн [ɛ---а, æ] эгшиг авиа, Жирим, Улаанхад хот, Хинган аймгуудад үгийн дунд үеийн [o:--- u:, ʊ, u] эгшиг авианууд тус тус сэлгэн хэрэглэгддэг байна. Халх аялгуунд мөн [l, r] гийгүүлэгч авиа, [č]--- [tʃ] гийгүүлэгч авиа, [ú]---[u:], [u:], [ū], [ō] эгшиг авианууд хоорондоо сэлгэн хэрэглэгдсэн бөгөөд [artšöl], [artšūl] гэх мэтээр үйлээс нэр үг бүтээх -уур [yur] дагаврын [r] гийгүүлэгч авиа [l] гийгүүлэгч авиа болон бүтэх аргаар ондоошсон байна. Буриад аялгуунд [altšūr] гэх хэлбэрээр өгүүлэгддэг байна.
2. Хэлбэрийн хувьд Хөлөн буйр аймагт “Алчуур” гэх үгийг [ɔmbɔrɔ:], [xuŋk] [palti:ns] зэргээр ялгаатай хэлбэрүүдээр өгүүлж, ойрад аялгуунд мөн [gimbɛŋ] гэх ялгаатай хэлбэрээр өгүүлэгддэг байна.

ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Ерөнхий өгүүлийн боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Алишаа аймгийн боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Баяннуур хотын боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Ордос хотын боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Улаанцав, Богд хотын боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Шилийн гол аймгийн боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Шилийн гол аймгийн Цахарын боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Шилийн гол аймгийн Авга хошуу, шилийн хотын боть”. Өвөр Монгол

- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Шилийн гол аймгийн Үзэмчний боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Улаанхад хотын боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Жирим аймгийн боть” Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Хинган аймгийн боть”. Өвөр Монгол
- Зоригт нар. (2018) “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Хөлөн буйр аймаг (Хөлөн буйр хот)”. Өвөр Монгол
- Амаржаргал, Б. (1988) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Халх аялгуу*. УБ
- Амаржаргал, Б., Гантогтох, Г., Цолоо, Ж. (1988) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Ойрад аялгуу*. УБ
- Гантонтох, Г. (2010) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Буриад аялгуу*. УБ

НОМ ЗҮЙ

- Мөөмөө, С. (1979). *Монгол хэлний авиа зүй*. Улаанбаатар.
- Санжаа, Ж., Надмид, Ж. (2008). *Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй*. Улаанбаатар .
- Цолоо, Ж. (2008). *Орчин цагийн монгол хэлний авиа зүй*. Улаанбаатар.
- Төмөртоогоо, Д. (2017). *Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Уртнасан, Д., Батдорж, Ц., Батхишиг, С. (2022). *Авиа зүй. Монгол хэл судлал VIII боть*. Улаанбаатар.

THE DISTRIBUTION OF THE WORD “ALCHUURI” AND PHONETIC VARIATIONII

Keywords: *Khalkha dialect, Buryat dialect, Oirat dialect, Inner Mongolian dialect, handkerchief, phonetic alternation, morphological difference*

ABSTRACT

In this article focuses on the phonetic variation of the word “alchuur” (handkerchief) across different Mongolian dialects. The geographical (areal) method is significant as it reveals how specific phonetic features (pronunciation, form) of a word vary across regions. Accordingly, this study analyzed the regional phonetic variations of the word “alchuur” in the Mongolian language, investigated the distribution of its dialectal forms, and presented the key findings based on a comparative analyses.



МОНГОЛ ХЭЛНИЙ *-yalja* ДАГАВРЫН ТУХАЙ

Зоригтын АНУЖИН

*МУИС. ШУС. ХУС Багш, монгол хэл,
уран зохиолын боловсрол IV түвшин*

Удирдагч багш: Ж. Ганбаатар

*МУИС. Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим
Ph.D, профессор*

Товч агуулга. *Тус судалгаанд бүх талаас нь судлаагүй -yalja хэмээх нийлмэл дагаврыг сонгож утга, бүтэц, байр, хувилбарыг нь тодорхойлон судлаачдын дунд нийлмэл дагавар биш, мөн гэсэн зөрүүтэй саналыг нэгтгэхийг оролдлоо. Ингэхдээ тус дагавраар бүтсэн үгсэд бүтцийн задлал хийн -ya-lja тусдаа бие даасан байдлаар хэрэглэгдэж байгаа тохиолдол, ижил язгуурын араас -yalja, -lja аль аль нь тохиож буй байдал мөн -yalja дагаваар тохиолдож байгааг хэлний баримтаар тайлбарлалаа.*

Түлхүүр үг: *нийлмэл дагавар, -галз дагавар, байдал, утга, бүтэц, байр*

Удиртгал. “Орчин цагийн монгол хэлний Э, Г, ЭГ, ГЭ гэсэн бүтэцтэй дагаврын ихэнх нь энгийн бүтэцтэй, ГЭГ, ГЭГЭ, ГЭГГЭ бүтэцтэй дагавар голдуу нийлмэл бүтэцтэй байна (Ц. Өнөрбаян, 2004: 126). Мөн “Одоо үеийн монгол бичгийн хэлний зарим үгэнд биеэ даахгүй үндэс бүтээх үйлдэлтэй үг бүтээх дагаврыг түүний хойнох дагавартай нь нийлүүлснийг нийлмэл дагавар гэнэ. Үгийн бүтэц дэх ийм хоёр зүйлийн бүтцийг утгат хэсэг болж задарч болох эсэхээр нь Ц. Норжин “хэвшмэл бус нийлмэл дагавар” ба “хэвшмэл нийлмэл дагавар” гэж ялгасан бөгөөд “хэвшмэл бус нийлмэл дагавар”-ын бүтцийг задалж, дан дагавраар төлөөлүүлэн утга чадамжийг нь шинжилнэ гэсэн саналыг дурдсан байна” (Сэцэн, 2004: 17) гэжээ. Дээрх судлаачдын саналд тулгуурлан ГЭГГЭ бүтэц бүхий *-yalja* нийлмэл дагаврын утга, бүтэц, байрыг хам ба цуваа цагийн үүднээс тодруулах юм.

Судлагдсан байдал. Үйлээс үйл үг бүтээх *-yalja* дагаврын гарал, бүтэц, утга, байр зэрэг бүх талыг нь хамарсан судалгаа байхгүй боловч судалгааны бүтээлүүдэд судалсан зүйл нэлээд бий. Тус дагаврыг судлаачид хоёр янзаар тодорхойлж байна. Нэгт: Ц. Өнөрбаян *-лз* дагаврын талаарх судлаачдын саналыг дурдаад “*-галз, -малз, -валз* гурвыг бие даасан дагавар гэж үзэж байгаагийн учир нь гадаад байдал дүрслэх *дарва-, сарвага-, арзага-, бултга-, сормо-, мэлмэ-* зэрэг *-в (ва), -г(га), -м(ма)*-аар төгссөн язгуурт *-лз* дагавар залгаж үүссэн үгсийн язгуур, дагаврын заагийг буруу ухаарсан хэрэг” гээд *татгалз-, дайвалз-, санагалз-, ганхалз-, гуйвалз-, анивалз-, дэрвэлз-* гэх мэт үгсийг адилтгах замаар (analogy)¹-оор үүссэн” (2000: 108) гэж үзээд *-галз* гэсэн бие даасан дагавар байхгүй гэжээ. Харин П. Бямбасан үйл үгийн давтан үйлдэх байдлын дагаварт *татвалз, найгалз, торголз, түдгэлз* гэсэн цөөн үгэнд тохиолдож байгаа *-галз*⁴ дагавар бүр ч цөөн тохиолдох *тормолз, эрмэлз* гэх мэт үгийн *-малз*⁴ дагавар нь *-га, -ма, -ла, -м* гэж задарч байгаа нь *-галз, -малз* бус *-лз* гэсэн дүгнэлтэд хүргэж байна” гэжээ. Хоёрт: Л. Болд “*-валз, -галз, -лз* дагаврыг залган тухайн үйлийг ахин давтсан байдлын утгатай мөн янз бүрийн хөдөлгөөн заасан үйл үг үүсгэнэ” (1986: 126) гэж үзээд *ань-валз, эргэ-лз, найга-лз, хар-галз, сана-галз, яр-лз, сорт-лз, сээт-лз, сарвай-лз, улай-лз* гэх мэт жишээ татжээ. Уг дагаврыг Мандах, Гарьд, Юван Цоо нар дундад үеийн монгол хэлний баримтад тулгуурлан “Үйл үндсэнд чанга хөндийн эгшиг зохицлоор хэлбэржүүлээд тухайн үйл нь биелэгдэхээс өмнө урт хугацаагаар эргэлзэн хууртаж бэлтгэн базаасан төгс бус байдалт үйл үндсийг бий болгодог” (1997: 527) гэсэн бол Ц. Норжин “Эс тусах үйл үг бүтээх дагавар бөгөөд *-га + -лз* гэсэн бүтэцтэй олон дахин зогсолхийлэх маягийн эгзэгтэй үйл үүсгэхийг илтгэх утгатай” хэмээн *навтгалз, хүлгэлз, агдгалз, түдгэлз, маймгалз* (2001: 61) гэх мэт үгээр жишээлжээ. Сэцэн үйлээс үйл үг бүтээх *-yalja* дагаврыг “нэгдүгээр дэсийн буюу зөвхөн язгуур үндсэнд л залгагддаг дагавар хэмээн *татгалз, харгалз* гэх мэт үгсэд тохиолдоно” (2004: 186) гэсэн байна. Шиотани “Үйл үгийн язгуурт шууд холбогдон, давтагдах утга илтгэх үйл үгийн үндэс үүсгэнэ” гээд “*-лз* дагаврын хувилбар бөгөөд *-валз* нь биеийн хэсгийн хөдөлгөөн гэх мэт тодорхой зүйлсийг *-галз* нь сэтгэлийн хөдөлгөөн гэх мэт хийсвэр зүйлсийг илэрхийлдэг” (2006: 175) гэж үзсэн байна. Энэ бүхнээс үзвэл *-yalja* дагавар нь *-га+lja* гэсэн бүтэцтэй бөгөөд язгуурын дараа шууд тохиолдож, үйлийн давтан үйлдэх байдлын утга илэрхийлдэг аж. Тэгвэл тус дагавар нь зарим судлаачдын үзсэн шиг *-га* хэмээх хагас үүрэгт бүтээвэр болон *-лз* гэсэн бие даасан дагаврын хэвшээгүй нийлэмж байна уу? эсвэл бие даасан нийлмэл *-yalja* дагавар болон хэвшихсэн байна уу? гэдгийг хэлний баримтаар тодруулан үзье.

¹ Аналогические нь хэлний бүтээлч байдал буюу төсөөт байдлаар үг бүтээх арга юм.

1. Үйлээс үйл үг бүтээх “-*yalja*” дагаврын утга

Үйлээс давтан үйлдэх байдлын утгат үйл үг бүтээх -*yalja* дагавраар хэлбэржсэн үгсийг монгол хэлний тайлбар толь бичгүүдээс шүүн илэрхийлэх утгыг тодруулан үзвэл дан ганц үйлийг давтсан байдал илэрхийлдэггүй байна. Үүнийг хэлний баримтаар тайлбарлавал:

Хүснэгт: 1

“-галз” хэлбэр P _{в.} V _{галз} , P _{в.} V _{лз} (ижил язгуурт -галз болон -лз залгаж болж буй хэлбэр)		“-галз” хэлбэр P _{в.} V _{галз} (язгуурт зөвхөн -галз залгах хэлбэр)
агд-галз	агдалз	сана-галз
өм-гөлз / өм-гөнө	өмөлз	дамна-галз
дэрэм-гэлз	дэрмэлз	хар-галз
тор-голз	торолз	гунь-галз
доно-голз	донолз	хам-галз
дэрвэ-гэлз	дэрвэлз	зогс-голз
нэвт-гэлз	нэвтэлз	хэл-гэлз
сүүд-гэлз	сүүдэлз	түд-гэлз
навс-галз	навсалз	хүл-гэлз
балт-галз	балталз	ялам-галз
ов-голз	оволз	хом-голз
тэгд-гэлз	тэгдэлз	майм-галз
бүрэг-гэлз	бүргэлз	

Үйлээс үйл үг бүтээх хоёр янзын -*yalja* бүтээвэр байгаа бөгөөд үүнээс нэг ижил язгуурт -*yalja*, -*lja* гэсэн хэлбэрийг аль алиныг нь залгаж болж байгаа нэг хэсэг, -*yalja* хэлбэрээр идэвхтэй язгуурын араас залгагдаж байгаа хэсэг гэж хувааж болохоор байна. Харин -*ya* төгсгөлт язгуурын араас -*lja* хэлбэрээр тохиолдож байгаа нэг хэсэг байгаа ба үүнийг шууд -*yalja* гэж үзэх болохгүй юм. Энэ нь -*yalja* гэсэн биеэ даасан дагавар байгаа эсэх эсвэл -*lja* гэсэн дагаврын өмнө хагас үүрэгт -*ya/-ge* бүтээвэр байна уу? гэсэн эргэлзээнд хүргэж байгаа ба уг бүтээврийн бүтцийг тус тусын бие даасан байдлаар салган утга бүтцийг тодорхойлъё.

1.1 -*yalja* дагаврын “-*ya*” хэлбэрийн учир

Үйлээс үйл үг бүтээх -*yalja* дагаврын бүрэлдэхүүн дэх -*ya* хэлбэр нь язгуурын утгыг бууруулах маягтай хэрэглэгдэж байна. Тус -*ya* дагаврын талаар тухайн үгийн язгуур бүтээвэртэй нийлэг байдлаар байхаас гадна -*lja* бүтээвэртэй хамт -*yalja* хэлбэртэй байгаа хэдий ч -*lja* бүтээвэр бие даан үүрэг гүйцэтгэж байна.

Ингэж орохдоо тухайн үгийн утгыг төдийлөн өөрчлөхгүй ч үйлийн давтах, эрчмийг нь алгуураар бууруулсан утгатай болгодог байна. Үүнийг М. Базаррагчаа “зогсосхийх” гэсэн утгатай (2015: 17) гэсэн бөгөөд П. Бямбасан “дүр байдлыг заасан идэвхгүй язгуур дээр ордог морфем” (1970: 279) гэжээ. Харин Ц. Өнөрбаян “Язгуурын бүтцэд -г, (-га); -в зэрэг хагас үүрэгтэй дагавар орвол огцом цочмог давтагдах нэмэлт утга илэрнэ ” (2000:110) гээд дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

Нуруу нь гэдэлзэнэ. (удаавтар давтагдах)

Нуруу нь гэдгэлзэнэ. (удаавтар хурдан давтагдах)

Хамар нь сарталзана. (удаавтар давтагдах)

Хамар нь сартгалзана. (огцом удаавтар давтагдах)

Нүд нь бүлтэлзэнэ. (удаавтар давтагдах)

Нүд нь бүлтгэлзэнэ. (огцом хурдавтар давтагдах) гэж ялгааг харуулсан байна. Гэхдээ хэлний баримтаас утгын хүрээнд үзвэл тус бүтээврийн -га хэлбэр үйлийн байдлын шинжийг зөвхөн огцом хурдан болгохгүй язгуурын утгаас хамааран удаан, алгуур болгож байна. Энэ нь дараах байдлаар харагдана.

Хүснэгт: 2

Язгуур	-галз хэлбэр	Язгуур	-лз хэлбэр
Агд-	Агдгалз	Агд-	Агдалз
Утга	1. Хорхой шавжийн агиран сунал алгуураар хөдлөх 2. Агдгар юмны үргэлжлэн хөдлөх		1. Хорхой шавж зэргийн байн байн агдайн сунах 2. Агдгар юмны агдас агдас хөдлөх
Өм-	Өмгөлз	Өм-	Өмөлз
Утга	Өмөлзөх (уруул нь бага зэрэг цорвойн хөдлөх)		Хүн, амьтан, юмны ам, амсар өмийж хөдлөх
Гэлмэ-	Гэлмэгэлз	Гэлмэ-	Гэлмэлз
Утга	Бага хүүхэд унтаж байгаад айж гэнэт уйлах ба гэнэт цочин хөдлөх		Юмыг гайхаж болгоомжлон сандрангуй харах

Эндээс ижил язгуурт -*γalʃa*, -*lʃa* дагаврыг залгахад -*lʃa* нь тухайн үйлийг маш богино хугацаанд дахин давтсан байдлыг илэрхийлж байгаа бол -*γalʃa* хэлбэр дээр тухайн үйлийн эрчим нь удаашран хугацаа нь уртсаж байгаа ялгаа харагдаж байна. Мөн -*γa* үе утгалбар нь дангаар үйлийн дүр байдлыг илэрхийлдэг. Ингэхдээ үйлийн үргэлжлэх утгатай байдаг. Энэ нь:

Агдга агдга хийх - юмны үргэлжлэн хөдлөх

Овго овго хийх - овгор юмны үргэлжлэн хөдлөх

Навсга навсга (навсга нэвсгэ) - том зүйлийн эв хавгүй хөдлөх

Балтга балтга - бүдүүн, намхан, өргөн юмны үргэлжлэн хөдлөх

гэх мэтээр илэрч байна. Тиймээс *-yalja* дагаврын бүрэлдэхүүнд *-ya* нь үргэлжлэх утга илэрхийлээд *-lja* нь удаан эсвэл хурдан байдлыг нь харуулж, өөр хоорондоо утгын тодорхой ялгаа үзүүлдэг байна. *-yalja* дагаврын *-ya* хэлбэр нь биеэ даасан хагас үүрэгт дагавар юм. Мөн тухайн үйлийн давтан үйлдэж байгааг задлаг аргаар илрүүлнэ. Үүнд:

Arba-ya arba-ya

danqa-γ denke-g

tata-ya tata-ya

darba-γ derbe-g

dal-ba-ya del-be-ge

darqa-γ derke-g

Өөрөөр хэлбэл *арвага* гэхэд нэг удаа хөдлөх *арвага арвага* гэж давтах утгаа бүрэн гаргаж чадна.

1.2. Зөвхөн *-yalja* хэлбэрээр тохиолдож буй хэлбэр

Энэхүү *-yalja* хэлбэр нь үйлийн гадаад дүр байдлаас илүү сэтгэл хөдлөлийн эргэцэх маягтай утгыг бий болгох ба идэвхтэй язгуурт *-yalja* байдлаар шууд залган нэг утга санаа илэрхийлнэ. Жишээлбэл:

Хүснэгт: 3

<i>Язгуур</i>	<i>-галз хэлбэр</i>
Хар-	Харгалз
Утга	1. Гэмт хэрэгтэн болон бусдын амь нас, эд хөрөнгийг харах, хянах, сахих, манах 2. Бусдыг тэтгэх, харж үзэх 3. Анхаарах, анхаарч үзэх
Гуень-	Гунигалз
Утга	Гуниглангуй байдалтай байх, уйтгарлангуй байх
Тат-	Татгалз
Утга	1. Үл зөвшөөрөх 2. Сэжиглэн бодолхийлэх
Сана-	Санагалз
Утга	Нэхэн санах, дурсан бодох

Дээрх хүснэгтэд язгуурын утга нь тодорхой байгаа үед түүний хойноос залгасан *-yalja* дагавар нь үйлийн удаан үргэлжлэх, сэтгэл хөдлөлийн шинжийг илэрхийлэх, дүр байдлыг үзүүлэх утга илрүүлнэ. Үүнд:

Сэтгэл хөдлөлийн байдал илэрхийлэх утга	Дүр байдал илэрхийлэх утга
Гунь-(уйтгарт автах, ямар нэгэн зүйлд санаашран байн байн гомдох) →	Зогс-(хөл дээрээ босоо байх, юмны хөдөлгөөн намжих) →
Сана-(нэхэн дурсах, бодох) →	
Хар-(нүдээр үзэх) →	
Тат-(чангаах) →	
Дам-на-(хамжилцах) →	
Хүл-(-) →	
Хом-(-) →	

Эндээс үзвэл язгуурын утга сэтгэл хөдлөл, хийсвэр үйлийг илэрхийлж байвал тэр утгад үргэлжлэх байдлын шинж нэмнэ. Харин бодит үйл хөдлөлд үйлийн эрчмийг бууруулан алгуур үйлдэх утгатай болгож байгаа нь шууд ажиглагдаж байна. Мөн тус хэлбэрийг Ц. Өнөрбаян “Г. И. Рамстедт монгол хэлний *-лжа* дагавар нь түүхэн үүднээс *-л-жа* гэсэн нийлмэл бүтэцтэй бөгөөд *-га-лжа*, *-ба-лжа* гэсэн нийлмэл бүтцэд тохиолддогийг төрөл хэлний үзэгдэлтэй харьцуулсан” гэдгийг дурдаад “Язгуур дагаврын зааг нь орчин цагийн монгол хэлэнд ч гэсэн амьд тодорхой учраас *-валз*, *-галз*, *-малз* зэргийг бие даасан дагавар гэж үзэх шаардлагагүй” гэжээ. Мөн дээр өгүүлсэнчлэн *санагалз*, *дайвалз*, *татвалз*, *харгалз*, *эргэлз* зэрэг үгсэд тохиохдоо аналогior үүсжээ. Учир нь: *-лз* дагавар нь *арвага*, *сарвага*, *гэлмэ* гэх мэт гадаад байдал дүрслэх язгуурын дараа тохиодог ба хэлний баримтаас үзвэл 1.) *-лз* дагавраар бүтсэн үгийн тоо 2.) *-га*, *-ва*, *-ма* төгсгөлт үйл үгийн дараа тохиож буй *-лз* дагавар нь эдгээр үгстэй байраараа ялгаатай. Үүнийг дараах хэсэгт үзнэ.

2. *-yalja* дагаврын хувилбар, байр, харьцаа

Дүрслэх язгуураас давтах утгатай үйл үг үүсгэх *-галз*, *-малз*, *-валз* дагаврыг *-лз* дагаврын хувилбар хэмээн (Ц. Өнөрбаян, 2000:108) үздэг ч угтаа байдлын утга илэрхийлсэн хагас үүрэгтэй *га*, *ма*, *ва* төгсгөлт үгтэй нийлэн хэвшжээ. Тиймээс *-галз*, *-малз*, *-валз*, *-балз* бүтцийн бүрэлдэхүүнтэй үгс ижил утгыг бий болгодог аж. Үүнийг үгийн бүтцийн талаас ажиглаж болно.

Ani- *hani-

Ani-ba-/l/ja| oni-ba-/l/ja

Ani-ba-/l/ja-γu:l

Ani-ba-/l/ja-γu:r

Ani-l/ja- Ani-l/ja-γu:l

Ön

Ön-de-/l/je-

Ön-de-/l/je-gū:l

Ön-ge-/l/je-

Ön-de-/l/je-gū:l

Arba| arja

Arba-γa | arja-γa

Arba-/l/ja-| arja-/l/ja-

Arba-/l/ja-γu:l | arja-/l/ja-γu:l

segú:-

segú:-me-/l/je-

segú:-me-/l/je-gú:l

Ань-ба-лз, арба-га-лз, сүү-мэ-лз гэх мэтээр *-лз* дагаврын өмнөх хагас үүрэгт дагавар нь *-лз* дагавартай нийлэн нэг дагавар мэт болжээ. Үүнийг дээр дурдсантай адил нийлэг болон задлаг байдлаар утгыг ялгаж болно. Учир нь *-l/ja* дагаврын өмнө язгуурын дараа тохиолдох *-ba, -γa, -me, -de* зэрэг мөхөж буй дагаврууд тохиолдон нэг дагаврын хувилбар мэт болсон байна. Гэхдээ эдгээрийг байрын хувьд харвал

dal-bi-γa-/l/jadal-bi-/l/jaAtu-ba-/l/ja-

Atu-/l/ja

Al-ča-ba-Al-ča-/l/ja-An-γa-ba-/l/ja-An-γa-l/ja-Ge-de-be-/l/je-Ge-de-/l/jegi-l-ba-/l/ja| gi-l-be-/l/je

-γa, -ba хоёр бүтээвэр *-l/ja-* дагаврын өмнө тохиолдож байна. Энэ нь ижил язгуурт *-l/ja, -ba/l/ja, -γa/l/ja* -г аль алиныг нь залгаж болж байгаа хэлбэр болно. Үүнээс харвал *-l/ja* дагавар нь язгуур-үндэс-*/l/ja* гэсэн маягтай тохиолддог үндсэн байртай байхад цөөн үгэнд *-γa, -ba* тохиолдож байна. Эдгээр *-γa, -ba* нь үндсэн байрлалдаа бол нэг дагаврын хувилбар боловч дээрх тохиолдолд үгийн бүтцэд хоёрдугаар үндэс үүсгэхдээ ар араасаа ээлжилж ордог байна. Энэхүү үзэгдэл нь магадгүй Сажа бандид Гунгаажалцан, Чойжи-Одсэр нарын энэтхэг, төвөдийн үсгийн системд тулгуурлан тайлбарласан цагаан толгойн хэв шинжээс бий болсон зүйл байж болох юм. Учир нь Ш. Лувсанвандан “Эртний монгол хэлний зарим залгавар морфемд *-γ, -b, -y* гийгүүлэгч морфемын утга ялгахгүй сэлгэдэг үзэгдлээс илэрнэ. Жишээлбэл, үйлдэхийн тийн ялгалын дагавар *-γar(-ger), -bar(-ber), -iyar(-iyer)* үг бүтээх дагавар *-γan(-gen), -yan(-yen)* нь тус тусдаа хэл зүйн утга илрүүлж чадахгүй, ижил утгатай” (2002:107) гэж тайлбарлажээ.

-*yalja* дагаврын байр нь дараах байдалтай байна.

-*лз* дагавар нь хойшоо тэмдэг нэр бүтээх дагавартай харьцана.

-*лз* ^{өнгөлзөмтгий} -*мхай*

-*лз* ^{гялалзуур} -*уур*

-*лз* ^{гэгэлзэнгүй} -*нгуй* (Ж. Ганбаатар, 2023:190)

Мөн идэвхтэй язгуураас бүтсэн *харгалз*, *татгалз*, *санагалз*, *түдгэлз* гэх мэт үгсэд тохиох -*галз* хэлбэр нь *харгалз-аа*, *харгалз-л*, *харгалз-гч*, *татгалз-л*, *татгалз-аа*, *татгалз-уур*, *санагалз-л*, *түдгэлз-ээ*, *түдгэлз-л* гэх мэтээр V-V-N загвартай бүтэц үүсгэнэ. Харин -*лз* дагавар нь дүрслэх язгуураас үйл үг үүсгэн зөвхөн -*мхай*, -*уур*, -*нгуй* дагавруудтай цөөн тоогоор тохиолдоно. Тиймээс эдгээр үгсийг төсөөгөөр үүссэн үг гэж үзэж болохоор байна.

Харин идэвхтэй язгуурын араас тохиох -*yalja* хэлбэр нь дүрслэх язгуураас тохиох үйл үгийн байрыг зөрчин үүссэнийг үйлийн гадаад байдал дүрслэх чөлөөт биш язгуураас хоромхон давтагдан болох үйл хөдлөл заасан үйл үг бүтээх -*уана* дагавартай харьцуулбал:

Татгана *Сартгана*

Татгалз *Сартгалз*

Сүүдгэнэ *Навсгана*

Сүүдгэлз *Навсгалз* гэх мэт дээрх -*yalja* болон -*lja* хэлбэрийн аль алиныг залгаж болж байгаа тохиолдолтой таарч байгаа нь төсөөгөөр үүссэн гэдгийг харуулж байна. Мөн түүнчлэн дагавар мөхөх шалтгаанд тулгуурлан үзвэл:

- Үндсийн бүтэц тодорхойгүй болох үед;

- Дагаврын утгыг урьдчилан таних боломжгүй үед

- Загварт байдал нь өөрчлөгдөх буюу хэв маяг нь өөрчлөгддөг (L. Bauer, 2023:8) гэсэн саналыг харвал -*ya* хэлбэрийн утга зарим үгнээ ялгагдахгүй болж -*yalja* дагавар нь *татгалз*, *харгалз*, *санагалз*, *түдгэлз*, *тээнэгэлз*, *эргэлз* гэх мэт идэвхтэй язгуурт тохиолдон хэрэглээний цар хүрээ нь өргөжсөн байна.

ДҮГНЭЛТ

Орчин цагийн монгол хэлний “-*yalja*” дагаврын утга, бүтэц, байрыг хэлний баримтаар тодруулахад хагас үүрэгт -*га* бүтээвэр үйлийн давтан үйлдэх байдлын утгат -*лз* бүтээврүүд нийлж бүтжээ. Мөн тус бүтэц дэх -*га* хэлбэр нь язгуурын ард үндэс бүтээх үүрэгтэй хоршиж (R_v -га+ R_v -га) үйлийн давтан үйлдэх байдал илтгэнэ.

1. Тус дагавар нь: Идэвхгүй дүрслэх язгуураас үйл үг бүтээх -лз дагавар -га, -ма, -ва, -ба гэсэн хагас үүрэгтэй дагаврын араас тохиолдож байгаа хэлбэр юм. Ингэхдээ үйл байдал дүрслэх үг үүсгэхдээ хараахан нийлмэл дагавар болж хэвээгүй байна. Харин ижил язгуурт -*yalja*, -*lja* дагавруудын аль алиныг нь авч болж байгаа хэлбэр нь энэтхэг, төвөдийн үсгийн системд тулгуурлан тайлбарласан цагаан толгойн хэв шинжээс бий болсон зүйл байж болох юм.
2. Сана-галз, хар-галз, түд-гэлз гэх мэт цөөн үгийн бүтцэд идэвхтэй хэрэглэгдэж байгаа хэлбэр нь идэвхтэй үйл язгуураас сэтгэл хөдлөлийн байдал илэрхийлэх утгатай үг үүсгэх -галз хэмээх дагавар болон analogy-оор үүсэн хэвшжээ.

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн:

- Чоймаа, Ш., Баярсайхан, М (2005) *Монгол бичгийн хэлний тонгоруу толь*. I боть. Улаанбаатар хот. Монгол Улсын Их Сургууль.
- Болд, Л. (2008) *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. I боть. Улаанбаатар хот. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн.
- Мөнх-Амгалан, Ю. Кан Шин. (2014) *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*. Улаанбаатар хот.
- Өнөрбаян, Ц. (2004) *Орчин цагибайрын монгол хэлний үг зүй*. Улаанбаатар хот.
- Төмөртоогоо, Д. (2014) *Монгол хэлний үгийн бүтцийн толь*. Улаанбаатар хот.

Монгол хэлээр:

- Базаррагчаа, М. (2017) Монгол хэлний бүтээвэр судлал. *Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган II боть*. Улаанбаатар хот.
- Болд, Л. (1986) *Монгол хэлний дагавар*. Улаанбаатар хот. х126
- Бямбасан, П. (2006) *Монгол хэлний онол бүтцийн асуудалд*. х117-186.
- Ганбаатар, Ж. (2020) *Үйлээс үйл үг бүтээх дагаврын байрын тогтолцоо*. Монгол судлал(543) х62. Улаанбаатар хот.
- Заяабаатар, Д. (2011) *XIII-XVI зууны монгол бичгийн дурсгалын авиа зүй, үг зүйн тогтолцоо*. Улаанбаатар хот.
- Лувсандэндэв, А. (1960) *Монгол үгийн бүтэц*. Улаанбаатар хот. х11
- Лувсанвандан, Ш. (2002) *Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудлууд*. Улаанбаатар хот. х130-135
- Өнөрбаян, Ц. (2000) *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар хот.

Өнөрбаян, Ц. (2004) *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар хот. х51

Монгол бичгээр:

Ишдорж, Б. (1930) *Монгол хэлний дүрэм*. Улаанбаатар.х69.

Мандах, М. Гарди Ван Цоо (1997) *Дундад эртний монгол хэл*. Ляонингийн
Үндэсний Хэвлэлийн Хороо. Х526

Норжин, Ц. (2001) *Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй*. Хөх хот:Өвөр
Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.

Гадаад хэлээр:

Шиотани Шигэки. (2006) *Монгол хэлний халхын аялгуун дахь үг бүтээх
дагаврын судалгаа*. Осакагийн Их Сургуулийн Гадаад хэлний сургууль.
х175-176

Bauer.L (2023) The Birth and Death of Affixes and Other Morphological Processes in
English Derivation. Languages, 8 (244)

ABOUT THE -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ SUFFIX IN MONGOLIAN

Keywords: *compound suffix, -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ suffix, situation, meaning, structure, position*

ABSTRACT

In this study, we selected the compound suffix -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ, which has not been fully studied by researchers from all aspects, determined its meaning, structure, position, and relational variants, and tried to reconcile the different opinions among researchers that it is not a compound suffix, but rather a suffix. In doing so, we analyzed the structure of words formed with this suffix and explained the cases where -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ is used independently, the cases where both -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ and -ᠯᠵ᠎ᠠ occur after the same root, and the cases where -ᠭᠠᠯᠵ᠎ᠠ occurs after the same root.



МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛ ҮГИЙН УТГЫН ӨРГӨСЛИЙГ СУДЛАХ НЬ

(“Ор- язгуурт үгийн жишээн дээр)

Цэдэндамбаагийн СУВД- ЭРДЭНЭ

МХУЗ-ын IV курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл

МУБИС. НХУС. МХТ /Ph.D/

Агуулгын товч: Монгол хэлний хөл төвт “ор-” хэмээх үйл үгсийн утгыг өргөслийг тайлбардахдаа уран зохиолын дээж 108 ботийн цахим сангийн баримтаас түүвэрлэн, язгуурын болон хэл шинжлэлийн томоохон толь бичгүүдийн утгатай харьцуулж тодорхойллоо. Үгийн утга, утгын өргөслийг тодруулахдаа тэдгээрийн бүтэц, хэл зүйн хэлбэр, хам сэдэвт тулгуурлан судалбал илүү оновчтой, үр дүнтэй болох нь ажиглагдлаа. Судалгааны үр дүнгээс ажиглахад ихэвчлэн жинхэнэ нэрийг захирч салаа утгын олон хүрээ үүсгэж байсан бол үйл үгтэй холбогдож хэрэглэгдэхдээ зөвхөн нэг утга илэрхийлж туслах үйл үгийн үүргээр тохиолдож байсан юм. Ийнхүү шинэ утгын хүрээг үүсгэхдээ мөн дээр дурдсанчлан нэр үгийг захирч, харилцан адилгүй нөхцөлөөр хэлбэржиж утгын хүрээг өргөсгөн тэлж байна. Утга өргөжин тэлэхэд хүн ба юм үзэгдлийн хэрэглээ, хэрэгцээ, шинж чанар, зориулалт нөлөөлж байна хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: утга, үндсэн утга, салаа утга, шилжсэн утга, утгын хүрээ

Судалгааны ажлын зорилго: Монгол хэлний “ор-” хэмээх үйл үгийн утгын хүрээг “Уран зохиолын дээж” 108 ботийн цахим сангийн баримтад тулгуурлан тодруулж, утгын өргөслийг тайлбарлах

Зорилт:

- ✓ “Ор-” хэмээх үйл үгийн үндсэн болон салаа утгыг тодруулах
- ✓ Судалгааны ажлын баримтын хүрээг тогтоож, баримт түүвэрлэх, ангилах
- ✓ Утгын хүрээг загварчлан тайлбарлах
- ✓ Утгын өргөслийг тодорхойлон тайлбарлах

Сэдвийн үндэслэл:

Нэг талаас монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгддэг “ор-“ язгууртай үйл үгийн үндсэн болон салаа утгыг толь бичгүүдээс харьцуулж, тодруулах, нөгөө талаас олон хэлний хоорондын машин орчуулга, цахим технологи хөгжиж буй энэ үед хэлний нэгжүүдийн утга, утгын өргөслийг тайлбарласан энэ төрлийн судалгаа нь чухал ач холбогдолтой тул сонгов.

Сэдвийн судлагдсан байдал:

Сүүлийн жилүүдэд монгол хэлний үйл үгийг тусгайлан судалсан судалгааны цөөн хэдэн бүтээл байна. Тухайлбал: Б. Пүрэв-Очир монгол хэлний “Хийх” хэмээх үгийн утгын өргөсөл, М. Долгор Монгол хэлний “Харах” хэмээх үйл үгийн хэв шинж, утга, хэрэглээ талаас нь, Л. Ганчимэг “Орох” хэмээх үйл үгийн нийлэмжийн утгыг ангилсан байдал, Ш. Баттөгс “Авах” гэдэг үйл үгийг утга зүйн талаас, Э. Хулан Монгол хэлний “Тарах” хэмээх үйл үгийн хэв шинжийг нээн илрүүлэх талаас нь С. Лхагвадулам “Тарах, Орох, Авах” зэрэг үйл үгийг хэлний найруулга, бүтцийн үүднээс тус бүр шинжлэн судалсан байна.

Судалгааны ажлын арга зүй/ methodology

Ажиглах харьцуулах, анализ синтез зэрэг хэл шинжлэлийн онолын аргуудыг ашигласнаас гадна Хавсарга хэл шинжлэлийн нэгэн төрөл болох компьютер хэл шинжлэл, түүний дотроос корпус хэл шинжлэлийн аргаар судалгааны үндсэн хэсгийн түүврийг цуглуулж, танихуйн хэл шинжлэлд түлхүү хэрэглэгддэг загварчлах аргыг тус бүр ашиглав.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн: “Уран зохиолын дээжис” (108 боть)

Судалгааны шинэлэг тал, ач холбогдол

Утгын өргөслөөс хэл шинжлэлийн хувьсал хөгжил буюу үгийн утга цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг, сэтгэхүйн онцлог буюу хүмүүсийн ойлголт хэрхэн өргөжиж, үгийн хэрэглээний нөхцөл бий болдгийг тус бүр харж болно. Үүнээс гадна утгын өргөсөл нь “Танихуйн хэл шинжлэл”-д багтах ойлголт бөгөөд энэ нь сэтгэц хэл шинжлэл, нейро хэл шинжлэлийн салбаруудтай илүү холбогдоно.

Нэг талаас хэлний нэгжүүдийн утгын гүн бүтцийг тайлахад үгийн утгын өөрчлөлт, өргөсөл, утгын хүрээг орчин үеийн шинжлэх ухаануудын уулзварт шинэлэг арга зүйд тулгуурлан тогтоох, нөгөө талаас хэлний утга, утгын өөрчлөлтүүдийг нарийвчлах судалгаа чухал байгаа энэ үед монгол хэлний уран зохиолын цахим санд тулгуурлан тухайн үгийн утга, утгын өөрчлөлт өргөслийг судлахдаа хам сэдвийн шугаман харьцаанд хамт хэрэглэгдэж буй нийлмэл нэгжийн давталтаас үгийн утгын хүрээг тодорхойлж буйгаараа шинэлэг юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

“ОР-” ХЭМЭЭХ ҮЙЛ ҮГИЙН ҮНДСЭН БА САЛАА УТГА

Монгол хэлний “Ор-” хэмээх үгээс дараах утганцрууд үүсэж байна. Үүнд:

1. Байршилд нэвтрэх,
2. Юмны дотор шингэх, байрших,
3. Хэмжээнд хамаарах,
4. Жагсаалтад орох,
5. Ямар нэг үйл ажиллагаанд хамрагдах,
6. Багтах, завсар хооронд, нэвтрэх,
7. Төлөв байдалд шилжих, хувирах,
8. Хэн нэгний эрхшээл, нөлөөлд автах,
9. Сэтгэл санааны байдал өөрчлөгдөх,
10. Эдийн засаг санхүүгийн байдал, нийгэм, гэр бүл амьдралын байдал өөрчлөгдөх гэсэн утганцрууд үүсэж байна.

Дээрх утганцруудаас улбаалан “Ор-” хэмээх үг нь “Сэцэнцогтын язгуурын толь”-д дараах утгуудыг илэрхийлж байна.

1. *Амьтан буюу хэрэг будсын гаднаас дотогшоо дээрээс доошоо, нэг байраас нөгөө байрт шилжин багтах*- гэрт орох, усанд орох, хуралд орох, цас орох, тэргүүнд орох,
2. *Болох, бий болох*- хувьсгалд орох, намд орох, шавь, зориг, итгэл орох, амь орох, үнэр орох
3. *Мэдэгдэх, сэрэгдэх, төөрөгдөх*- зүүдэнд орох, санаанд орох, ой тоонд орох,
4. *Автагдах, нэрвэгдэх, шунах, захирагдах, хамаарагдах, дагах*- хонинд чоно оров, өвчин, гал, архинд, тамхинд, арганд, эргэнд, номд, амтанд орох, гарт орох
5. *Хэрэглэх, хэрэглэгдэх, зарцлагдах, шингээх*- хүч, цаг, зоос орох
6. *Сурч мэргэжиж эхлэх*- хэлд орох, нүд орох, хөлд орох

7. Хичээллэх- хичээл орох
8. Туслах үйлээр хэрэглэгдэхдээ үйлийн шилжин хөгжих байдлын утгыг илтгэнэ- ...харьяанд орох,
9. Туслах үйлээр хэрэглэгдэхдээ хэрэг бодсыг харьцуулах буюу оруулах утгыг илтгэнэ- үүнд ортол тэр дээр... тэнд очсонд ортол энд байсан нь дээр
10. Туслах үйлээр хэрэглэгдэхдээ үйлийн бүрмөсөн биелэгдэж байх санааг илтгэнэ- идэж орох, унтаж орох

Дээрх язгуурын утгаас үүдэн “ор-” хэмээх үг нь тайлбар толь бичгүүдэд дараах утгыг илэрхийлж байна.

Хүснэгт 1 Ор- хэмээх үгийн толь бичгүүд дэх утгын давхцал

Д/д	Толь бичгүүд Утгын ангилал	Сэцэнцогтын язгуурын тайлбар толь бичиг	Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 1966 он	“Монгол хэлний хорин наймтын тайлбар толь” 2013 он	“Монгол хэлний гучтын тайлбар толь” 2013 он	ШУА-ХЭХ “Монгол хэлний их тайлбар толь”
1.	Хүн амьтан юмны гадна талаас дотогшлох, ил байдлаас далд болох	+	+	+	+	+
2.	Алив нэгэн юм руу чиглэн одож дотор нь хийх		+	+	+	+
3.	Дэс дараа бүхий зүйлийн дотор байх эзлэх		+	+		+
4.	Ямар нэгэн газарт очих хүрэх		+	+	+	+
5.	Ямар нэгэн зүйлийг туулах, давж гарах	+	+		+	+
6.	Ямар нэг зохион байгуулалттай юманд багтах нийлэх		+		+	+
7.	Ямар нэг юмны харьяанд багтах, хамрагдах	+	+		+	+
8.	Зохих чадвар эзэмших		+	+	+	+
9.	Их хэрэглэгдэх, зарцуулагдах	+		+		+
10.	Агаарын тунадас, хур буух	+	+	+		+
11.	Ажил хэрэг нь цэгцрэх		+			+

12.	Нэг зүйл нөгөөдөө уусч шингэх	+	+			+
13.	Халдан дайрах довтлох	+			+	+
14.	Тухайн зүйл бий болох	+		+		+
15.	Тухайн шинж чанар бүхий зүйл нэмэгдэх					+
16.	Мэдрэлд сэрэгдэн өртөгдөх	+	+			+
17.	Ямар нэг зүйл болон хэн нэгэнд итгэж бишрэн дагах					+
18.	Юманд шунах дур сонирхолтой					+
19.	Таагүй хэрэг явдалд холбогдох					+
20.	Хүнтэй суух, гэрлэх	+				+
21.	Барилдааны үед нөгөө бөхийнхөө хий чөлөөг харж түргэн зуур довтлох, монгол бөхийн мэх					+
22.	Эрхшээлд автах				+	
23.	Жиших харьцуулах холбох				+	
24.	Оронд төлөөнд					+
25.	Үйлчилгээний газраар үйлчлүүлэх				+	

Толь бичгүүд дэх утгын давхацлыг графикаар харвал

График 1



Дээрх ангиллаас үзэхэд **“ор-” хэмээх үйл үгийн гол буюу цөм утга нь:**

Хүн амьтан юмны гадна талаас дотогшилох ил байдлаас далд болох шилжих орны утга юм.

-гэрт орох, дэлгүүр орох, айлд орох, цүнхэнд орох, байшинд орох,

“ор-” хэмээх үгийн салаа утгууд нь:

Үг бүр үгийн сангийн утгатай бөгөөд зөвхөн ганц утгатай биш өөр олон утгыг илэрхийлж болно. Үгийн салаа утга хэлий олон байсан ч үндсэн утгатайгаа холбоотой байдаг. Үгийн гол утга нь салаа утгуудаа холбосон цөм шинжтэй байдаг. Монгол хэлний хөдөлгөөн заасан “ор-” хэмээх үйл үг нь гол төлөв нэр үгийг захирч салаа утгууд үүсгэж байна.

- 1- *Дэс дараа бүхий зүйлийн дотор байх эзлэх-* тэргүүнд орох, сүүлд орох, эхэнд орох
- 2- *Ямар нэгэн газарт очих хүрэх-* сум орох, аймаг орох, хот орох
- 3- *Ямар нэгэн зүйлийг туулах, давж гарах-* онд орох, жил орох
- 4- *Халдан дайрах, довтлох-* чоно орох, хөлд орох мэх
- 5- *Ямар нэг юмны харьяанд багтах, хамрагдах-* адуунд орох, малд орох, дансанд орох, найрлагад орох
- 6- *Ямар нэг зохион байгуулалттай юманд багтах нийлэх-* шавь орох, ажилд орох, үйл ажиллагаанд орох
- 7- *Зохих чадвар эзэмших-* хэлд орох, хөлд орох, бор хоолонд орох
- 8- *Их хэрэглэгдэх, зарцуулагдах-* мөнгө орох, хоол орох, материал орох, хөрөнгө орох
- 9- *Агаарын тунадас, хур буух-* бороо орох, мөндөр орох, цас орох
- 10- *Нэг зүйл нөгөөдөө уусч шингэх-* өнгө орох, амт орох, үнэр орох
- 11- *Мэдрэлд сэрэгдэн өртөгдөх-* зүүдэнд орох, бодолд орох, сэтгэлд орох
- 12- *Хүнтэй суух гэрлэх-* хүргэн орох, бэр орох
- 13- *Тухайн шинж чанар бүхий зүйл нэмэгдэх-* үнэ орох, маяг орох, сүү орох
- 14- *Тухайн зүйл бий болох-* буурал орох, гэгээ орох, хүйт орох
- 15- *Нэвчих-* гэрэл орох, шүүс орох, ус орох

“ор-” хэмээх үгийн олдмол утгууд нь

- 1- *Элдэв дэмий юманд донтох-*архинд орох, тамхинд орох, тоглоомд орох, утсанд орох
- 2- *Чиглэсэн зүйлийг дагах-* үгэнд орох, шашинд орох
- 3- *Эрхшээлд автах, таагүй хэрэг явдалд холбогдох-* аргад орох, хэл аманд орох, мэхэнд орох, хэрэгт орох

- 4- Оронд төлөөнд, жишиж харьцуулан холбох- оргүйд орвол охинтой нь
- 5- Үйлчилгээний газраар үйлчлүүлэх- хоолонд орох, үсчинд орох

“ОР-” ХЭМЭЭХ ҮЙЛ ҮГИЙН УТГЫН ӨРГӨСӨЛ

А. Монгол хэлний “ор-” хэмээх үйл үг оролцож бүтсэн нийлэмж үгсийг бүтцээр нь ангилж үзвэл:

Дараах бүтцээр тохиолдож буй холбоо үгийн утгын өргөслийг авч үзвэл,

1. жинхэнэ нэр + ор-

1. Эртхэн үхэж далд **орох** юм сан” гээд өвгөд хөгшид нь гутарч гомдон суух ба зарим залуу эрчүүд нь хөрөнгө мал байсны ч хэрэггүй болжээ гээд мал хөрөнгөө үрэх болон зарим хий хөөрүү өвчтэй нь биеэ ямар нэгэн их гайхамшигтай хувьсгалч болсон мэтээр бодож... (Б.Б)
2. Хоёр морь шумбаж бараг усанд далд **орох** шахаж, зөвхөн толгой дэл нь харагдана. (Б.У)

Нэгдүгээр өгүүлбэрт “далд орох” хэмээх холбоо үг нь шилжсэн утгаар хэрэглэгдэж “үхэх, үгүй болох” гэсэн утгыг илэрхийлж байгаа бол;

Хоёрдугаар өгүүлбэрт “далд орох” хэмээх холбоо үг нь салаа утгаар хэрэглэгдэж “алга болох, далдлагдах” гэсэн утгыг илэрхийлж байна.

1. Шинэ оноо бид нэг гэртээ **орж** тэмдэглэхээр боллоо. (Д.Э)
2. Балжид, Төмөр хоёр нэг гэрт **ороод** нэлээн хэдэн жил өнгөрлөө. (С.Б)

Нэгдүгээр өгүүлбэрт “нэг гэрт орох” гэдэг нь шууд утгаараа буюу шилжиж, багтах гэсэн утгыг илэрхийлж байгаа бол;

Хоёрдугаар өгүүлбэрт “нэг гэрт орох” хэмээх холбоо үг нь шилжсэн утгаар хэрэглэгдэж “хамт амьдрах” гэсэн утгыг илэрхийлж байна.

1. Одоо **ухаан орох** цаг болжээ. (Ц.Д)
2. Догсомын хүү мориноос унаад саяхан л **ухаан орж** гэнэ. (Б.Ж)

Нэгдүгээр өгүүлбэрт “ухаан орох” хэмээх холбоо үг нь шилжсэн утгаар хэрэглэгдэж амьдралын ухаантай болох гэсэн утгыг илэрхийлж байна.

Хоёрдугаар өгүүлбэрт “ухаан орох” хэмээх холбоо үг нь салаа утгаар хэрэглэгдэж сэхэх, ухаантай болох гэсэн утгыг илэрхийлж байна.

1. Тэгээд Норов Шаравыгаа **яланд орох** байх гэж айгаад өнөөх төмс тариагийг нь сахиж арчилж байна гэж хэлэлцдэгсэн... (Б.Г) - *Ял эдлэх гэсэн утгаар;*
2. Энэ үгийг сонсоод Жуужаа зайсан **урам орох** шиг болж аяга цайгаа ууж тавтай суугаад ярьж эхлэв: -За үүнд чинь учир бий дээ. (Х.У)- *урам зориг бий болох, эрчимтэй болох утгаар;*

3. Дашням гүн Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн түшмэл байсан боловч намайг Шинжлэх ухааны хүрээлэнд **оюутнаар орох үед** нэгэнт халагдсан байлаа. (Н.Ц)- *Оюутан болж ирэх үе буюу цаг хугацааны утгаар;*
4. Ийнхүү тэмцэлдсээр Хасбаатар нар бүгд монгол цэрэг хийгээд хориод шалгарсан орос цэрэг сонгож авч Далай ханы **нутагт орох** болж, Байкалов үлдсэн цэргүүдийн хамт Улаан Байшинтын тус хүлээж тухайг үзэж хөдлөхөөр зөвлөж байтал мөнөөхөн Абмадтай далай ханы... (Ц.Д)- *нутагт очих, хүрэх гэсэн утгаар;*
5. Ээ хар хог гэж саяхан манай гэрт хорооны Алтангэрэл **хэрэгт орох** шахаад гүйж ирснийг би энэ хойт пинд дараад байгаа. (М.Я)-*таагүй явдалд орооцолдох дөхөх гэсэн утгаар;*
6. Дараагаар хурлын дарга **гишүүнд орох** гэсэн нөхрийг одоо таныг гишүүнд авахгүй гэнэ. (Н.Ш)- **Гишүүн болох, эслэх гэсэн утгаар;**
7. Та чинь ямар буянтай хүн явж, миний **аминд орох** нь энэ вэ? (Ш.А)- *амийг нь нь аврах, туслах гэсэн шилжсэн утгаар;*
8. Ийнхүү ойр холыг ярилцан суутал гаднаас Найдангийн эхнэр Чимэг аргал хормойлсоор орж ирээд Найдан тийш хандаж “Үд болж **хонь орох** оройтож байна. (Д. Ц)- *Цаг хугацааны утгаар;*
9. **Санаанд орох** нь бүдэг бадаг байна шүү. (Э.О)- *Сэтгэлд мэдрэгдэн өртөгдөх гэсэн утгаар;*
10. Би шатарт эхлэн нүүхийг гол болгодог боловч **хожигдолд орох** нь өөрийн эрхгүй байдаг. (Д.Н)- *Таагүй үр дүн, үр дагаврын утгаар;*
11. Соёлын ордны зохион байгуулагч, -Бүжгийн **уралдаанд орох** уу? /гэж асуухад эхний хүн/. (Д.Н)- *Зохион байгуулалттай зүйлд оролцох нэгдэх хамрагдах утгаар ;*
12. Зургаан өнгийн цаас наалдсан тэр өдөр Тоо-хуарт бас нэг **олз орох** өдөр ирэв. (Д.Н)- *гаднаас өөрт ашигтай зүйлийг олох авчрах гэсэн утгаар;*
13. Ялангуяа хатсан уруулынх нь цаанаас харлан цухуйсан хэлий нь ажихад “хоол хоол юу ч яахав, **хоолой руу орох** зөөлөн юм” гээд байх шиг. (Д.Н)- *чиглэн нэвтэрч, дотор орох утгаар;*
14. Тэр цагт өөрийн ажиллагааг тэргүүний шинэ аргаар хөдөлгөн бусадтай уралдах ба бусдын **тэргүүнд орох** юм шүү дээ гэж бодно. (Д.Н)- *Дэс дараа бүхий зүйлийн дотор байр эзлэх утгаар;*
15. Энэ удаагийн тэр хоёрын ярианы гол нь сүүлчийн хичээлийн улсын **шалгалтад орох** нэг номын зарим бүлгээр эдэнд семинар өгч байсансан. (Б.Б)- *Тодорхой хугацаанд зааж сурсан зүйлээ шалгуулах, дүгнүүлэх утгаар тус бүр хэрэглэгдсэн байна.*

Б. Монгол хэлний “ор-” хэмээх үйл үг оролцож бүтсэн нийлэмж үгсийг утгаар нь ангилан үзвэл:

Дараах жишээнүүдэд ор- хэмээх үйл үг нь шууд утгаараа хэрэглэгдэж, хүн амьтны бодит орон зайнаас хөдөлж, шилжиж ил байдлаас далд орох утгыг илэрхийлж байна. *Тухайлбал:*

Намар орой болж байна гадаа суугаад яах вэ? Жуужаа гэрт орох нь таван үг солиход ч хэрэгтэй байхлгүй яах вэ? гээд Должин дагуулаад оров. (Б.Э)

Гэртээ тогтохгүй айлд орохын оронд энэ хэдэн хурганы арьсыг нухаад сууж байхгүй яав даа. (Н.У)

Өчигдөрхөн галзуурч байсан энэ хэдэн хулгана гангийн борооноор нүхэндээ ороод хэдэн өдөр боллоо шүү. (Г.Х)

Шилжсэн утга (чөлөөт бус холбоо үг)-

Ор- хэмээх үгтэй нийлж шилжсэн утга илэрхийлж байгаа үгс нь хязгаарлагдмал орны утгыг зааж байна. *Тухайлбал:*

3. Дорлигийнх барын амнаас гараад чонын аманд оров гэгчээр өвсийг нь голоод нүүсэн чинь хор ургадаг газар буусан гэнэ шүү гээд Балдан хүр хүр инээв. Үүнд орох, гарах хэмээх эсрэг утгатай үгсийг зэрэгцүүлж ашигласан бөгөөд өгүүлбэрийн хам сэдвийн хүрээн дэх утга нь өмнөх зүйлээсээ ч дор үр дагавартай юманд орсныг илэрхийлж байна.

Мөн ор- хэмээх үг нь хүн амьтны бие, эрхтэнтэй холбогдож зан байдал, дадал чадвар, орон зайг илэрхийлэх утгуудыг зааж байна. *Тухайлбал:*

1. Чонын аманд орох
2. Гарт орох
3. Орсон буур шиг
4. Атганд орсон
5. Амандаа орсон тосыг хэлээрээ түлхэх
6. Нүдэнд орсон
7. ам руу орох
8. толгойд орох
9. шүд орох
10. нүдэнд орсон хог
11. шүдэнд орсон мах
12. цээжинд орох
13. Шумуулын хошуу ч орох
14. Дэвсгэрт нь могой орсон хүн шиг
15. Нохойн замаар орох

Дараах жишээнүүдэд ор- хэмээх үг нь эд юмстай холбогдож багтах орны болон үй зайгүй болох мөн таагүй байдалд орох утгуудыг тус бүр илэрхийлж байна.

16. Торонд орсон
17. буруу замаар орох
18. Нэг гэрт орох
19. Өвөр түрийдээ орох
20. Зүү орох зайгүй
21. Нохойн замаар орох
22. Хавханд орох
23. саванд орсон хэдгэнэ шиг

Дараах жишээнүүдэд ор- хэмээх үг нь хийсвэр ухагдахуунтай холбогдож эрч хүч, тамир тэнхээтэй болох, аливаа зүйлд шимтэн суралцах, хүчээр дагах элсэх, оюун бодолд орших утгуудыг тус бүр илэрхийлж байна.

24. Аминд орлоо
25. Ухаан орсон
26. Буяны мөрд орох
27. Мөхлийн хар замд орох
28. Гол орлоо
29. амин сүнс орох
30. сэм сэмхэн орох
31. сэтгэлд орох
32. урам орох
33. шавь орох
34. тамын оронд орох
35. үгэнд орох
36. өнгө зүс орох
37. гуна орох
38. мэдээ орох
39. хараанд орох
40. хараа орох
41. хүний эрхэнд орох
42. аминд орох,
43. морины сүүл мөр дор орох

Ор- хэмээх үгийн жишээ баримтыг толь бичгийн утгаар ангилсан байдал

Хүснэгт 5

<i>Д/д</i>	<i>Толь бичиг дэх утгууд</i>	<i>Баримт, түүвэр</i>
1.	Хүн амьтан юмны гадна талаас дотогшлох, ил байдлаас далд болох	Гэрт орох, хашаанд орох, модонд орох, булшинд орох, хоолой руу орох, нүхэнд орох, дэлгүүр орох, байшинд орох, майханд орох
2.	Алив нэгэн юм руу чиглэн одож дотор нь хийх	Саванд орох, авдарт орох, ёроолд орох, ам руу орох, ходоод руу орох,
3.	Дэс дараа бүхий зүйлийн дотор байх эзлэх	Тэргүүнд орох, баян ходоодод орох, эхэнд орох, гуравт орох, айргийн тавд орох
4.	Ямар нэгэн газарт очих хүрэх	Нутаг орох, хот орох, хүрээ орох, сум орох, нэгдэл орох,
5.	Ямар нэгэн зүйлийг туулах, давж гарах	Ондр орох, гуна орох, жил орох, тавтай орох,
6.	Ямар нэг зохион байгуулалттай юманд багтах нийлэх	Хуралд орох, жагсаалд орох, нэгдэлд орох, намд орох, цэрэгт орох, улс төрд орох, уралдаанд орох, шалгалтад орох, уншлагад орох, утгад орох,
7.	Ямар нэг юмны харьяанд багтах, хамрагдах	Хяналтад орох, НҮБ-д орох, тэргэнд орох, тоонд орох, тэтгэвэрт орох, найрлагад орох, эмчилгээнд орох
8.	Зохих чадвар эзэмших	Хэлд орох, хөлд орох, тусад орох,
9.	Их хэрэглэгдэх, зарцуулагдах	Мөнгө орох, хоол орох, төсөв орох, цаг орох, шатахуун орох, зардал орох,
10.	Агаарын тунадас, хур буух	Бороо орох, цас орох, мөндөр орох, хяруу орох
11.	Ажил хэрэг нь цэгцрэх	Замдаа орох,
12.	Нэг зүйл нөгөөдөө уусч шингэх	Өнгөнд орох, амт орох, будаг орох,
13.	Халдан дайрах довтлох	Чоно орох, хулгай орох,
14.	Тухайн зүйл бий болох	Хараа орох, мэдээ орох, гэгээ орох
15.	Тухайн шинж чанар бүхий зүйл нэмэгдэх	Сэрүү орох, хүйт орох, дулаан орох
16.	Мэдрэлд сэрэгдэн өртөгдөх	Зүүдэнд орох, сэтгэлд орох, ухаан орох,
17.	Ямар нэг зүйл болон хэн нэгэнд итгэж бишрэн дагах	Шашинд орох, шавь орох, үгэнд орох,
18.	Юманд шунах дур сонирхолтой	Архинд орох, тоглоомд орох, тамхинд орох,

19.	Таагүй хэрэг явдалд холбогдох	Хэрэгт орох, шоронд орох, хэл аманд орох, яланд орох,
20.	Хүнтэй суух, гэрлэх	Хүргэн орох, бэр орох,
21.	Барилдааны үед нөгөө бөхийнхөө хий чөлөөг харж түргэн зуур довтлох, монгол бөхийн мэх	Хөл рүү орох, хөлд орох,
22.	Эрхшээлд автах	Ятгалгад орох, дагаар орох, гарт орох,
23.	Жиших харьцуулах холбох	Энд байсанд орвол явсан минь дээр
24.	Оронд төлөөнд	Оргүйд орвол охинтой,
25.	Үйлчилгээний газраар үйлчлүүлэх	Хоолонд орох, үсчинд орох

Дээрх үр дүнгээс харахад:

“Ор-” хэмээх үйл үг нь ихэнхдээ жинхэнэ нэрийг захирч салаа утгын олон хүрээг үүсгэдэг ба үйл үгтэй хоршихдоо орох үйлийн дүр байдал, болц, явцыг илэрхийлдэг нь тус бүр ажиглагдаж байна. Тодруулбал *бүтцийн хувьд* жишээ баримтын дийлэнх нь:

“Жинхэнэ нэр + үйл үг” бүтцээс хамаарч салаа болон шилжсэн утгын хүрээг үүсгэж байна.

Хэл зүйн хэлбэрээр дамжуулан илэрхийлж буй утгуудыг дэлгэрүүлэн тайлбарлавал:

“Ор-” хэмээх үйл үгийн үндсэн утга нь өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржиж үүснэ. Жишээ нь: гэрт орох, айлд орох, нүхэнд орох гэх мэт. **Бодит оронд** шилжиж багтах утгыг зааж буйгаараа ижил хэл зүйн хэлбэртэй утгын хүрээнээс ялгаатай гэж үзэж байна.

Нэрлэхийн тийн ялгал + “ор-” гэсэн хэлбэрээр үүссэн холбоо үг нь:

- ямар нэгэн зүйлийг туулах, давж гарах
- их хэрэглэгдэх зарцуулагдах утга,
- агаарын хур тунадас буух утга,
- халдан дайрах довтлох утга,
- хүнтэй суух гэрлэх утга,
- мэдрэлд сэрэгдэн өртөх утга
- тухайн зүйл бий болох утга,
- тухайн зүйлийн шинж чанар нэмэгдэх утга,
- ямар нэгэн газарт хүрэх очих утгыг тус бүр илэрхийлж байна.

Өгөх оришихын тийн ялгал + “ор-” гэсэн хэлбэрээр үүссэн холбоо үг нь:

- дэс дараа бүхий зүйлийн дотор байр эзлэх,
- ямар нэг зүйлийг давж туулж гарах,
- ямар нэг юмны харьяанд багтах,
- хамрагдах утга зохих чадвар эзэмших утга,
- нэг зүйл нөгөөдөө уусч шингэх утга,
- мэдрэлд сэрэгдэн өртөгдөх утга,
- Ямар нэг зүйл болон хэн нэгэнд итгэж бишрэн дагах утга,
- юманд дур сонирхолтой болох,
- таагүй хэрэг явдалд ходбогдох утга,
- эрхшээлд автах,
- жиших харьцуулах,
- үйлчилгээний газраар үйлчлүүлэх, утгыг тус бүр илэрхийлж байна.

Чиглэхийн тийн ялгал + “ор-”

- Алив нэгэн юм руу чиглэн одож дотор нь багтах утгыг илэрхийлж байна.

“Ямар нэг зүйлийг давж туулж гарах,

Мэдрэлд сэрэгдэн өртөх” утгууд нь дээрх хэл зүйн хэлбэрийн аль алинд багтаж “ор-” хэмээх үйл үг нэг утгыг, хэл зүйн хоёр хэлбэрээр илэрхийлж байгаа нь тухайн үгийн идэвхтэй хэрэглээг харуулж байна.

Үйл үг + зэрэгцүүлэн холбох “-ж” нөхцөл + ор-

Үйл үг + хам холбох “-н” нөхцөл + ор- гэсэн хэл зүйн хэлбэрээр хэлбэржиж үйл үгээ захирч үйлийн болц, байдлыг тодотгон, туслах үйл үгийн үүргээр баймж утга илэрхийлэн хэрэглэгдэж байна.

Баримт түүврийг толь бичгийн утгын хүрээнд тодруулахдаа бүтэц, хэл зүйн хэлбэр, утгаар нь ангиллаа. Эдгээрээс гадна толь бичигт дурдагдаагүй утгын хүрээ баримтын явцад тохиолдсоныг доор тайлбарлая. Энэ нь нөгөө талаас утга өргөсөн тэлж байгааг харуулж байна.

1. Дундаа орох, талдаа орох

- ❖ Хоёр сар дундаа орлоо. (Я.Г)
- ❖ Хэний ч хажууд дундаа орохоо мэдээрэй чи гэж Галсан ууртайхан хэлээд явхав. (Н.О)
- ❖ Дөнгөж замынхаа талд ороход авч явсан тараг маань сагачихлаа. (Б.Н)

Дундаа орох, талдаа орох гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: тэмдэг нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: нэрлэхийн тийн ялгал + ор-

“Тухайн зүйлийн хэмжээг заах” салаа утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

2. Зориг орох, хүч орох, эрч орох

- ❖ Хэд хоног архидсаны шарыг уй гашуу тайлах хундагаар давхар тайлан зориг орсон Төмөрхүү “Хууль цаазгүй ч болоосой доо” хэмээн амандаа гунганан аялсаар байшингийн буланг тойрон одлоо. (П.С)
- ❖ Дэжид ч ажил хийж сурсан хүн дээ. Ярих зуураа л хэд эргүүлээд эрч оруулчихдаг юм. (Л.Ө)
- ❖ Мядагийн нэрлэгийн юмыг ууж зоригоо чангалчаад Нарийны голын ямх Бямбын авдрын ганцыг гаргуулна аа... (Ө.Э)
- ❖ ...чамайг тэгж хэлэхэд өөрийн эрхгүй зориг ороод явчихсан... (Н.З)

“Зориг орох, хүч орох, эрч орох” гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: жинхэнэ нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: нэрлэхийн тийн ялгал + ор

“Эрчимжүүлэх” салаа утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

3. Усанд орох

- ❖ Усанд орох тэргүүтний үед хийн чадлаар нууцын орныг далдлан, бие нүцгэн, очир завилал хийгээд хоёр мутар тэгш бөгөөд уул зохиож хийгээ барьж суувал биеийн нь мандал маш үзэсгэлэн болж, сэтгэлийг булаах шагшаабалын үнэр өсөд холд анхилна. (Д.Д)
- ❖ Нимгэн дээлтэй хонины цаагуур тойроход усанд орсон юм шиг боллоо. Гантай жилийн бороо хүчтэй орж байна шүү... (Н.Д)
- ❖ Чамайг усанд орохоор л нэг мөсөн угаая... (Ж.Б)

“Усанд орох” гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: жинхэнэ нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: өгөх оршихын тийн ялгал + ор-

“цэвэрлэх, угаах” гэсэн салаа утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

4. Нар орох буурал орох-

- ❖ Яасан эрт буурал орох нь вэ. С. Бадраа Улаанбаатар минь сайн байна уу (С. Б)
- ❖ Гангийн халуун наранд эмээл авч хэрэггүй. Нар орохоор ав. (Г.Б)

“Нар орох, буурал орох” гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: жинхэнэ нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: нэрлэхийн тийн ялгал + ор

“цаг хугацааны” олдмол утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

5. Сэхээнд орох, хэвтэрт орох

- ❖ Балбарын хүү бие нь базаахгүй сэхээнд орсон гэнэ... (Ж.Л)
- ❖ Үе тэнгийн найз өвгөдөө дуудуулахад за, даа хэвтэрт орсон хүн дуудуулахыг бодоход тоогүй л юм дуулах нь дээ гэж бодсоор... (Х.У)

“Сэхээнд орох, хэвтэрт орох” гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: жинхэнэ нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: өгөх оршихын тийн ялгал + ор-

“доройтох буурах” гэсэн олдмол утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

6. Рашаанд орох

- ❖ Ээжийг рашаанд ороод ирэхэд нь гам сайн бариулах хэрэгтэй гэсэн шүү... (Д.Ж)
- ❖ Рашаанд орохоор жижиг жижиг хайрхнууд ирээд бүр тойроод яваад байдаг гэж Гомбо гуай ярих юм билээ... (Б.Н)

“Рашаанд орох” гэсэн холбоо үгс нь:

Бүтцийн хувьд: жинхэнэ нэр + ор-

Хэл зүйн хэлбэрийн хувьд: өгөх оршихын тийн ялгал + ор

“эдгэрэх, эмчлүүлэх” гэсэн олдмол утгын хүрээг үүсгэж байна гэж үзэж болно.

ДҮГНЭЛТ

1. Ор-, хэмээх язгууртай үгсийн утгын хүрээг тодруулж утгын өргөслийг тайлбарлах ажлын хүрээнд нэгдүгээр бүлэгт үг тус бүрийн үндсэн болон салаа утгыг

- ✓ Сэцэнцогт “Язгуурын толь бичиг”
- ✓ Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 1966 он
- ✓ “Монгол хэлний гучтын тайлбар толь” 2013 он
- ✓ “Монгол хэлний хорин наймтын тайлбар толь” 1743 он
- ✓ ШУА-ХЗХ “Монгол хэлний их тайлбар толь” 2022 оны толь бичиг дэх утгад тулгуурлан давхацлыг хүснэгтээр жагсаан тодруулж, графикаар загварчлав. Толь бичгүүдийн ижил утгуудыг нэгтгэж боловсруулав. Үүний үр дүнд:

“Ор-” язгуурт үйл үг нь толь бичигт үндсэн утгаас гадна салаа утгын 15, олдмол утгын 5 нийт 21 утгын хүрээгээр тэмдэглэгдсэн байна. Үүнээс үзэхэд “ор” язгуурт үйл үгс нь аливаад юманд багтах, харьяалагдах, шилжих орны хязгаарлагдмал утгыг илэрхийлж байна.

2. Судалгааны ажлын баримтыг Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн “Уран зохиолын дээж” (108) ботийн цахим сангийн баримтаас сэдвийн хүрээн дэх үг тус бүрээр түүвэрлэв. Түүвэрлэсэн жишээ баримтаар дамжуулан тухайн үгсийн утгыг нь тодруулахын тулд бүтэц, хэл зүйн хэлбэр, ерөнхий утга болон толь бичигт тусгагдсан салаа утгын хүрээгээр задлан ангилж боловсруулсны үр дүнд “ор-” хэмээх үгэнд: *хэмжээ заах, эрчимжүүлэх, цэвэрлэх, цаг хугацааны утгалбар буюу салаа утга үүсгэж байна.*
3. Монгол хэлний идэвхтэй хэрэглэгддэг “ор-” хэмээх үгс нь бүтэц, хэл зүйн хэлбэр, ерөнхий утгаараа ойролцоо бөгөөд толь бичиг дэх утгын хүрээгээрээ бага зэргийн ялгаатай байна. Эдгээр үгс нь бүтцээсээ хамаарч харилцан адилгүй утгуудыг илэрхийлж байна. Үүнийг тодруулбал:

- Холбоо үг тус бүр хэл зүйн нэг хэлбэрээр өөр өөр утгыг үүсгэж байна. Жишээ нь:

дуу орох- бий болох утга,

нар орох- цаг хугацааны утга гэх мэт

- Холбоо үг тус бүр хэл зүйн хэд хэдэн хэлбэрээр нэг утга илэрхийлж байна. Жишээ нь: *Дамжуулах утга-*

Онц орох- өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр холбогдсон

Жил орох- Нэрлэхийн тр ийн ялгалын тэг нөхцөлөөр холбогдсон.

Тавтай орох- нэрлэхийн тийн ялгалын нөхцөлөөр холбогдсон

- Холбоо үг тус бүр өөр өөр утгыг хэл зүйн хэд хэдэн хэлбэрээр дамжуулан үүсгэж болно. Энэ нь судалгааны явцад ихэвчлэн тохиолдож байсан хэрэглүүр юм. Жишээ нь: *Ямар нэгэн газарт хүрэх очих утга*

Сум орох, хот орох аймаг руу орох- чиглэхийн тийн ялгалын нөхцөлөөр холбогдсон.

Дэс дараа бүхий зүйлийн дотор байр эзлэх утга

тэргүүнд орох- өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр холбогдсон

- Холбоо үг дангаараа өөр өөр утгуудыг үүсгэж байна. Энэхүү утгын ялгааг хам сэдвийн хүрээнд л тодруулах боломжтой. Жишээ нь:

Дуу орох- бичлэгт орох дүрсээ авчихсан одоо **дуу орохыг** нь хүлээж сууна.

Дуу орох- Хэдэн өдрийн турш чимээгүй юу болсон нь мэдэгдэхгүй уурлаад байсан Сүнжидмаа өнөөдөр л нэг **дуу орж** байна.

Эдгээрээс дүгнэхэд үгийн утга, утгын өргөслийг тодруулахдаа тэдгээрийн бүтэц, хэл зүйн хэлбэр, хам сэдэвт тулгуурлан судалбал илүү оновчтой, үр дүнтэй болох нь ажиглагдлаа. Судалгааны үр дүнгээс ажиглахад ихэвчлэн жинхэнэ нэрийг захирч салаа утгын олон хүрээ үүсгэж байсан бол үйл үгтэй холбогдож хэрэглэгдэхдээ зөвхөн нэг утга илэрхийлж туслах үйл үгийн үүргээр тохиолдож байсан юм. Ийнхүү шинэ утгын хүрээг үүсгэхдээ мөн дээр дурдсанчлан нэр үгийг захирч, харилцан адилгүй нөхцөлөөр хэлбэржиж утгын хүрээг өргөсгөн тэлж байна. Утга өргөжин тэлэхэд хүн ба юм үзэгдлийн хэрэглээ, хэрэгцээ, шинж чанар, зориулалт нөлөөлж байна хэмээн үзэж байна.

НОМ ЗҮЙ

Бадамдорж, Б. *Монгол хэлний утга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2001.

Бадамдорж, Б. *Монгол хэлний үгийн сангийн утга зүй*. Улаанбаатар: ШУА-ийн ХЗХ-ийн хэвлэл, 2006.

Чоймаа, Ш. *Монгол хэлний хорин наймтын тайлбар толь*. Улаанбаатар: ШУА-ийн ХЗХ-ийн хэвлэл, 1991.

Монсудар. *Монгол хэлний тайлбар толь бичиг*. Улаанбаатар: Монсудар, 2011.

МУИС, Монгол судлалын хүрээлэн. *Монгол хэл судлал боть-2,10,11*. Улаанбаатар: ШУА-ХЗХ-ийн хэвлэл, 2022

Ням-Очир, Ц. *Үг судлал ба утга зүй*. Улаанбаатар: Сод процесс, 2016.

Одонтөр, Ш., Баттөгс, М. *Монгол хэлний гучтын тайлбар толь*. Улаанбаатар: Цагаан бамбарууш, 2021.

- Өнөрбаян, Ц. *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар: ШУА-ХЗХ-ийн хэвлэл, 2000.
- Сарангэрэл, Р., Пүрэвсүрэн, Т. С. *Эрдэнийн зохиолын хэлний толь бичиг боть-1*. Улаанбаатар: Арвай бархан, 2021.
- Содномпил, Ж. *Монгол хэлний үгийн бүтэц, хэл зүй*. Улаанбаатар: Эрдэм, 1998.
- Сэцэнцогт, Ш. *Монгол үгсийн язгуурын толь*. Хөх хот: Ардын хэвлэлийн хороо, 1988.
- Цэвэл, Я. *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: УБ, Хэвлэлийн комбинат, 1966.
- ШУА-ХЗХ. *Монгол хэлний их тайлбар толь*. Улаанбаатар: Цахим сан, 2021.
- ШУА-ХЗХ. *Уран зохиолын дээж 108 боть*. Улаанбаатар. Цахим сан, 2021.
- Geeraerts, D. (2020). *theoretical of lexical semantics*. Oxford: Oxford University Press.
- Lakoff, George. (1980). *Metaphors we live by*. Chicago: University of Chicago Press.
- Oomen, M. (2018). *Verb types and semantic maps*. Amsterdam: University Amsterdam Press.

A STUDY ON THE SEMANTIC EXTENSION OF MONGOLIAN MOTION VERBS; A CASE OF ENTER

Key words: meaning, derived meaning, figurative meaning, semantic frame

Abstract: This study aims to examine the semantic structure and derivational extensions of the Mongolian verb “enter” by analyzing its usage in 108 selected literary works from a digital corpus. Through comparison with lexicographic definitions, the core meanings and semantic variations of the verb were identified. The research reveals that the verb “enter-” forms a rich network of meanings and derivatives, shaped by its morphological structure, syntactic behavior, and contextual usage. The study highlights how the verb expands its meaning through semantic shifts, metaphorical expressions, and grammatical transformations. Particular attention is given to the root meaning, semantic field, derivational forms, and the relationship between primary and extended meanings. By examining the verb’s word family and semantic scope, the research clarifies the underlying mechanisms of semantic development within modern Mongolian. This contributes to a deeper understanding of verb semantics in literary language and enhances the methodology for analyzing semantic extension in Mongolian verbs.



**ПҮРЭВ ГҮНГИЙН ОРЧУУЛСАН “ХААНЫ БИЧСЭН
НЭМЖ ТОГТООСОН МАНЖ ҮГНИЙ ТОЛЬ БИЧИГ”-ИЙН
“ХӨГЖМИЙН ЗҮЙЛ”-ИЙГ “ХОРИН НЭГТ”-ИЙН ТАЙЛБАР
ТОЛЬТОЙ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Чимиддоржийн ӨНӨРЗАЯА

*МУИС. ШУС. Монгол хэл, уран зохиолын боловсрол
хөтөлбөр 2 дугаар түвшин*

Удирдагч багш: М. Жавхлан (PhD, дэд профессор)

Товч агуулга: Манж, монгол хэлний дундын үгийг сурвалж бичиг, түүхэн харилцаа, ном зохиол, албан бичиг, толь бичиг зэрэг баримтаар тодруулах боломжтой. Манж, монгол хэлийг түүхэн харьцууллын аргаар судалсан судалгааны ажил байгаа ч орчуулгын толь бичиг зэргээс судалсан нь цөөн байсан. Иймд манж, монгол хэлний толь бичгийн харилцан нөлөөллийг судалж, тодруулах зорилгоор “Пүрэв гүнгийн орчуулсан Хааны нэмж тогтоосон манж үгний толь бичиг”-ийн “Хөгжийн товчоо”-г “Хорин нэгт тайлбар толь”-той харьцууллаа. Эх хэрэглэгдэхүүнээ боловсруулахдаа харьцуулах, задлан тайлбарлах аргыг ашиглаж, кирилл үсэг болон эрдэм шинжилгээний латин галигт буулгав. Ингэж харьцуулахдаа ялгаатай байдлаар ангилж, манж, монгол толь бичиг хэрхэн харилцан нөлөөлснийг тайлбарлаж, нэгтгэн дүгнэсэн болно. Тус судалгааны үр дүнд манж толь бичиг нь өнөөгийн зарим монгол толь бичигт нөлөөлснийг хэлний баримтаар нотлон харуулав.

Түлхүүр үг: Манж, монгол толь бичиг, толь зүйн уламжлах шинж, харилцан нөлөөлөл, үгийн сан

УДИРТГАЛ

Аливаа хэлний нийт үгийг үгийн сан гэдэг бөгөөд бүрэлдэхүүний онцлогийг судалдаг хэл шинжлэлийн салбар ухааныг үгийн сан судлал (lexicology) хэмээн үздэг. “Монгол хэл бол алтай язгуурын хэл юм. Алтай хэлний мөчирлөх онолын үүднээс өвөг монгол, түрэг, манж хэлний нийт дундын үг хэллэг, хэлц үг зэрэг нэгжүүд нийтлэг бөгөөд эдгээр нь тухайн хэлнүүддээ уугуул үгийн бүрэлдэхүүн болно. Эдгээр хэлний нийтлэг үгийг Алтай хэлний дундын үг, нийтлэг үг ч гэж нэрлэх нь бий” (Шагдарсүрэн нар 2022:30) гэж үзсэн байна. Тэгвэл, дундын үгс нь түүхэн нөхцөл байдалтай холбоотой бөгөөд соёлын харилцан нөлөөлөл, бичиг үсэг, толь бичиг зэрэг шалтгаанаар хэл, соёлын хувьд харилцан нөлөөтэй болсоор ирсэн байна. Хэл шинжлэлийн үгийн сангийн судлалд багтах салбар ухагдахууныг *толь бичгийн судлал (lexicography)* хэмээн нэрлэдэг. Судалгаагаар манж, монгол хэлний дундын үгс нэлээдгүй байх бөгөөд толь бичгийн уламжлалаар ч харилцан нөлөөлсөн зүйл цөөнгүй ажиглагдана.

Жүрчин угсаатан шинэ улсын байгуулахдаа улсын нэрээ Манж Чин гүрэн болгож, өөрсдийн хэрэглэж байсан бичгээ монголчуудын бичиг үсгээр сольж хэрэглэсэн юм.

Манж Чин гүрний үед олон ном бүтээл, орчуулга, толь бичиг зохиох ажлуудыг өрнүүлж байсны нэгээхэн хэсэг нь толь бичиг юм. Тухайн толь бичгүүд нь дорно дахины уламжлалаар зүйл хуваан зохиосон байна. Жишээлбэл, 1708 онд “Хааны бичсэн манж үгний толь бичиг”, 1717 онд “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг”, 1708 оны “Хааны бичсэн манж үгний толь бичиг” дээр суурилж 1717 онд зохиогдсон “Хорин нэгт” тайлбар толь, 1771 онд “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг” зэрэг толь бичгүүд багтах бөгөөд тус зүйл хуваасан толь бичгүүдээс өнөөгийн толь бичгийн уламжлал эхтэй билээ.

Пүрэв гүнгийн орчуулсан 1771 оны “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг”-ийн (цаашид Пүрэв гүнгийн толь бичиг гэх) манж тайлбарыг хадаж орчуулсан толь бичгийн эх нь Монгол Улсын Үндэсний номын сан (цаашид МУУНС гэх)-д 14012-14051/96 тоот дансны дугаартай хадгалагдаж байна.

Тус сурвалж нь үгийн сангийн судлал, толь зүйн судалгааг нөхвөрлөх баримт бөгөөд одоогоор тоймтой судалгаа хараахан байхгүй байна. Иймээс зүйл хуваасан толь бичгээс долоодугаар дэвтрийн “Хөгжмийн товчоо” хэмээх зүйлийн 623 толгой үгийг сонгон авч “Хорин нэгт” тайлбар тольтой харьцуулан ангилж, цуваа цагийн үүднээс харилцан нөлөөллийг тодруулан нэгтгэв. Эх

хэрэглэгдэхүүнд ашиглаж буй толь бичгүүдийн үгийн санг харьцуулан, кирилл үсэг болон эрдэм шинжилгээний латин галигт буулгав. Үгийн санг ангилж, тухайн тайлбар хийлээ. Харьцуулан задлан тайлбарлах аргыг баримталж, *тусгай үгийн сан судлалын онол*-ын дагуу түүхэн он цагийн үүднээс хэрхэн харилцан нөлөөлсөн, хувиран өөрчлөгдсөнийг ажигласан *түүхэн харьцууллын арга* (comparative-historical method)-ыг ашигласан болно.

Судлагдсан байдлын хувьд монгол, манж хэлний харилцан нөлөөллийн асуудлаар хийсэн хэл шинжлэлийн бүтээлүүд нэлээдгүй байна. Жишээлбэл, монгол хэлэнд орсон манж үгсийн талаар Л. Мишиг (1972), Г. Дөрфер (1985), В. И. Рассадин (1989; 2007), П. Аюушжав (1996), М. Баярсайхан (2007), Б. Түвшинтөгс (2003) нар тусгайлан судалжээ. Тухайлбал, М. Баярсайхан “Жүрчин ба манжийн зарим цол хэргэмийн учир”, “Манж, монгол уламжлалт албан бичгийн харилцан холбогдол”, “Монгол хэлэнд орсон манж үгсийн тухай” зэрэг өгүүлэл бичсэн бөгөөд тэр “Зарим үгийн язгуур нь гарлын хувьд үзвэл, монгол ба манж хэлний дундын мөн боловч, тухайн үгийн хэлбэр, утгаараа яах аргагүй чингийн үеийн нийгмийн онцлогийг тусган орж ирсэн үгс байна. Тийм үгийг бид ормол үгээр авч үзэх нь зүйтэй гэж үзэв” хэмээн нийт 97 үгийг бүртгэжээ. Л. Мишиг “Монгол бичгийн хэлэнд орсон зарим манж үгсийн тухай” өгүүлэлдээ судлаачдын цухас цухас дурдсан сэлэнгэ, сэлэс, бейс, хуаран гэх мэт үгээс гадна М. Жавхлан “галд, занги, хурандаа, буухиа, амбан” зэрэг 20 гаруй манж хэлнээс монгол хэлэнд орсон үгсийг тайлбарлан бичжээ” (Жавхлан 2021:30-32).

Манжийн үед хамаарах толь зүйн талаар В. И. Цинциус “Түнгүс хэлний харьцуулсан толь” (1975), О. Сүхбаатар “Харь үгийн толь” (1997), Н. Балжинням “Монгол хэлний гадаад үгийн толь” (2005) зэрэг толь бичигт монгол хэлний ормол үгсийг тэмдэглэсэн зүйл бий (Энхсувд 2023:17). Э. Мөнхцэцэг “18 дугаар зууны үеийн манж толь бичгийн үгийн сангийн судалгаа” гэх бүтээлүүдийг дурдаж болно.

2024 онд МУҮНС-д нэг хувь хадгалагдаж буй “Пүрэв гүнгийн толь бичиг”-ийг С. Мөнхсайхан, Л. Бүрэнбилиг, Б. Дүүрэн нар гэрэл зургаар хэвлүүлсэн байна. Нарийн судалсан эрдэм шинжилгээний ажил төдий л байхгүй байсаар байна.

Ингээд тус ажлаараа монгол-манж хадмал толийн орчуулгыг үгийн сангийн хувьд харьцуулж, манж толь бичиг нь монгол толийн харилцаа холбоог тодруулан үгийн оновчтой сонголт, өнөөгийн монгол хэлний толь бичигт уламжлагдсан зэргийг тодруулах зорьсон билээ.

Нэг. Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Пүрэв гүнгийн тухайд “Пүрэв гүнгийн толь бичиг”-ийн гэрэл зургаар хэвлэгдсэн бүтээлд “Пүрэв гүнгийн тухай тэмдэглэн үлдээсэн архивын баримт хомс учир янз бүрийн ташаа мэдээ (Тухайлбал, Гучин зургаатын тайлбар толь зохиож Богд хаанд өргөн барьж гүн цол авсан гэх мэт) байдаг. Түүний амьдралын замналын талаар нэлээн эрэл хайгуул хийж, судалсан хүн бол Баянхонгор аймгийн уугуул, соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Г. Аюурзана бөгөөд түүний ярьсан зүйлийг товчлон дурдвал “Пүрэв гүнгийн гүн хэргэм үе тасралтгүй уламжилсан манж хэргэм аж. Пүрэв гүнгийн тухай хамгийн тод ярьсан хүн нь бөмбөгөр ногоон театрын дуучин Дорждагва гуай юм. Дорждагва гуай шавь нартаа *“Эртний сайхан” дууны тухай ярьсан хэсэг бусаг тэмдэглэлд театрт ажиллаж байсан хоёр гүнгийн тухай ярьжээ. Нэг нь Түдэв гүн, нөгөө нь Пүрэв гүн гэдэг. Үүнд, Пүрэв гүн Судар бичгийн хүрээлэнгээс ирсэн гэж ярьсан байдаг. Пүрэв гүнгийн үр хүүхэд нь одоо бий, ганц хүү нь эцгийнхээ тухай тас нуусан, 1990-ээд онд л ноёны удам гэдгээ мэдсэн гэдэг.*” гэх аман баримт байгаа бөгөөд судар бичгийн хүрээлэнгийн архиваас Пүрэв гүнгийн тухай ямар нэг баримт олдоогүй байна. Ямар ч байсан Пүрэв гүн бол гурван үеэрээ гүн хэргэмтэй бичгийн эрдэм болон хөгжмийн эрдэмд төгс хүн байсан ажээ” (Мөнхсайхан нар 2024:4) хэмээсэн байдаг.

Толь бичгийн тухайд “Хааны бичсэн” толиудыг анх Чин улсын Энх-Амгалан хааны 47-р он (1708)-д “Хааны бичсэн манж үгний толь” нэртэйгээр хэвлэсэн нь 25 дэвтэр, 280 зүйл бүхий манж хэлний тайлбар толь байв. Хожим 1717 онд манж монгол хэлний толь болгон нэмж засан найруулсан байдаг.

Дараа нь Чин улсын Тэнгэрийн тэтгэсний 36-р он (1772)-д “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг буюу хятад манж хэлний толь зохиосон нь 32 дэвтэр, уулын 280 зүйлийг 292 болгосон байна. “Манж, хятад хэлээр. 40 дэвтэр. мөр хооронд улаан шунхаар монгол орчуулгыг Пүрэвжав гэх хүн хийжээ” (Түвшинтөгс, 2023:154). Пүрэв гүн нь хошуу ноёны агь учир хэд хэдэн хэл мэддэг, монгол бичигт сайн суралцсан тул түүнд *“Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг”* хэмээх хятад манж хэлний толь орчуулах ажлыг даалгасан, жил гаруй хугацаанд хийж 1920 онд орчуулж дууссан бололтой. Мөн энэхүү гар бичмэлийг Богд хааны ордноос МУҮНС-д шилжүүлэн өгсөн гэдэг (Мөнхсайхан нар 2024:5).

“Хорин нэгт” тайлбар толийн тухайд анх 1708 оноос 1717 он хүртэл монгол хэл шинжээч нар манж, монголыг харшуулан 280 зүйл, 21 дэвтэр болгон модон бараар барлуулжээ. 1743 онд хоёр дахь удаагаа барлуулсан “Хорин нэгт

тайлбар толь” бол орчин цагийн монгол хэлний ууган тайлбар толь болно. Тус барлалд цахар найман хошууны аман аялгуугаар тухайн тухайн үеийн монгол хэлний суурь аялгуу болгон, үндсэн долоон эгшгийг ялгаж бусад олон монгол хошууны нутгийн аялгууны үгсийг оруулан зохиожээ” (Гэгээнтанаа, 2013:2).

Уг толь нь дээр дурдсанчлан 1708 онд хэвлэгдсэн “Хааны бичсэн манж үгний толь” дээр суурилж зохиогдсон толь бөгөөд анхны хэвлэл нь монголд бүрэн олдоогүй тул бид хоёр дахь хэвлэлийг судалгааны эх хэрэглэгдэхүүндээ ашигласан болно.

Хоёр. Харьцуулан ангилсан үг

“Цаг үеийн тусгал болж байнга баяжиж, шинэчлэгдэж, хувирч өөрчлөгдөж байдаг үгийн санг бүртгэх журамлах асуудалд анхаарч, нөгөө талаас монгол хэлээр хэлэлцэгчдийн хэлний хэрэглээнд жишиг болох шинэ толь бичиг зохиох зүй ёсны шаардлага бий болох нь дамжиггүй. Хэдийгээр толь бичиг зохиох нь үгийн сангийн хөгжлөөс ямагт хоцорч байдаг ч шинэ зууны босгон дээр өнгөрсөн зууны эцэст монголчуудын хэлэлцэж ирсэн үгийн сан толь бичигт эрхбиш тусгах учиртай” (Нансалмаа, 2015:177). Үүний нэгэн адил тухайн үед Манж Чин улс хүчирхэгжиж, өөрийн эрхшээлд оруулсан үндэстнийхээ хэлийг нэмсээр хоёр, гурван, дөрвөн, таван хэлний гэх зэрэг толь бичгийг нэмэн боловсруулсаар ирсэн байна. Үүний нэгэн жишээ нь “Пүрэв гүнгийн толь бичиг” юм. Тус толь дахь “Хөгжмийн товчоо”-ны сонгон авсан 623 үгийг “Хорин нэгт” тайлбар тольтой харьцуулан ялгаатай байдлаар нь ангилахад дараах байдалтай байна. Үүнд:


Хүснэгт 1. Хоёр толь бичгийн ялгаатай байдлыг ангилсан нь

№	Ялгаатай байдлыг ангилсан нь	Үгийн тоо
1	“Хорин нэгт” тайлбар тольд тайлбарлаагүй үгийн тоо	381
2	Хоёр толь бичгийн утгын зөрүүтэй байдлын үгийн тоо	103
3	Хоёр толь бичигт утга ижил үгийн тоо	96
4	“Хорин нэгт” тайлбар тольд олон салаа утгаар тайлбарласан үгийн тоо	43
Пүрэв гүнгийн орчуулсан “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг”-ийн “Хөгжмийн зүйл”-ийн нийт толгой үгийн тоо		623

“Хорин нэгт” тайлбар тольд тайлбарлаагүй үг. Цуваа цагийн үүднээс харьцуулахад зохиогдсон цаг нь зөрүүтэй боловч зүйл хуваасан нь адил байна. “Хөгжмийн товчоо”-д нийт толгой үгээс 381 үгийг “Хорин нэгт” тайлбар тольд тайлбарлаагүй нь ялгаатай байна. Жишээлбэл:

- *Дундад найрт яруу хөгжим* (dumdadu nayirtu irayū kögjim) - Тэнгэр, газар, тариа гуйх зэрэг мандал тийм юу күнзийн сүм тайхуйд үүсгэмүй. Бүгд наян дөрвөн анги.
- *Тэнгэрс баясгалант хөгжим* (tngris bayasyulangtu kögjim) - Үдлэл эмч нарын зэрэг тэнгэрсийг тайх бага тайлгад үүсгэмүй. Нэгэн бүлэг.
- *Төв найрт залгамжлалт хөгжим* (töb nayiratu zalgamjilaltu kögjim)- Төв найрт залгамжлалт хөгжим- Эзний бие баярын ёсонд сууринд өөд болох ба ордонд өөд болох зэрэг газарт үүсгэмүй. Бүгд найман бүлэг

Тоон үзүүлэлт 1. “Хорин нэгт” тайлбар толь бичигт тайлбарлагдаагүй үгс



Эндээс харахад “Хорин нэгт” тайлбар толийг зохиохдоо толь зүйн уламжлах шинжээр манж үгний толь бичгээс орчуулгын үгсийг авч ашигласан боловч “qorin nigetü tayilburi toli”-ийн хоёр дахь хэвлэлтийн өмнөх үгд “Монголчуудын амьд ярианы үгсийг цуглуулан оруулсан” (1743:1) гэж тэмдэглэсэн баримтаар монгол толь зүйн уламжлалд илүү чухал байр суурийг эзэлж байна. Иймээс тухайн үеийн хэл шинжээч нар “Хорин нэгт” тайлбар толийг зохиохдоо манжийн үеийн соёл, хөгжмийн зэмсэг, төр ёсны арга хэмжээнд хэрэглэдэг хөгжмийн соёлыг тусгасан тайлбаруудыг хасаж “Хорин нэгт” тайлбар толийг зохиосон болох нь энэхүү харьцууллаас харагдаж байна. Мөн дээрх түүсэн үгсээс “Хорин нэгт” тайлбар тольд оруулаагүй ч өнөөгийн зарим толь бичигт уламжлагдан ирсэн тайлбарууд цөөнгүй тохиолдож байна. Жишээлбэл: Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д:

- *Дундад найрт яруу хөгжим*- *Тэнгэр, газар, сүм тахиж, тариа ургац гуйхад үүсгэх хөгжим.*
- *Тэнгэрс баясгалант хөгжим*- *Үдлэл эмч нарын зэрэг тэнгэрсийг тайх бага тайлгад үүсгэмүй. Нэгэн бүлэг*


гэх зэргээр “Хорин нэгт” тайлбар тольд орхиж, хасан найруулж зохиосон

боловч зарим үгс нь “Монгол хэлний товч тайлбар толь”-д уламжлагдаж ирсэн байна.

1717 оны “Хорин нэгт тайлбар толь” болон 1771 оны “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг” зэргийг 1708 оны “Хааны бичсэн манж үгний толь бичиг”-т суурилан зохиосон бол дээрх хоёр толь бичиг нь орчин цагийн монгол хэлний тайлбар толиудад дам нөлөөлсөн нь ажиглагдаж байна. Иймээс тухайн үеийн манж, монгол толь бичгүүд нь дараа дараагийн толь бичгүүдэд нөлөөлсөөр ирсэн бөгөөд өнөөгийн толь бичгүүдэд зарим үгсийн тайлбар нь манж толь бичгээс уламжлагдсан нь харагдаж байна.

Үгийн сангийн зөрүүтэй байдал. Хэл шинжлэлийн салбар ухаанд толь бичиг уламжлах шинжтэй байдаг ч тухайн үеийн нөхцөл байдал, нийгмийн хэл яриа зэргээс хамаараад орчуулагч, шинэ толь бичиг зохиогч хэл шинжээч нар тодорхой хэмжээний тольд өөрчлөлт, нэмэлт зүйлт оруулах нь ажиглагдаж байна. Бидний харьцуулсан толиудад 103 үгийг зөрүүтэй тайлбарласан байна.

Тоон үзүүлэлт 2. Хоёр толь бичгийн үгийн сангийн зөрүүтэй байдал



Жишээлбэл,


Хүснэгт 2. Үгийн сангийн зөрүүтэй байдлыг харьцуулсан нь

Пүрэв гүнгийн толь бичиг: Хөгжмийн зүйл-Гуравдугаарт	Хорин нэгт тайлбар толь: Хуудас-42
<i>egüsgemüi-</i> Үүсгэмүй- <i>kögjim-i egüs-geküi-dor modun-u ekilegči-yi čokiγsan qoyin-a sayi jöng ging törü-yin yatuγ-a aqui yeke yatuγ-a-u jerge jebseg-i du-uγarayaqui-yi egüsgemüi kememüi.</i>	<i>egüsgemüi-</i> Үүсгэмүй- <i>kögjim-i egüs-geküi-dor ekilegči-yi čokiγsan qoyin-a sayi al-tan kökürge, törü-yin yatuγ-a aqui yeke yatuγ-a-u jerge jebseg-i duuγarayaqui egüsgemüi kememüi.</i>

Энэ мэтчилэн бага боловч найруулга, үгийн сангийн хувьд зөрүүтэй тэмдэглэсэн үгс нийт үгийн 16,5 хувийг эзэлж байна. Найруулга болон үгийн сан зөрүүтэй боловч ойролцоо үгсээр сэлгэн найруулсан байна. Иймээс Хорин нэгт тайлбар толийг зохиохдоо “Хааны бичсэн манж үгний толь бичиг”-ээс шууд хуулбарлан аваагүй ч дам байдлаар эсвэл ойролцоо утгаар нь солин найруулж зохиосон нь бидний энэхүү харьцуулалтаас ажиглагдаж байна.

Ижил утгаар тайлбарласан үг. Толь зүйн судлагдахууны уламжлах шинжийн хүрээнд адил үгийг адил тайлбарласан 96 үг байна.

Тоон үзүүлэлт 3. Хоёр толь бичигт ижил утгаар тайлбарласан үг.



Бидний сонгож авсан 623 үгээс энэ мэтчилэн 96 үгийг үгийн сангийн хувьд зөрүүгүй тайлбарласан байна. Энэ нь уг толь бичгүүд 1708 онд хэвлэгдсэн “Манж үгний толь бичиг”-т суурилагдсан байдал ажиглагдаж байна.

Харин Пүрэв гүнгийн орчуулсан тольд “togšimui” хэмээн бичих хэлбэрийг “toγšimui- ᠲᠣᠭᠰᠢᠮᠤᠢ” хэмээн орчуулах явцдаа бичсэн нь тухайн үеийн бичгийн мэргэд “х,г” хоёрыг ялгах зорилгоор дусал тавьж бичсэн бололтой.

Хүснэгт 3. Хэл зүйн харьцуулал

“Хөгжмийн товчоо”-ны Хөгжмийн зүйл- гуравт	“Хорин нэгт” тайлбар тольд
toγšimui	togšimui
ᠲᠣᠭᠰᠢᠮᠤᠢ	ᠲᠣᠭᠰᠢᠮᠤᠢ
Өчүүхэн өчүүхэн цохихыг тогшмуй хэмээв.	Өчүүхэн өчүүхэн цохихыг тогшмуй хэмээв.

Салаа утгаар тайлбарласан үг. Хэл бол харилцагч хүмүүсийнхээ соёл, сэтгэлгээний цар хүрээг харуулдаг тогтолцоотой байдаг. Тиймээс толь бичгээр дамжуулан тухайн ард түмний соёл сэтгэлгээг илэрхийлэх боломжтой. Харин алтай язгуурын хэлний ихэнх толь бичгийг зүйлчлэн зохиодог уламжлалтай

байдаг нь орчин цагийн толь бичгээс ялгаатай байна. Зүйлчилсэн толь бичиг нь ерөнхий ойлголтын хүрээнд зүйл хувааж толгойлдог бол харин орчин ацгийн толь нь цагаан толгойн үсгийн дараалалд оруулж, хэрэглэгдэх хялбар, салаа утгыг нэг дор харах боломжтойгоор ялгаатай байдаг байна.

Тоон үзүүлэлт 4. “Хорин нэгт” тайлбар тольд салаа утгаар тайлбарласан үгс



Жишээ нь:

Хүснэгт 4. Үгийн сангийн харьцуулал

Пүрэв гүнгийн толь бичиг: Хөгжмийн зүйл- Гуравдугаарт:	Хорин нэгт тайлбар толь: Хуудас-472
1. <i>Татмуй</i> (Tatamui)- Хулсан модны бяцхан нумд хялгас торгон уяж, хийлийн чавхдасанд тулгуулж, хойш урагш таталхийлэн дуугаргахыг татмуй хэмээв. (Тайлбар: нэг зүйлийн үгийн санг харьцуулсан тул бусад зүйлээс татмуй хэмээх утгыг хайгаагүй болно.)	<i>Татмуй</i> (Tatamui)- 1. Аливаа юмыг огцруулан авахыг татмуй хэмээмүй. 2. Хонины махыг хоёр хутгаар харшуулан хярахыг татмуй хэмээмүй. Хэрчих адил. 3. Залгарламуйг үз. /Огцорсон сум зэвийн үүсгэрийг цавуудан залгахуйг залгарламуй хэмээмүй. Бас татмуй хэмээмүй/ 4. Биеийн зүг шадарлан авч ирэхийг татмуй хэмээмүй. 5. Авын сайран газрыг нягт болгон хойш татан авч ирэхийг татмуй хэмээмүй. 6. Мах булгиан хөдөлгөхийг татмуй хэмээмүй. 7. Харвах зэвсгийг онилж нум сая ангайлгахыг татмуй хэмээмүй.

Дээрх хэсгээс харвал “Хорин нэгт” тайлбар толь хоёр дахь хэвлэлээ цагаан толгойн дараалалд оруулж, үгийг олон салаа утгаар нэг дор хураан тайлбарлаж зохиосон байна. Үүнээс үзэхэд “Хорин нэгт” тайлбар толийг зохиохдоо монгол хэл шинжээч нар өөрсдийн сэтгэлгээнд тулгуурлан үгийн сангийн олон салаа

утгатай үгийг аль болох багтаан оруулахыг зорьсон нь харагдаж байна. Ингээд “Хорин нэгт”-д 7 янзаар тайлбарласан мөртөө Пүрэв гүнгийн толь бичиг дэх “Tatamui” хэмээх үгийг *хулсан модны бяцхан нумд хялгас торгон уяж, хийлийн чавхдасанд тулгуулж, хойш урагш таталхийлэн дуугаргахыг татмуй хэмээв* хэмээн тайлбарласан байгаа ч нэг зүйлийн толгой үгийг сонгон авч харьцуулсан тул бусад зүйлээс *татмуй* хэмээх үгийг хайгаагүй билээ. Тиймээс цаашдын ажилдаа бид илүү дэлгэрэнгүй харьцуулалт хийж, бусад зүйл ангийн үгийн санг хамруулах судлах болно.

Дүгнэлт

Манжийн үед толь бичиг зохиох ажил ихээхэн өрнөж байсан бөгөөд тэр дундаа монгол, манж хоёр хэлний толь бичиг нэлээдгүй зохиогдсон нь бидний тус ажил харуулж байна. Тухайн хоёр хэлний холбоо хамаарал, харилцан нөлөөллийг тодруулахад толь бичгүүдийг харьцуулан үзэх нь эрдэм шинжилгээний чухал ажил болж байна. Ингээд өөрсдийн хийсэн ажлаасаа доорх хэдэн саналыг дэвшүүлж байна.

Нэг, Пүрэв гүнгийн орчуулсан “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг”-ийн “Хөгжмийн товчоо”-ны 623 үгийг орчин цагийн монгол хэлний ууган тайлбар толийн нэг “Хорин нэгт тайлбар толь”-той харьцуулан үзэхэд бидний сонгон авсан зүйлийн үгийн сан дахь 61% нь “Хорин нэгт тайлбар толь”-д тайлбарлаагүй буюу байхгүй байна. Энэ нь монголчууд манж толь бичгийн уламжлал дээр суурилж толь бичгээ зохиож байсан боловч өөрсдийн соёл, сэтгэлгээнд холбоогүй үгийг толь бичигтээ төдий л ашигладаггүй зохион найруулдаг байжээ.

Хоёр, Үгийг сэлгэн найруулсан, адил утгаар үгийг тайлбарласан зэрэг баримт илэрч байгаа тул “Хорин нэгт” тайлбар толь бичгийг зохиоход манж толь бичгийн үгийг цөөн тохиолдолд орчуулан авч хэрэглэсэн байна.

Гурав, Тус хоёр толь бичиг дэх үгийн тайлбар нь харилцан бие биедээ нөлөөлсөн бөгөөд толь зүйн уламжлах шинжийг баримтлан зохиогдсон байна.

Эцэст нь уг судалгааны ажлыг үргэлжлүүлэн Пүрэв гүнгийн толь бичгийг бүрэн судалж, бусад манжийн үед зохиогдсон толь бичиг, өнөөгийн монгол хэлний тайлбар толь бичгүүдтэй харьцуулан судлах нь үгийн сангийн судлал, толь зүйн судалгаа, харилцан нөлөөллийг тогтооход эрдэм шинжилгээний ач холбогдолтой ажил хэмээн үзэж байна.

COMPARISON OF THE “DICTIONARY OF TWENTY-ONE SECTIONS” WITH THE “MUSICAL SECTIONS” IN THE “MANCHU DICTIONARY OF ADDITIONAL TERM ORDERED BY THE EMPEROR” TRANSLATED BY PRINCE PÜREV

The common vocabulary between the Manchu and Mongolian languages can be identified through sources such as historical records, literary texts, official documents, and dictionaries. Although there are studies that examine the historical comparative analysis of Manchu and Mongolian, few studies specifically focus on bilingual dictionaries and their translation effects. This study investigates the interplay between Manchu and Mongolian dictionaries by comparing two key sources: the Manchu dictionary of Additional terms ordered by the Emperor, translated by Prince Purev, and the Dictionary of Twenty-One sections. In the preparation of source material, comparative and descriptive-analytical methodologies were used, and relevant lexical entries were transcribed into both Cyrillic and academic Latin scripts. Through this comparative approach, the entries were classified according to their distinctions, and the mutual influence between Manchu and Mongolian dictionaries was analyzed and synthesized. As a result of this study, linguistic evidence demonstrated that certain Manchu dictionaries have influenced some contemporary Mongolian dictionaries.

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

(2014). “*qorin nigetü tayilburi toli*” öber mongyul-un arad-un keblel-ün qoriy-a.

(2024). Пүрэв гүнгийн орчуулсан “*Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг*” УБ.

Судалгааны бүтээл

Gegeentan-a, (2013). “*mongyul toli bičig-ün quriyangyui*” öber mongyul-un soyul-un keblel-ün qoriy-a.

Jibqulang, Мө. (2021). “*bürinbayar-un kelegsen yurban ulus-un üliger dahi qorčın aman ayalу ba jigelege üge-yin sudulul*” kele šinjilel-ün uqayan-u doctor-un jerge yorilaysan bütügel.

Мөнхцэцэг, Э. (2022). “*XVIII зууны үеийн манж толь бичгүүдийн үгийн сангийн судалгаа*” УБ. Мөнхийн Үсэг ХХК.

Нансалмаа, Н. (2015). “*Үгийн сан судлал*” УБ. Соёмбо принтинг.

Түвшинтөгс, Б. (2023). “Монгол Улсын Үндэсний номын сангийн манж дурсгалын бүртгэл” УБ. Соёмбо принтинг.

Цэвэл, Я. (2022). “Монгол хэлний товч тайлбар толь” УБ. Хэвлэлийн комбинат.

Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., Самбуудорж, О., Пүрэвжав, Э., Баттөгс, Б., Гэрэлмаа, Г. (2022). “Үгийн сан, утга зүй Х. Монгол хэл судлал XV боть” УБ: МУИС-МСХ.

Энхсүвд, Б. (2023). “Дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалын үгийн сангийн бүрэлдэхүүн, давтамжийн судалгаа” Хэлшинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл.

Товчилсон нэрийн хэлхээ

1. МУҮНС-Монгол Улсын Үндэсний номын сан
2. Пүрэв гүнгийн толь бичиг- Пүрэв гүнгийн орчуулсан “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг”



ХУТАГТ СУДРЫН АЙМГИЙН ЭРХЭТ ХААН ХЭМЭЭХ ИХ ХӨЛГӨНИЙ СУДАР

Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ
МУБИС. НХУС. МХУЗ 3-р курс

Удирдагч багш: Г. Цэцэгдарь /доктор (Ph.D), дэд профессор/

Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-ийн Монгол хэлний тэнхим (1-301 тоот)-д хадгалагдан буй *Xutuqtu sudariyin ayimagiyin erketü xa'an keme'eqdekü yeke kölgön sudar*¹-ын судалгааны анхан шатны боловсруулалтын үргэлжлэлийг энэхүү өгүүллээрээ танилцуулж байна.

Ойрадын Зая бандида Намхайжамцын 1648 оны шар хулгана жил зохиосон тод бичгийн тус судрыг др. Д.Ганболдын үйлдсэн тодорхойлолтын дагуу танилцуулбал:

Судрын нэр: *Xutuqtu sudariyin ayimagiyin erketü xa'an keme'eqdekü yeke kölgön sudar*

Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээгдэх их хөлгөн судар, гүн

Шифр: МоБ.040

Бичгийн хэлбэр: гар бичмэл, хар улаан шунх

Хэл: монгол, тод бичиг

Судрын хэмжээ: 5215.5 см

Бичвэрийн хэмжээ: 5012 см

Хуудасны тоо: бүрэн, 93

Тус судрын бичвэрийг улаан хүрээний дотор бичсэн, хуудсын дугаарыг бичвэр бүхий хүрээний гадна нүүрэнд голлуулан бичмэлээр бичсэн, нэг хуудас нь хоёр талдаа бичвэртэй (бид а, б гэж ялган тэмдэглэв), нэг хуудас дахь мөрийн тоо 26-34.


¹ Д.Ганболд, «Бичиг соёлын төв»-д буй монгол, төвөд судрын гарчиг, бичвэрийн тодорхойлолт, Улаанбаатар, 2012, 4

Тус судар нь төвөд үгсийн өмнө төвөд үсгээр давхар хадсан², хар, улаан шунхаар ялган бичсэн³ *Алтангэрэл* судар болно. Энэ далимд дурдахад, тод бичгийн *Хутагт дээд Алтан гэрэл судрын аймгийн эрхэт хаан хэмээх их хөлгөн судар*-уудын модон барын дурсгалууд олон байдгийг др. Б. Түвшинтөгсийн саяхны шинэ бүтээлээс мэдэж болно.⁴

Энэ удаа нийт 93 хуудас, 184 тал бүхий Алтангэрэл судрын бичвэрийг эрдэм шинжилгээний галиг үсэг болон кирилл үсгээр хөрвүүлсэн ажлын дараагийн хэсгээс танилцуулж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЛИГ БОЛОН КИРИЛЛ ҮСГИЙН ХӨРВҮҮЛГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Хавтас




Xutuγ tu suduriyin ayimaγiγin *Erketü xān*
kemēkü yeke kölgöni sudur orošiboi
Хутагт судрын аймгийн
Эрхэт хаан хэмээх
их хөлгөний судар оршвой

² Энэ удаа төвөд үсгийг мэдэхгүйн харгайгаар тухайн үсгийг галигласангүй, зориуд орхисон ба судалгааны ажлын дараагийн шатанд хийхээр төлөвлөж байна. Харин дөрвөлжин хаалт []-аар төвөд үг байгааг тодорхой зааж мэдүүлэхээр шийдвэрлэв.

³ Улаан шунхаар бичсэн үгсийг бид энэ удаагийн хэвлэлд өнгөөр ялгасангүй, харин налуу (*italic*) үсгээр ялган бичив.

⁴ Б.Түвшинтөгс, Тод бичгийн модон барын дурсгалын судалгаа, Улаанбаатар, 2024, 256

**ба. Эрдэм шинжилгээний галиг****ба. Jurγā**

- ба-1. damnan bū üyiled, ilayūqsani gegēn
- ба-2. nasuni ečūšiyin, tō xamiya ču jori
- ба-3. xu ügei. Tende tere čay tu nöküd
- ба-4. tende suryaliiyin bayši eši üjüü
- ба-5. lügči biraman güüdine kemēkü kigēd
- ба-6. olon mingyan biraman, *ilayun tögüsün*
- ба-7. *ülegseni* takin üyiled či, tögün
- ба-8. čilen boluqsan oγōto yeke yasalang
- ба-9. ēče nögčiküi doū sonosōd
- ба-10. daruyid uyila, Ilayun tögüsügse
- ба-11. ni xoyor ölmidü kürgeji, ilayun
- ба-12. tögüsügsen dü jalbarbai, Kerbe
- ба-13. ilayun tögüsügsen xamuy amitan du
- ба-14. sedkil enerigči, yeke nigüülesküi
- ба-15. tögüsügsen, tusalaxui tālaxči, xamuy
- ба-16. amitan du ečiḡe eke metü sača busu
- ба-17. luyā sača boluqsan, saran metü gegē
- ба-18. rüülün üyiledügči, *Bilig kigēd*
- ба-19. *yeke belge biligiiyin* naran urγuqsan
- ба-20. metü mün, kerbe či xamuy amitan du
- ба-21. [raxulā] bariqsan metü üjegülē, Nad-a
- ба-22. nige dēdū yi ögün soyirxo, ila
- ба-23. γun tögüsün ülegsen youma jar
- ба-24. lig ese bolbai, Tende burxani auyā
- ба-25. bēr, nöküd tende xamuy amitan
- ба-26. üjegülē tālaxu kemēkü [...] küü


ба. Кирилл үсгийн хөрвүүлэг.**ба. Зургаа**

- ба-1. дамнан бүү үйлд. Ялгуусны гэгээн
- ба-2. насны эцсийн, тоо хаана ч зорь-
- ба-3. х үгүй. Тэнд тэр цагт нөхөд
- ба-4. тэнд сургаалын багш эш үзүү-
- ба-5. лэгч бирман гүүд нь хэмээх хийгээд
- ба-6. олон мянган бирман, *Ялгуун төгссөн*
- ба-7. *үлсэнийг* дахин үйлд чи. Түүн -
- ба-8. чилэн болсон огоот их гасланг -
- ба-9. аас нөгчих дуу сонсоод
- ба-10. даруйд уйл. Ялгуун төгссөн -
- ба-11. ий хоёр өлмийд хүргэж, ялгуун
- ба-12. төгссөнд залбирбай. Хэрвээ
- ба-13. ялгуун төгссөн хамаг амьтанд
- ба-14. сэтгэл энэрэгч, их нигүүлсэхүй
- ба-15. төгссөн, туслахуй таалагч хамаг
- ба-16. амьтанд эцэг эх мэт сац бус
- ба-17. лугаа сац болсон, саран мэт гэгээ -
- ба-18. рүүлэн үйлдэгч, *билиг хийгээд*
- ба-19. *их бэлгэ билгийн* наран ургасан
- ба-20. мэт мөн, хэрвээ чи хамаг амьтанд
- ба-21. [...] барьсан мэт үзүүллээ. Над
- ба-22. нэг дээдийг өгөн соёрх, ял -
- ба-23. гуун төгсөн үлсэн юм зар -
- ба-24. лиг эс болбой. Тэнд бурхны аугаа -
- ба-25. аар, нөхөд тэнд хамаг амьтан
- ба-26. үзүүлэхүүлээ таалах хэмээх [...] хүү -

6a-27. ken tere cölörküi töröjī, sur
 6a-28. ʔaliyin baʔši eši üjүүлүгči
 6a-29. bira^{man} gүүdine dū eyin kemēn
 6a-30. ögүүлēbei, Aya youn yeke bira
 6a-31. man čī, ilayun tögүsün dū nige
 6a-32. dēdū yi ayiladxahu buyu, bi
 6a-33. čimadu nige dēdū yi ögүye, Bira
 6a-34. man ögүүлēbei, [...] kүүken bi

6a-27. хэн тэр цөлрөх төрж, сур -
 6a-28. - гаалын багш эш үзүүлэгч
 6a-29. бирман гүүдэд ийн хэмээн
 6a-30. өгүүлвэй. Аяа юун их бир -
 6a-31. ман чи, ялгуун төгсөнд нэг
 6a-32. дээдийг айлтгах буюу. Би
 6a-33. чамд нэг дээдийг өгье. Бир -
 6a-34. ман өгүүлвэй. [...] хүүхэн би

№12



66. Эрдэм шинжилгээний галиг

66-1. Иlayun tögүsün ülegse ni
 66-2. takixui kigēd, Šaliri^yin kemketüg
 66-3. xubāxuyin tula, Иlayun tögүsüg
 66-4. seni šalir kijiyin činēni šütüküi
 66-5. küsemüi, Šalir kijiyin činē töüni
 66-6. ilerkei takixulā, Гуčin yurban
 66-7. tenggeri noyöüdiyin ejeni imaxta
 66-8. olxu kemēn aldaršibai, Aya [...]
 66-9. [...] kүүken dēdū altan gereliy^yin sudur
 66-10. хамуу [...] kigēd [...] [...]
 66-11. medekü berke, Dotoro oroul
 66-12. xu berke. Tere metü belge činar kigēd
 66-13. erdem tögүsүgsen, dēdū altan
 66-14. gereliy^yin sudur nomloxu kemēn dou
 66-15. risunai čingnan üyiled. Aya [...]
 66-16. kүүken dēdū altan gereliy^yin sudur,
 66-17. tere metü medekü berke onoxu
 66-18. berkeyin tula, bide kijār küšöün


66. Кирилл үсгийн хөрвүүлэг.

66-1. Ялгуун төгсөн үлсэн нь
 66-2. тахихуй хийгээд. Шалирын хэмхтэг
 66-3. хуваахын тул. Ялгуун төгс -
 66-4. сөнийг шалир хижийн чинээнийг шүтэхүй
 66-5. хүсмүй. Шалир хижийн чинээ түүнийг
 66-6. илэрхий тахихуул. Гучин гурван
 66-7. тэнгэр нүгүүдийн эзнийг ямагт
 66-8. олох хэмээн алдаршвай. Аяа [...]
 66-9. [...] хүүхэн дээд алтан гэрлийн судар
 66-10. хамаг [...] хийгээд [...] [...]
 66-11. мэдэх бэрх. Дотор оруул -
 66-12. х бэрх. Тэр мэт бэлгэ чанар хийгээд
 66-13. эрдэм төгссөн. Дээд алтан
 66-14. гэрлийн судар номлох хэмээн дуу -
 66-15. рьсаныг чагнан үйлд. Аяа [...]
 66-16. хүүхэн дээд алтан гэрлийн судар,
 66-17. тэр мэт мэдэх бэрх онох
 66-18. бэрхийн тул бид хязгаар хөшүүн

66-19. tibiyin biraman noyöüd ali yi
 66-20. xadyalaxulā, Amitan noyöüd ötör
 66-21. yučin yurbani ejeni olun üyi
 66-22. ledküi, *Šalir kiŋiyin* činēni saba
 66-23. dotoro duruŋi xadyalabču
 66-24. bolxu, aya [...] kүүken čī
 66-25. tögүнčilen boluqsan du kiŋiyin
 66-26. činē šalir ayiladxād, Šaliriyin
 66-27. saba du duruŋi xadyalasqan iyār,
 66-28. amitan noyöüd *yučin yurbani*
 66-29. ejeni olxui ülü durašixu buyu
 66-30. aya [...] kүүken bi dēdū tere
 66-31. metü yi ayiladxamui, tende xamuy
 66-32. yertүнčüner üjekülē tālaxui
 66-33. [...] kүүken, suryaliyin bayši
 66-34. eši üjүүлүгči biraman güüdine

66-19. тивийн бирманууд алийг
 66-20. хадгалхуулаа. Амьтан нугууд үтэр
 66-21. гучин гурваны эзнийг олон үй -
 66-22. лдвэй. *Шалир хижийн* чинээ сав
 66-23. дотор дүрж хадгалавч
 66-24. болох, аяа [...] хүүхэн чи
 66-25. түүнчлэн болсонд хижийн
 66-26. чинээ шалир айлтгаад, шалирын
 66-27. саванд дүрж хадгалснаар
 66-28. амьтан нугууд *гучин гурваны*
 66-29. эзний олохуй үл дурших буюу
 66-30. аяа [...] хүүхэн би дээд тэр
 66-31. мэтийг айлтгамуй. Тэнд хамаг
 66-32. ертөнц нэр үзэхүүлээ таалахуй
 66-33. [...] хүүхэн, сургаалын багш
 66-34. эш үзүүлэгч бирман [...]

№13



7а. Эрдэм шинжилгээний галиг

7а. Dolō

7а-1. dū šlүglęjī xarin ögүülebei,
 7а-2. keŋē yangyayin usunī ürgүljidү čеčег
 7а-3. noyöüd urγun, xong kerē ulān bolun
 7а-4. kökü dunggiyin önggү metü bolun, jam
 7а-5. bu du dalayin үre toγton, [...] dү
 7а-6. amrayin nabči urγuxulā, Tere čay tu
 7а-7. kiŋiyin činē, šalirtu todorxoi
 7а-8. bolxu, *Keŋē yasutu melekeyin* үsүн
 7а-9. noyöüd iyār, xubčasun du sayitur
 7а-10. neken үyiledči, үbüliyin küyitöni


7а. Кирилл хөрвүүлэг.

7а. Долоо

7а-1. д шүлэглэж харин өгүүлвэй.
 7а-2. Хэзээ гангын усны үргэлжид цэцэг -
 7а-3. нүгүүд урган, хун хэрээ улаан болон
 7а-4. хөх дунгийн өнгө мэт болон, зам -
 7а-5. бууд далайн үр тогтон, [...]
 7а-6. амраагийн навч ургахуулаа, тэр цагт
 7а-7. хижийн чинээ, шалирт тодорхой
 7а-8. болох. *Хэзээ яст мэлхийн* үсэн
 7а-9. нүгүүдээр, хувцсанд сайтар
 7а-10. нэхэн үйлдэж, өвлийн хүйтнийг

7a-11. arilyan üyiledkölē, Tere çay tu šalir
 7a-12. bui bolxu, Kejē jöküyin kül yar iyār,
 7a-13. dēdū būrkūl sayitur üyiledün, batu
 7a-14. maši ülü küdölkölē, tere çay tu šalir
 7a-15. bui bolxu, kejē xoroxoi [...] būrkün,
 7a-16. šütün čaγan bolun xurča yeke bolxulā,
 7a-17. tere çay tu šalir bui bolxu, Öndür
 7a-18. ijourtan du yarxuyin tul, kejē tou
 7a-19. layin eber noγöüd iyār, šatu sayitur
 7a-20. üyiledküi, tere çay tu šalir bui bolxu,
 7a-21. kejē tere šatu bēr yarči, xuluyuna
 7a-22. sara ideküi, [raxula] du ču xor üyi
 7a-23. ledküi, tere çay tu šalir bui bolxu,
 7a-24. balγad tu yabuyči bataγana, kejē
 7a-25. butunggiyin araki uūji, gerte oro
 7a-26. šin üyiledküi, tere çay tu šalir bui
 7a-27. bolxu, Kejē eljigen amuyūulang
 7a-28. bolun, xošoun ulān bimba metü
 7a-29. bolun, doulan böjig noγöüd tu
 7a-30. mergen boluqsan, tere çay tu šalir bui
 7a-31. bolxu, Kejē šara šobūün xong
 7a-32. kerē noγöüd, axlay tu odči
 7a-33. nādun, inayši činayši jokildun
 7a-34. üyiledkölē, tere çay tu šalir bui

7a-11. арилган үйлдэхүүлээ. Тэр цагт шалир
 7a-12. буй болох. Хэзээ зөгийн хөл гараар
 7a-13. дээд бүрхүүл сайтар үйлдэн, бат
 7a-14. маш үл хөдөлхүүлээ. Тэр цагт шалир
 7a-15. буй болох. Хэзээ хорхой [...] бүрхэн
 7a-16. шүтэн цагаан болон хурц их болохулаа.
 7a-17. тэр цагт шалир буй болох. Өндөр
 7a-18. язуртанд гарахын тул, хэзээ туу -
 7a-19. лайн эвэр нүгүүдээр, шат сайтар
 7a-20. үйлдэхүй. Тэр цагт шалир буй болох.
 7a-21. Хэзээ тэр шатаар гарч, хулгана
 7a-22. сар идэхүй, [...] д ч хор үй -
 7a-23. дэхүй. Тэр цагт шалир буй болох.
 7a-24. балгадад явагч батгана, хэзээ
 7a-25. бутангийн архи ууж, гэрт ор -
 7a-26. шин үйлдэхүй. Тэр цагт шалир буй
 7a-27. болох. Хэзээ илжгэн амуулан
 7a-28. болон, хошуун улаан бямба мэт
 7a-29. болон, дуулан бөжиг нүгүүдэд
 7a-30. мэргэн болсон, тэр цагт шалир буй
 7a-31. болох. Хэзээ шар шувуун хон
 7a-32. хэрээ нүгүүд, аглагт одож
 7a-33. наадан, нааш цааш зохилдон
 7a-34. үйлдэхүүлээ. Тэр цагт шалир буй

**76. Эрдэм шинжилгээний галиг**

- 76-1. bolxu, Balašiyin nabči noγoūd γur
 76-2. ban jüyil erdeni kükür bolun, xura
 76-3. oroxuyin nemürge keĵe bolxu, Tere
 76-4. čay tu šalir bui bolxu, Keĵe dalayin
 76-5. yeke ongγočo, endöüröülküi
 76-6. kürdü kigēd xayibu selte tala du γar
 76-7. ču yabuxulā, tere čay tu šalir bui
 76-8. bolxu, Keĵe šara šobüün, küjiiyin
 76-9. ünür anggilaxui oula, хоšoün
 76-10. dā abči yabuxulā, tere čay tu
 76-11. šalir bui bolxu, *Surγaliyin bayši*
 76-12. eši üjүүлүгči biraḡan güüdi
 76-13. ne šülüg edeni sonosöd,
 76-14. xamuy yertünčü nēr üjegülē
 76-15. tālaxu yi [...] küüken dü šülüg
 76-16. eden iyēr xarin ögüülebei, sayin
 76-17. sayin dēdү küüken, Ilayuqsan
 76-18. küböün yeke oki tu, bātur uran
 76-19. arγa tögüsүgsen, eši üjүү
 76-20. lүgsen dēdү yi oluqsan yertün
 76-21. čüyin itegel ibēgči, Tөгүнčilen
 76-22. boluqsani yeke yi. Sedkiši
 76-23. ügei ulamiyin üy bēr, Küüken
 76-24. namai čingnan üyiled, Burxani oron
 76-25. sedkiši ügei, tögүнčilen boluqsan ada
 76-26. lidxal ügei, Xamuy burxad nasuda
 76-27. amurliqsan, *xamuy burxad* sayitur boluq

76. Кирилл үсгийн хөрвүүлэг.

- 76-1. болох, балшийн навч нугууд гур -
 76-2. ван зүйл эрдэнэ хүхэр болон, хур
 76-3. орохуйн нөмрөг хэзээ болох тэр
 76-4. цагт шалир буй болох. Хэзээ далайн
 76-5. их онгоц, эндүүрүүлхүй
 76-6. *хурд хийгээд* хайв сэлт талд гар -
 76-7. ч явахуулаа. Тэр цагт шалир буй
 76-8. болох. Хэзээ шар шувуун, хүжийн
 76-9. үнэр ангилахуй уул. Хошуун
 76-10. даа авч явахуулаа. Тэр цагт
 76-11. шалир буй болох. *Сургаалын багш*
 76-12. эш үзүүлэгч бирман гүүдийг
 76-13. нь шүлэг эднийг сонсоод,
 76-14. хамаг ертөнцөөр үзэхүүлээ,
 76-15. таалахыг [...] хүүхэнд шүлэг
 76-16. эднээр харин өгүүлвэй. Сайн
 76-17. сайн дээд хүүхэн, ялгуугсан
 76-18. хөвүүн их охьт, баатар уран
 76-19. арга төгссөн, эш үзүү -
 76-20. лсэн дээдийг олсон ертөн -
 76-21. цийн *итгэл ивээгч*. Түүнчлэн
 76-22. болсныг ихийг, сэтгэш
 76-23. үгүй улмын үеэр. Хүүхэн
 76-24. намайг чагнан үйлд. Бурхны орон
 76-25. сэтгэш үгүй, түүнчлэн болсон ад -
 76-26. литгал үгүй. Хамаг бурхад насад
 76-27. амирласан, *хамаг бурхад* сайтар бол -

76-28. san, Xamuγ burxad önggü adali.
 76-29. ene burxani nomiyin činar mün,
 76-30. ilayun tögüsün ülegsən yasaq
 76-31. san busu, tögünčilen boluqsan ese
 76-32. törögsön, Očir metü batu
 76-33. beyetei, xubilayāni beye üjüü
 76-34. lün üyiledümüi, Yeke arši yin

76-28. сон. Хамаг бурхад өнгө адил,
 76-29. энэ бурхны номын чанар мөн.
 76-30. Ялгуун төгсөн үлсэн зас -
 76-31. сан бус, түүнчлэн болсон эс
 76-32. төрсөн. Очир мэт бат
 76-33. биетэй, хувилгааны бие үзүү -
 76-34. лэн үйлдмүй. Их аршийн

№15



8а. Эрдэм шинжилгээний галиг

8. Nayima

8а-1. šalir inü, kijiyin činē kemēn
 8а-2. ögüülekü ügei, Beye dü yasun
 8а-3. čusun ügei bolbösu, šalir
 8а-4. bui xamiγan bolxu amitan noγoü
 8а-5. di tasulaxuyin tula. Arya bēr
 8а-6. šalir talbin üyiledümüi. Douсуq
 8а-7. san *burxan nomiyin* beye, tögünčilen
 8а-8. boluqsan nomiyin činar, nom
 8а-9. üjüülün üyiledkü yambar metü,
 8а-10. ilayun tögüsün ülegsēni
 8а-11. beye tere metü, Bi öüni
 8а-12. sonoson medēd, bi dēdü yi
 8а-13. ayiladxan üyiledbei, Tere imay
 8а-14. ta du eši üjüülүgsēni tula,
 8а-15. ögüülen duradxuyigi bi üi
 8а-16. ledbei, Tende γurban түmen
 8а-17. хойор mingγan *tenggeriyin küböün*,
 8а-18. tögünčilen boluqsani gegēn nasuni
 8а-19. kemjē, üjüülүgsen gün tēdeni

8а. Кирилл үсгийн хөрвүүлэг


8. Найм

8а-1. шалир нь, хижийн чинээ хэмээн
 8а-2. өгүүлэх үгүй. Биед ясан
 8а-3. цусан үгүй бөгөөс, шалир
 8а-4. буй хаа болох амьтан нугуу -
 8а-5. дыг таслахуйн тул. Аргаар
 8а-6. шалир тавин үйлдмүй. Дуус -
 8а-7. сан *бурхан номын* бие, түүнчлэн
 8а-8. болсон номын чанар. Ном
 8а-9. үзүүлэн үйлдэх ямар мэт.
 8а-10. Ялгуун төгсөн үлсэнийг
 8а-11. бие тэр мэт. Би үүнийг
 8а-12. сонсон мэдээд, би дээдийг
 8а-13. айлтган үйлдвэй. Тэр ямаг -
 8а-14. тад эш үзүүлсэний тул,
 8а-15. өгүүлэн дуртгахыг би үй -
 8а-16. лдвэй. Тэнд гурван түмэн
 8а-17. хоёр мянган тэнгэрийн хөвүүн,
 8а-18. түүнчлэн болсныг гэгээн насны
 8а-19. хэмжээ, үзүүлсэн гүүн тэднийг

8a-20. sonosöd, xamuγ iyēr dēre ügei
 8a-21. sayitur doṣuqsan [...] du sed
 8a-22. kil öüsgen, tede sedkiliyin бүхүн
 8a-23. dü seǰigleküi maši bayasun, nige
 8a-24. egešig doṣin du šülüg edeni ögüü
 8a-25. lebei, *Burxan* ʔasalang ēče oγō
 8a-26. to ülü nögčün, nom ču ülü ečüd
 8a-27. kü, amitani oγōto bolbosuroölun
 8a-28. üyiledküyin tula oγōto ʔasalang
 8a-29. ēče oγō nögčiküi üjüülkü, ilayun tögü
 8a-30. sügsen burxan sedkiši ügei, tögün
 8a-31. čilen boluqsan möngkü beye, amitan
 8a-32. noγōüdi tasulaxuyin tula, joköl
 8a-33. eldeb jüyil üjüül kü,
 8a-34. Tende üjesgüleng oki

8a-20. сонсоод, хамгаар дээр үгүй
 8a-21. сайтар дууссан [] – д сэт -
 8a-22. гэл үүсгэн, тэд сэтгэлийн бүхэн -
 8a-23. д сэжиглэхүй маш баясан, нэг
 8a-24. эгшиг дуунд шүлэг эднийг өгүү -
 8a-25. лвэй. *Бурхан* гаслангаас огоо -
 8a-26. т үл нөгчин, ном ч үл эцэд -
 8a-27. х амьтныг огоот боловсруулан
 8a-28. үйлдэхүйн тул, огоот гаслан –
 8a-29. гаас огоо нөгчихүй үзүүлэх, ялгуун төг -
 8a-30. сөн бурхан сэтгэш үгүй, түүн -
 8a-31. члэн болсон мөнх бие. Амьтан -
 8a-32. нугуудыг таслахуйн тул, зохиол
 8a-33. элдэв зүйл үзүүлэх.
 8a-34. Тэнд үзэсгэлэн охъ

№16



86. Эрдэм шинжилгээний галиг

86-1. [...] [...], ilayun tögüsügsen
 86-2. burxan tede kigēd, dēdү töröl тү
 86-3. tere хойор ēče, ilayun tögüsügsen
 86-4. [...] [...] gegēn nasuni kemjē üjüü
 86-5. lügseni sonosöd, xanun gesči sedkil
 86-6. xanun maši bayasči, bayasaxui kigēd amu
 86-7. yuulang sedkil töröji, bayasun geskü
 86-8. aγui yeke bēr түгēmел болбой, Tөгүн
 86-9. čilen boluqsani gegēn nasuni kemjē öü
 86-10. ni nomloγson čay tu, töloši ügei
 86-11. čaylaši ügei amitan dēre ügei sayi

86. Кирилл хөрвүүлэг.

86-1. [] [], ялгуун төгсөн
 86-2. бурхан тэд хийгээд, дээд төрөлт
 86-3. тэр хоёроос, ялгуун төгссөн
 86-4. [...] [...] гэгээн насны хэмжээ үзүү -
 86-5. лсэнийг сонсоод, ханан гэсэж сэтгэл
 86-6. ханан маш баясаж, баясахуй хийгээд амуу -
 86-7. гуулан сэтгэл төрж, баясан гэсэх
 86-8. агуй ихээр түгээмэл болбой. Түүн -
 86-9. члэн болсныг гэгээн насны хэмжээ үү -
 86-10. нийг номлосон цагт тоолош үгүй
 86-11. цаглаш үгүй амьтан дээр үгүй сай -

86-12. tur doısuqsan [...] du sedkil öüs
 86-13. kebei, Tögünçilen boluqsan tede čü
 86-14. üjegdekü ügei bolboi, Suduriyin ayi
 86-15. mayiyin erketü xān dēdū altan gerel
 86-16. ēče, Tögünçilen boluqsani gegēn nasuni
 86-17. kemjē üjүүлүgsen bōlōg kemēkü inü
 86-18. xoyoduγar bui,
 86-19. Tegēd üjesgöleng oki [...] [...]
 86-20. noyirtu noyirsuqsan jöüdün dü,
 86-21. bükün dü gegereküi altan kenggerge ene
 86-22. metü narani maidal metü nigeni üjebei
 86-23. yi, xamuy jügtü čü tōloši ügei čay
 86-24. laši ügei burxad, erdeni moduni
 86-25. dergede [...] erdeni širē noyōüd
 86-26. tu soun, olon joun mingγan nōküd
 86-27. oγōtu kürēlen, emüne ēče xaraji
 86-28. nom üjүүлkui üjebei, Tende basa
 86-29. törölkitü biramani dürsün metü nigen,
 86-30. tere kenggerge deledküi üjen, kenggergiyin
 86-31. tere doün ēče üjүүлүgsen šlög ene
 86-32. metü noyōüd boluqsani sonosboi,
 86-33. Tede üjesgöleng oki [...] [...]
 86-34. serimegče, üjүүлүgsen šlög tedeni
 86-35. dayan sanabai, Dayan sanād ču tere

86-12. тар дуусан [...] - д сэтгэл үүс -
 86-13. гэвэй. Түүнчлэн болсон тэд ч
 86-14. үзэгдэхгүй болбой. Судрын ай -
 86-15. мгийн эрхэт хаан дээд алтан гэрэл -
 86-16. ээс, түүнчлэн болсныг гэгээн насны
 86-17. хэмжээ үзүүлсэн бүлэг хэмээх нь
 86-18. хоёрдугаар буй.
 86-19. Тэгээд үзэсгэлэн охь [...] [...]
 86-20. нойрт нойрсон зүүдэнд,
 86-21. бүхэнд гэгээрэхүй алтан хэнгэргэ энэ
 86-22. мэт нарны майдал мэт нэгийг үзэв -
 86-23. ийг, хамаг зүгт ч тоолошгүй цаг -
 86-24. лаш үгүй бурхад, эрдэний модны
 86-25. дэргэд [...] эрдэнэ ширээ нүгүүд -
 86-26. д суун, олон зуун мянган нөхөд
 86-27. огоот хүрээлэн, өмнөөс харж
 86-28. ном үзүүлэхүй үзвэй. Тэнд бас
 86-29. төрөлхөт бирманы дүрсэн мэт нэгэн,
 86-30. тэр хэнгэргэ дэлдэхүйг үзэн, хэнгэргийн
 86-31. тэр дуунаас үзүүлсэн шүлэг энэ
 86-32. мэт нүгүүд болсныг сонсвой.
 86-33. Тэд үзэсгэлэн охь [...] [...]
 86-34. сэрмэгц, үзүүлсэн шүлэг тэднийг
 86-35. Даган санавай. даган санаад ч тэр



9а. Эрдэм шинжилгээний галиг

9. Yesün

- 9а-1. söni döüsād xāni xaršiyin yeke
- 9а-2. abxui balʼyad ēce ʼarčī, olon mingʼyan
- 9а-3. amitan tai xamtu ʼaʼjaʼr čöyčö oula,
- 9а-4. xamiʼya kigēd, Ilayun tögösün ülegsēn
- 9а-5. xamiʼya bui tende odun kürēd, Ilayun
- 9а-6. tögösügsēni ölmidü terigüü bēʼr
- 9а-7. mürǵüji, Ilayun tögösügsēni ʼurbaʼn
- 9а-8. ta ergin üyiledēd, nigen жүг тү соү
- 9а-9. bai. Nigen жүг тү соүʼyād üjesgüʼleng
- 9а-10. oki [...] [...], Ilayun tögösügsēn
- 9а-11. xamiʼya bui tere жүг тү alixa xabsurčī
- 9а-12. söǵüdün, jöüdün dü ali kenggergeyin
- 9а-13. döün ēce üjүүлүgsēn šülüg sono
- 9а-14. suqsan tedeni ayiladxabai, Suduriyin
- 9а-15. ayimayiyin erketü xān dēdү gerel ēce,
- 9а-16. jöüdү üjesgēn bölöǵ kemēkü inү
- 9а-17. ʼutayar bui.
- 9а-18. Nige söni alyasal ügei čү, minү jöüdү
- 9а-19. jöüdүlүgsēn, üjesküʼlengtei
- 9а-20. yeke kenggerge üjen, xamuʼy tu altani
- 9а-21. gerel, Yamāru naran metү badaran, бүкүндү
- 9а-22. gegēreküi todorxoi, arban жүг
- 9а-23. noyöüd tu gegēren üyiledčī, Bükүндү
- 9а-24. erdeni moduni dergede, [...]
- 9а-25. erdeni širēdү, burxan noyöüd soün,
- 9а-26. olon mingʼyan joün, nöküd dunda
- 9а-27. ʼarxui üjebei, Biramani dürsün ene

9а. Кирилл үсгийн хөрвүүлэг

9. Ес

- 9а-1. Шөнийг дуусаад, хааны харшийн их
- 9а-2. авхуй балгадаас гарч, олон мянган
- 9а-3. амьтантай хамт газар цогц уул
- 9а-4. хаа хийгээд, ялгуун төгсөн үлсэн
- 9а-5. хаа буй тэнд одон хүрээд, ялгуун
- 9а-6. төгссөний өлмийд тэргүүгээр
- 9а-7. мөргөж, ялгуун төгссөний гурван -
- 9а-8. таа эргэн үйлдээд, нэгэн зүгт суу -
- 9а-9. вай. Нэгэн зүгт суугаад үзэсгэлэн
- 9а-10. охь [...] [...], ялгуун төгссөн
- 9а-11. хаа буй тэр зүгт алга хавсарч
- 9а-12. сөгдөн, зүүдэнд аль хэнгэргийн
- 9а-13. дуунаас үзүүлсэн шүлэг сон -
- 9а-14. ссон тэднийг айлтгавай. Судрын
- 9а-15. аймгийн эрхэт хаан дээд гэрлээс
- 9а-16. зүүд үзсэн бүлэг хэмээх нь
- 9а-17. гутгаар буй.
- 9а-18. Нэг шөнө алгасал үгүй ч, миний зүүд
- 9а-19. зүүдэлсэн, үзэсгэлэнтэй
- 9а-20. их хэнгэргэ үзэн, хамагт алтны
- 9а-21. гэрэл. Ямаару наран мэт бадран, бүхэнд
- 9а-22. гэгээрхүй тодорхой, арван зүг
- 9а-23. нүгүүдэд гэгээрэн үйлдэж, бүхэнд
- 9а-24. эрдэнэ модны дэргэд, [...]
- 9а-25. эрдэнэ ширээд, бурхан нугууд суун,
- 9а-26. олон мянган зуун, нөхөд дунд
- 9а-27. гарахуй үзвэй. Бирманы дүрс энэ

9a-28. metü kü, *Yeke kenggerge sayitur*
deledküi
9a-29. üjebei, Tere töüni deledügsen dü
9a-30. šülüg ede yarbai. Dēdū altan
gereliyin
9a-31. yeke kenggergeyin doün iyār yurban
mingyan
9a-32. yertünčü yurban yertünčü ende,
9a-33. moü amitanı jobulong kigēd erli
9a-34. giyin jobulong, yadoügiyin

9a-28. мэт хө. *Их хэнгэргэ сайтар*
дэлдэхүйг
9a-29. үзвэй. Тэр түүнийг дэлдсэнд,
9a-30. шүлэг эд гарвай. Дээд алтан
гэрлийн
9a-31. их хэнгэргийн дуунаар гурван
мянган
9a-32. ертөнц гурван ертөнц энд,
9a-33. муу амьтны зовлон хийгээд эрлэ -
9a-34. гийн зовлон, ядуугийн

№18



96. Эрдэм шинжилгээний галиг

96-1. jobulong хоцорли ügei amurlaxu
96-2. boltuyai, yeke kenggergeyin oki doün
96-3. öün iyēr, yertünčüyin xamuγ mungxay
96-4. amirlaxu boltuyai, Yamāru čidayči
96-5. erketü ayoül ügei ayoül amirlaqsan
96-6. metü, Amitan ayoül ügei ayoül ēče
96-7. xayačaxu boltuyai, Yamāru orčilong
96-8. du xamuγi medegči čidayči erketü
96-9. yaruqsani erdem бүгүде төгүсүgsen
96-10. metü, yesün *törölkitön diyān* [...]
96-11. yin gešöün iyēr, erdem төгүсүн erde
96-12. miyin dalaı boltuyai, Yeke kenggergeyin
96-13. oki doün öün iyēr, Xamuγ amitan
96-14. esürüni egešig төгүсүн, *burxani*
96-15. *dēdū manglai* [...] du kürkü boltuyai,
96-16. Nomiyn kürdü buyan tai ergiülkü bol
96-17. tuyai, Sedkiši ügei yalab tu soüxu


96. Кирилл үсгийн хөрвүүлэг

96-1. Зовлон хоцрол үгүй амирлах
96-2. болтугай. Их хэнгэргийн охь дуун
96-3. үүнээр, ертөнцийн хамаг мунхаг
96-4. амирлах болтугай. Ямаару чадагч
96-5. эрхэт аюул үгүй аюул амирласан
96-6. мэт, амьтан аюул үгүй аюулаас
96-7. хагацах болтугай. Ямаару орчлон -
96-8. д хамгийг мэдэгч чадагч эрхэт
96-9. гарсны эрдэм бүгд төгссөн
96-10. мэт. Есөн *төрөлхтөн* даян [...]
96-11. ийн гишүүнээр, эрдэм төгсөн эрдэ -
96-12. мийн далай болтугай. Их хэнгэргийн
96-13. охь дуун үүнээр, хамаг амьтан
96-14. эсрүүний эгшиг төгсөн, *бурхны*
96-15. *дээд* манлай [...] – д хүрэх болтугай.
96-16. Номын хүрд буянтай эргүүлэх бол -
96-17. тугай. Сэтгэш үгүй галавт суух

96-18. boltuṣai, Amitan du tusa bolxuyin tula
 96-19. nom ču üjүүлкү boltuṣai. [...]
 96-20. darun üyiledči jobulong arilxu
 96-21. boltuṣai, tačāngyui urin mungxaṣ
 96-22. amirlaxu boltuṣai, Ali amitan moü
 96-23. jāyātani ʔajartu orošiju, yasun
 96-24. beyetü ʔaliyin nilči maši badaraqči
 96-25. tede kenggerge doürisxaxui sonos
 96-26. xu boltuṣai, *Burxan du mörgümüi*
kemē
 96-27. kü oki sonosxu boltuṣai, Amitan бүгү
 96-28. de ʔöin töröl kigēd, [...]
 96-29. mingyan töröl dü töröl iyēn sanaxu
 96-30. boltuṣai, Čidaqči erketü yi nasuda
 96-31. sanaxu boltuṣai, Tedeni aṣui yeke
 96-32. ʔarliṣ sonosxu boltuṣai, Yeke kengger
 96-33. geyin oki doün öün iyēr burxan
 96-34. noṣöüd luṣa nasuda
 96-35. nöḡöcöküi olxu

96-18. болтугай. Амьтанд тус болохын тул
 96-19. ном ч үзүүлэх болтугай. [...]
 96-20. даран үйлдэж зовлон арилах
 96-21. болтугай. Тачаангуй урин мунхаг
 96-22. амирлах болтугай. Аль амьтан муу
 96-23. заяатныг газарт оршиж, ясан
 96-24. биет галын нилч маш бадрагч
 96-25. тэд хэнгэргэ дуурьсахуйг сонс -
 96-26. х болтугай. *Бурханд* мөргөмүй
 хэмээ -
 96-27. х охь сонсох болтугай. Амьтан бүг -
 96-28. д зуун төрөл хийгээд, [...]
 96-29. мянган төрөлд төрлөө санах
 96-30. болтугай. Чадагч эрхтийг насад
 96-31. санах болтугай. Тэдний агуй их
 96-32. зарлиг сонсох болтугай. Их хэнгэр -
 96-33. гийн охь дуун үүнээр бурхан -
 96-34. нугууд лугаа насад
 96-35. нөхцөхүйг олох

№19



10а. Эрдэм шинжилгээний галиг


10. Arban
 10a-1. boltuṣai, Kilencetü üyile noṣöüdi
 10a-2. teyin tebčikü boltuṣai, Üyile buyn
 10a-3. noṣöüdi edlekü boltuṣai, Kümün tengge
 10a-4. ri kigēd xamuṣ amitan бүгүде, tedeni sed
 10a-5. kil kigēd iröl ali bui, Yeke kenggerge
 10a-6. yin oki doün öün iyēr, tedeni tede
 10a-7. бүкүн бүтүкү boltuṣai, Ali amitan tесеši

10а. Кирилл үсгийн хөрвүүлэг.

10. Арван.
 10a-1. болтугай. Хилэнцэт үйл нүгүүдийг
 10a-2. тийн тэвчих болтугай. Үйл буян -
 10a-3. нугуудыг эдлэх болтугай. Хүн тэнгэ -
 10a-4. р хийгээд хамаг амьтан бүгд, тэдний сэт -
 10a-5. гэл хийгээд ерөөл аль буй. Их хэнгэргэ -
 10a-6. ийн охь дуун үүнээр, тэдний тэд
 10a-7. бүхэн бүтэх болтугай. Аль амьтан тэсэш

10a-8. ügei tamuyin amitan du törögsön, beye
 10a-9. dü ɣaliyin nilči bükündü maši badaran,
 10a-10. *ibēl ügei ɣasalun üyiledči oyōto*
 10a-11. tenügseni, ɣal noyōüdi tede maši amurli
 10a-12. xu boltuɣai, Tamu biridiyin amitan
 kümüni
 10a-13. yertünčü dü, teskel ügei küčir jobu
 10a-14. longtoi ali amitan, yeke
 kenggergeyin oki
 10a-15. doün öün iyēr, tedeni jobulong бүгү
 10a-16. de amirlaxu boltuɣai, Šütē ügei ömō
 10a-17. sadun ügei, ibēl ügei čü boluqsan tede
 10a-18. ni ibēgčī kigēd šütēn, ömō saduni
 10a-19. dēdū bi boltuɣai, *Xoyor kültüni dēdū*
 10a-20. *burxan*, sedkil enerigčī nigüülesküi
 10a-21. tögüsügen sedkil tü, ali arban
 10a-22. жүгийн yertünčü dü, soüqčī namai
 10a-23. ayildun soyirxo, Mini urida kelin
 10a-24. čе тү üyile, Maši teskeši ügei ali
 10a-25. üyildügen, Tede xamuɣ iyān arban
 10a-26. küčütüyin, nidüni emüne bi odji
 10a-27. namančilan üyiledümüi, Ečige ekedü
 10a-28. ülü bariqčī kigēd, *burxan* noyōüd
 10a-29. tu ülü bariqčī, buyan noyōüd tu
 10a-30. ülü barin, kilenče mini ali üyile
 10a-31. dügsen, Bayan čaduraxui
 10a-32. bēr omorxoqson, ijour
 10a-33. kigēd ɣarɣalang iyār
 10a-34. čaduraqsan külgün iyēr
 10a-35. čaduran omorxoqson iyēr

10a-8. үгүй тамын амьтанд төрсөн, бие -
 10a-9. д галын нилч бүхэнд маш бадран,
 10a-10. *ивээл үгүй* гаслан үйлдэж огоот
 10a-11. тэнэснийг, гал нугууд тэд маш амирла -
 10a-12. х болтугай. Там бирдийн амьтан
 хүний
 10a-13. ертөнцөд, тэсгэл үгүй хүчир зов -
 10a-14. лонтой аль амьтан, их хэнгэргийн
 охь
 10a-15. дуун үүнээр, тэдний зовлон бүг -
 10a-16. д амирлах болтугай. Шүтээ үгүй өмөө
 10a-17. садан үгүй, ивээл үгүй ч болсон тэд -
 10a-18. нийг ивээгч хийгээд шүтээн өмөө садны
 10a-19. дээд би болтугай. *Хоёр хөлтний дээд*
 10a-20. *бурхан*, сэтгэл энэрэгч нигүүлсэхүй
 10a-21. төгссөн сэтгэлт, аль арван
 10a-22. зүгийн ертөнцөд, суугч намайг
 10a-23. айлдан соёрх, миний урьд хилэн -
 10a-24. цэт үйл, маш тэсгэш үгүй аль
 10a-25. үйлдсэн, тэд хамгаа арван
 10a-26. хүчтийн, нүдний өмнө би одож
 10a-27. наминчлан үйлдмүй. Эцэг эхэд
 10a-28. үл баригч хийгээд, *бурхан* нугууд -
 10a-29. д үл баригч, буян нугуудад
 10a-30. үл барин, хилэнц миний аль үйл -
 10a-31. дсэн, баян чадархуй -
 10a-32. аар оморхсон, ёзоор
 10a-33. хийгээд жаргалангаар
 10a-34. чадарсан, хөлгөнөөр
 10a-35. чадран оморхсоноор

**106. Эрдэм шинжилгээний галиг**

- 106-1. mini kilenče ali üyiledügsen, buruü
- 106-2. ögüülegsen buruü sedkigsen, buruü
- 106-3. üyiledügsen üyile noγoüd
- 106-4. kigēd, buruü sedkigsen dü ese
- 106-5. üjegsen iyēr, mini kilenče ali üyi
- 106-6. ledügsen, *Nilxayin oyoün iyār oroq*
- 106-7. son kigēd, ülü medeküi xarangyui
- 106-8. sedkil, kilenče tü nököriyin erkēr
- 106-9. boluqsan kigēd, [...] teyin dayiba
- 106-10. luqsan sedkil, nādun bayasxuyin erkēr
- 106-11. ɣasalang kigēd ebečini
- 106-12. erkēr boluqsan, ed iyēr ülü böliłökü
- 106-13. yi gem iyēr, mini kilenče ali üyiledüg
- 106-14. sen, ɣaruqsan busu törölkitön lugē
- 106-15. neyilegsen, üjē yadaxui xaramiyin ündü
- 106-16. sün kigēd, mekeleküi kigēd yadoügiyin gem iyēr,
- 106-17. mini kilenče ali üyiledügsen, Yadoü
- 106-18. boluqsan *ɕay üydü*, küsel noγoüdi
- 106-19. yin ayoüliyin ündüsün kigēd,
- 106-20. bayan busu boluqsan iyār, mini
- 106-21. kilenče ali üyiledügsen, Kelbe
- 106-22. riküi sedkiliyin erkēr boluqsan,
- 106-23. küsel kigēd kilinggiyin erkēr

106. Кирилл үсгийн хөрвүүлэг.

- 106-1. миний хилэнц аль үйлдсэн, буруу
- 106-2. өгүүлсэн буруу сэтгэсэн, буруу
- 106-3. үйлдсэн үйл нүгүүд
- 106-4. хийгээд, буруу сэтгээнд эс
- 106-5. үзсэнээр, миний хилэнц аль үй -
- 106-6. лдсэн. *Нялхын оюун* - аар ор -
- 106-7. сон хийгээд, үл мэдэхүй харангуй
- 106-8. сэтгэл, хилэнцэт нөхрийн эрхээр
- 106-9. болсон хийгээд, [...] тийн дайв -
- 106-10. лсан сэтгэл, наадан баясахын эрхээр
- 106-11. гаслан хийгээд өвчний
- 106-12. эрхээр болсон, эдээр үл бөлилөх
- 106-13. ийг гэмээр, миний хилэнц аль үйлд -
- 106-14. сэн, гарсан бус төрөлхтөн лүгээ
- 106-15. нийлсэн, үзээд ядахуй хармын үнд -
- 106-16. сэн хийгээд мэхэлхүй хийгээд ядуугийн гэмээр,
- 106-17. миний хилэнц аль үйлдсэн. Ядуу
- 106-18. болсон *цаг үед*, хүсэл нүгүүд -
- 106-19. ийн аюулын үндсэн хийгээд,
- 106-20. баян бус болсноор, миний
- 106-21. хилэнц аль үйлдсэн. Хэлбэ -
- 106-22. рихүй сэтгэлийн эрхээр болсон
- 106-23. хүсэл хийгээд хилэнгийн эрхээр

106-24. boluqsan, ölösügsen undāsuq
106-25. sani gem iyēr, mini kilenče ali
106-26. üyiledügsen, *Idē kigēd* undā
106-27. nayijiriyin ündüsün kigēd xub
106-28. časuni tula, [...] eldeb
106-29. enelgen iyēr, mini kilenče ali
106-30. üyiledügsen, Beye kelen
106-31. kigēd sedkiliyin kilenče,
106-32. gemtei üyiledüg
106-33. sen yur ban

106-24. болсон, өлссөн ундаас -
106-25. саны гэмээр, миний хилэнц аль
106-26. үйлдсэн. *Идээ хийгээд* ундаа
106-27. найжирын үндсэн хийгээд хув -
106-28. цасны тул, [...] элдэв
106-29. энэлгэнээр, миний хилэнц аль
106-30. үйлдсэн. Бие хэлэн
106-31. хийгээд сэтгэлийн хилэнц
106-32. гэмтэй үйлд -
106-33. сэн гурван.

(Үргэлжлэл бий.)

НОМ ЗҮЙ

Ганболд, Д., «Бичиг соёлын төв»-д буй монгол, төвөд судрын гарчиг, бичвэрийн тодорхойлолт, Уб., 2012, 4

Түвшинтөгс, Б., Тод бичгийн модон барын дурсгалын судалгаа, Уб., 2024, 256

Шагдарсүрэн, Ц нар., Үсэг зүй, Монгол хэл судлал VII боть, Уб., 2022, 113-129



1990-ЭЭД ОНЫ МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ ДАХЬ ХОТЫН УРАН ЗОХИОЛЫН ШИНЖ

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн хүүрнэл зохиолуудын жишээн дээр

Цогтбаатарын ТӨГСБААТАР

МУИС. ШУС. ХУС.

Утга зохиол судлалын IV курсын оюутан

Удирдагч багш: Г. Нандинбилиг, доктор (Ph.D), профессор

Агуулгын товч: “Хүрээ хөвгүүд” бүлгэм нь 1990-ээд оны Монголын уран зохиолын төлөөлөгчдийн нэг юм. Бид энэхүү судалгааны ажилдаа “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүдийн бүтээлээс хотын уран зохиолын шинжтэй бүтээлүүдийг задлан шинжилсэн бөгөөд тайлан тайлбарлах, нэгтгэн дүгнэх аргыг ашиглахыг зорив.

Түлхүүр үгс: “Хүрээ хөвгүүд” бүлгэм, хүүрнэл зохиол, өгүүллэг, хот, хотын уран зохиол, монголын уран зохиол

УДИРТГАЛ

Монголын уран зохиолд 1990-ээд онд нийгмийн шилжилт, улс төрийн дэглэмийн өөрчлөлттэй холбоотойгоор олон уран зохиолын нэгдэл, бүлгэм тодрон гарсны нэг нь “Хүрээ хөвгүүд” бүлгэм юм. Монголын уран зохиолын шинэчлэл өөрчлөлт буюу олон ургалч үзэл хандлага руу давшсан хөдөлгөөн, сэдэв “чөлөөт” болсноор тэндээс гарсан яруу найраг, хүүрнэл болон жүжгийн зохиол, түүнээс улбаалан тэсрэлтийн, эрэлхийллийн, төөрөгдлийн үе гэх зэрэг нэршил авах болсон нь тухайн үеийн төлөөллийг сонгох шалтгаан болж байна.

“Хүрээ хөвгүүд” бүлгэм нь “Замдаа гарцгаая...хүрээ хөвгүүдээ” (1997) бүтээлдээ хотын уран зохиол, хотын яруу найраг бичих нь тэдний гол зорилго хэмээн онцолжээ. Хотын уран зохиол судлагдах шаардлагатай болсныг судлаач С. Энхбаяр “Ерөөс хотын уран зохиол нь МУЗ-ын салшгүй нэгэн хэсэг төдийгүй, хэлбэр, агуулга, төрөл зүйл, хэл найруулга, бүтэц, үзэл санаа гэх мэт агуулга,

туурвил зүйн бүх төвшинд тодорхой бие даасан судалгаа, үнэлэлт дүгнэлт шаардсан нэгэн өвөрмөц цогц судлагдахуун нэгэнт буй болсон байна” (Энхбаяр, 2021, 454-455) гэжээ. Энэхүү судалгаанд хотын уран зохиол хэмээх ойлголтыг шинжлэн, “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүдийн хотын уран зохиолын шинж бүхий бүтээлүүдээс задлан шинжилж тайлан тайлбарлахыг зорилоо.

Уран бүтээлийн нэгдлүүдийн тухай профессор Д. Галбаатар “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд” (2001) нэрт ганц сэдэвт бүтээлдээ “Монголын нэн шинэ үеийн утга зохиолд орчин үеийн модерн уран зохиолыг тойрсон маргаан намжаагүй л байна. Энэ нь нэг талаас, уран бүтээлийн арга барилын чиг хандлага, тэдгээрийн нэгдлийг тунхагласан зохиолчдын төрөл бүрийн дугуйлан, нэгдэл, уран зохиолын янз бүрийн урсгалууд цагийн эрхээр үүссэнтэй холбоотой юм. Нөгөө талаас XX зууны хоёрдугаар хагасын Монголын утга зохиолд баттай байр суурийг эзэлсэн онол, арга зүйн хуучин хил хязгаарыг гатлах боломж бололцоог эрэлхийлсэн шинэ зууны зохиолчдын бүтээлч санааны философи болон соёл судлалын чиглэл гэж авч үзэж болно” (Галбаатар, 2001, 89) гэж тэмдэглэжээ.

Монголын уран зохиол дахь хотын шинжийг судлаач М. П. Петрова “Хорин нэгдүгээр зууны эхэн үеийн Монголын яруу найраг дахь хот” (2011) өгүүлэлдээ “XXI-р зууны эхэн үеийн Монголын яруу найраг ихэнхдээ хот төлөвлөлт, шалтаг шалтгаан, дүр төрхийг илэрхийлэх болсныг тэмдэглэх хэрэгтэй” (Петрова, 2011, 25) гэж дүгнэжээ.

Профессор Д. Галбаатар “Уран зохиол” нэвтэрхий толь (2012) бүтээлдээ “Дэлхий нийтийн уран зохиолд томоохон хотууд бий болж, хүмүүс нийтээрээ нэг дор амьдрах болж, хүмүүс олноороо суурьшмал соёл иргэншилд эрчимтэй шилжиж, соёл, ажил үйл, амьдрал ахуйн хэв маяг түүний хэрээр өөрчлөгдөж эхэлсэн IX зууны үеэс европын том хотын хөгжил урлаг уран зохиолд нөлөөлснөөр “хотын урлаг”, “хотын уран зохиол” хэмээх ойлголт бий болж, өвөрмөц ялгарал, аян дан, өгүүлэмж, дүр бүхий бие даасан төрөл зүйлүүд үүсэж хөгжжээ. Хотын уран зохиол нь хот, суурины тухай өгүүлсэн зохиол бус хот суурины хүн зоны иргэншил, аж төрөх ёс, маяг, зан суртахуун, амьдралын хэмнэлийг өөртөө гүн гүнзгий шингээсэн уран бүтээлийн ай хүрээг нийтэд нь илэрхийлнэ” (Галбаатар, 2012, 470-471) хэмээн хотын уран зохиол гэх ойлголтыг тодорхойлжээ.

Мөн профессор С. Энхбаяр “Урбанизм” буюу “Хотын уран зохиол” нь XXI зууны Монголчуудын үнэт зүйлийн өөрчлөлтийн нэг толь мөн (2017) өгүүлэлдээ Б. Галсансүх, Л. Моломжамц, Г. Сүхзориг нарын нэг нэг шүлгийн жишээг задлан шинжлээд, “Хотын уран зохиолын хамгийн нийтлэг шинж нь зохиролт

бус шинжийг агуулдаг” гэж дүгнэн түүнийгээ 8-н шинжид хуваан үзжээ. Үүнд:

1. Цаг хугацаа- орон зайн дүрслэлийн хувьд үлэмж явцуу
2. Агуулгын хувьд үлэмж хаос шинжтэй
3. Түгээмэл үнэмлэхүй жам ёсны хувьд абсурд чанартай
4. Үнэт зүйлийн үнэлэмжийн хувьд гоо сайхны сонгодог зохирол нь алдагдсан
5. Постмодерн соёлын хамгийн гол шинжийг агуулсан
6. Гоо сайхны үндсэн шинж нь дисгармония буюу зохицолгүй шинжтэй
7. Орчин цагийн хотын уран зохиолын гол дүр нь виртуал орчинд амьдарч аж төрөх болсон “Е-хүн” буюу “Хотын хүн”
8. Монголчуудын нүүдэлчин удмаас шалтгаалан орчин цагийн хотын яруу найраг нь ихээхэн хэмжээгээр сентименталь өнгө аяс, утга агуулгатай (Энхбаяр, 2021, 447-462).

Хотын уран зохиолын шинжтэй бүтээлүүдийг түүвэрлэн цуглуулж, задлан шинжилж, мөн хотын уран зохиол гэх ойлголтыг тодруулахдаа “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн уран бүтээлийн жишээн дээр авч үзэх нь энэхүү ажлын зорилго болно. Бид “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн 1990-2000 оны хооронд хэвлэгдсэн бүтээлүүдээс буюу хамтын бүтээл болох “Замдаа гарцгаая...хүрээ хөвгүүдээ” (1997) номоос хүүрнэл зохиолыг эх хэрэглэгдэхүүн болгон ашиглана. “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн бүтээлүүдийг цогцоор нь судалсан судалгаа одоогоор байхгүй байна. Тиймээс 1990-ээд оны энэхүү “содон” төлөөллийн жишээн дээр судлах ажлыг эхлүүлэх хэрэгтэй гэж үзсэн болно. Хотын уран зохиолын судалгаа нь судалгааны эргэлтэд төдийлөн ороогүй ба эрдэмтэн судлаачдын дунд онолын маргаантай сэдэв билээ. Хотын уран зохиол гэх ойлголтыг гүнзгийрүүлэн судалснаар цаашдын судалгаануудад суурь жишээ болох ач холбогдолтой билээ. Мөн хотын уран зохиолыг судалснаар орчин үеийн зохиолч, уншигчдад зохиол бүтээлийг тайлах, бүтээлчээр ашиглах туурвил зүйн жишээ болох юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хотын уран зохиол нь хот, суурины тухай өгүүлсэн зохиол бус хотын хүний аж төрөх ёс, зан суртахуун, ертөнцийг үзэх үзэл, сэтгэл зүйн байдал, амьдралын хэмнэлийг өөртөө шингээсэн байдаг. “Зохиолчоос бүтээлдээ илэрхийлэх гэсэн утга санаа үзэл саналаа хурц тодоор гаргаж чадах үнэн байдал, хүний аж төрөл, харилцаа холбоог санаанаасаа туурвин зохиож эмхлэхийг зохиолчийн уран санаа гэнэ” (Гаадамба, 1989, 42-43). Уран санаа хэдий зохиолчийн хувийн зүйл

байж болох ч цаанаа амьдралыг уран сайхнаар төлөөлүүлэн үзүүлсэн байдаг. “Утга зохиол нь амьдралыг “дүрсэлдэг”, хэдийгээр уран зохиолын “дуурайлган дүрсэлдэг” тэр зүйлс хувь хүний дотоод субъектив ертөнц, байгаль дэлхий, гадаад ертөнц ч байж болох ч энэхүү амьдрал гэдэг нь өргөн утгаараа нийгмийн амьдралыг хэлсэн хэрэг юм” (Уэллек, Уоррен, 2015, 68). Тиймдээ ч аливаа зохиолд санаатай болон санамсаргүйгээр цаг үеийн дүр төрхийг нээн илрүүлж орчин, уур амьсгалаар дамжуулан хүргэдэг байна.

Уран зохиолын нэгэн төрөл болох хүүрнэл зохиол, түүний нэгэн зүйл буюу өгүүллэгт “...нэг асуудал, нэг үйл явдал дээр гол анхаарал нь төвлөрч, байр суурь, зан төрх нь төлөвшчихсөн баатруудын хамгийн эгзэгтэй үеийг сонгон авч дүрслээд түүгээрээ ямар нэг санаа бодлыг илэрхийлдэг” (Галбаяр, 2002, 163) болно. Түүнчлэн судлаачид өгүүллэгийг авч үзэхдээ “Хүний зан байдлын хувирч байгааг дүрслэвч чухамхан хувирч байгаа үеийн нь эрс эргэлтийг дүрслэхээс, түүний хувьсах явцыг дэс дараалан гаргаж чаддаггүй” (Гаадамба, 1989, 199) хэмээгээд “Өгүүллэгт хүний амьдралын үзэгдлийг өчүүхэн хэсэг дээр нь дүрслэн үзүүлнэ” (мөн тэнд, 1989, 199) гэжээ. Хүүрнэл зохиолын хүрээнд “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүдийн (Б. Бадрал, Д. Дашмөнх, Г. Батнасан) өгүүллэгүүдэд буй хотын уран зохиолын шинжийг авч үзье.

2.1 Зохиолууд дахь хотын хүний дүр (зан төрх) ба үйл явдал

Дүрийн тухай ойлголтыг ерөөс “Урлаг хүний зан чанарыг уран сайхны дүрээр дамжуулан өөр ямар ч шинжлэх ухаан судалж чадахааргүйгээр тийм гүнзгий ухааран таньдаг” (Галбаяр, 2002, 78) гэж ойлгож болох юм. Нарийвчилбал судлаач С. Байгалсайхан дүрийн тухай дагнан судалгаа хийж “Уран дүр гэдэг маань эцсийн эцэст “А бол Б шиг юм” гэсэн томъёолол бөгөөд амьдрал түүний үзэгдэл юмсын шинж чанарыг А гэж үзвэл Б гэсэн түүний төлөөлөл, харьцуулал, тодорхойлол, бэлгэдэл мэтийн үндсэн аргуудаар илэрхийлэгдсэн цогц гэж ойлговол зохино” (Байгалсайхан, 1998, 5) гэж тодорхойлсон бөгөөд “Урлаг, уран зохиолын туйлын шинж, гол зорилго бол уран сайхны үлэмж төгс дүр бүтээх явдал юм” (Галбаяр, 2002, 72) хэмээн үзэж байна.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Б. Бадралын “Тагтны уянга” (1994) өгүүллэгт дүр нэгдүгээр биеэс дан дотоод бодрол (монолог) болж хүүрнэх бөгөөд хотын барилгын арван хоёр давхрын тагтан дээр зогсож буйгаар зохиол өрнөнө. Дүр хотыг толгойдоо эргэцүүлэн байхдаа эндээс үсэрвэл яах бол хэмээн тунгааж, түүнээсээ “аугаа сэрэл” авч байна хэмээгээд шүлсээ хаях, ерөөс энэ шүлс шиг үсэрчихвэл, тэгээд үүнийхээ тухай шүлэг бичвэл гэх зорилго тээж буйгаа хэлнэ.

Шүлстэй ХАМТ бус ӨӨРӨӨ доошоо үсэрье дээ. Хэн ч бичээгүй шүлэг бичнэ, “Доорд этгээдэд зорчсон тэмдэглэл”. Зүүнээ тавиад, баруун хөлөө шидээд “Хүү-үү-ү”... Ер нь би арван хоёр давхраас үсэрчихлээ л дээ. Хачирхалтай нь унаж буй мөртөө өөдөө өгсөж байх юм. Өө! Тэнгэр хөл доороос холдон холдох юм. Би уруугаа харжээ. За даа, агуу сэрэл дээ, өлгөсөн борц, улаан цамц уранхай шуудай... Ер нь юу юу байна аа? Цагаан дотуур өмд жаахан шарлачихсан, Хи хи, Вааг вааг. Болжмор жиргээд л... Жиргээж л бай маргааш би нэг... Харин ямар үзгээр бичих вэ? Нял-л!... Хамгийн сүүлчийн агиинд тийм ч нарийн бус, саарал засмал дээр, том нохой, хүүхдийн хажууд унахдаа тэрээр бичгийн ширээ, хар цайнд харласан эмтэрхий шаазан, чихрээ хутгадаг зунгааралдсан наалдангитай халбага дээр нь зүүрмэглэх ялаагаа төсөөлж амжлаа. Тэрээр одоо нам үхсэн бөгөөд агуу сэрлийнх нь тухай хэн ч мэдсэнгүй. Тийм гэж үү! Хэн мэдлээ! Хэн мэдлээ! (Батхуяг нар, 1997, 56-57).

Дээрх хэсэгт дүрийн дотоод зөрчил хийгээд хүсэл зорилгодоо хүрэх замыг дүрийн үхлээр шийдсэн нь харагдана. Дүр үхлээ анзааран түүнээсээ зугтах, тэмцэх зэрэг үйлдэл хийгээгүй бөгөөд хувь хүний гоо зүйн ялгамжтай байдал, угтаа бүхнээс цэнгэл таашаал(зохиолд сэрэл гэж бичсэн) авахаа больсон зан төрхийг хотын хүний дүрээр харуулжээ.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Д. Дашмөнхийн “Хөлийн чимээ” (1991) өгүүллэгт зохиолын дүр Бадам хотын нэгэн эмнэлэгт хэвтрийн байдалтай эмчлүүлж байгаагаар гарна. Түүний өрөөний хамтрагч Бат гэх дүр босон алхаж чадах нэгэн бөгөөд оройн цагаар бөх гэгч унтдаг хэмээн зохиолд хэлнэ. Зохиолыг гуравдугаар биеэс хүүрнэн өгүүлэх ба Бадамын дүрийн сэтгэлзүйн шинжийг тодоор гарган үзүүлжээ.

Өнөөх хөлийн чимээ дахин гарав. Хонгилын мухарт үл таних бүсгүй гадсан өсгийт гутлаа тог тог хийлгэн, шал товишин алхаж гарлаа. Уржигдар, өчигдрийнхийг бодвол илүү тод сонсогдож байна. Өвчтөн сахиж буй хүн л сэтгэл нь тавгүйтэхээр хойш урагш холхиж байна даа янз нь. Өмнөх хоёр шөнө шиг бас л энэ чимээг сонссоор үүр цайлгах нь гэж санамагц сэтгэл нь эвгүй болчихлоо. Хэн яваад байгаа юм бол? Бадам өндийж ч эс дөнгөх тул хий дэмий өөдөө тааз ширтэн, тачигнасан хөлийн чимээг чагнасаар шөнийг барахдаа ганц л зүйлийг сайтар ойлгов. Энэхүү хөлийн чимээ учир битүүлгээсээ илүү ер бусын ажээ. Сэтгэл нь эгэл бусаар үүлгэртэж тэгснээ учиргүй оволзоно (мөн тэнд, 1997, 81).

Дээрх хэсэгт өгүүлснээр Бадам шөнө бүр хэн нэгэн хонгилын үзүүрт өсгийт гутлаараа шал товшин алхахыг сонсож буйгаар эхэлнэ. Энэхүү зохиолын зангилаа үргэлжилж өнөөх хөлийн чимээ шөнө бүр улам ойртон сонстоно. Тэрхүү чимээнд Бадамын сэтгэлзүй ер бусын “сайхан” мэдрэмж авах ч сэтгэлийн дарамт мэдэрсээр байна. Тэгж явсаар нэгэн шөнө өрөөний хамтрагч Батыг сэрээн өнөөх хөлийн чимээг чагнуулбаас Бат юу ч сонсохгүй байгаагаа хэлэх бөгөөд гарч шалган хэн ч байхгүй байгааг Бадамд хэлнэ. Гэлээ ч Бадам өнөөх чимээг сонссоор буйгаа гайхан бодож эмчээс асуувал хонгил дүүрэн хивс дэвссэн байгаа тийм чимээ гарах учиргүйг дуулгадаг. Зохиолын төгсгөлд чимээ өрөөнд орж ирэн хэвтрийн өвчтөн байсан Бадам эрүүл болсон мэт босож цонх цохин хагалаад үсэрч амиа хорлосноор зохиол төгсөнө.

Энэхүү өгүүллэгт хөлийн чимээгээр төлөөлүүлэн Бадамын дотоод сэтгэлийн дарамт хэрхэн түүнд нөлөөлж байгааг харуулсан байна. Зохиолд хөлийн чимээг хүсэмжлэн хүлээх болсноор бусдад биш зөвхөн Бадамд хамаарах сэтгэлзүйн хүнд зовнил, зөрчил туйлдаа хүрснийг мөн адил дүрийн үхлээр шийджээ.

Мөн Д. Дашмөнхийн “Зэрлэг нохой” (1995) өгүүллэгт хувь хүний дотоод зөрчил хийгээд хотын их хэмнэлээс улбаалан гарах зан төрхийн шинжийг тусган үзүүлжээ. Зохиолд “Би” болон Очир гэх хоёр дүр нэгэн өдрийн тэмдэглэл орцноосоо олсноор эхлэх бөгөөд гол үйл явдал тэрхүү өдрийн тэмдэглэлд гарч буй зүйлс юм. Тэмдэглэлд нэгэн залуу Жаргал гэх бүсгүйтэй ханилан аз жаргалтай амьдарч болох хэдий ч ядуу зүдүү амьдрал, цаашлаад дүү нараа өсгөх хүнд ачаа нь сэтгэлийн дарамт болж буйг өгүүлнэ. Зохиолд,

Гэтэл авсан цалин маань байрны хөлсөө төлж хэдэн өнчин дүү нараа тэжээхэд, бас өдөрт долоон ширхэг тамхи татаж, хааяа нөхөдтэйгөө нийлж дарвихад маань чүү чамай хүрдэг (мөн тэнд, 1997, 101),

болон

Орчлонгийн юм бүхэн мөнгөөр хэмжигдэх болохоор би ажиллах хэрэгтэй. Би хэдий чинээ тэвчээртэй зогсож, хэдий чинээ олон арьс цуглуулна вэ? төдий чинээ их мөнгө олно (мөн тэнд, 1997, 103),

мөн

Яагаад өөрийнхөө хүслээр амьдарч болохгүй, юм бүхний өмнө тэр дундаа амьдралаа хамтдаа туулна гэж найдаж буй бүсгүйнхээ өмнө бөхөлзөх учиртай төрөө вэ? гэж гуниглан бодож байна. Би энэ амьдралаас залхаж гүйцсэн. Би бусдын төлөө өөрөө чармай шалдан зүтгэх гэж төрсөн машин юм уу? (мөн тэнд, 1997, 104)

гэх зэргээр тэмдэглэлийн эзний хот буюу суурьшмал соёлын дарамт шахалт, нийгмийн тогтолцоотой зөрчилдөх зан төрхийг тодоор гаргажээ.

Энэхүү дотоод болон гадаад зөрчлүүд нь явсаар тэмдэглэлийн эзэн Жаргал гэх хайртай бүсгүйгээ алах шийдвэр гарган ойн гүнд модонд хүлэн “зэрлэг ноход” идэг хэмээн үлдээснээр тэмдэглэл дуусдаг. Зохиолд гарч буй тухайн дүр нийгмийн дарамт шахалт, соёлын хүлээсэнд баригдан эцэстээ хүний ёсонд баймгүй зүйл хийж байгаа нь ерөөс хотын хэмнэл, суурьшмал иргэншил хувь хүний ертөнцийг үзэх үзэл, зан төрх, сэтгэлзүйн байдалд ихээхэн нөлөөлж буйг дэлгэн харуулжээ.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Г. Батнасангийн “Түлээчин-2” (1994) өгүүллэгт хотын хүний амьдралдаа дассан дүрийн зан төрхийг гаргажээ. Зохиолд гуравдугаар биеэс өгүүлэх ба дүрийн одоогийн байр байдал болоод өнгөрсөн цагийн хүсэл тэмүүлэл, зорилгыг хүүрнэнэ.

Түүний хувьд бүх л юм болж байна. Болоод л байна. Өглөө босно, ажилдаа явна. Өдөржин компьютер нүднэ. Энэ нь түүнд хэрэгтэй юу, үгүй юу гэдгийг огтхон ч үл бодно. Цалин авна хаяа мөнгөгүй болно. Гэвч буруу нь юунд ч биш, зүгээр л дуусчихсан хэрэг. Хүмүүстэй мэндэлнэ, инээнэ, ярина. Энэ бүхэнд сэтгэл хангалуун байгаа, дундуур байгааг эргэцүүлэх нь үгүй. Тэгээд яах ёстой гэж. Бүх л юм нэгэн хэвийн байгаад залхаж дургүйцэн зугтах хэрэг үү? Үгүй дээ, энэ бол аль эрт өнгөрсөн зан. Одоо бол ажилдаа явна, оройд бага зэрэг зугаална. Гэхдээ ховорхон. (мөн тэнд, 1997, 119).

Дээрх хэсгийг харвал хотын хүний өдөр тутмын үйлийг бичжээ. Зугтах гэдэг ч нэгэнтээ өнгөрсөн буюу энэ амьдралын эргүүлгээ хүлээн зөвшөөрч болоод л байгаа гэж итгэсэн хүний байр байдлыг үзүүлсэн байна. Зохиолд дүр өнгөрснөө буюу хийх дуртай болоод хийж чаддаг байсан зүйлсээ нэгэн цайны газар хоол идэж байхдаа дурсан буйгаар гардаг. Дүрийн ном унших их хүсэл, түлээ хагалж байхдаа авдаг байсан сайхан мэдрэмжээ дурдагддаг бөгөөд мөнгөгүйн улмаас номуудаа заран өмд авч түлээ хагалахаа ч больсон байдаг.

Мөнгө олох тухайд нэг шөнийн эхний 18-20 минутыг зарцуулан бодоод нам унтсаны эцэст өглөөтэй золгон, ажил олохоор урам зориг төгөлдөр гарч одов. Уг нь хар бор нь хамаагүй түр хийгээд хөлсөө авчихаар ажил захаас авхуулаад бий гэж бодсон нь олдсонгүй, олдсон нь түүнийг авсангүй. Хүнээс мөнгө зээлэхээр шийдсэн боловч хэн ч түүнд мөнгө зээлдүүлсэнгүй. Энэ хугацаанд мөнгө олох философи нь бүрдсэний үрээр өөрт ашиглагдахаа больсон хэдэн номоо худалдаачинд аваачвал зуун тавин төгрөг дутуу ч

энгийн даруухан, огтхон ч гологдохооргүй нэг өмд авах мөнгө олов. (мөн тэнд, 1997, 120)

Дээрх хэсгээс өөрийн хүчээр мөнгө олох ажил болон зээлдүүлэх хүн ч олдохгүй байх зэргээр хотын соёл иргэншлийн өрсөлдөөн, дүр төрх харагдаж байгаа бөгөөд эцсийн сонголт нь номоо буюу дүрийн хувьд хүсэл мөрөөдлөө худалдан энгийн даруухан өмд авч байна.

Зохиолд дүр түлээ хагалах дуртай байснаа дурсан суух ба хүчтэйгээр хагалж байгааг төсөөлөх үед хоолтой таваг нь хага үсэрдэг. Түүнийг тойрон суух хүмүүс доогтойгоор шоолон жуумалзахад олны нүднээс зугтан гарах ба хутга ямар сүх биш дээ хэмээн халаглан бодож буйгаар зохиол төгсөнө. Энэхүү өгүүллэгт хотын амьдралд дасан зохицох гэсэн хүний зан төрхийг харуулсан байгаа хийгээд нийгэмд хүсэл мөрөөдөл, хийж чадах зүйлээрээ амьдралаа залгуулах боломжгүй гэх гутранги байдлыг тодруулж өгч байна.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Г. Батнасангийн “Эрэлчид-2” (1993) өгүүллэг хоёр хэсэгтэй буюу Санса хэмээх дүрийн гэрт ба бодол, оюун санаанд үйл явдал өрнөх бөгөөд хотын аж амьдрал, хүн хоорондын харилцаа, хэмнэл зэрэг нь хувь хүнд хэрхэн дарамт болон нөлөөлж буйг үзүүлсэн байна.

Санса толинд өөрийгөө удтал харах. Тэгснээ үсээ нямбайлан хусаж эхэллээ. Мөр рүү нь бөөн бөөн үс унах тусам Санса үсэн дор нуугдаж байсан хэсэгхэн арьс хэрхэн ил гарч ирж байгааг харж байлаа. Толгойгоо хүйтэн усаар угаахад хага ташина. Гэвч үүгээр ажил дууссангүй. Мэс заслын хөрөө аваад гавлаа хөрөөдөж гарав. Түүний цус гадагш гарах дургүй байх шиг. Хөрөөдөгдсөн гавлын хэсэг ширээн дээр далбилзан эргэлдэнэ. Тольны хавтсанд тархиныхаа арыг тольдол амьсгалан түхэлзэж, бас цохилон, судас бололтой улаан нялзрай юмс нааш цааш зөрөлджээ. Энэ атираанууд ухаан санаа хэр зэрэг хөгжсний илэрхийлэл гэж бодоход нэг л марзан. (мөн тэнд, 1997, 124)

Дээрх хэсгээр зохиол эхлэх бөгөөд энэ хот, хүмүүс, нийгмээс залхсанаа хэлдэг. Гавлаа хөрөөдөн тархиа салган авах гэсэн шалтгаан нь бодож тунгаан шаналж байхаас салахыг хүссэн шинж бөгөөд “Саяын зүйлийг энэ тархи л бодож байгаа шүү дээ” (мөн тэнд, 1997, 124) гэж өөртөө хэлдэг.

Зохиол Сансагийн дотоод бодрол, зөрчлөөр үргэлжилж байгаад нэгэн үйл явдал руу шилждэг. Санса лифтэнд нэгэн рок хөгжим сонсдог залуу болон өлгийтэй хүүхдээ тэвэрсэн бүсгүйтэй өгсөх ба өнөөх рок залуу байн байн тамхи гарган асаахад Санса хүүхдийн хажууд тамхи татаж буй залууг харж дотроо ихээхэн бухимддаг.

Яахлаараа ийм новишийн амьтад амьд явдаг байна аа? Өчигдрийн согтуу өвгөн энэ хоёр яг адилхан. Нэвширсэн архины үнэр, увайгүй гөлтөлзөх нүд, над хар нүүрэн дээр нил шүлс болж байдгаараа дарвайсан час улаан ам. Түй! Яахлаараа ийм хогийн юмнууд амьд явдаг байна аа? Би адилхан уу? Өөр. Үгүй ээ адилхан, адилхан байх цаг зөндөө. Тийм биш ээ, би бол огт өөр! (мөн тэнд, 1997, 126)

Дээрх бодлоор Сансагийн дотоод зөрчил туйлдаа хүрэн лифтнээс буугаад рок залууг багалзуурдах бөгөөд нэг мэдэхэд рок залуу үхнэ. Санса хэргийн газраас зугтан гүйх бөгөөд яагаад гэдгээ мэдэлгүй хайрт бүсгүйнхээ үүдэнд хаалгыг нь тогшин зогсож байдаг. Бүсгүй гарч ирэхэд “Би ер нь яавал чамд хайртай гэдгээ итгүүлэх вэ?” хэмээн асуух ба “ямар тэнэг юм хэлэв ээ” хэмээн шуудхан зугтаана. Хүн хоорондын ёс зүй хэрхэн алдагдсан болон ямар учир ойлгомжгүй зүйлс өөрийг нь хүрээлж байгааг Сансагийн хайр сэтгэлийн асуудал болон хүн алах шийдвэрт хүрч байгаагаар үзүүлжээ.

Таваг, сэрээ, хутга, аяга цай бүгд. Хоол идэх дур хөдөлгөм цэвэрхэн. Савны тагийг нээлээ. Пор пор буцална. Давс бас амтлагчууд хийв. Гараа алгуур өргөж байтал нүдний нь үзүүрт хуруунууд нь сарвайн харагдахад гар нь тэрүүхэндээ зогсчихов. (Би, Гар-багаж, харин Тархи тусдаа. Гурван хэсэг зүйл. Тархи айн доошоо шигдэж байх шиг хачин хүндэрч байна.) Гэнэт: -Үүнийг энэ тархи л бодож байгаа шүү дээ! гэж хэлэв. Гараа огцом өргөөд толгой руугаа дүрж тархиа базан чангаалаа. Сансагийн аймаар чарлах дуунд сандал ширээ тагчигнан, сав баярлан бүжих мэт дэвхцэнэ. Бүх л юм улаан нялга болж, урсана. Сүүлчийн удаа өвдсөндөө салгалан татваганасаар байгаа гартаа одоо хэнийх ч биш болсон тархиа барьж байснаа савтай усанд пал хийтэл алдав. (мөн тэнд, 1997, 127)

Дээрх хэсгээр зохиол төгсөх ба Санса тархиа салган гаргаж ирж сүүлийн удаа харж аваад үхдэг. Зохиолд хотын хүний ёс зүй алдагдан хүн хоорондын харилцааг ойлголгүй дотоод зөрчил нь туйлдаа хүрч буй дүрээр хотын дарамт, зан төрх хүний сэтгэлзүйд хэрхэн нөлөөлж буйг гарган харуулжээ. Мөн зохиолын үйл явдал гэнэт үсрэн шилжиж, яагаад гэдгээ мэдэлгүй хүн алж, алснаа гэнэт мартан өөр зүйлс хийж байгаа нь хотын хурдассан хэмнэлийг төлөөлүүлэн үзүүлсэн байна.

Энэ хэсгийг нэгтгэн дүгнэж үзвэл хотын соёл, хэмнэл, дарамтыг зохиолуудын дүр, зан төрхөөр нээн харуулахдаа хотын хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлзүйн байдлыг эцэж туйлдсан, зугтах хүсэлтэй ч зугтах боломжгүй нөхцөл байдалд дүрслэн үзүүлсэн төдийгүй чухам үүнээс шалтгаалан дүрүүд нь үхэлтэй ямар нэгэн байдлаар холбогдон төгсөж байна.

2.2 Зохиолууд дахь хотын орчин, уур амьсгал

Уран зохиолд орчин буюу цаг болон орон нь “...хэлбэр агуулгыг тодорхойлогч хүчин зүйлийн хувьд уран зохиолын баатрын дүр ямар байхыг /голлон/ босгож ирэх нөхцөл болдог. Дүр үргэлж цаг-орон зайн орчилд төрөн гардаг” (Бахтин, 2017, 15) болно. Дүрд орчин ихээхэн нөлөөлдөг. Зохиолын орчны хамаарлаар дамжуулан зөрчил үүсэх суурь болдог буюу “Зөрчил бол хүүрнэлийн амин сүнс нь юм. Зөрчил нь үйл явдлын цогц байдал, дүрийн өсөлт, өөрчлөлтийн шалтгаан болж байдаг. Туульсын хүүрнэл зохиолуудад орчин нь зөрчлийг зохион байгуулахаас гадна дүрийн дотоод тэмцлийг үзүүлдэг” (Нандинбилиг, 2018, 32) байна.

Хүүрнэл зохиолд уур амьсгалаар дамжуулан утга санаа илэрч болдог. Зохиолын уур амьсгал гэдэг нь “...орчин ба юмс, зөн совин зэрэг нарийн ширийн зүйлсэд суурилсан хүүрнэлээс уншигчийн авч байгаа мэдрэмжийн нэг хэлбэр юм. Уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд аливаа уран сайхны аргуудыг ашиглаж, сэтгэл санааны байдлыг бүтээнэ. Утга зохиолын бүтээлд уур амьсгал гэдэг бол зохиогчоос орчин болоод юмсын дүрслэлээр дамжуулан, уншигчдадаа дамжуулж байгаа сэтгэл хөдлөл болоод мэдрэмжийн хамаатай зүйл юм” (мөн тэнд, 2018, 32) билээ.

Өмнөх хэсэгт зохиолууд дахь үйл явдал, хотын хүний дүр, зан төрхийг задлан шинжилсэн бол энэхүү хэсэгт зохиолууд дахь хотын орчин, уур амьсгалыг авч үзье. “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Б. Бадралын “Тагтны уянга” (1994) өгүүллэгт орон зайн хувьд хотын нэгэн барилгын арван хоёр давхрын тагтан дээр үйл явдал өрнөнө.

Алсын уулс, барилгын кран, хүйтэн агаарыг ширтэх нүдний яг өмнүүр сэвхийтэл нисэж одсон улаан хошуутын орилох нь болжморын жигд чичрэх жиргээнийг нам дарна. “Вааг, вааг” (Батхуяг нар, 1997, 55)

Зохиолд эхнээсээ л сайн зүйл болохгүй гэдгийг дуу чимээгээр дохиолж байна.

Түй!!!...Вааг! Вааг! Вааг! Бур сүрэг жунгаа! Сapp! Бас-с салхи (мөн тэнд, 1997, 56)

Зохиолд дуу чимээгээр дамжуулан уур амьсгалыг бүрдүүлэх бөгөөд дүр тагтнаас үсрэх агшин хүртэл шувуудын чимээ тодорсоор байдаг. Мөн цаг агаарын байдал буюу үе үе хүчтэй салхи дэгдэн байгаа нь таатай зүйл өрнөхгүй гэдгийг харуулна. Хүн бага холхих саарал гудамж, гудамжны том ноход, тэртээд үзэгдэх барилга чүдэнзний хайрцаг мэт харагдах нь зохиолын орчноор

дамжуулан уур амьсгалыг мэдрүүлж зохиолын үйл явдалд оролцох үүрэгтэй байгааг харж болно.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Д. Дашмөнхийн “Хөлийн чимээ” (1991) өгүүллэгийн нэрээс харахад л дуу чимээ илэрхий үүрэгтэй байна. Зохиолд гарах хонгилын үзүүрт шал товших өсгийтэй гутлын чимээ нь дүрийн сэтгэлзүй, дотоод зөрчил үүсэх гол шалтгаан болдог. Өдөр бүр давтагдан бага багаар ойртон ирж буй “тог, тог” дугарах чимээ нь дүрийн сэтгэлзүйн дарамтыг шууд ба шууд бусаар илтгэнэ.

Бүрий баруйд цагаан тааз ээглээр сааралтана. Гудамжны гэрлийн бүдэгхэн туяа, өрөөнд үл мэдэг гэгээ оруулах авч харанхуй дэндүү нүсэр (мөн тэнд, 1997, 81)

Дээрх хэсэгт гарч байгаачлан зохиолын гол үйл явдал цаг хугацааны хувьд байнгын харанхуй шөнө ба орон зайн хувьд хотын нэгэн эмнэлгийн жижигхэн өрөөнд өрнөнө. Дуу чимээний дарамт дээр нэмээд орноосоо босож чадахааргүй болсон өвчтөн тул ор, хөнжил, хүйтэн хана, тааз, харанхуй зэрэг нь дүрд нөлөөлөх орчин юм.

Унаж байхдаа тэр бээр чихээ гараараа таглаж, ёолон орилж, чарлаж байв. Тог тог гэсэн хөлийн чимээ сарны доор хадна (мөн тэнд, 1997, 89)

Ийнхүү зохиол төгсдөг ба зохиолд эмнэлгийн орчин хийгээд шөнийн харанхуйд эмнэлгийн эзгүй хонгилд сонсогдох хөлийн чимээгээр дамжуулан, дүрийн амиа хорлох сэтгэл зүйн байдал хийгээд зохиолын уур амьсгалыг бүтээсэн байна.

Мөн Д. Дашмөнхийн “Зэрлэг нохой” (1995) өгүүллэгт хувь хүний дотоод зөрчил хийгээд хотын их хэмнэлийг үзүүлэхдээ орчин, уур амьсгалыг ашиглажээ. Зохиолд,

Жавар тачигнасан харанхуй гудамжинд “Жаргал аа” гэж хаширч зогссоноо төсөөлөхөд бэрх байна (мөн тэнд, 1997, 101),

Өдөржин даарч, хөрж, нэхий зөөж, үнэ хаялцан бусадтай хэрэлдэж, хоолойгоо царцтал бархирчхаад ганц хором тайван амралгүй тэднийх рүү гүйх ёстой мэт (мөн тэнд, 1997, 102),

Ажил, нүүсийн эзэн, автобус, телевизор, дуу чимээ, таван өнчин дүү гээд юм бүхэнд “идүүлж” байгаа юм шиг санагдах юм (мөн тэнд, 1997, 102),

Энэ ойд зэрлэг нохой их байдаг юм. Чамтай уулзах гэж танай хашааны үүдэнд очиход танай хоёр нохой тамын чөтгөр үзсэн юм шиг над руу

агсардаг даа. Эндхийн ноход зэрлэг юм чинь танай хоёроос долоон дор байлгүй. Шөнө болохоор бүр хотын зах хүртэл тэнэдэг юм (мөн тэнд, 1997, 107),

Өдрийн дөрвөн цаг өнгөрчээ. Өвлийн богино өдөр дуусаж ердөө хагас цагийн дараа бүрэнхий болно. Түүнийг улам айлгах гэж (мөн тэнд, 1997, 107),

Тэмдэглэл ийн төгсжээ. Очир жихүүцэн “Тий тий” гэж тургиад -Муухай хүйтэн байна гэснээ халуун цайнаас нэг ойчиж, -Үнэхээр болсон явдал бол аймишигтайяа гэж өгүүлээд тамхиа асаав. Харин би бол болсон явдал гэж бодож байна (мөн тэнд, 1997, 108)

гэх зэргээр орчин, юмс үзэгдэл, дуу чимээ ашиглан уур амьсгалыг бүтээж байна. Зохиолын үйл явдал, дүр, зөрчлийг эдгээр зүйлс нь тодруулан өгч цаашлаад зохиолд хөндөгдөх хотын хүний сэтгэлзүйн доройтол, хэм хэмнэл, соёлын дарамтыг тодорхой харуулсан юм.

“Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Г. Батнасангийн “Түлээчин-2” (1994) өгүүллэгт орчны хувьд өглөө гэрээс гараад орой гэртээ ирэх, өдөржин ажил дээрээ суух, нэгэн хэвийн давтамжид орсноор дүрслэгддэг.

Цаг хугацааг ч анзааралгүй ажилласаар нэлээд хожуу цайны газар орлоо. Бөөрөнхийлж шарсан махтай, хачиртай, будаатай хоол, шөл, бас бус юмс. Түүний дотор яагаад ч юм бачуураад явчихсан ч хоолоо аваад суув. Нэг гарт нь сэрээ, нөгөөд нь хутга. Ийм маягаар хооллохыг хэзээ анх сурснаа бодоод олсонгүй (мөн тэнд, 1997, 119)

Нэг мэдэхэд маханд сэрээгээ зоогоод удаан суучихжээ. Үргэлж л энэ ширээнд сууж, цонхоор харан хоолоо яаралгүй иднэ. Юундаа ч яарах билээ дээ. Энэ нэг цагийг “цайны цаг” гэдэг биз дээ (мөн тэнд, 1997, 120)

Дээрх хэсгүүдэд хотын нэгээхэн цайны газрын орчин дүрслэгдэх бөгөөд эд юмс, үйл хөдлөлөөр зохиолын уйтгартай уур амьсгалыг үзүүлжээ. Энэ хэсэгт орон зайн хязгаарлалыг “цайны газар”-ын дөрвөн ханаар хязгаарлаад, цаг хугацааг “цайны цаг”-аар хязгаарлан үзүүлснээр “Бөөрөнхийлж шарсан махтай, хачиртай, будаатай хоол, шөл” төдийхний төлөө амьдарч буй хотын хүний нэгэн хэвийн амьдралыг эргэцүүлжээ.

Оюун санаанд буусан болгон сэтгэл хөдөлгөн хөвсөлзүүлж орхидог тийм л цаг. Номын сан түүний хайртай байшин, тэр өөрөө үүгээр мөнхөд эргэлдэгч болохыг мөрөөдөгч (мөн тэнд, 1997, 119)

Модны үнэр ч гэж хачин сайхан. Хагалахад хэцүү ч чийгтэй модны үнэр үү... Мод хөрөөднө гэдэг мөн ч жаргалтай ажил. Юм бодоод л, шийг шууг гэх чимээг нь чагнаж, доош цацрах цагаан шаргал үртсийг харж байх таатай (мөн тэнд, 1997, 120)

Энэ хэсгүүдэд орон зай, үнэр, дуу чимээгээр зохиолын дүр таатай дурсамж, хүсэл мөрөөдөл байсан зүйлсээ дурсаж байгааг тодруулж өгч байна.

Мөн “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн гишүүн Г. Батнасангийн “Эрэлчид-2” (1993) өгүүллэг нь Сансагийн гэрт болон лифтэнд гэсэн хоёр хэсэглэлтэй өрнөдөг бөгөөд хотын орчин, уур амьсгал хэрхэн дүрд нөлөөлж буйг харж болно.

Эцэст нь зөвхөн цөхрөл, бөөн бодол. Энэ үед нь түүнд эргэн тойрон байх баахан хүмүүс, агаар, салхи ч хүртэл уйтгар зэвүү хүргэсэн зүйлс санагдан өөрийгөө хэчнээн их ганцаардаж байгааг мэдрэх шүд өвдөх мэт шаналгаатай. (мөн тэнд, 1997, 125)

Энэ хэсэгт агаар, салхи зэрэг орчин нь уйтгар зэвүү хүргэж буйг болон эргэн тойрон байх хүмүүс нь хүртэл өөрийг нь ганцаардлаас аварч чадахааргүй болсон нь дүрийн сэтгэлзүйн байдлыг тодруулан гаргаж байна.

Хот гэдэг саарал таазтай асар том тоглоомын өрөө. Энд сонирхол татахааргүй маруухан тоглоомнуудаас авахуулаад, тоглоод тоглоод ханашгүй сайхан сайхан тоглоом зөндөө бий. Тэднийх “зүдэргээнтэй” хэмээх бартаат тоглоомын хэсэгт байдаг. Байшинд нь хүрэхэд ногоон хаалга бариулаа эрсэн нүдээр газар ширтэн угтана. Лифтний дэргэд дээл, гутал малгай нь “Гудамжны” гэмээр авангард хослолтой хүн хана түшин тамхи баагиулна. Хаалга онгойж нэг эмэгтэй хүүхдээ тэврэн тэдэнтэй цуг өгсөхөөр хажууд нь ирж зогсов. (мөн тэнд, 1997, 125-126)

Дээрх хэсэг нь зохиолын гол зангилаануудын нэг ба хотыг шууд саарал таазтай тоглоомын өрөө хэмээн орон зайн хашигдмал байдлаар хэлж байгаа нь дүрд хот, түүний хэмнэл, аж байдал хэрхэн нөлөөлснийг төлөөлж буй юм. Мөн,

Сансагийн аймаар чарлах дуунд сандал ширээ тагчигнан, сав баярлан бүжих мэт дэвхцэнэ. (мөн тэнд, 1997, 127) гэжээ.

Зохиолд гарч буй орчин, уур амьсгал нь хотын хэмнэл, дарамт, хотын хүний сэтгэлзүйн байдал буюу ойлгомжгүй зүйлс дунд аж төрж түүнээсээ зугтахыг хүссэн зан төрхийг илтгэжээ хэмээн үзэж байна.

Энэ хэсгийг нэгтгэн дүгнэж үзвэл зохиолууд дахь хотын орчин, уур амьсгал, эд юмс нь дүрүүдийн зорилго, сэтгэлзүйн байдлыг нээж харуулан тэдгээр нь зохиолын үйл явдал, зөрчилд хэрхэн нөлөөлж байгааг харж болно.

ДҮГНЭЛТ

Хотын уран зохиолд хотыг дүрслэн үзүүлэх төдий бус хотын аж төрөл, хотын хүн, хотын асуудлыг үзүүлдэг. Энэхүү судалгааны ажлын хүрээнд бид өөрсдийгөө “Хүрээ хөвгүүд” хэмээн зарласан уран бүтээлийн нэгэн бүлгэмийн нөхдийн 1990-ээд онд туурвисан өгүүллэгүүдийг задлан шинжилж, тайлан тайлбарлаад дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэгдүгээрт хотын хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлзүйн байдлыг эцэж туйлдаа хүрсэн, зугтах хүсэлтэй ч зугтах боломжгүй байдалд дүрслэн үзүүлж, мөн тэрхүү шинжээс шалтгаалан дүрүүд үхэлтэй ямар нэгэн байдлаар холбогдож, соёл, хэмнэл, дарамтыг зохиолуудын дүр, зан төрхөөр нээн харуулжээ.

Хоёрдугаарт зохиолууд дахь орчин, уур амьсгал, эд юмс нь дүрүүдийн зорилго, сэтгэлзүйн байдлыг нээж харуулан тэдгээр нь зохиолын үйл явдал, зөрчилд хэрхэн нөлөөлж байгааг харуулсан байна.

Эдгээр нь “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн хүүрнэл зохиолд илрэхдээ хотын хүнийг хотын орчин, нөхцөл байдал, соёлын хүрээнд үзүүлж байгаагаар нь хотын уран зохиол болохыг баталж байна. Хотын уран зохиолд хотыг дүрсэлсэн байдаг ч түүгээрээ хотод амьдарч буй хүний амьдралын хэмнэл, сэтгэлзүйн байдал, үнэлэмж, зан төрх, соёлыг өөртөө агуулж байдаг уран сайхны бүтээлүүд орно хэмээн үзэж байна.

Цаашид хотын уран зохиолын судалгааны сэдвийг өргөн цар хүрээнд цаг үеийн ялгаатай уран бүтээлчдийг хамруулж авч үзэн задлан шинжилж судалгааны ажлаа үргэлжлүүлэх санал дэвшүүлээд “Хүрээ хөвгүүд” бүлгэмийн зохиолуудад хотын уран зохиол бүтээхийг зорьсон оролдлого илэрлээ хэмээн дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Батхуяг, П., Батнасан, Г., Бадрал, Б., Дашмөнх, Д., Ням-Очир, Г., Энхболдбаатар, Д. (1997). *Замдаа гарцгаая...хүрээ хөвгүүдээ*. Улаанбаатар: “БАРХАН” хэвлэлийн газар.

Судалгааны бүтээл

Бахтин, М. (2017). *Эпос хийгээд роман*. Улаанбаатар: Жиком пресс.

Гаадамба, Ш. (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар: УХГ.

Галбаатар, Д. (2001). *Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Галбаатар, Д. (2006). *Урлахуйн галыг бадраагч зул эндүүрлийн гэмийг ариусгагч зул*. Улаанбаатар: Бемби сан хэвлэх үйлдвэр.

Галбаатар, Д. (2012). *Уран зохиол тайлбар: Онол, түүх, шүүмжлэл*. МУИС хэвлэх үйлдвэр.

Галбаяр, Г. (2002). *Уран зохиол шинжлэлийн лекц*. Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр.

Нандинбилиг, Г. (2018). *Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй*. Улаанбаатар: МУИС Пресс.

Нарантунгалаг, Г. (2021). *Хариу шүүмж*. Улаанбаатар: Удам соёл хэвлэх үйлдвэр.

Петрова, М. П. (2011). *Нүүдэлчний уран зохиолыг шинжлэхүй*. Улаанбаатар: Жиком пресс.

Петрова, М. П. (2016). *XX зууны эцэс XXI зууны эхэн үеийн Монголын утга зохиол дахь модернизм болон постмодернизм*. Улаанбаатар.

Уэллек, Р. Уоррен, О. (1998). *Уран зохиолын онол*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэлийн товчоо.

Энхбаяр, С. (2011). *Утга зохиолын онол*. Улаанбаатар: Бэмби сан.

Энхбаяр, С. (2017). “Урбанизм буюу хотын уран зохиол нь XXI зууны монголчуудын үнэт зүйлийн өөрчлөлтийн нэг толь мөн” *Утга зохиолын судлал шинжлэл* 12. Улаанбаатар: Жиком пресс.

Энхбаяр, С. (2021). *Утга зохиолын ерөнхий онол-туурвил зүй*. Улаанбаатар: Жиком пресс.



П. БАТХУЯГИЙН ӨГҮҮЛЛЭГ ДЭХ БОЛЗОЛТ ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГ

Эрхэмбаярын БУДСҮРЭН
МУБИС. НХУС. МХУЗ III курс

Удирдагч багш: П. Яньдий (Ph.D)

Хураангуй: Шинэ зуун гарсаар хүүрнэл зохиолын богино хэлбэрийн бүтээлүүд нэлээд гарч, уран бүтээлчид үзэл санаа, арга, уран сайхны туурвил зүйн хувьд янз бүрийн эрэл хийж байна. Энэ үед Д. Цэнджав, Г. Аюурзана, Л. Өлзийтөгс, Ц. Буянзаяа, П. Батхуяг, Ц. Түмэнбаяр, Д. Энхболдбаатар зэрэг олон уран бүтээлчид монгол өгүүллэгийн урын санг баяжуулсаар байна. Бид энэ удаа нэн шинэ үеийн монгол өгүүллэгт өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн зохиолч П. Батхуягийн өгүүллэгт болзолт дүрслэлийн аргыг хэрхэн ашигласныг тодруулахыг зорьсон. Түүний өгүүллэгүүд нь гротеск, далдын хүч, зүүдний дүрслэлийн аргыг ашиглан бичсэнээр нэн шинэ үеийн өгүүллэгийн туурвил зүйн хөгжилд өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрхөө нэмж чадсан байна.

Түлхүүр үг: болзолт дүрслэл, өгүүллэг, зүүд, гротеск, далдын хүч

УДИРТГАЛ

Утга зохиол судлалд болзолт дүрслэлийг ерөнхий, тодорхой хоёр хүрээнд авч үзэн, хоёр түвшинд хуваан тайлбарладаг байна. Тодорхой хүрээнд авч үзсэн судлаач эрдэмтэд болзолт дүрслэлийг “Хоёрдогч шатны болзолт дүрслэл” гээд болзолт шинжийн дээд түвшин, уран зохиол доторх уран сайхан дүрслэлийн нэг арга гэж үзсэн байдаг.¹

Уран зохиол судлаач, эрдэмтэн С. Байгалсайхан “Уран зохиолын арга нь гурван хүчин зүйлээс бүрэлддэг. Үүнд: а. Бодит байдал, б. Зохиолчийн

¹ Хурцгуяа. Б. Болзолт дүрслэл уран сайхны сэтгэлгээний өвөрмөц илрэл болох нь. Уб., 2018. 3.

ертөнцийг үзэх үзэл, в. Зохиолчийн ургуулан бодох сэтгэлгээ”² гэж аргын талаар тодотгосон байдаг. Харин судлаач Д. Галбаатар “Уран бүтээлийн реалист бус арга нь уран сайхны танин мэдэхүйн мөн чанар, зөрчлийг оюун санаа, сэтгэхүйн үүднээс болзмол болоод хийсвэрлэл, ёгт чанар ба далд утга, зөн совин, зүүд бэлгэдэл... зэрэг дүрслэлийн янз бүрийн арга маягуудыг ашиглан амьдралын бодит байдлыг үнэмшилгүй “этгээд”, “гажуу” мэт байдалд утга ба дүрсийг шилжүүлэн хийсвэр байдлаар (дүрслэлээр) орлуулдаг онцлогтой³ гэж үзсэн байдаг. Эдгээрээс үзвэл болзолт дүрслэл нь реалист бус аргын нэгэн илрэл юм.

Болзолт дүрслэлийн талаар Оросын утга зохиолд олон янзаар судалж, тодорхойлсон байдаг. Оросын утга зохиолд “Художественная условность” буюу “Болзолт дүрслэл” гэж, нэрлэдэг байна. Д. Н. Ушаковын “Орос хэлний нэвтэрхий толь”-д “Болзолт дүрслэл гэдэг бол бодит байдлын реалист ойлголтоос татгалзаж, бодит байдлыг бэлгэ тэмдгээр дүрсэлдэг арга”⁴ гэж утга агуулгынх нь талаас тодорхойлсон байдаг бол судлаач А. Михайлова болзолт дүрслэлийг хэлбэрийн нь талаас “Амьдралын үнэнийг урлагийн хэлбэрт тусгахын тулд үзэгдлийн мөн чанарыг нь төвлөрүүлээд, байгалийнх нь хэлбэр, дүр байдлыг өөрчилж дүрсэлдэг арга”⁵ гэж үзжээ.

Болзолт дүр, дүрслэл нь уран сэтгэмж, хэтрүүлэг, бэлгэ тэмдэг, зүүд зөн, ид шид далдын хүч, зөн совин, ёгтлол зэрэг хэлбэрээр илэрдэг.⁶

ҮНДСЭН ХЭСЭГ

П. Батхуяг нь хүүрнэл зохиол, яруу найраг, жүжиг, кино зохиол, утга зохиол судлал, шүүмж зэрэг уран зохиолын бүхий л төрлөөр бичиж, туурвидаг билээ. Түүний өгүүллэгийн онцлогийг судлаачид өөр өөрсдийнхөөрөө үнэлж дүгнэсэн байдаг. Сүүлийн үед тасралтгүй өгүүллэг бичсэн зохиолчдоос П. Батхуягийн өгүүллэгүүд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, уншигчдын сонирхлыг ихээр татсан, чөлөөт байдлыг эрэлхийлсэн чанараараа ялгарч байдаг.⁷ Доктор С. Амартүвшин “Орчин үеийн утга зохиол шинжлэл” хэмээх бүтээлдээ “П.Батхуяг ямар нэг “-изм”-д баригдахыг хүсдэггүй ч орчин цагийн уран сайхны сэтгэлгээний чиг хандлагаас татгалзаагүй нь түүний

² Байгалсайхан. С. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Уб., 1995. 112

³ Галбаатар. Д. *Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд*. Уб., 2021. 69.

⁴ Хурцтуяа. Б. *Болзолт дүрслэл уран сайхны сэтгэлгээний өвөрмөц илрэл болох нь*. Уб., 2018. 8.

⁵ Лувсанвандан. С. *Түүвэр зохиол II Амьдрал урлагийн сайхан*. Уб., 2002. 84.

⁶ МУБИС. *Монголын уран зохиолын судлал-орчин үе*. Уб., 2008. 112.

⁷ МУБИС. *Монгол судлалын чуулган*. Уб., 2020. 97.

өгүүллэгүүдээс харагддаг⁸ гээд “Хүрэл зүрх”, “Миний хийл” өгүүллэгүүдийг нь жишээ баримтаар тайлбарласан байдаг. Мөн докторант Б. Бүжинлхам “Утгын чимэг наадмын шилдэг өгүүллэгт болзолт дүрслэл ашигласан нь” өгүүлэлдээ “Далавч” өгүүллэгийн өгүүлэмж нь уран зохиолын уран сайхны үнэмшилтэй байдлыг эвдсэн, бодит байдлыг ухамсартайгаар өөрчилсөн ер бусын өгүүлэмжтэй болжээ⁹ гэх мэтээр онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ мэт эрдэмтэн судлаачид зохиолч П. Батхуягийн өгүүллэгүүдийн туурвил зүйн талаас нь задлан шинжилж үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Бид энэ удаа зохиолч П. Батхуягийн “Далавч” /2005/, “Загас мэт” /2009/, “Хүрэл зүрх” /2006/ зэрэг өгүүллэгт болзолт дүрлэлийн аргыг хэрхэн ашигласныг дараах байдлаар тодруулан авч үзлээ.

1. П.Батхуягийн “Хүрэл зүрх” өгүүллэгт далдын хүчний дүрслэлийг ашигласан нь

Өгүүллэгийн гол дүрийн баатар хуучин номын худалдаан дээр танилцсан найзынхаа гэрт очоод ур хийц муутай хүрэл зүрхнээс хараагаа салгаж чадаагүй. Юу түүнийг тэгтлээ татаад байгааг тэр залуу өөрөө ч мэдээгүй бөгөөд ямар ч эргэлзээгүйгээр тэр зүрхийг өндөр үнээр худалдаж аваад гэртээ харьдаг. Харих замд нь атганд нь байгаа тэр хүрэл зүрх лугшиж байгааг мэдэрдэг. Тэр цагаас хойш хүрэл зүрхээ хаа явсан газраа зүүж явдаг болсон бөгөөд хүрэл зүрхтэй байхдаа өөртөө илүү их итгэлтэй, эрч хүчтэй байх шиг санагддаг болсон. Нэг удаа гэрээсээ гарахдаа хүрэл зүрхээ орхиод гарсанд үүдэн дээрээ халтирч унаад шагайгаа мулталчихсанаас болж байнга авч явдаг болсон.

Нэг өдөр хүрэл зүрхээ тэр гээчхэв. Тэр орой нь хар дарж цочиж сэрэв. Тэгээд “Олсон хүнд нь өндөр шагналтай” гэж зар тавиулсанд маргааш нь нэг охин олсон гэх бөгөөд хүрэл зүрхээ очиж аваад бөөн баяр болон гэр лүүгээ гүйж явахад нь хүрэл зүрх нь нойтон болчихсон байсан. Түүний хамаг биеийн хөлс нь асгарч байлаа. Ахиж алга болгоогүй дээрээ нүхлээд зүүе гэж бодоод өрөм аваад цоолж байтал гэнэт түүний нүд харанхуйлаад хамаг бие нь сулардаг бөгөөд зүрх рүүгээ хартал дотроос нь цус шүүрч байлаа. Амьсгал авах аргагүй болж залуу үхэж байлаа.

- ❖ Хүнд аливаа саад бэрхшээл бидний үл мэдэх далд ертөнцөөс шалтгаалж байдаг. Үүнийг далдын хүч гэж хэлнэ.¹⁰

⁸ Амартүвшин. С. *Утга зохиолын судлал шинжлэл боть 32*. Уб., 2019. 271.

⁹ Бүжинлхам. Б. *Утгын чимэг наадмын шилдэг өгүүллэгт болзолт дүрслэл ашигласан нь*. Уб. 2024

¹⁰ Гурван эрдэнэ БДС. *Эрдэм шинжилгээний бичиг №7*. Уб., 2012. 75.

- ❖ Уг өгүүллэгт хүрэл зүрх түүний сэтгэлийг татаж эцэс сүүлд нь амилсан мэт түүний зүрх нь болж өөрчлөгдөж байгааг харж болно. Хүний зүрх зогсоход хүний амьдрал ч мөн дуусдагийн адил хүрэл зүрхийг цоолоход залуугийн амьдрал дуусаж байгаагаар далдын хүчний зүйл илэрч байна. Ямар нэгэн далдын хүчээр тэр зүрхээрээ хүрэл зүрхтэй холбогдож, хүрэл зүрхнээс холдвол түүний амьдралд хачин жигтэй зүйл тохиолдож, хамгийн эцэст нь хүрэл зүрхийг өрөмдөхөд цус шүүрч байгаа дүрслэлээс мөн далдын хүчний дүрслэлийг харж болно.

2. П. Батхуягийн “Далавч” өгүүллэгт зүүдний дүрслэлийг ашигласан нь

Оршин суугчид нь өөрсдийгөө “тэнгэр” язгууртай, бүргэдийн удам гэж үзэх нэгэн жижигхэн хот байдаг. Өвөл өнгөрч уулын цас нимгэрэх үед тэр хот нэг баяр тэмдэглэдэг. Тэр нь “Сайхан зүүдний баяр” юм. Өглөө эрт төв талбайд цуглараад урьд шөнө “сайхан зүүдний баяр”-аар хэн юу зүүдэлсэн тухайгаа нийтэд ярих ба хотын дарга шилдэг зүүд шалгаруулж мөнгөн шагналаар шагнах бөлгөө. Харин сайхан зүүдээ манаж хонох шөнө тэнэмэл өвгөний дотор бэмбэгэнээд нэг ч хором дугхийсэнгүй. Баярын өдрийг мартсан янхан бүсгүй шөнөжин үйлчлүүлэгч хайсаар үүл цайлгажээ. Тэр хоёроос бусад нь цөм ер бусын сайхан зүүд зүүдлэхээр унтацгаав. Өглөө болоход шөнө баяр тэмдэглэхээр унтсан хүн бүхний хоёр гарын оронд хос далавч ургажээ. Үүний учир нь хот даяараа ижил зүүд зүүдэлсэнд байгаа юм. Далавчтай бүх хүмүүс тэнгэрт гарч баяр хөөр болсон ч эргээд буух аргаа мэдэхгүй бүгд л газарт пидхийн унаж үхэцгээж байлаа. Хөөрхий өвгөн газарт унасан хүмүүсийг ганцаараа хөдөөлүүлж, харин бүсгүй гэрээсээ огт цухуйлгүй 10 хонов. Хотынхныгоо дурсаж эзгүй уушны газар сууж тэр хоёр ярилцсан нь:

- Би жар гаруй наслахдаа элдвийн юм бишгүй л үзсэн. Хүн гэдэг амьтан далавчтай болоод чиг тэнгэрийн амьтан биш юм даа? Үхэхдээ бүгд газарт л уналаа шүү дээ? Шунал хүсэл хоёр нь хотынхныг маань далавчтай болгосон. Тэгэхээр тэд маань тамд л нисэж яваа даа.

- ❖ Зүүд бол бидний ухамсар, сэтгэл мэдрэмжийн гүн нууцлаг язгуурт байрлаж, өөрийн үнэн цэвэр дүр төрхөө бодгалийн адал явдалт бэлгэдлээр илэрхийлж байдаг, бид бүхний хамгаас далдлан нууцалдаг элдэв нууцыг илтгэгч мөн. Түүнчлэн зүүд бол зүүдлэгч эзнээсээ үл хамааран ер бусын, жиг хачин шинжтэй байдаг бөгөөд бодит байдал, хуурмаг байдал хоёрын хоорондын тэнцүү болзомж үүсгэдэг.¹¹

¹¹ Дулам. С. Монгол бэлгэдэл зүй. Уб., 2002. 1.

- ❖ П. Батхуягийн “Далавч” өгүүллэг нь “Зүүд”-ийг уран санаагаар баяжуулан, хэтрүүлэгтэй, ер бусын өгүүлэмжтэй хослуулж, болзолт дүрслэлийг бүтээжээ. “Далавч” бол хүмүүсийн хязгааргүй эрх мэдэл, хүсэл шуналыг илэрхийлсэн. Нөгөөтээгүүр “хүн далавчтай болохыг мөрөөддөг, далавчныхаа хүчээр хязгааргүй эрх чөлөөтэй дүүлэн нисэхийг хүсдэг” гэсэн хүн төрөлхтний төрөлхийн болзолт сэтгэлгээтэй холбож тайлбарлаж болох юм.

“Зүүдний ерөнхий чиг үүрэг нь сэтгэцийн тэнцвэрт байдлыг сэргээхэд оршдог. Үүнийг сэтгэцийн амьдрал дахь зүүдний тэтгэх үүрэг гэж нэрлэж болно. Үл гүйцэлдэх зорилт дэвшүүлэгч, өөрийгөө хэт магтагч, боломжгүй их зүйл төлөвлөгч хүмүүс нисэж хөөрөх ч юм уу унаж ойчих зүүд зүүдэлдэг нь ийм учиртай. Зүүд нь хувь хүний дутуу дулимгийг нөхөх төдийгүй, таарамжгүй явдал суудал дахь аюул заналыг урьтан сануулдаг”¹² гэж “Бэлгэдэлт амьдрал” ном дээр дурдсан байдаг.

Мөн зүүдний дүрслэл бүхий жишээн дээр хүн унтаад зүүдлэх тэр дундаа зүүдээ манаж хонох гэдэг нь нэг зан үйл бөгөөд зүүдээ манаж хоносноор урьд шөнө юу зүүдэлсэнээ тод санах учиртай. Өгүүллэгт тэрхүү зүүдэлсэн янз бүрийн зүүд өгүүллэгийн үйл явдал, өгүүлэмжийг хэрхэн өөрчилж байна вэ? гэдгээр болзолт дүрслэл мөн илэрч байна.

Зохиолын дүрүүд юу зүүдэлсэн бэ? гэдгээсээ хамаарч тухайн өгүүллэгийн үйл явдалд ямар ч өөрчлөлт гарч болох байсан бөгөөд зохиолч далавчтайгаар нисэж байна гэж зүүдлүүлсэн нь зохиолын уншигчдад хэлэх гэсэн, зорьсон санаатай авцалдсан дүрслэл болжээ.

Хот даяар зөвхөн нэг л зүүд зүүдэлсэн нь бодит амьдрал дээр хэрхэн биеллээ олж, хүн итгэмээргүй зүйл болж байгааг хачин жигтэй байдлаар, хэтрүүлэл ашиглан харуулжээ. Үүний цаад санаа нь хүн хэдий далавч ургаж тэнгэрт ниссэн ч ерөөсөө л хүн хэвээрээ бөгөөд тэнгэрийн амьтан биш газарт л унах болно гэдгийг болзолт дүрслэл ашиглан илэрхийлэхийг зорьжээ.

3. П. Батхуягийн “Загас мэт” өгүүллэгт гротескийг ашигласан нь

Эхнэрийгээ үглэхэд өөрийн зохиосон “Загас мэт” аргыг нөхөр нь байнга хэрэглэдэг бөгөөд үглэж эхлэхээр нь л загас адил болж юу ч сонсохгүй зөвхөн ямар нэг зүйлийг л харна. Хэнтэй ч юм ярихгүй загас мэт дуугүй байх нь түүнд таалагддаг байв. Тэднийд нэг муур байдаг бөгөөд хүүхдүүд нь хамт унтах нь холгүй байгааг харсан аав нь 4 алтан загас авч өгөв. Загаснуудыг хараад

¹² Юнг. К.Г. *Бэлгэдэлт амьдрал*. Уб., 2011. 184.

хүүхдүүд нь муураа тоохоо больсон бөгөөд нэг өглөө сэрэхэд загаснуудыг нь муур бүгдийг нь идчихсэн байдаг. Цонхоор гадагш нааш цааш яаран явах хүмүүсийг харж зогстол эхнэрийн минь эрэн муур над руу гэтэн гэтсээр дөхөж явааг харав. Яг л модон дээр суугаа шувуу шүүрэх гэж буй мэт, эсвэл усан дотор яваа загас шүүрэхээр яваа мэт аяархан. Дэргэд байсан савтай цэцгийг би түүн рүү нүүлгэв. Огло үсрэн бултаад цааш гүйж одов. Тэр өдөржингөө миний араас гэтэв. Эгзгийг минь тааруулж байгаад над руу дайрах гээд байгааг би зөнгөөрөө мэдрээд байв. Шөнө нь ч олигтой унтаж чадсангүй. Аварга том ирвэст бариулж байна гэж хар дарж зүүдлээд хамаг биеийн хар хөлс асгарчихсан сэрэв. Хэд хоногийн дараа загас мэт байдалд шилжихээс өөр аргагүйд хүрэхэд эрэн муур биеэ хураан залуу руу үсрэв. Түүнийг сэрэхэд хүзүү ам битүү боолттой бололтой. Бага хүү амаа ангалзуулан :

-Аав аа, та загас болж хувираад, эрэн муур тань руу дайраад... гэхэд эхнэр минь үгийг нь тасалж:

-Загас шиг муриганаад байхаар чинь хөөрхий амьтан андуураад дайрсан байлгүй. Харин би өөрийгөө загас болсон гэдэгт эргэлзэхгүй байв...

- ❖ Зохиолыг сонирхолтой болгох үүднээс бодит байдлын зүй тогтол, жам ёс, хэлбэр, байр байдлыг зориуд ер бусын болгох, хэтрүүлэх аргаар бичсэн зохиолыг гротеск гэнэ.¹³
- ❖ Энэхүү өгүүллэгт зүүд, зөн совингийн дүрслэл байгаа ч өгүүллэгийн төгсгөлд хүүгийнх нь хэлдэг загас болж хувираад гэдэг үгнээс нь харвал түүний урьд өмнө хэрэглэдэг байсан тэр нэг арга нь биеллээ олж жинхэнэ загас болж хувирсан ч байж магадгүй мэт хачин жигтэй байдлаар дүрслэгджээ. Эсвэл тэр өөрийгөө загас мэт болж хувирахдаа загас шиг муриганаж хөдөлдөг гэдгээ мэддэггүй бөгөөд энэ аргад шилжихдээ загас шиг хөдлөхөд нь тэдний муур загас гэж бодон дайрсан байж ч магадгүй юм. Гэнэт л жинхэнэ загас мэт болж хувирсан нь өөрөө хачирхалтай дүрслэл юм.

ДҮГНЭЛТ

1. Болзолт дүрслэл бол зохиолыг амттай, сонирхолтой, гайхалтай болгох үүднээс бодит байдлын мөн чанар, зүй тогтол, жам ёс зэргийг үл анхааран аливаа хүн, амьтан, юмсын хэлбэр хэмжээ, байр байдал, шинж чанарыг зориуд өөрчилсөн уран сэтгэлгээний өвөрмөц хэлбэр бөгөөд энэ нь нэн шинэ үеийн монгол өгүүллэгийн туурвил зүйн нэг арга болон төлөвшиж

¹³ Галбаатар. Д. *Уран зохиол нэвтэрхий толь*. Уб., 2012. 100.

буйг зохиолч П. Батхуягийн цөөнгүй өгүүллэгүүд нотлон харуулж байна.

2. П.Батхуяг зохиолчийн өгүүллэгт болзолт дүрслэл нь зүүд, далдын хүч, гротеск гэх мэт дүрслэлүүдээр илэрч байна. Жишээ нь: “Хүрэл зүрх” өгүүллэгт амьдрал, зүрхнийх нь цохилт хүрэл зүрхнээс шууд хамааралтай болсныг өвөрмөц дүрслэлээр өгүүлсэн бол “Далавч” өгүүллэгт хүний хүсэл шунал, өөрийгөө бусдаас илүүд үзэх бодол, хожимдсон ухаарлыг нэгэн хотынхонд тохиолдсон явдлаар харуулахдаа зүүдийг уран санаагаар баяжуулан, ер бусын өгүүлэмжээр баяжуулан дүрсэлсэн нь уншигчдыг тунгаан бодох, эргэцүүлэх зэрэг ухаарлын замд хөтөлж буйгаараа өвөрмөц ажээ.
3. Энэхүү реалист бус өгүүллэгүүд нь туурвил зүйн хувьд сэтгэлгээний чиг хандлага руу хөтөлсөн, дүр, дүрслэл өгүүлэмжийн шинэчлэл хийсэн, содон сонин өнгө аясаар баяжин хөгжиж буй нь шинэ зуун гарснаас хойших үеийн монгол өгүүллэгийн хөгжлийн онцлогийг харуулж байна.

НОМ ЗҮЙ

Нэг зохиогчтой ном

- Амартүвшин. С. (2019). *Утга зохиолын судлал шинжлэл №32*. Улаанбаатар.
- Байгалсайхан. С. (1995). *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.
- Гаадамба. Ш. (2014). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Галбаатар. Д. (2021). *Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд*. Улаанбаатар.
- Дулам .С. (2002). *Монгол бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Бит пресс.
- Лувсанвандан. С. (2002). *Түүвэр зохиол II Амьдрал урлагийн сайхан*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Хоёр зохиогчтой ном

- Аюурзана. Г, Өлзийтөгс. Л. (2005). *Монголын сонгомол өгүүллэг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Онолын ном

- Галбаатар. Д. (2012). *Уран зохиолын нэвтэрхий толь*. Улаанбаатар.

Орчуулгын ном

- Юнг. К. Г. Орч. Энхбаатар. А. (2011). *Бэлгэдэлт амьдрал*. Улаанбаатар: ADMON.

Сэтгүүл

Гурван эрдэнэ БДС. (2012). *Эрдэм шинжилгээний бичиг №7, 75.*

Бүжинлхам. Б. (2024). *Утгын чимэг наадмын шилдэг өгүүллэгт болзолт дүрслэл ашигласан нь.*

МУБИС. (2008). *Монголын уран зохиолын судлал- орчин үе.* Улаанбаатар: Сорхон цагаан.

МУБИС. (2012). *Монгол судлалын чуулган.* 112.

МУБИС. (2020). *Монгол судлалын чуулган.* 97.

Ганц сэдэвт бүтээл

Хурцтуяа. Б. (2018). *Болзолт дүрслэл уран сайхны сэтгэлгээний өвөрмөц нэг илрэл болох нь.* 8.

THE FEATURE OF CONDITIONAL REPRESENTATION IN THE SHORT STORIES OF P. BATKHUYAG

Abstract

Since the beginning of the new century, many short-form narrative works have emerged, with writers exploring various themes, techniques, and artistic approaches. During this period, numerous authors such as D. Tsendjav, G. Ayurzana, L. Ulziitugs, Ts.Buyanzayaa, P.Bathuyag, Ts. Tumenbayar and D. Enkhboldbaatar have enriched the repertoire of Mongolian short stories. This time, we aim to examine how the writer P. Bathuyag, who has established a unique position in the newest generation of Mongolian short story writers, utilizes the method of conditional representation in his stories. His works incorporate grotesque elements, supernatural forces, and dream-like representation, contributing a distinct and original tone to the stylistic development of contemporary short fiction.

Key words: *conditional representation, short story, dream, grotesque, supernatural power*



МОНГОЛ ҮЛГЭР ДЭХ ШИДЭТ ТУСЛАГЧИЙН ДҮР, ӨГҮҮЛЭМЖИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Батсүхийн ЗОЛБОО

МУИС-ийн Утга зохиол судлал, II түвшний оюутан

Удирдагч: И. Даваадорж

МУИС-ийн УЗУСТ-ийн багш

Хураангуй: Уг өгүүлэлд монгол аман зохиолын төрөл зүйл болох үлгэрийн шидэт туслагчийн дүр, өгүүлэмжийг синтагматик анализын хүрээнд задлан шинжиллээ. Ийн судлахдаа “Болдоггүй бор өвгөн”, “Алтан мөнгөн аргай”, “Хаан, хүргэн, хангарди шувуу”, “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийг жишээлэн авч, өгүүлэгдэхүүний цувааг формаль байдлаар илэрхийлж, шидэт туслагчийн гүйцэтгэх үүргийг тодрууллаа. Мөн “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн нисдэг бор морь, “Алтан мөнгөн аргай” үлгэрийн үнэг, “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийн буга, эмгэн болон “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрийн хангарди шувууны бэлгэдлийн утгыг тус тус авч үзэв. Түүнчлэн “Хаан, хүргэн, хангарди шувуу”, “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт гарч буй “Хангарди”-ийн дүр ялгаатай өгүүлэмжээр илэрч буй учир харьцуулан дүгнэлээ.

Түлхүүр үг: шидэт үлгэр, шидэт туслагч, синтагматик анализ, функц, өгүүлэгдэхүүн

Судлагдсан байдал: Монгол аман зохиол дахь үлгэр, тэр дундаа шидэт үлгэрийн төрөл зүйлийг судалсан байдлыг авч үзвэл удаах байдалтай байна. П. Хорлоо “Монгол ардын явган үлгэр” (1960) нэг сэдэвт бүтээлийн “Ид шидэт үлгэр” бүлэгт “Алтан гуу, мөнгөн гуу” үлгэрийн баатрын үйл хэрэг нь ямагт шидэт туслагчийн хүчээр хийгдэж байна”¹ хэмээн шидэт туслагчийн үүргийг онцолжээ.

¹ П. Хорлоо, Монгол ардын явган үлгэр (Улаанбаатар: Эрдэм шинжилгээний хэвлэх үйлдвэр, 1960), 54.

Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв “Монгол ардын аман зохиол” (1988) бүтээлд шидэт үлгэрийн онцлог нь уран сэтгэмж, ид шидийн зүйлс хэмээн дүгнэсэн байна².

С. Дулам “Монгол бэлгэдэл зүй: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй” (2000) нэгэн сэдэвт бүтээлдээ монгол туульсын дэд, туслах баатад нь зүүн зүгийг эрхшээдэг³ хэмээжээ.

Ц. Нямсүрэн “Монгол, Грек туульсыг бүтцийн анализаар харьцуулан судалсан нь” (2017) докторын зэрэг горилсон бүтээлд Владимир Проппын “Үлгэрийн морфологи”-ийг ашиглан, “Донорын анхны үйлдэл” нь Хан харангуй болон Жангар туульд хэрхэн илэрч буйг судалсан байна⁴.

Б.Дайриймаа “Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж” (2017) номдоо “Өнчин Буш хүү” үлгэрийн баатар Буш хүү цагаан сахалт өвгөний тусламжтайгаар шидэт үг суран өшөөгөө авч буй шидэт туслагчийн өгүүлэмжийг тодотгон бичсэн⁵.

Г. Нандинбилиг, С. Дулам “Монгол аман зохиолын онол II” (2020) бүтээлд монгол үлгэрийн гол баатар шидэт туслагч болох Хангардийн зулзагыг аварсныхаа хариуд сайн сайхантай золгодог тухай, мөн “Өнчин Буш хүү, түс годилын үлгэр”-ийн Цагаан өвгөний дүр байдлыг тодотгон бичжээ⁶.

И. Даваадорж “Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж” (2022) эрдэм шинжилгээний өгүүлэлд “Өнчин Буш хүү Түс годил” шидэт үлгэрийн шидэт туслагч болох цагаан сахалт өвгөн гол баатрын зүүдэнд үзэгдэж буйг зүүдэнд үзсэн зүйл даруй биелэх шидтэй зүүдний уг шинжтэй холбон тайлбарласан байна⁷.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: Монгол аман зохиол, тэр дундаа шидэт үлгэрийн шидэт туслагчийн дүрийг судалсан боловч Владимир Проппын таксономик загварыг ашиглан, өгүүлэгдэхүүнд гүйцэтгэх үүргийг тодорхойлсон ажил судалгаа ховор байна. Тиймийн учир “Болдоггүй бор

² Ш. Гаадамба., Х. Сампилдэндэв, *Монгол ардын аман зохиол* (Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр., 1988), 267-268

³ С. Дулам, *Монгол бэлгэдэл зүй II-Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй* (Улаанбаатар: Битпресс., 2000), 131.

⁴ Ц. Нямсүрэн, *Монгол, Грек туульсыг бүтцийн анализаар харьцуулан судалсан нь* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2017), 38-60.

⁵ Б. Дайриймаа, *Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж* (Улаанбаатар: Соёмбо принтинг., 2017), 30.

⁶ Г. Нандинбилиг., С.Дулам, *Монгол аман зохиолын онол II* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2020), 144-145.

⁷ И. Даваадорж, *Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2022), 132.

өвгөн”, “Алтан мөнгөн аргай”, “Хаан, хүргэн, хангарди” болон “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийг синтагматик анализын хүрээнд шинжилж, шидэт туслагчийн үүргийг тодруулах юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Бид эл илтгэлд монгол шидэт үлгэрийн өгүүлэгдэхүүнийг шинжлэхдээ синтагматик анализыг тулгуур болгон ашигласан. Энэхүү анализ нь В. Проппын шидэт үлгэрийн бүтцийг судлах “Үлгэрийн морфологи” бүтээлийн 31 функцэд төвлөрдөг. В. Проппын тодорхойлж буйгаар “Морфологи гэдэг нь ургамлын янз бүрийн хэсгийн харилцан хамаарлыг судалдаг. Үүний адилаар үлгэрийн бүтцийг судлах юм. Хэрэв бид үлгэрийг бүтцээр нь судлахгүй бол харьцуулалт хийхэд төвөгтэй болно гэжээ. Мөн “функц” нь үлгэрийн баатрын үйл хэргээр илэрдэг аж. В. Пропп функцийг товч утга, тодорхойлолт, тэмдэглэгээ гурвыг багтаадаг гэж үзжээ”⁸ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. В.Проппын функцийн тэмдэглэгээ

Тэмдэглэгээ	Тодорхойлолт	Жишээ
β	Эзгүй байх	Гэр бүлийн нэг гишүүн гэртээ байхгүй байх

Аман зохиолын бүтээлийг судлах структуралист аргыг хоёр төрөлд хувааж болно. Нэгдүгээрт тухайн аман хүүрнэл, зохиол бүтээлээс хосмолжин эсрэгцлийг олж, өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх парагдигматик анализ, удаах нь синтагматик юм. “Синтагматик анализ нь парагдигматик анализаас зөвхөн бичвэр доторх текстийг судалж, нийгэм болоод соёлын хам сэдэвт төвлөрдөггүйгээрээ ялгардаг”⁹ (Propp, 1968: 12-13). Синтагматик анализ нь “...аман зохиолын текстийн бүтэц болон формал байгуулалд хандан, цуваа цаг хугацааны дагуу функцийг дараалуулан судалдаг синтагматик анализ юм”¹⁰. Тиймээс бид монгол үлгэрийн шидэт туслагчийг судлахдаа анхлан синтагматик анализын хүрээнд өгүүлэгдэхүүний цувааг тогтоож, шидэт туслагчийн гүйцэтгэх үүрэг, түүнээс улбаалан дүр, бэлгэдлийг судлах юм.

Шидэт үлгэр нь “байгаль нийгэм дэх хүнд эерэг эсрэг хүчний зөрчил тэмцэлд оролцож, сайн сайхан үнэн шударгын төлөө тэмцэгч хувилгаан чадалт

⁸ Sapna Dogra, *The Thirty-One Functions in Vladimir Propp's Morphology of the Folktale: An Outline and Recent Trends in the Applicability of the Proppian Taxonomic Model* (Rupkatha Journal on Interdisciplinary Studies in Humanities, 410-9), 2017.

⁹ Vladimir Propp, *Morphology of the Folktale* (University of Texas Press., 1968), 12-13.

¹⁰ И. Даваадорж, *Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2022), 70.

хүн ба хүн бус төрөлтөн...ер бишийн үйл явдлын тухай хүүрнэн өгүүлэх уран сэтгэмж голлосон байдаг”¹¹ онцлогтой. Монгол шидэт үлгэрийн гол баатрын тухайд “...нусгай бор хүү буюу эхлээд хөөгдмөл, хаягдмал, өнчин ядуу баатрууд байснаа сүүлдээ эрэлч хайгуулч эрэлхэг баатрууд болж өсдөг”¹². Өнчин хүү нь ихэвчлэн сайн санаа, сайхан сэтгэлтэй, хүнд тустай баатар байх агаад үлгэр, ялангуяа шидэт үлгэрийн гол баатар өөрийн зорьсон үйл хэргээ бүтээхэд шидэт туслагч (donor) чухал үүрэгтэй байдаг. Тиймээс ч үлгэрийн гол баатар “шидэт туслагч”-ийн үүрэг, оролцоотойгоор цаашдын үйл хэргээ гүйцэлдүүлж, сайн сайханд хүрдэг.

В. Пропп “Үлгэрийн морфологи” бүтээлдээ “шидэт туслагч”-ийг “donor” хэмээн тэмдэглэж, “... Баатар шидэт туслагчийн тусламжтайгаар золгүй явдлыг даван туулах ид шидийг олж авдаг”¹³ хэмээжээ. Монгол үлгэрийн өгүүлэгдэхүүнд шидэт туслагчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлохын тулд “Болдоггүй бор өвгөн” үлгэрийг жишээлэн авч, синтагматик анализаар шинжлэн үзье (Хүснэгт 2).

Хүснэгт 2. “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн задлал

Функц	“Болдоггүй бор өвгөн” үлгэр ¹⁴
α - Орон зай цаг хугацааны хамаарал, гэр бүлийн байдал, ер бусын төрөлт, бэрхшээлээс өмнөх сайн сайхан байдал.	Эрт урьд цагт Болдоггүй Боролзой өвгөн гэж нэг өвгөн байж гэнэ. Энэ өвгөн долоон бор хоньтой, нисдэг бор морьтой, бас нисдэггүй бор морьтой юм гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн Болзоотын бор толгойн тэнд овоохой бариад суудаг байжээ. Болзоотын бор толгойд долоон бор хонио хариулдаг байжээ...
α ⁶ - Баатар ямар нэг зүйлээр дутагдах, түүнийгээ авахыг эрмэлзэх	Болдоггүй Боролзой өвгөн “Хув бор хониноос минь хундан цагаан хурга гараасай, Хурмаст тэнгэрээ тайх юм сан” гэж бодож явдаг байжээ
↑ - Баатар гэрээс гарах нь	...Хув бор хониноос нь хундан цагаан хурга гарсанд Хурмаст тэнгэрээ тахина гэж баярлаад хурганы уутанд хийж хээр тавиад, хонио буцаагаад ирсэн...

¹¹ Ш. Гаадамба., Х.Сампилдэндэв, *Монгол ардын аман зохиол* (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1988), 366.

¹² Г. Нандинбилиг., С. Дулам, *Монгол аман зохиолын онол II* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2020), 143.

¹³ Propp, 39.

¹⁴ *Монгол ардын үлгэр*, эмх. Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1982), 85.

А ¹³ - Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах А ⁶ - Хорон санаатан бусдын биеийг шархтуулах нь	Хурмастын хон хэрээ нисэж ирээд, хурганы нь нүдийг ухчихсан байж гэнэ.
G ¹ - Баатар агаарт нисэх	Болдоггүй Боролзой өвгөн уурлаж, нисдэг бор морио унаж, нисэж очоод...
I - Хорон санаатныг дарах	...хон хэрээний эвэр хошуугий нь аваад модон хошуу хийгээд тавьчихаж гэнэ.
А ¹³ - Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Гэтэл Хурмаст тэнгэр “Хон хэрээний минь хошууг солилоо” гэж уурлаад хоёр чоноороо нисдэг бор морийг идүүлэхээр явуулж гэнэ.
η ¹ - (neg) Хорон санаатан залилан ятгах	Үүнийг Болдоггүй Боролзой өвгөн мэдээд нисдэг бор морио зүүн талдаа, нисдэггүй бор морио баруун талдаа солиод аргамжиж гэнэ.
А ¹⁴ -Хорон санаатан аллага үйлдэх	Хурмаст хааны хоёр чоно ирээд нисдэггүй бор морийг нь идчихээд явчхаж гэнэ.
G ¹ - Баатар агаар дээр нисэх	Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж хөөж очоод...
I - Хорон санаатныг дарах	...хоёр чонын арьсыг өвчөөд хоншоорт нь унжуулаад тавьчихаж гэнэ.
А ¹³ - Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Тэгэхлээр нь Хан Хурмастаас Болдоггүй Боролзой өвгөнийг даруулахаар Мичид толгойт, Марал толгойт хоёр чөтгөрөө явуулж гэнэ.
А ¹³ - Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Хан Хурмаст уурлаж, Болдоггүй Боролзой өвгөнийг хоёр луугаараа ниргүүлэхээр явуулжээ.
А ³ - Хорон санаатан ургац, тариаг дээрэмдэх эсвэл сүйтгэх	Хоёр луу Болзоотын бор толгойг бор нүүрс болтол нь ниргээд явчихжээ.
G ¹ - “Баатар агаар дээр нисэх”	Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж нисэж...
I - Хорон санаатныг дарах	...хөөж очоод хоёр лууны сүүлийг тас цавчаад явуулжээ.
Н - Хорон санааттай баатар тэмцэлдэх	Чи яагаад хэрээний минь эвэр хошууг модон хошуугаар сольсон гэж асууж гэнэ. Хув бор хониноос минь хундан цагаан...Тэгвэл тэр чиний зөв гэжээ.
F ² - Хорон санаатныг өрсөлдөөний үеэр ялах	Хурмаст хаан, тэгвэл тэр чиний зөв гэжээ.

Дээрх үлгэрийг бүрдүүлэгч функцийг нэгтгэн үзвэл доорх шинжтэй байна.

$$\alpha a^6 \uparrow A^{13} A^6 G^1 I A^{13} \eta_{neg}^1 A^{14} G^1 I A^{13} A^{13} A^3 G^1 I H I^2$$

Энэхүү синтагматик бүдүүвчид $G^1 A^{13}$ болон функц тогтвортой байна. “Болдоггүй бор өвгөн” үлгэрт илэрч буй баатар агаар дээр нисэх - G^1 болон хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах A^{13} - функц нь цуваа байдлаар давтагджээ. Үүнээс үзвэл, үлгэрийн өрнөл хэсэгт баатар хорон санаатны үйлдэлд хариу үзүүлэхдээ нисдэг бор морио унаж, баатар агаар дээр нисэх G^1 - функц илэрчээ.

Эндээс харвал нисдэг морь нь хорон санаатанд хариу үйлдэл үзүүлэхээр зэхэж буй гол баатарт туслах чиг үүрэг бүхий шидэт туслагч юм. Энд нэг зүйлийг тодруулан дурдах шаардлага нь В. Пропп шидэт туслагчийг (donor) баатартай санамсаргүй байдлаар учирдаг¹⁵ хэмээн тодорхойлсон бол монгол шидэт үлгэрт нисдэг бор морь хэмээх туслагч нь тухайн гол дүрийн эзэмшил, заяамал хөрөнгө болох шинжтэй байна.

“Монгол шидэт үлгэрийн гол баатарт унаж яваа морь нь хүний хэлээр ярьж, ямар нэгэн бэрхшээлээс гаргаж, дайснаа дарахад идэвхтэйгээр тусалдаг...үлгэрт нисдэг морь хамгийн түгээмэл байдаг”¹⁶. Иймийн тул “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн нисдэг бор морь нь бэлгэдлийн утгаараа “...аяар хол газрыг товчлох... ид шидтэй хөлгө”¹⁷ юм. Уг үлгэрийн баатрын хорон санаатанд үзүүлэх хариу үйлдэлд шидэт туслагч буюу “нисдэг бор морь”-ны оролцоо зайлшгүй шинжтэй юм.

Удаах “Алтан мөнгөн аргай” үлгэрт шидэт туслагч нь өгүүлэгдэхүүний өрнөл хэсэгт гарч байна (“Алтан мөнгөн аргай” үлгэрийн синтагматик задаргааг хавсралтаас үзнэ үү). Энэхүү үлгэрийн шидэт туслагчид нь найман хөлтэй найр алаг морь, үнэг, бухан бяруу юм. Гэрээсээ гарч буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно (β^1) функц нь үлгэрийн зангилаа хэсэгт илэрч байна. Ингэхдээ Чагаа хүүгийн “...нэг өглөө найман зуун адуугаа наашлуулах гэж арын уулаар ан гөрөө хайж, өврийн уулаар адуу малаа хайж...”¹⁸ яваад, мангас эмгэнтэй учирч буйг өгүүлдэг. Ийн үзвэл, гэрээс гарах функц нь “...зохиол цааш өрнөх зайлшгүй шаардлагатай суурь, уншигчдын сэтгэлийн түгшүүр, хямралд

¹⁵ Propp, 39.

¹⁶ П. Хорлоо, *Монгол ардын явган үлгэр* (Улаанбаатар: Эрдэм шинжилгээний хэвлэх үйлдвэр., 1960), 48.

¹⁷ С. Дулам, *Монгол бэлгэдэл зүй II-Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй* (Улаанбаатар: Битпресс., 2000), 73.

¹⁸ *Монгол ардын үлгэр*, эмх. Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 83.

дагуулж байгаа үйл явдлын зангилаа”¹⁹ болж, хорон санаатан хүүхдийн байгаа газрын байршлыг олох эсвэл үнэ цэнтэй эд зүйл олохыг оролдох (¹) функцийг нөхцөлдүүлжээ. “Алтан мөнгөн аргай” үлгэрийн синтагматик бүдүүвч нь доор шинжтэй байна.

$$\left\{ \begin{matrix} \alpha\beta^1 \eta^3 \varepsilon^1 \theta^3 \uparrow \\ A^8 A^6 A^{14} R s^8 \end{matrix} \right\} \left\{ \begin{matrix} D Pr^7 D Pr^6 F^6 H^2 \eta^3 (neg) I^2 \\ D^3 E^3 F^1 \\ K^1 \downarrow \delta^1 I^5 \end{matrix} \right\}$$

Уг синтагматик бүдүүвчийг үзвэл, $F^6 H^2 D^3$ [$D^3 F^1$] функцүүд нь хоорондоо холбоо хамаарал бүхүй хэлхээг үүсгэжээ. Тухайлбал, Шидэт хэрэглэл гэнэт гарч ирэх F^6 - функц-д хамаарах үлгэрийн хэрэг явдал нь Чагаа хүү мангас эмгэнээс зугтаж явахдаа айлын бууц дээрээс “...Аавын нь билүүний хагархай, ээжийн самны хугархай”²⁰-г олох хэсэг юм. Ийн Чагаа хүү билүүний болон самны хугархай, тэвнэ зэргийг олдог. Эдгээр нь мангас эмгэнтэй тэмцэхэд хэрэг болдог шидэт хэрэглэл юм. Эл функцийн дараа H^2 - баатар, хорон санаатан нар өрсөлдөх, I^5 - Баатар хорон санаатныг өрсөлдөөний үеэр ялах зэрэг функцүүд илэрч байна. Өөрөөр хэлбэл, баатар шидэт хэрэглэлтэй болсноор өрсөлдөгчөө ялах нөхцөл бүрдэх юм. Үлгэрт гарч буйгаар “Тэгэхлээр нь Чагаа хүү ээжийн саамаа “Батганын толгой багтахгүй баг хар ширэнгэ бол!” гэж мангас эмгэний урд хаялаа...”²¹ хэмээн баатар ээжийнхээ самны хугархайг ашиглан мангас эмгэнтэй тэмцэж байна. Ийнхүү баатар шидэт хэрэглэлийнхээ тусаар өрсөлдөгчөө ялдаг.

Уг үлгэрийн өрнөл хэсэг дэх шидэт туслагч нь “найман хөлтэй найр алаг морь” юм. Чагаа хүү алтан, мөнгөн аргайгаа авахаар бууц нь дээрээ иртэл мангас эмгэн түүгээр нь наадан тоглож байдаг. Тийнхүү алтан мөнгөн аргайгаа авахаар зэхтэл эмгэн “Эмээ нь босвол сууж чаддаггүй, суувал босож чаддаггүй...Хүү минь буугаад ав”²² гэдэг. Тэгмэгц найман хөлтэй найр алаг морь нь “Би хотойхын сайнаар хотойё, чи шүүрэхийн сайнаар шүүр” гэж хэлдэг нь Донорын анхны үйлдэл - D функцэд хамаарах хэрэг явдал юм. Ингэснээр Чагаа хүү мориныхоо тусламжтай аргайгаа авч зугтаадаг. Уг донорын анхны үйлдэл илэрч буй функцийг авч үзвэл, $A^8 D A^6 A^{14}$ хэмээх хэлхээг үүсгэжээ. A^8 - хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах буюу мангас эмгэн Чагаа хүүг идэхээр завдаж хүүг аргайгаа “Буугаад ав” гэснээр найр алаг морь нь

¹⁹ Г. Нандинбилэг, *Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2020), 23.

²⁰ *Монгол ардын үлгэр*, эмх. Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 85.

²¹ MAY, 85.

²² MAY, 84.

D - донорын анхны үйлдэл функц дараалан орж байна. A^6 - *Хорон санаатан бусдын биеийг шархтуулах* функцэд хамаарах хэрэг явдал нь Чагаа хүү алтан мөнгөн аргайгаа аваад зугтаахад мангас эмгэн хойноос нь хөөж, морийг нь шархтуулдаг. A^{14} - *Хорон санаатан аллага үйлдэх* функцэд хамаарах хэрэг явдал нь “...нэг даваа даваад мангас эмгэн хянгаараа тэр морины толгойг тас...”²³ цавчсанаар морь аргагүйн эрхэнд үхэж буй юм. Тиймээс D - донорын анхны үйлдэл функцийн өмнө болон дараах функцүүд нь хорон санаатны үйл хэргээр нөхцөлджээ. Мөн шидэт туслагч болох найман хөлтэй найр алаг морь нь “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн ижил тухайн баатрын өөрийн заяамал эзэмшил, эд хөрөнгө байж, монгол үлгэрийн шидэт туслагчийн шинжийг тодотгож байна.

Уг үлгэрийн удаах шидэт туслагч нь үнэг юм. Чагаа хүү морио алдаж, мангас эмгэнд хөөгдөн явахдаа алтан улиасанд авирч гардаг нь баатар мод руу авирах функц болно. Мангас эмгэн модны үндсийг цавчих гэтэл нэгэн үнэг гарч ирэн “Ээж, ээж, энэ улиасыг би унагая. Та нэг хэсэг унтаад аваарай”²⁴ гэдэг. Уг үнэгний үйлдэл нь D - донорын анхны үйлдэл функцэд тохирох хэрэг явдал юм. Үнэг мангас эмгэнийг ахин хуурах гэхэд, мангас эмгэн “Үгүй, тэгж болохгүй. Намайг нэг үнэг тэгж хэлээд нүдий минь цавуудаж орхилоо”²⁵ гэдэг. Тэгэхлээр нь үнэг овжин арга ухаан сэдэж, “Ухай тэр чинь талын үнэг байгаа биз ээ. Би болбол тайгын цагаан үнэг байна” гэж итгүүлэн мангас эмгэнийг унтуулдаг. Тийнхүү үнэг Чагаа хүүг модноос буулгадаг. Эл үнэг нь бэлгэдлийн утгаараа “заль мэхийн ёгтолмол”²⁶ юм. Учир нь мангас эмгэнийг овжин, сэргэлэн ухаанаар унтуулан, Чагаа хүүг модноос буулгаж байна. В.Проппын “Үлгэрийн морфологи”-д шидэт туслагч (donor) нь баатартай учирмагцаа харилцан яриа үүсгэсний дараа туслах үүргээ гүйцэтгэдэг²⁷. Харин “Алтан мөнгөн аргай” үлгэрийн шидэт туслагч болох үнэг баатартай мэндлэх зэргээр харилцан яриа үүсгэдэггүй. Энэ нь монгол үлгэрийн шидэт туслагчийн нэгэн онцлог юм.

“Алтан мөнгөн аргай” үлгэрийн шидэт туслагч болох “бухан бяруу” Чагаа хүүгийн хамт мангас эмгэнийг ялсны дараа ийн хэлдэг. “За, Чагаа хүү минь, чи намайг алаад дөрвөн хөлийг минь дөрвөн тийш залаад зүрхийг минь өвөртлөөд унтаарай” гэж захидаг нь D^3 - нас нөгчиж буй болон хэдийнээ нас нөгчсөн хүн захиас захих функцэд хамаарч байна. Түүнчлэн $[D^3E^3F^1]$ буюу хоорондоо

²³ МАУ, 84.

²⁴ МАУ, 85.

²⁵ МАУ, 85

²⁶ Г. Нандинбилиг, *Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр., 2020), 138.

²⁷ Propp, 72.

холбоо хамаарал бүхий функц илэрчээ. Энэ тухайд, В. Пропп “Хоорондоо холбоо хамаарал бүхүй функцууд олон янз байдаг... D ба F хэлбэрийн функцүүд уялдаа холбоотой”²⁸ гэжээ. Эдгээр функц нь хоорондоо холбоо хамааралтай байснаар логик эрэмбийг бүрдүүлнэ хэмээн Пропп үзсэн юм. Харин $[D^3E^3F^1]$ функц нь “Алтан мөнгөн аргай үлгэр”-т *баатар нас барсан хүний захиасыг дамжуулах, дамжуулахгүй* гэсэн утга бүхий функц нь Чагаа хүү уйлж байгаад дөрвөн хөлийг нь дөрвөн тийш залаад, толгойг нь урд зүг залаад зүрхийг нь өвөртлөөд унтлаа гэсэн хэрэг явдлаар илэрч байна. Үүний дараагаар “Хойд өглөө босоход нь олон мал өтгөрч, сайн гэртэй, сайхан авгайтай болсон байлаа” гэх хэрэг явдал нь *баатарт шидэт хэрэглэл олгох* F^1 - функц-д таарч байна. Ингэснээр Чагаа хүү бухан бярууны захисан захиасыг биелүүлж, хариуд нь сайн сайхантай учирч байгаа нь дээр дурдсан логик эрэмбийг бүрдүүлжээ.

Найман хөлтэй найр алаг морь

$A^8D A^6A^{14}Rs^8$

Үнэг

$Rs^8D Pr^6F^6H^3(neg)I^2$

Бухан бяруу

$[D^3E^3F^1]$

Эдгээр гурван шидэт туслагчийн функцийг үзвэл, үлгэрийн хорон санаатан болох мангас эмгэний мөшгөлтөөс Чагаа хүүг аварч, цаашдын үйл хэргийг нь нөхцөлдүүлж байна. Тухайлбал, Чагаа хүүгийн найман хөлтэй найр алаг морь нь мангас эмгэнд хорлогдож, явганаар явах болдог. Ийнхүү мангас эмгэнээс зугтааж, алтан улиас модонд гарснаар Чагаа хүүд туслахаар үнэг гарч ирдэг. Үнэг хүүг модноос буулгасны дараагаар бухан бяруу тааралдаж, мөн л мангас эмгэнээс зугтаахад нь тусалдаг. Тиймээс дээрх шидэт туслагчид нь баатар ямар нэг бэрхшээлтэй тулгармагц ар араасаа дараалан үүргээ гүйцэтгэж, үлгэрийн үйл явдлыг баяжуулж буйгаараа онцлогтой.

“Ягаан морьтой Ягандуран хүү” болон “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрийн шидэт туслагчийн дүрийг шинжлэхэд удаах онцлогтой байна. “Ягаан морьтой Ягадуран хүү” үлгэрийн шидэт туслагч нь буга, согоо хоёр, эмгэн, ягаан морь болон хангарди юм. Буга, согоо хоёр нь үлгэрийн зангилаа хэсэгт гарч байгаа бөгөөд үлгэр цааш өрнөх суурь нөхцөлийг бүрдүүлжээ. Учир нь *гэрээсээ гарч буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно* β^1 - функцэд хамаарах Ягандуран хүүгийн эх гэрээсээ гарч, булаг дээр очоод, буга, согоо хоёр “Ягаан морь нь гадаа л бий биз, ясан тэвхрэг нь тэр дээрээ л байгаа биз...Яаж нэг уулзъя даа”²⁹ хэмээн ярьж байхыг сонсдог. Уг хэрэг явдлаас үүдэн эх нь хүүдээ хэл дамжуулж, Ягандуран гэрээсээ гарах буюу $\uparrow$ *Баатар гэрээс*

²⁸ Propp, 48-49.

²⁹ MAY, 89.

гарах функц илэрдэг. Ийнхүү Ягандуран хүү гэрээсээ гарч, “Буга согоо хоёрыг харваад...” орхиход шүрэн дээл үлдээгээд тэнгэр лүү нисээд явчихдаг юм. Эл хэрэг явдал нь F^3 - шидэт хэрэглэл бүтээгдэх, F^1 - баатарт шидэт хэрэглэл олгох функцтэй таарч байна. Шүрэн дээлтэй болсноор f^1 - материаллаг мөн чанартай бэлэг функцэд тохирох “Маргааш өглөө нь боссон чинь таван хошуу мал нь тал дүүрэн бэлчсэн, тансаг сайхан идээ нь таваг аягаар нь дүүрэн...”³⁰ болсон байдаг. Ингээд хаан Ягандуран хүү яаж баяжсан тухай асуулгахаар элч явуулдаг. Тийм учраас үлгэрийн гол баатрын эх гэрээсээ гарч, буга согоо хоёрын яриаг эс сонссон бол эл үлгэрийн үйл явдал цааш өрнөхгүй, баатар гэрээс гарах, алив зүйлийг далдлан нуух зэрэг үлгэрийн үйл явдал цааш өрнөхгүй юм. “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт буга, согоо хоёрыг агнасны дараа шүрэн дээл хоцроон, тэнгэрт нисэн одож буй нь “Монгол домгийн өгүүлэмжээр энэ ертөнцийг анх туурвихад буулгасан, анхны туруутан амьтан...монгол ардын оньсого тааварт “Тэнгэрийн хаан Титмээ гэнэ” гэхчлэн бугыг дээд тэнгэрийн хаан хэмээн өргөмжилж буй нь буга тоглоомын журмын санаа...”³¹ буюу бугыг тэнгэртэй холбон үзэх сэжим бүрдүүлж байна.

Удаах шидэт туслагч нь “Эмгэн” юм. Ийн үзэж буй учир нь Ягандуран хүүгийн цаашдын үйл хэргийг бүтэмжтэй байлгах үүднээс захиас захиж буйд оршино. Хаан Ягандуран хүүг тэнгэрийн цагаан ингэний сүү авчир хэмээн тушаахад хүү “Хойд зүгт яваад л байж... гурван өдөр гурван шөнө яваад нэгэн оосор бүчгүй орд цагаан өргөө байхыг үзэж гэнэ” (G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах), “Хүрээд очсон чинь настай эмгэн гарч нохой хорьж өгөөд мэнд усаа мэдэлцэж” (D^2 Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих), “Ягандуран хүү хэрэг зоригоо хэлж дээ” (E^2 Баатар шидэт туслагчийг мэндлэхэд хариу өгөх, өгөхгүй), Эмгэн Ягандуран хүүг явахад нь ингэж захижээ. За чи замдаа тохиолдох гурван хонхрыг давбал хэргээ биелүүлж чадна... (F^1 Баатарт шидэт хэрэглэл олгох) хэмээн Ягандуран хүүд захиас захидаг нь шидэт хэрэглэл нь зөвхөн эд өлгийн зүйлс бус үг, захиас ч болно. Хэрвээ уг үлгэрт эмгэн байгаагүй бол Ягандуран хүү замд гурван хонхор тааралдана гэж урьдчилан мэдэхгүй бөгөөд цаашид эрж явсан тэнгэрийн цагаан ингэний сүүгээ олж эс чадах юм.

Ягандуран хүү эмгэний захиасаар цааш замдаа явахдаа гурван хонхрыг дайран өнгөрдөг. Гурав дахь хонхрыг өнгөрөөд явж байтал, морь нь гэнэт хүний хэлээр “За эзэн минь чи тэр уул шиг, үүл шиг хар юмыг харж байна уу? Тэр бол

³⁰ МАҮ, 89

³¹ Г. Нандинбилиг, *Монгол тоглоомын зан үйл: Дүр, бэлгэдэл* (Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2024), 104.

тэнгэрийн цагаан ингэний ботго байгаа юм. За чи миний хондлойноос гурван хуруу өргөн аргамж зүсэж аваад ботгыг оосорлож аваад чирээд давхичхаарай”³² гэж хэлдэг нь *донорын анхны үйлдэл* - D функцэд таарах хэрэг явдал юм. Уг үлгэрийн шидэт туслагч нь дээр дурдсан “Болдоггүй бор өвгөн” үлгэрийн нисдэг бор морьтой адил “заяамал” шинжтэй байна. Учир нь Ягандуран хүүгийн унадаг ягаан морь нь үлгэрт гардгаар “Ягандуран хүүгийн байгаа хөрөнгө, эдэлдэг эдлэл нь гэвэл ягаан морь, ясан тэвхрэг хоёроос өөр юу ч байхгүй...”³³ (МАУ, 1982: 89) буюу үлгэрийн баатарт анхнаасаа байсан “заяамал” хөрөнгө болох юм. Тийн Ягандуран хүү мориныхоо хэлснээр хондлойноос нь зүсэж аваад, ботгыг оосорлон давхидаг. Тэгсэн эх нь ботгоныхоо араас хөөн ирж, Ягандуран хүү гүйцэгдэхийн даваан дээр ботгыг нь үлдээнэ. Морь нь “За одоо хоёул энд унтана. Маргааш нар гарахаас өмнө ингэний явсан мөрөөр очвол сүүгээ гоожуулсан байх вий” гэж хэлснээр маргааш нь очвол ингэний сүү тогтсон байх аж. Үүнээс үзвэл, ягаан морь Ягандуран хүүд тэнгэрийн цагаан ингэний сүүг авахад тусалж буй учир “шидэт туслагч” мөн.

“Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийн шидэт туслагч хангардийг синтагматик анализын хүрээнд авч үзье. Уг үлгэрийн шидэт туслагч болох Хангарди шувуу, Ягандуран хүүтэй учирч буй хэсгийг авч үзвэл доорх шинжтэй байна.

$$D^2 E^2 K^4 N U K^1$$

Шидэт туслагч баатартай учирмагцаа баатрын мэндийг мэдэх юм уу, эсвэл асуулт асуудаг. D^2 - *шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих* нь функц ёсоор “...Та ямар хэргээр яваа вэ?” хэмээн Хангарди шувуу Ягандуран хүүгээс асуухад, “Аа би хангарди шувууны өдийг хаандаа олж өгөхөөр явна...” гэдэг. Хариуд нь Ягандуран хүү Ягандуран хүү Хангардийн охидыг аварга могойн аюулаас аварсан тул, Хангарди “Миний охидыг аварсан танд би бүх зүйлээрээ тусалъя” хэмээнэ. Ингэснээр баатар Хангардийн өдийг авч хайж байсан зүйлээ олж байгаа нь K^4 - *баатар хайж буй зүйлээ өмнөх үйлдлийн үр дүнд олж авах* функцтэй таарах юм.

Эл үлгэрийн шидэт туслагч Хангарди нь нэрийн гарлын хувьд “...эртний энэтхэгийн вээдийн домгийн “garuda”-аас гаралтай. Вээдийн болон хиндү шашны домогт “Вишнүү тэнгэрийн хөлгө болдог”³⁴ Түүнчлэн бидний судалж буй “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт Ягандуран хүү хааны зарлигаар

³² МАУ, 91

³³ МАУ, 89-91

³⁴ С. Дулам, *Хүрээ дөрвөн уулын тахилга, бэлгэдэл* (Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК., 2004), 286.

Хангарди шувууны өд авч ирэхээр эрж явахдаа хангардийн гурван охинтой учирдаг. Тэдгээр гурван охид нь аварга могойд идүүлэх ээлжээ хүлээж, “нэг нь уйлж, нөгөө нь бодол болж, гурав дахь охин нь дуулж”³⁵ суудаг. Эл өгүүлэмж нь “...Эртний энэтхэгийн Вээдийн домог зүй, “Махаабхаарада” их туульсын хангарди, могой хоёрын дайсагналын өгүүлэмж байна”³⁶. Тиймээс “...Хангарди шувуу нь энэтхэг гаралтай боловч монгол газрын соёлд идээшин жигүүртний хаан шувуу болж, улмаар зарим газар орны шувуун шивдагтай байсан уул усны эзнийг орлон эзэгнэх болсон шиг байна” гэж профессор С. Дулам дүгнэжээ.

Харин “Хаан, хүргэн, хангарди шувуу” болон “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт “Хангарди” ижил бус өгүүлэмжтэйгээр дүрслэгдэж байгаа юм. Тухайлбал, “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрт Хангарди шувуу нь “...Хааны адуунд шөнө бүр алтан цээжтэй мөнгөн бөгстэй унага гараад...” байсныг хулгайлдаг. Харин “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт Ягандуран хүү хааны зарлигаар “хангардийн өд”-ийг эрэхээр явдаг бөгөөд замдаа Хангардийн гурван охиныг аварга могойн аюулаас авардаг. Ингэснээр Хангарди охидыг нь аюулаас аварсны төлөө өд сөдөө хүүд өгч, үйл хэргийг нь гүйцээж буй “шидэт туслагч” дүр юм.

Эдгээр хоёр үлгэрийн баатрууд бол В. Проппын тодорхойлсноор “seeker hereos” буюу эрэлч хайгуулч баатрууд юм. В.Пропп үлгэрийн баатрыг хоёр төрөлд хувааж болно хэмээн үзэж, “эрэлч хайгуулч баатар”, “хохирч үлдсэн баатар” хэмээн ангилсан байна³⁷. Эдгээр үлгэрт баатар ямарваа нэгэн зүйлийн эрэлд гардаг. Жишээлбэл, “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрийн Тархай хожгор хүү хааны “алтан цээжтэй, мөнгөн бөгстэй” адууг эрэхээр явдаг бол “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийн Ягандуран хүү хааны зарлигаар “Тэнгэрийн цагаан ингэний сүү, хангардийн өд” зэргийн эрэлд гардаг. Тийм учраас Тархай хожгор хүү, Ягандуран хүү хэмээх үлгэрийн баатруудыг “эрэл хайгуулч баатар” (seeker hereos) гэж үзэх нь зүй юм.

“Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрт Хангарди шувууны дүр нь үлгэрийн зангилаа хэсэгт гарч байна. Ингэхдээ, *A⁵ - хорон санаатан өөр аргааг хулгайлах гэж оролдох* функцтэй тохирох хэрэг явдал нь “...Найман хүргэн ээлж дараагаар манаад хулгайчийг олж чадсангүй унагаа алдчихжээ” юм.

“Хаан, хүргэн, хангарди шувуу” болон “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт адил болоод ялгаатай өгүүлэмж байна. Ижил өгүүлэмж нь хоёр үлгэрийн баатад нь В. Проппын ангилал ёсоор “эрэл хайгуулч” баатар болох

³⁵ МАУ, 92.

³⁶ С. Дулам, *Хүрээ дөрвөн уулын тахилга, бэлгэдэл* (Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК., 2004), 56.

³⁷ Vladimir Propp, *Morphology of the Folktale* (University of Texas Press., 1968), 39.

юм. Ялгаатай өгүүлэмж “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрт хааны алтан цээжтэй, мөнгөн бөгстэй адууг хулгайлснаар Проппын 31 функц ёсоор “(А) хорон санаатан”-ы функц-д харьяалагдаж байна. Харин “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрт хангарди Ягандуран хүүд өд сөдөө өгч, үйл хэрэгт нь тусалдаг шидэт туслагчийн үүргээ гүйцэтгэж буйгаараа ялгаатай юм.

ДҮГНЭЛТ

Монгол аман зохиолын төрөл зүйл болох үлгэрийн шидэт туслагчийн дүр, өгүүлэмжийг синтагматик анализын хүрээнд шинжлэн, дараах дүгнэлтэд хүрч байна.

Анхлан, “Болдоггүй бор өвгөн”, “Алтан мөнгөн аргай” болон “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрийн шидэт туслагч нь ихэвчлэн өгүүлэгдэхүүн дарааллын өрнөл хэсэгт гарч байна. Үлгэрийн шидэт туслагч өрнөл хэсэгт илэрч буй нь үйл явдлыг баяжуулж, баатрын цаашдын үйл хэргийг нөхцөлдүүлэгч шинжтэй юм. Харин “Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэрийн шидэт туслагч нь зангилаа хэсэгт гарч буйгаараа бусад үлгэрээс ялгарах онцлогтой юм. Уг үлгэрт шидэт туслагч нь зангилаа хэсэгт гарч байгаа нь үйл явдал цааш өрнөх суурь нөхцөлийг бүрдүүлжээ.

Хоёрдугаарт, эдгээр үлгэрийн функцийн цувааг ажиглан үзвэл дараах функц үлгэр дотооддоо тогтвортой давтагдаж байна. “Болдоггүй бор өвгөн” үлгэрт $G'A^{13}$ функц үйл явдлын цуваа байдлаар, “Алтан мөнгөн аргай” үлгэрт $F^6H^2FD^3$ $[D^3F^3F^1]$ функц хоорондоо холбоо хамаарал бүхий хэлхээг үүсгэжээ. Нийт үлгэрт тогтвортой буй функц нь баатар гэрээс гараад (†) хорон санаатан эсвэл шидэт туслагчтай учирч буй А, D функцүүд цуваа байдлаар илэрч байгаа юм. Эдгээр үлгэрт шидэт туслагч (donor) баатар гэрээс гармагц учирч байгаа нь баатарт тохиолдсон бэрхшээл, дутагдал, гачаалыг даван туулахад чухал үүрэгтэй байна.

Гутгаарт, “Ягаан морьтой Ягандуран хүү”, “Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэрийн “Хангарди” шувууны дүрийг харьцуулан үзвээс ижил болон ялгаатай дүр, өгүүлэмж илэрч байна. Эл хоёр үлгэрийн баатар нь В.Проппын шидэт үлгэрийн баатрын ангилал ёсоор “эрэл хайгуулч” баатрууд болох юм. Харин хангардийн үйлдлийн сэдэл ялгаатай байдлаар илэрч, үлгэрийн функцийн хэлхээнд нэг бол хорон санаатан эсвээс шидэт туслагчийн байдалтай буй юм.

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Монгол ардын үлгэр (Монгол ардын аман зохиолын чуулган I). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1982.

Судалгааны бүтээл

Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х нар. Монгол ардын аман зохиол. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1988.

Дулам, С. Хүрээ дөрвөн уулын тахилга, бэлгэдэл. Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК, 2004.

Дулам, С. Монгол бэлгэдэл зүй II: Өнгө, зүг чигийн бэлгэдэл зүй. Улаанбаатар: Бит пресс ХХК, (2011 [2007])..

Дулам, С. Монгол домог зүйн дүр. Улаанбаатар: Бит пресс ХХК, (2020 [1989])..

Даваадорж, И. Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж. Магистрын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2022.

Нандинбилиг, Г., Дулам, С. Монгол аман зохиолын онол II. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2020.

Нандинбилиг, Г. Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2020.

Нандинбилиг, Г. Монгол тоглоомын аман зохиол: Дүр, бэлгэдэл. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэлийн газар, 2024.

Хорлоо, П. *Монгол ардын явган үлгэр*. Улаанбаатар: Эрдэм шинжилгээний хэвлэх үйлдвэр, 1960.

Гадаад хэлээрх бүтээл

Propp, V. *Morphology of the Folktale*. University of Texas Press, (1968 [1929]).

Sapna Dogra. *The Thirty-One Functions in Vladimir Propp's Morphology of the Folktale: An Outline and Recent Trends in the Applicability of the Proppian Taxonomic Model*. Rupkatha Journal on Interdisciplinary Studies in Humanities, 2017, 410-9.

Товчилсон үгийн жагсаалт

MAY Монгол Ардын Үлгэр

AN ANALYSIS OF CHARACTER AND MOTIF OF THE DONOR IN MONGOLIAN FOLKTALE

Keywords: Fairytale, donor, syntagmatic analysis, function, narrative

ABSTRACT

In this paper, we analyzed the character and motif of donor in Mongolian folktales by using syntagmatic analysis. The study examines selected tales such as “Boldoggui bor uvgun”, “Altan mungun argai”, “Khaan, khurgen, khangardi shuwuu” and “Yagaan moritoy Yaganduran khuu”. Through a formal expression of the sequence of narrative elements, the specific functions performed by the donor are identified. Additionally, the symbolic meanings of the donor, such as the flying brown horse in “Boldoggui bor uvgun”, the fox in “Altan mungun argai”, the deer and old woman in “Yagaan moritoy Yaganduran khuu”, and the khangardi bird in “Khaan, khurgen, khangardi shuwuu” are explored individually. Furthermore, a comparative analysis is conducted on the differing narrative representations of the khangardi in “Khaan, khurgen, khangardi shuwuu” and “Yagaan moritoy Yaganduran khuu”.

ХАВСРАЛТ 1. “БОЛДОГГҮЙ БОР ӨВГӨН” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	“Болдоггүй бор өвгөн” үлгэр ³⁸
α Анхдагч нөхцөл: Орон зай цаг хугацааны хамаарал, гэр бүлийн байдал, ер бусын төрөлт, бэрхшээлээс өмнөх сайн сайхан байдал.	Эрт урьд цагт Болдоггүй Боролзой өвгөн гэж нэг өвгөн байж гэнэ. Энэ өвгөн долоон бор хоньтой, нисдэг бор морьтой, бас нисдэггүй бор морьтой юм гэнэ. Болдоггүй Боролзой өвгөн Болзоотын бор толгойн тэнд овоохой бариад суудаг байжээ. Болоотын бор толгойд долоон бор хонио хариулдаг байжээ. Нисдэг бор морио гэгийнхээ баруун талд уядаг, нисдэггүй бор морио гэрийнхээ зүүн талдаа аргамждаг байжээ.
↑ Баатар гэрээс гарах нь	...Хув бор хониноос нь хундан цагаан хурга гарсанд Хурмаст тэнгэрээ тахина гэж баярлаад хурганы уутанд хийж хээр тавиад хонио буцаагаад ирсэн...
а ⁶ Баатар ямар нэг зүйлээр дутагдах, түүнийгээ авахыг эрмэлзэх	Болдоггүй Боролзой өвгөн “Хув бор хониноос минь хундан цагаан хурга гараасай, Хурмаст тэнгэрээ тайх юмсан” гэж бодож явдаг байжээ
А ¹³ Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах А ⁶ Хорон санаатан бусдын биеийг шархтуулах нь	Хурмастын хон хэрээ нисч ирээд хурганы нь нүдийг ухчихсан байж гэнэ.
G ¹ Баатар агаар дээр нисэх	Болдоггүй Боролзой өвгөн уурлаж, нисдэг бор морио унаж, нисч очоод...
I Хорон санаатныг дарах	...хон хэрээний эвэр хошуугий нь аваад модон хошуу хийгээд тавьчхаж гэнэ.
А ¹³ Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Гэтэл Хурмаст тэнгэр “Хон хэрээний минь хошууг солилоо” гэж уурлаад хоёр чоноороо нисдэг бор морийг идүүлэхээр явуулж гэнэ.
А ¹⁴ Хорон санаатан аллага үйлдэх	Хурмаст хааны хоёр чоно ирээд нисдэггүй бор морийг нь идчихээд явчихаж гэнэ.
G ¹ Баатар агаар дээр нисэх	Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж хөөж очоод...
I Хорон санаатныг дарах	...хоёр чонын арьсыг өвчөөд хоншоорт нь унжуулаад тавьчхаж гэнэ.

³⁸ Монгол ардын үлгэр, эмх. (Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 81-83.

A^{13} Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Тэгэхлээр нь Хан Хурмастаас Болдоггүй Боролзой өвгөнийг даруулахаар Мичид толгойт, Марал толгойт хоёр чөтгөрөө явуулж гэнэ.
A^3 Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр туслахаа явуулах	Хан Хурмаст уурлаж, Болдоггүй Боролзой өвгөнийг хоёр луугаараа ниргүүлэхээр явуулжээ.
A^3 Хорон санаатан ургац, тариаг дээрэмдэх эсвэл сүйтгэх	Хоёр луу Болзоотын бор толшойг бор нүүрс болтол нь ниргээд явчихжээ.
G^1 Баатар агаар дээр нисэх	Болдоггүй Боролзой өвгөн нисдэг бор морио унаж нисч...
I Хорон санаатныг дарах	...хөөж очоод хоёр лууны сүүлийг тас цавчаад явуулжээ.
I^2 Хорон санаатанг өрсөлдөөний үеэр ялах	Хурмаст хаан, тэгвэл тэр чиний зөв гэжээ.

ХАВСРАЛТ 2. “АЛТАН МӨНГӨН АРГАЙ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	“Алтан мөнгөн аргай” үлгэр ³⁹
α Анхдагч нөхцөл: Орон зай цаг хугацааны хамаарал, гэр бүлийн байдал, ер бусын төрөлт, бэрхшээлээс өмнөх сайн сайхан байдал.	Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр байжээ. Өвгөнийг найман зуун адуутай, найр алаг хүлэг морьтой найман настай Чагаа хүүтэй Намтай мэргэн гэдэг юм санжээ. Найман настай Чагаа хүү нь алтан мөнгөн хоёр аргайгаар тоглодог юм санжээ.
β ¹ Гэрээсээ гарч буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно.	Өвгөн нэг өглөө найман зуун адуугаа наашлуулах гэж арын уулаар ан гөрөө хайж, өврийн уулаар адуу малаа хайж...
η ³ Бусад төрлийн залилан эсвэл албадлага (Хорон санаатан баатрыг сүрдүүлэх) ε ¹ Хорон санаатан хүүхдийн байгаа газрын байршлыг олох эсвэл үнэ цэнтэй эд зүйл олохыг оролдох (Хорон санаатын баатрын талаар мэдээлэл олох гэж тандах)	...Гэрийн чинээ гэдэстэй, тогоон чинээ толгойтой том хар мангас эмгэн тосож ирээд «Насан болсон амиа өгөх үү? Найман зуун адуугаа өгөх үү? найман настай хүүгээ өгөх үү? гэж аймшигтайгаар асууж, аван идэн завджээ.
Θ ³ Хорон санаатны заль мэхэнд баатар шууд орох эсвэл хариу үзүүлэх	Насан болсон намайгаа өршөөж хайрла. Найман зуун адууг минь үлдээж хайрла! Найман настай хүүгээ өгье.
↑ Баатар гэрээс гарах нь	Аав аа, аав аа. Би алтан мөнгөн аргайндаа яваад ирье! гэтэл аав нь: «Тэг дээ!» гэжээ... Тэгээд найман хөлтэй найр алаг морио унаад хуучин нутаг бууц дээрээ давхиж ирсэнд...
Α ⁸ Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах	Эмээ нь босвол сууж чаддаггүй, суувал босож чаддаггүй хөгшин шүү. Хүү минь буугаад ав!...
Д Донорын анхны үйлдэл	...Гэтэл найман хөлтэй найр алаг морь нь шивнэв. Би хотойхын сайнаар хотойё. Чи шүүрэхийн сайнаар шүүр...
Α ⁶ Хорон санаатан бусдын биеийг шархтуулах нь	...Хөөсөөр хөөсөөр гүйцэж очоод тэр морины нэг хөлийг нь төмөр (шилбүүрээрээ) хянгараараа тас ширвэв. Найман хөлтэй найр алаг морь долоон хөлөөрөө доголон доголон давхиж явлаа... Тэгээд бас нэг даваа даваад мангас эмгэн цээжийг нь тас цавчив.

³⁹ Монгол ардын үлгэр, эмх. (Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 83-86.

A ¹⁴ Хорон санаатан аллага үйлдэх	Тэгээд бас нэг даваа даваад мангас эмгэн хянгаараа тэр морины толгойг тас цавчив. Тэр морин тэгсээр аргагүй үхжээ.
Rs ⁸ Баатар мод руу авирах	Тэгэхлээр Чагаа хүү явган болж явгаар гүйж нэг талд алтан улиасанд гарлаа.
D Донорын анхны үйлдэл	Тэгээд мангас үндсийг нь цавчих гэж байтал нэг үнэг ирж, “Ээж ээж энэ улиасыг би унагая. Та нэг хэсэг унтаад аваарай... Чагаа хүүг модноос буулгаж билээ”
Pr ⁷ Мөшгигч баатрын хоргодож буй модыг хазах гэж оролдох Pr ⁶ Мөшгигч баатрыг хөнөөх гэж оролдох	Тэгэхлээр мангас хянгаараа алтан улиасны үндсийг цавчина гэж... Тэгээд мангас эмгэн шинэ мөрөөр нь шиншиж, хуучин мөрөөр нь хуншиж, гүйгээд Чагаа хүүг нэхэж...
D Донорын анхны үйлдэл	Тэр хүүг долоон даваа даваад явахад нь их далайн захад бухан бяруу явж байлаа.
F ⁶ Шидэт хэрэглэл гэнэт гарч ирэх	Тэгээд хүү бух бяруу хоёр нэг айлын бууц хүртэл аавын нь билүүний хагархай, ээжийн самны хугархай байсныг оллоо. Ээжийн тэвнэ бас хэвтэж байлаа.
H ² Баатар, хорон санаатан нар өрсөлдөх η ³ (neg) Бусад төрлийн залилан	Тэгэхлээр нь Чагаа хүү ээжийн самаа «Батганын толгой багтахгүй баг хар ширэнгэ бол!» гэж мангас эмгэний урд хаялаа... «Энэ далай мөрнөөр та багачуул яаж гарлаа?» гэж мангас эмгэн асуулаа. «Үхрийн чинээ хоёр чулуу хоёр мөрөндөө уяад холбис холбис гэж гарлаа би» гэж Чагаа хүү хэллээ.
I ² Баатар хорон санаатанг өрсөлдөөний үеэр ялах	Тэгэхлээр нь мангас эмгэн үхрийн чинээ хоёр чулуу хоёр мөрөндөө уяад далай дотор орж далайн ёроолд живж үхсэн боллоо.
D ³ Нас нөгчиж буй болон хэдийнээ нас нөгчсөн хүн захиас захиx нь. [D ³ E ³ F ¹]: Нас барах гэж буй эцэг нь хүүгээсээ булшных нь дэргэд гурав хонохыг гуйх. Хамгийн бага хүү нь ёсоор болгож, хариуд нь морьтой болно.	Тэгээд бух бяруу хэллээ: «За Чагаа хүү минь, чи намайг алаад дөрвөн хөлийг минь дөрвөн тийш залаад зүрхийг минь өвөртлөөд унтаарай» гэж. Тэгсэн Чагаа хүү уйлж байгаад дөрвөн хөлийг нь дөрвөн тийш залаад толгойг нь урд зүг залаад зүрхийг нь өвөртлөөд унтлаа. Хойд өглөө босоход нь олон мал өтгөрч, сайн гэртэй, сайхан авгайтай болсон байлаа.

К ¹ Баатар хайж буй зүйлээ хүч чадлаар эсвэл мэргэн ухаанаар олж авах.	Тэгээд Чагаа хүү алтан мөнгөн аргайгаа аваад аз жаргалаа олоод...
↓ Баатар гэртээ ирэх	Тэгээд Чагаа хүү алтан мөнгөн аргайгаа аваад аз жаргалаа олоод эргэж ирэхэд аав нь адуундаа явчихсан, ээж нь энгэрээ нэвт уйлчихсан байжээ.
δ ¹ Хоригийг зөрчих Γ ⁵ Хорон санаатныг тулалдахгүйгээр ялах	Ээж нь хонь алахаараа үнхэлцгийг нь хүүдээ тавьдаг юм. Тэгэхлээр эцэг чинь намайг юуны чинь хүү гээд зоддог юм...Тэгэхлээр нь хүү авдрынхаа араас гарч ирээд “Үхээгүй хатаагүй хүүд үнхэлцэг тавих ёстой” гээд алтан мөнгөн аргайгаараа “аргай аргай түг” гээд аавынхаа толгойг цохиод алчихжээ.

ХАВСРАЛТ 3. “ЯГААН МОРЬТОЙ ЯГАНДУРАН ХҮҮ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	“Ягаан морьтой Ягандуран хүү” үлгэр ⁴⁰
α Анхдагч нөхцөл: Орон зай цаг хугацааны хамаарал, гэр бүлийн байдал, ер бусын төрөлт, бэрхшээлээс өмнөх сайн сайхан байдал.	Эрт урьд цагт нэг хаант улсад ядуу эхтэйгээ хамт амьдран суудаг Ягандуран хүү гэдэг нэгэн хүү байжээ. Ягандуран хүүгийн байгаа хөрөнгө, эдэлдэг эдлэл нь гэвэл ягаан халзан морь, ясан тэвхрэг хоёроос өөр юу ч байхгүй юмсанжээ. Өдөрт нэг буга алдаг. Нэг өдөр буганд эс явж, хоёр өдөр эс явж, гурван өдөр эс явжээ.
β ¹ Гэрээсээ яван одож буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно.	Тэгсэн эх нь ус авахаар явж байсан алтан булаг дээр нь буга, согоо хоёр “Ягаан морь нь гадаа л бий биз, ясан тэвхрэг нь гэр дээрээ л байгаа биз... Яаж нэг уулзъя даа
	За хө үүнийг чинь хүүдээ очиж хэлэх юм байна даа гээд аргалаа түүсээр гэртээ иржээ. Тэгээд хүүдээ үзсэн зүйлээ хэлж гэнэ.
↑ Баатар гэрээс гарах	Тэгсэн чинь хүү нь ягаан морио унаж, ясан тэвхрэгээ зүүгээд л явж очоод...
F ³ Шидэт хэрэглэл бүтээгдэх F ¹ Баатарт шидэт хэрэглэл олгох	...Буга согоо хоёрыг харваад орхисон шүрэн дээл унагаачихаад тэнгэрт нисээд гарчихжээ.
f ¹ Материаллаг мөн чанартай бэлэг	Маргааш өглөө нь боссон чинь таван хошуу мал нь тал дүүрэн бэлчсэн, тансаг сайхан идээ нь таваг аягаар нь дүүрэн, таван ханатай цагаан гэрт тавтай унтаж байна гэнэ дээ.
γ ² Тушаах эсвэл зааварлах	Хүү явах бүрдээ л эхдээ “За ээж минь ямар ч хүнд баяжсанаа битгий хэлээрэй. Шүрэн дээлээ битгий үзүүлээрэй” гэж захиад явдаг гэнэ.
ε ¹ Баатрын талаар хорон санаатан мэдлэгтэй болохын тулд танадах A ¹³ Хорон санаат ан хэн нэгнийг хөнөөлгөхөөр хүн явуулах	Нэг өдөр тэр нутгийн хаан Ягандуран хүүгийн баяжсаныг мэдэхээр нэг элч явуулжээ.
ε ¹ Баатрын талаар хорон санаатан мэдлэгтэй болохын тулд танадах A ¹³ Хорон санаатан хэн нэгнийг хөнөөлгөхөөр хүн явуулах	...Хаан бодож байгаад заль хэрэглэхээр шийдэж нэг шивгэчин эмгэнийг явуулжээ.

⁴⁰ Монгол ардын үлгэр, эмх. (Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 89-93.

η¹ Хорон санаатан баатрыг ятгах гэж оролдох Ө¹ Баатар хорон санаатны бүх ялгалгад өртөх нь	Эмгэн ирээд Ягандуран хүүгийн эхтэй уулзаад яаж баяжив? Гэж асуухад нь эмгэн яагаад ийгээд баяжсан гээд л бас л хэлсэнгүй...Тэгэхлээр шивгэчин эмгэн чи бид хоёр тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу байж хэнээсээ юу нуух вэ? Чи надад хэл л дээ гэж ятгасаар байгаад эмгэнээр учрыг хэлүүлж гэнэ.
ε¹ Баатрын талаар хорон санаатан мэдлэгтэй болохын тулд танадах	Тэгээд эмгэнийг цаашаа харахынх нь хооронд шүрэн дээлий нь аваад зугтаачихаж гэнэ.
λ Хуурмаг хэлцлээс үүдсэн урьдчилсан азгүйтэл	...Өглөө боссон чинь хуучин ядуу хэвэндээ болчихсон орц овоохойныхоо мухарт хэвтэж байна гэнэ.
ζ² Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт.	...Шүрэн дээл өмссөн хаан би сайхан байна уу?... Хаан та шүрэн дээл өмсөөд мөн сайхан байгаа юм. Тэнгэрийн цагаан ингэний сүүгээр нүүрээ угаавал бүр ч сайхан болно доо.
В² Баатар шууд яван одох	Хаан Ягандуран хүүг дуудаж авчраад Тэнгэрийн цагаан ингэний сүүг олж ирэхийг тушаагаад явуулжээ.
↑ Баатар гэрээс гарах G² Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Ягандуран хүү ягаан морио унаад ясан тэвхрэгээ үүрээв явж гэнэ.
G² Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Хойд зүгт яваад л байж, яваад л байж, гурван өдөр гурвөн шөнө яваад нэгэн оосор бүчгүй орд цагаан өргөө байхыг үзэж гэнэ
D² Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих нь.	Хүрээд очсон чинь настай эмгэн гарч нохой хорьж өгөөд мэнд усаа мэдэлцэж Нүдэндээ галтай Нүүрэндээ цогтой Шилэндээ шандастай Шилбэндээ чөмөгтэй залуу хүү хаачиж явна вэ? гэж асуужээ.
E² Баатар шидэт туслагчийг мэндлэхэд хариу өгөх, өгөхгүй	Ягандуран хүү хэрэг зоригоо хэлж дээ.
F¹ Баатарт шидэт хэрэглэл олгох (Шидэт хэрэглэл нь зөвхөн эд өлгийн зүйлс бус үг, захиас ч байж болно)	Эмгэн Ягандуран хүүг явахад нь ингэж захижээ. За хүү минь эр бисийнхээ мэнд дээр эмээл хазаарынхаа бүтэн дээр буцсан чинь дээр байсан биш үү. За чи замдаа тохиолдох гурван хонхрыг давбал хэргээ биелүүлж чадна...

G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Ягандуран хүү цааш явсаар нэг их хонхорт оржээ...Нэлээд яваад нум сумаар дүүргэсэн нэг хонхорт оржээ.
K^2 Хайж буй объектыг хэд хэдэн хүмүүс өөрсдийн үйлдлээр тус тус хурдтайгаар солилцон олж авах. K^3 Баатар Шидэт хэрэглэл (шидэт туслагч)-ийн тусламжтайгаар хайж буй зүйлээ олж авах.	Явсаар байтал морь нт гэнэт хүний хэлээр За эзэн минь чи тэр уул шиг үүл шиг хар юмыг харж байна уу, тэр бол тэнгэрийн цагаан ингэний ботго байгаа юм. За чи миний хондлойноос гурван хуруу өргөн аргамж зүсч аваад ботгыг оосорлож аваад чирээд давхичхаарай.
K^7 Баатар хайж байсан зүйлээ барьж авах	Хүү мориныхоо хэлснээр ботгыг оосорлож аваад чирээд давхиж гэнэ.
Pr^1 Мөгшигч баатрын араас нисэх	Тэгсэн чинь эх нь хойноос нь хөөгөөд л ирж яваа харагдаж гэнэ...Тун гүйцэгдэхийнхээ даваан дээр ботгы нь хаячихаад давхижээ.
F^6 Тэр аяндаа гарч ирэх	За одоо хоёулаа энд унтана. Маргааш нар гарахаас өмнө ингэний явсан мөрөөр очвол сүүгээ гоожуулсан байх бий.
K^5 Баатар Шидэт хэрэглэл (шидэт туслагч)-ийн тусламжтайгаар хайж буй зүйлээ олж авах ↓ Баатар гэртээ ирэх	Маргааш нь очиход үнэхээр сүү нь царцчихсан нь бүтэн тойром болоод байжээ. Хүү түүнээс нь аваад буцжээ.
η^1 Хорон санаатан баатрыг ятгах гэж оролдох	...Хаан нөгөө сүүгээр нь нүүрээ угаачихаад л шадар түшмэдүүдээ цуглуулаад...Аа хаан минь ингэний сүүгээр нүүрээ угаагаад ийм гоё байгаа юм, Хангардийн өд малгайндаа хатгавал бүр ч гоё болно доо.
B^2 Баатар шууд яван одох (Тушаал эсвэл хүсэлтээр)	...Тэгэхлээр нь хаан Ягандуран хүүг бас л дуудаж авчраад За чи надад Хангарди шувууны өдийг авчир.
↑ Баатар гэрээс гарах G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	...Тэгэхээр нь Ягандуран хүү ягаан морио унаж, ясан тэвхрэгээ зүүгээд л явж гэнэ.
G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	...Яваад л байж, яваад л байж. Тэгтэл тээр хойно нэг цагаан гэр харагдаж гэнэ.
ζ^2 Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт.	Очоод морио гадаа нь уячихаад ороод очжээ... Харсан чинь нэг нь уйлж байна гэнэ ээ...Намайг нөгөөдөр иднэ...

P^2 Хорон санаатанг задгай талбайд буулгаж авах E^9 Тулаанд ялах	...Тэгж байтал нар шингэх болж гэнэ...том хар юм цухуйж байна гэнэ. Тэгэхээр нь Ягандуран хүү за энэ ч толгой нь мөн биз гэж тааварлан бодоод яг голд нь сумаа тааруулж байгаад татаж тавив.
D^2 Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих нь.	...Тэгтэл салхи намдаад нэг сайхан хүүхэн ороод ирж гэнэ...Миний охидыг аварсан танд би бүх зүйлээрээ тусалъя. Та ямар хэргээр яваа вэ?...
E^2 Баатар нөхөрсгөөр мэндлэх	...Аа би хангарди шувууны өдийг хаандаа олж өгөхөөр явна даа...Үзсэн мэдсэн юм юу байна. Та надад тусалбал би их баярлана.
K^4 Баатар хайж буй зүйлээ өмнөх үйлдлийн үр дүнд олж авах	Тэр ч болно. Хангарди гэдэг бол би байгаа юм аа. Би танд тусалж өгнө...За чи надаас сүүлд гэрээс гараарай. Би түрүүлээд гаръя гэжээ. Хүү хэлснээр нь хоцорч байгаад гараад ирсэн чинь үүдний нь өмнө асар том шувуу сууж байна гэнэ...За чи миний сүүлний өднөөс хоёрыг аваад морьтойгоо миний нуруун дээр суу.
E^x Хуурамч баатар илчлэгдэх	...Очоод чи хаандаа энэ өдийг өгөөд тэндээ сууж бай. Хаан энэ өдийг хатгаад л түшмэдүүдээсээ Би сайхан байна уу? л гэх байх. Хэрэв зүүн урд суусан түшмэд дуугарахгүй байвал би тоонон дээр нь сайхан өнгөөр донгодно. Чи тэгэхлээр яасан сайхан шувуу вэ? гээрэй. Тэгэхэд нь би тэр түшмэлийн уушги зүрхийг сугалаад хааны өвөр дээр хаячихна...
N Баатар даалгаврыг биелүүлж дуусгах	Тэгээд л хаандаа өдөө аваачиж өгчихөөд байж дээ.
U Хорон санаатан шийтгэгдэх	...Тэгтэл ч нөгөө шувуу тооноор нь урт гэгчийн төмөр хошуу оруулж ирээд л нөгөө түшмэдийн уушги зүрхийг амаар нь гаргаад хааны өвөр дээр хаячихжээ.
K^1 Баатар хайж буй зүйлээ хүч чадлаар эсвэл мэргэн ухаанаар олж авах.	...Тэгэхлээр нь хаан чи үүнийг зайлуулбал чамайг би үнэнч байсны чинь хувьд чиний шүрэн дээлийг буцааж өгнө гэжээ...Хүү тэгэхлээр нь түүнийг зайлуулж хаячихаад хөгшин эхийнхээ хамт урьдын адил элбэг, баялаг эд малтай айх аюул, алдаж осолдох гарзгүй амар сайхан амьдран сууж болжээ.

ХАВСРАЛТ 4. “ХААН, ХҮРГЭН, ХАНГАРДИ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	“Хаан, хүргэн, хангарди шувуу” үлгэр ⁴¹
α Анхдагч нөхцөл: Орон зай цаг хугацааны хамаарал, гэр бүлийн байдал, ер бусын төрөлт, бэрхшээлээс өмнөх сайн сайхан байдал.	Урьд нэг хаан байжээ. Есөн сайхан охинтой юм байжээ. Эгчмэд найм нь цөм хаан аавын зориг зарлигийг дагаж, уг сурвалжтай, ухаантай бодолтой эрд очжээ. Харин отгон охин нь тэгсэнгүй тархай хожгор хүүтэй суух гэдэг байжээ. Хаан эцэг, хатан ээж, олон эгч нар нь аргадаж аашилж элдвээр явгатал ер болохгүй тулд аргагүй тэр хоёрыг гэрлүүлэх болж хотныхоо хойд захад тэнгэрт тулсан хар овоохой барьж өгчээ.
B ⁴ Золгүй явдал тохиосныг дуулгах	Тэгж байтал хааны адуунд шөнө бүр алтан цээжтэй мөнгөн бөгстэй унага гараад алга болоод байдаг болов.
A ⁵ Хорон санаатан өөр аргааг хулгайлах гэж оролдох нь	Найман хүргэн ээлж дараагаар манаад хулгайчийг олж чадсангүй унагаа алдчихжээ.
A ⁵ Хорон санаатан өөр аргааг хулгайлах гэж оролдох нь	Тэгтэл нь хаан өөрөө манаад ч бас хэн авсныг олж чадсангүй унагаа алджээ
ε ² Хорон санаатны талаар мэдээлэл авах гэж баатар тандах	Тархай хожгор хүү тэр хүргэдийн адил адуу маная гэж гуйдаг боловч түүнийг тоодоггүй байжээ.
ζ ³ Өөр аргаар мэдээлэл олгох	Адаг сүүлд нь Тархай хожгор хүргэнээр мануулахаас өр аргагүй болжээ.
A ⁵ Хорон санаатан өөр аргааг хулгайлах гэж оролдох нь	Тэгтэл аварга том Хангарди шувуу нисч ирээд өнөөх алтан цээжтэй мөнгөн бөгстэй унагыг нь шүүрэн аваад нисжээ.
B ² Баатар шууд яван одох	Адаг сүүлд нь одоо түүгээр мануулахаас аргагүй болжээ.
B ⁴ Бусад хэлбэрээр золгүй байдлыг зарлах	Дэвэн дэлхийг тойрч байгаад ч хамаагүй тэр хулгайчийг олж алтан цээжтэй, мөнгөн бөгстэй адуугий минь тууж ир гэж зарлиг буулгав.
С Эрэл хайгуулч баатар эсэргүүцэх эсвэл зөвшөөрөх	Адууны эрэлд чинь би явалцъя гэж тархай хоцгор хүүг гуйхад...
↑ Баатар гэрээс гарах нь	Гэргийтэйгээ салах ёс хийгээд хүргэдийн хойноос гэлдэрч гарчээ.
G ² Баатар газар дээр эсвэл усан дээр явах	...Харин бага хүргэн явсаар л байжээ.

⁴¹ Монгол ардын үлгэр, эмх. (Д. Цэрэнсодном (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар., 1982), 96-99.

$D^2(neg)$ Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих нь.	Эмгэнээс үг асуусан чинь эс тоож дуугарсангүй гэнэ.
F^1 Хорон санаатан тулалдаан, өрсөлдөөнгүйгээр ялагдах	Гэнэт хуй салхи босч Хангарди гэрийн тоонон дээр суухыг завдмагц тархай хожгор хүргэн татсан сумаа харвасан нь амин зүрхээр нь орчихжээ.
G^3 Баатрыг ямар нэгэн зүйл замчлах	Тэгж Гарьдыг алчихаад гэрт нь эргэж ирж өнөөх эмгэнээс шаардаж байж хангарьдын хулгайлсан олон унага хаана байгааг заалгаж авчээ.
K^1 Баатар хайж буй зүйлээ хүч чадлаар эсвэл мэргэн ухаанаар олж авах.	Тэр ерөн есөн алтан цээжтэй мөнгөн бөгстэй адуугаа олж авч туугаад эргэжээ.”
A^{15} Хорон санаатан хэн нэгнийг хорих	Тархай хожгор хүргэнийг энэ сүрэг адууг олоод ирснийг үзээд тэд атаархах сэтгэл төрөөд түүнийг хорлохоор шийджээ.
A^{15} Хорон санаатан хэн нэгнийг хорих	Тэгээд тавин алд там нүх малтаж, хивсээр бүтээгээд адуу олж амьд ирсэнд найр хурим хийнэж гэж өнөөх хивсэн дээрээ суулгахаар зэхсэн юм байжээ
Rs^0 Баатар амь аврагдах D^4 Хоригдол чөлөөлөхийг хүсэх	Өнөөх хүү нүхэнд үхдэгийн даваан дээр болж байтал унасан шарга морь нь ерөн есөн алтан цээжтэй, мөнгөн бөгстэний адууны дэл сүүлийг хоньчин хүүхнээр томуулж...эзнээ гаргаж авчээ.
↓ Баатар гэртээ ирэх	Нүхнээс гаргаж авсан морь хоньчин хүүхэн хоёрт баярлахын ихээр баярлаад...амар сайн явж харьжээ.
E^5 Баатар хорон санаатанд өршөөл үзүүлэх U neg “Хуурамч баатар, хоёрдогч хорон санаатан нар шийтгэгдэх”	Өнөөх хүргэдийн бүтэлгүй муу явдлыг дуулж мэдээд цөмийг цаазлан хороох гэсэн боловч бага хүргэн ууч сэтгэлээр өршөөсөн тулд больжээ.
T^1 Биеийн шинэ дүр төрх w^0 Мөнгөн шагнал болон төгсгөл хэсэг дэх шагналын бусад хэлбэр	Бага дагина, бага хүргэн хоёрыг эрхэмлэн хүндлэх болсон тулд тархай хожгор хүү маань мөн биедээ хувилаад гоо сайхан хатантайгаа амар сайхан жаргаж...
W Баатар гэрлэж, хаан ширээнд суух	...Гоо сайхан хатантайгаа амар сайхан жарган сууж хааныг нас барахад хаан төрийн хэргийг мэдэх болжээ.



ДОРНО ДАХИНЫ АРД ТҮМНИЙ ЕРТӨНЦИЙН ҮҮСЛИЙН ДОМОГ ЗҮЙН ӨГҮҮЛЭМЖИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Мөнхбаярын АДЪЯАСҮРЭН
МУИС. ШУС.

*Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим
Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол
хөтөлбөрийн 2-р түвшин*

Удирдагч багш: С. Дашдэжид (PhD, дэд профессор)

Товч агуулга: *Ази тивийн өргөн уудам нутагт оршин суудаг Монгол, Энэтхэг, Хятад, Япон зэрэг улс түмний соёл, урлаг, утга зохиол, байгаль, нийгмийн үзэгдэл нь түүхэн хөгжлийнхөө явцад харилцан хамааралтай байдаг. Мөн тэдний эрт үеэс дэлхий ертөнцийг хэрхэн үзэж, төсөөлж, домоглож байсныг илтгэх үлгэр домог тэр дундаа ертөнц, нар, сар, одон эрхис, хүний үүслийн домгийн өгүүлэмж ижил байгааг анзааран тэдгээр улс үндэстэн бүрээс хэд хэдэн домгийн хувилбарыг нэгтгэн цуглуулж, өгүүлэмж, дүр дүрслэлийг харьцуулан судалж ертөнцийг үзэх үзэл, төсөөлөл, сэтгэлгээний онцлогийг тодруулахыг зорилоо.*

Түлхүүр үг: *Дорно дахин, ертөнцийн үүсэл, домог зүй, домгийн дүр*

УДИРТГАЛ

Монгол аман зохиол судлалд домог, домог зүйн харьцуулсан судалгаа нэн сонирхолтой, ач холбогдолтой билээ. Хүн төрөлхтөн эрт балар, нялх балчир цаг үеэсээ ертөнц хийгээд, аливаа юмс үзэгдлийг нэгдмэл нэг сэтгэхүйгээр таньж мэдэн, тайлбарлаж байсан. Үүнийг нэг язгуур хэлтэй, түүх соёлын нягт харилцаатай, байгаль-газар зүйн нэг мужлалд харьяалагдсан, мөн газар нутаг алслагдмал, түүх, соёлын хувьд харилцан нөлөөлөхгүй ч аливаа домог зүйд түгээмэл байдаг үзэл, төсөөлөл, дүр, дүрслэл, өгүүлэмжтэй улс үндэстэн, ард түмний домог зүй, тэр дундаа ертөнц, нар, сар, одон эрхис, хүний үүслийн домог,

тэдгээрийн ижил төсөө өгүүлэмжийг харьцуулан үзэж, тодруулж болох юм.

Бидний “Дорно дахины ард түмний ертөнцийн үүслийн домог зүйн өгүүлэмжийг харьцуулах нь” сэдэв нь Төв Азийн өргөн уудам нутагт оршин суудаг Монгол, Энэтхэг, Хятад, Япон зэрэг үндэстэн угсаатны ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмжийн ижил төсөө, ялгаатай өгүүлэмж, дүр, дүрслэлийг харьцуулж, тухайн үндэстнүүдийн ертөнцийг үзэх үзэл, төсөөллийн сэтгэлгээний онцлогийг тодруулан, монгол домог зүйн харьцуулсан судалгааг баяжуулж, шинэ сэдэл санаа нэмэрлэх зорилгыг тавьсан юм.

Судлагдсан байдлын хувьд Монгол домог зүйн судалгааны хүрээнд өдий төдий олон эрдэмтдийн хийсэн судалгаа, нэг сэдэвт бүтээл бий. Үүний тухай хэл бичгийн ухааны доктор Ч. Хулан “Монгол болон Уугуул Америкчуудын ертөнцийн үүслийн домог зүйн өгүүлэмжийг харьцуулан судлах нь” нэг сэдэвт бүтээлдээ “монгол домог зүйн судалгаа нь цуглуулан сурвалжлах, ангилан төрөлжүүлэх, дотоод зүй тогтлыг нь нээсэн судалгааны цаг үеийг нэгэнт ардаа орхисон бөгөөд энэ судалгааг Дорж Банзаров, Ц. Жамцарано, Г. Т. Потанин, И. П. Беннигсен, Н. О. Шаракшинова, Г. И. Михайлов, Н. Л. Жуковская, О. Ю. Неклюдов, Д. Шредер, Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ш. Гаадамба, Д. Цэрэнсодном, П. Хорлоо, С. Дулам зэрэг эрдэмтэн судлаачид хийж гүйцэтгэсэн ба одоо ч үргэлжүүлсээр байна.” хэмээсэн байна.

Энэ мэт домог зүй, домог зүйн харьцуулсан судалгаа хийсэн эрдэмтэн судлаачид, тэдний судалгааны өгүүлэл болон нэг сэдэвт судалгааны бүтээл бий хэдий ч монгол домог, тэр дундаа ертөнцийн үүсэл, угсаа гарвалын домгийн өгүүлэмжийг өрнө, дорнын улс орнуудтай харьцуулсан судалгаа цөөн байна. Дорно дахины улс түмний домог зүйтэй харьцуулсан нь Өвөр Монголын эрдэмтэн Г. Намжилын “Монгол домгийн харьцуулсан судлал” хэмээх Монгол домог зүйг Төвд, Энэтхэгийн домог зүйтэй харьцуулсан судалгаа нь нэлээд өргөн цар хүрээтэй, цогц бүтээл бий. Мөн манай эрдэмтэн судлаач, хэл бичгийн шинжлэх ухааны доктор С. Дулам “Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа” бүтээлдээ “Энэтхэг, Монгол домог зүйн харьцааны асуудал”, “Харь гаралтай үлгэр домгийн идээшихэд архетипийн нөлөө: Энэтхэг-Төвөд-Монгол домог зүйн жишээн дээр” өгүүллүүдийг хэвлүүлжээ. Мөн энэ бүтээл дэх “Харьцуулсан домог зүйн судалгааны хүрээ” өгүүлэлдээ одоогоор судлагдаагүй, цаашид харьцуулан судалж болох сэдэв, хүрээг ангилан дурдсан. Үүний дараагаар монгол домог зүйг алтай язгуурт хэлтний домог зүйтэй харьцуулсан “Алтай язгуурт хэлтний одон эрхисийн домгийг харьцуулах нь”, “Алтай хэлт угсаатан үүссэн тухай домгийг харьцуулах нь”, “Монгол, казах домог, үлгэр, туулийн баатар мангас, чөтгөр, шуламсын тухай” зэрэг

өгүүллүүд, Япон, Солонгос домог зүйтэй харьцуулсан “Монгол, япон помог зүйн харьцаа”, “Зүүн хойд Ази дахины эртний домгийн соёлт баатрын тухай”, “Жумонгийн домог, Алунгоогийн домог хоёрыг харьцуулах нь”, “Солонгосын Дангүний домгийг монголчуудын баавгайн домогтой харьцуулах нь” зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллийг бичжээ. Харин дорно дахины улс түмэн хэмээх Монгол, Энэтхэг, Төвд, Хятад, Япон, Солонгос зэрэг орнуудын угсаа гарвал, ертөнцийн үүслийн домгийг нэгтгэн цуглуулж, тусгайлан задлан шинжилж, харьцуулсан судалгаа байхгүй байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Ертөнцийн үүслийн домог нь хүн төрөлхтний хамгийн эртний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл санааг бүхэлд нь агуулдаг бөгөөд тухайн ард түмний соёл, шашин, гүн ухаан, ёс зүй, байгаль, нийгмийн үзэгдлийг уран сэтгэмж, төсөөллөөрөө тайлан үзэх оролдлого юм. Бид энэхүү судалгааныхаа хүрээнд Монгол, Энэтхэг, Хятад, Японы аман болоод бичгийн хэлбэрээр уламжлагдан ирсэн 9 өөр өгүүлэмж бүхий домгуудыг нэгтгэн цуглуулж, бэлтгэсэн бөгөөд эдгээрийн домог зүйн загвар, санаа сэдэл, дэс дараалал, дүр, дүрслэлийн давтамж зэргийг нь задлан шинжилж, харьцуулах юм.

Домог зүйн загварын тухайд эртний дорно дахины улсууд болон монголчуудын дунд ертөнц, газар дэлхий, хүний үүслийн домог голдуу тохиолддог бөгөөд “*бүтээл туурвилын*” “*хувьсал хөгжлийн*” гэсэн хоёр үндсэн загвартай. (Мифы народов мира 1, 1980, 11-12). “*Бүтээл туурвилын*” домог зүйн загвар нь дэлхий ертөнцийг ямар нэгэн ер бусын төрөлхтөн буюу бүтээгч тэнгэр, туурвигч баатар, аугаа ид шидтэн бүтээсэн гэдэг. Харин “*хувьсал хөгжлийн*” загвар нь дэлхий ертөнц анхны тодорхойгүй төлөв байдал буюу эмхгүй юм, түнэр харанхуй, нэлий далай зэргээс аажимдаа хэлбэржих төлөвт шилжсэн гэж үзүүлдэг (Дулам, С. Монгол аман зохиолын онол II, 2022, 42) бөгөөд домгийн өгүүлэмжүүдээ энэ хоёр загварт ангилан хуваана.

Домгийн өгүүлэмжид буй дүрүүдийг амьд болон амьгүй гэж ангилна. Амьд буюу бүтээгч эзэн, туслагч баатар, сөнөөгч баатар нь домгийн гол үйлийн эзэн бөгөөд эдгээрийг тэргүүн, дэд, дэс хэмээн ангилж үзсэн байдаг. Харин амьгүй буюу усан далай, түнэр харанхуй, салхи, шороо, гал гэх мэт нь үйл явдал өрнөж буй газар орон, тэдгээрийн гаднах шинж зэрэг нь дүрслэл болох юм. Мөн эдгээрийг үйл болон үйлийн харьцаа, эзэн үйлийн харьцаа, мөн нэг баатар, нэг дүрслэл, нэг үйл хэдэн домогт хэдэн удаа давтагдаж буйг тодруулж үзнэ.

Сая дурдсан дүрслэл, төлөв төрхийг юуны учир, яагаад, ямар туурвигч

баатар хэрхэн өөрчлөн, хэлбэржин тогтоохоор зорьж буй санаа сэдлийг ялган харьцуулна.

Нэг. Монголчуудын ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмжийн ангилал

Монголчуудын ертөнцийн үүслийн домог дахь анхны эмх замбараагүй их усан далай хэрхэн газар дэлхий болон биежин тогтож буй тухай эртний энэтхэг, хятадын алтан өндөг, галбингаа шувуу, далайн ёроолоос атга шороо авч ирдэг шумбагч баатар, алтан мэлхий, яст мэлхийний нуруун дээр тогтож үүссэн мөн харваач мэргэн баатар, бие биенээсээ өрсөж газар дэлхий, амьтан хүнийг бүтээдэг өрсөлдөгч баатар, мөнх тэнгэр, этүгэн эх гэх мэт өөр хоорондоо ижил төсөө, ялгаа бүхий хэд хэдэн өгүүлэмж байна.

Ертөнцийн үүслийн домгийн нэгдүгээр хувилбарт *“...Хурмаст тэнгэр галбингаа шувууг манай дэлхий рүү явуулжээ. Тэр шувуу гурван түмэн жилийн настай юм байна. Нэг түмэн жил болоод нэг өндөг гаргадаг гэнэ. Тэгээд өндгөө засах хуурай газар олдохгүй усан бөмбөлөг дээгүүр нисч нисч эцэс сүүлд нь өдөө зулгааж, усан дээр үүр засаад өндөглөжээ. Тэр зассан үүрэн дээр нь хумхийн тоос суусаар байгаад газрын хөрс үүссэн гэнэ. Гурав дахь түмэн жил дээр гарсан өндгөөс янз бүрийн амьтан үүсч, сүүлд хүн бий болжээ.”* гэж гардаг. Энэ хувилбарын ертөнцийг бүтээн туурвиж буй баатар нь галбингаа шувуу юм. Харин өгүүлэмжийн хувьд эртний энэтхэгийн Брахмагийн алтан өндөг, хятадын домог зүй дэх аварга том өндөгнөөс үүссэн Пань Гү-гийн өгүүлэмжтэй төстэй байгаагаас гадна энэтхэг домгийн нөлөө хүртсэний жишээ болж байна.

Өөр нэгэн хувилбарт нь тэргүүн туурвигч Очирмани, түүний туслах дэд туурвигч Цагаан-Шунгуд нарын домог бөгөөд энэ нь эхлээд эв эетэйгээр хамтран бүтээн туурвиж байгаад хожим нь нэг нэгнийгээ захирах гэснээс болон зөрчил үүсэн, өрсөлдөгч баатрууд болж байгаа өгүүлэмжтэй. Үүний төсөө өгүүлэмж япон арлыг үүсгэгч Изанаги, Изанами ах дүү хоёр тэнгэрийн домогт бий.

Харин “Галавын үлгэр” (Dulam, Vacek 1983) хэмээх домог туулийн эмхтгэлийн эхэнд байх ертөнцийн үүслийн домог нь Шагжамүни бурхан, харваач мэргэн баатар, яст мэлхий зэрэг туурвигч баатартай бөгөөд хожим бурханы шашин дэлгэрсэн үеэс зохиогдсон байж болох монгол, дорно дахины домог зүй, бурхны шашны үзэл төсөөлөл холилдон оршиж мөн өөр хоорондоо зөрчилдөж буй өгүүлэмжтэй билээ.

Төлөв төрх, дүрслэл: Монголчуудын ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмж дэх газар дэлхий үүсэхээс өмнөх эмх замбараагүй юмны төлөв төрхийн хувьд: нэгдүгээр халх хувилбарт *“манай дэлхий анх одоогийнх шиг хөрс шороо гэж байхгүй усаар бүрхмэл байсан”*, хоёрдугаар халх хувилбарт *“анхандаа газар байхгүй, гал, ус, салхи хольцолдсон юм байжээ.”* гэж, гуравдугаар домогт *“анхан газар дэлхий гэж үгүй нэлдээн ус, далай байсан”* хэмээж, дөрөвдүгээр халх хувилбарт бас л *“анхандаа дэлхий гэж байсангүй агаар, ус хоёр байжээ”* (Дулам, С. 2018, 18) хэмээн ертөнц тогтохоос өмнө нэлдээн усан бүрхмэл, усан галав байснаар дүрслэх нь элбэг байгаа бөгөөд зарим нэг халх хувилбарт “гал ус, салхи хольцолдсон”, “агаар, ус хоёр л байжээ” гэж дүрсэлсэн байна.

Сэдэл санаа: Анхан төлөв буюу нэлий далай, эмх замбараагүйг хэрхэн биежин тогтоохоор зорьж буй санаа нь нэгдүгээр халх хувилбарт *“.. Хурмаст тэнгэр галбингаа шувууг манай дэлхий рүү явуулжээ. Тэр шувуу гурван түмэн жилийн настай юм байна. Нэг түмэн жил болоод нэг өндөг гаргадаг гэнэ. Тэгээд өндгөө засах хуурай газар олдохгүй усан бөмбөлөг дээгүүр нисч нисч эцэс сүүлд нь өдөө зулгааж, усан дээр үүр засаад өндөглөжээ. Тэр зассан үүрэн дээр нь хумхийн тоос суусаар байгаад газрын хөрс үүссэн гэнэ. Гурав дахь түмэн жил дээр гарсан өндгөөс янз бүрийн амьтан үүсч, сүүлд хүн бий болжээ.”* гэж гардаг. Энэ жишээнээс үзвэл туурвигч баатарт өөрт нь өндгөө засах, үрээ бойжуулах, амьдрах тохиромжтой газар орон хэрэгтэй болсны үндсэнд өөрөөсөө өд зулгаан үүр зассанд газрын хөрс тогтож, газар дэлхий бүрэлджээ.

Загвар: Дээр дурдсан олон хувилбар бүхий домгийн өгүүлэмжид буй манай дэлхий анхандаа хөрс шороо гэж үгүй нэл усан бүрхмэл, далай байсныг аль нэг бурхан, чөтгөр, харваач мэргэн баатар, шумбагч баатар зэрэг туурвигч баатар тогтоон бүрэлдүүлж буйгаараа бүтээл туурвилын загвартай бөгөөд ихэнх нь энэ загварт хамаарна.

Дүрийн ангилал: Домгийн баатруудын хувьд ертөнц дэлхийг бүтээж буй туурвигч баатар, түүний зааврыг даган үйлийг гардан гүйцэтгэгч туслагч баатар, мөн бүтээл туурвилыг нь хорлон, эвдэн сүйтгэж, саад учруулдаг сөнөөгч баатар зэрэг байна. Эдгээрийг эрдэмтэн судлаач С. Дулам “Ертөнц тогтсон тухай домог” өгүүлэлдээ *тэргүүн туурвигч буюу Үг санааны эзэн, дэд туурвигч буюу Үйлийн эзэн, Дэс туурвигч буюу Үгүйсгэгч эзэн* хэмээн эмхлэн нэгтгэсэн. Мөн монгол угсаатны ертөнцийн үүслийн домгийн хувилбаруудын туурвигч баатруудын үйл бүтээлийг уг гурван ангилалд хуваан, дүгнэсэн байна.

Тэргүүн туурвигч буюу Үг, санааны эзэн: Бурхан, Бурхан, Шагжамуни, Очирмани, Яст мэлхий

Дэд туурвигч буюу Үйлийн эзэн: Цагаан шунгад, нугас буюу шумбагч шувуу, харваач мэргэн баатар

Дэс туурвигч буюу Үгүйсгэлийн эзэн: Чөтгөр, Эрлэг хэмээн олон хувилбар нэртэй гурван туурвигч баатар оролцсон утгыг харуулжээ.

Хоёр. Энэтхэгийн ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмжийн ангилал

Энэтхэгийн ертөнцийн үүслийн тухай Вээд, Пуран судар, Махабхарата их хөлгөн туульс зэрэгт хэд хэдэн өөр хувилбар домог бий бөгөөд энэхүү илтгэлдээ Махабхарата их хөлгөний тэргүүн боть Аадимбарва дахь хувилбарыг задлан харьцуулж үзлээ.

“Энэ ертөнц гэгч гэрэл гэгээгүй харанхуй бүрэнхий байх цагт өвсөөн бүтсэн Сваямбхү гэгч усанд үр хийж тавьснаас алтан туяа цацарсан өндөг гарчээ. Тэр өндөг хагараад энэ харанхуй ертөнцийн ганц гэрэл гэгээ Брахма тэнгэр төрөв. Брахмаагаас ертөнцийн бүх юм, олон тэнгэр асар нар гарав. Үүний удаагаар мэргэн ариш нар газар, ус, гал, салхи дөрвөн махбод он жил, сар өдөр хүртэл дэс дараагаараа солигдон гарсан” гэж юмс үзэгдлийн үүслийн учрыг тайлдаг. Үүнд буй өндөг хагарч буй өгүүлэмж дэлхий дэхиний домог зүйд түгээмэл тохиолддог бөгөөд дотроо ямар нэгэн шинэ, ер бусын, гайхамшгийг хадгалж байгаад, тэр нь хагарсанаар бүх юмс өөрчлөгдөн, шинэчлэгдэж, нэгэн ер бусын төлөвийг нээж буй бэлгэдэлтэй байж болох юм. Мөн энэ өгүүлэмж нь монголын галбингаа шувуу, хятадын паньгугийг домгийн өгүүлэмжийн эх үүтгэл нь гэж үздэг.

Харин домгийн гол үйл явдал болох *Сваямбхү усанд үр хийж тавьж* буй өгүүлэмж нь бүх юм санамсаргүйгээс бус үйлийн үр буюу ямар нэгэн тодорхой шалтгаан үрээс үүдэж, цаашид үргэлжилнэ гэсэн утгатай. Мөн дэс дараалал нь эхлээд бурхад, дараа нь тэнгэр асар нар, цаг хугацаа, газар дэлхий гэсэн шат дараатайгаар бүрэлдэж буй нь Хиндү шашны дхарма буюу дэс дараа, дэг журмыг илэрхийлжээ.

Төлөв төрх, дүрслэл: *“Эхлээд бүх юм эмх замбараагүй байв.”* хэмээн дэлхий дахины домог зүйн өгүүлэмжийн нэгэн адил хаос оршиж байжээ. Харин тэр эмх замбараагүйг түнэр харанхуй, хоосон харанхуй, гэрэл гэгээгүй бүрэнхий байснаар төсөөлөн дүрсэлдэг байна.

Сэдэл санаа: Энэтхэгийн их хөлгөн Махабхарата туулийн тэргүүн боть Аадимбарвад буй ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмж нь *“Энэ ертөнц гэгч гэрэл гэгээгүй харанхуй бүрэнхий байх цагт өвсөөн бүтсэн Сваямбхү гэгч усанд үр хийж тавьснаас алтан туяа цацарсан өндөг гарчээ. Тэр өндөг хагараад энэ харанхуй ертөнцийн ганц гэрэл гэгээ Брахма тэнгэр төрөв. Брахмаагаас*

ертөнцийн бүх юм, олон тэнгэр асар нар гарав. Үүний удаагаар мэргэн арш нар газар, ус, гал, салхи дөрвөн махбод он жил, сар өдөр хүртэл дэс дараагаараа солигдон гарсан гэж юмс үзэгдлийн үүслийн учрыг тайлдаг.” бүх юм үрээс тогтдог санаа сэдлийг илэрхийлсэн хэдий ч ямар нэгэн амьд биет орших байх газар орны хэрэгцээ гэх мэт зорилго байхгүй, санамсаргүйгээс тогтсон үр гэж үзэж болохоор байгаа ертөнцийг үүсгэх сэдлийнхээ хувьд бусад улс орны домгийг өгүүлэмжээс ялгаатай.

Загвар: Домгийн загвар нь ертөнц бүрэнхий байх цагт усанд үр хийж тавьсан Сваямбхү болон тэр үрээс гарсан өндөгнөөс гарч буй ертөнцийг туурвигч баатар Брахма зэргийн үйл бүтээл, туурвилаар орчлон тогтож буйгаараа бүтээл туурвилын загварт хамаарна.

Дүрийн ангилал:

Дүр	Үүрэг	Утга, бэлгэдэл
Сваямбхү	Усанд үр тавих	Шалтгаан үрийн холбоо
Брахма	Туурвигч баатар	Бүтээгч эзэн
Алтан өндөг	Орчлонгийн хэвлий	Ер бусын шидтэн, бүтээгч баатар төрөх
Тэнгэр асар нар, махбод	Байгалийн тогтолцоо, тэнцвэр	Бүх юм дэс дараа, дэг журамтай байх

Гурав. Хятадын ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмжийн ангилал

Хятад бол эрт дээр үеэс боловсон болсон үндэстэн бөгөөд дэлхий дахины соёлд их хувь нэмэр оруулсан. Тэрхүү балар эрт цагаас уран зохиолоо хөгжүүлснээс хамгийн эхэнд аман зохиол бий болж домог үлгэр буюу миф хөгжсөн. Харин тэдгээр домог үлгэрээ хожим бичиг үсэгтэй болсныхоо дараа “Шанхай жин” (Уул далайн ном) -д эмхтгэн тэмдэглэсэн байдаг. Мөн хятадын аман зохиол, домог үлгэрт ертөнц үүссэн тухай нэлээд өвөрмөц, ялгаатай хэд хэдэн хувилбар бий.

Домгийн хувилбаруудын ангилал: “Шанхай жин”-д буй дэлхий газар бүрэлдэн тогтсон тухай домог нь эртний египетийн домогтой адил гэж үздэг. “Паньгу гэж анхны хүн байжээ. Тэрээр гэрэл гэгээнд их дуртай тул байнга нарыг өмнөө туун явдаг байжээ. Тэгээд маш их халууцан ядраад голын усыг ширгэтэл нь уусан боловч цангаа нь гарсангүй тул гадаад далайн уснаас уух гэж явж байгаад замдаа үхчихжээ. Тэгээд түүний бие махбод нь газар шороо болж, үс гээг нь ой шугуй болон, цус нь гол горхи болж, биед нь байсан шавь хорхойнууд нь араатан гөрөөс болжээ.” (Хөвсгөл, С. 2010, 64) хэмээсэн

байдаг бөгөөд өгүүлэмжийн хувьд нэлээд өвөрмөц, сонирхолтой. Жишээлбэл, дэлхий дэхиний домог зүйн ихэнх өгүүлэмжид анхлан байсан эмх замбараагүй хоосноос газар дэлхий бүрэлдэж, дараагаар нь нар, сар, одон эрхис, хүн амьтан үүсдэг. Гэтэл эл домогт буй *“Тэрээр гэрэл гэгээнд их дуртай тул нарыг өмнөө туун явдаг байжээ”* хэсгээс харахад хамгийн түрүүнд нар сар үүсэж дараагаар нь хүн үүссэн нь домгийн тэргүүн туурвигч баатар Паньгу бөгөөд түүнээс газар дэлхийг бүрэлдэн тогтсон байна. Энэ нь бусад улс орны домгийн нийтлэг өгүүлэмж, дарааллаас тэс өөр байна. Мөн эл хувилбарт анхны хаосын төлөв төрхийг дүрслээгүй.

Өөр нэгэн хувилбарт *“Орчлон ертөнц анх ямар ч хэлбэр дүрсгүй, үүл мэт манантай, харанхуй байхад Ин буюу тэнгэр, Ян буюу газар үүсэн тогтжээ. Ин, Яныг үүсэхэд голд нь аварга том өндөг бий болж гэнэ. Өндөгний дотор талаас нь “Паньгу” нэртэй үс, сахал ихтэй сэгсгэр үстэй хүн бий болж гүн нойрноосоо сэрж, өндгийг дотроос нь хага татан онгойлгож Ин, Яныг зааглан мэндэлжээ. Ин, Ян он жил өнгөрөх тусам Паньгуг хавчин шахахад тэрээр 4 зүгийн сахиус болох цагаан арслан, луу, галт шувуу, яст мэлхий нараас туслалцаа авч тэрхүү заагийг дөрвөн талаас нь татан тогтоон барьдаг байжээ. 18,000 жил өнгөрөхөд Паньгу хүчин мөхөсдөнөөр нас баржээ. Түүнийг нас барахад баруун нүд нь тэнгэрт хөөрөн сар болж, зүүн нүд нь мөн л тэнгэрт хөөрсөөр нар болж, цус нь гол болж, толгой дахь цагаан үс нь хуйларсаар одод болж, хөл болон биеийн үс нь газарт үлдэн ой мод болж, бие дээрх бөөс хуурснууд нь амьтан болж, биеийнх нь бүхий л атираа нь уул болж, тэнгэр газрыг зааглан оришиж дэлхий үүссэн”*(Хэрлэн, Л. 2020, 10) гэдэг. Энэ 2 хувилбарын аль алинд нь туурвигч баатар үхсэнээр газар дэлхий үүсэж, биеийнх нь аль хэсгээс юу үүссэн зэрэг өгүүлэмж бий. Харин туурвигч баатрын үүссэн өгүүлэмж нь ялгаатай бөгөөд сая дурдсан домогт туурвигч баатар анх Ин, Яны заагт бий болсон өндөгнөөс мэндэлж, гүн нойрноосоо сэрж байгаа нь Энэтхэгийн Брахмагийн алтан өндөг, монголчуудын галбингаа шувууны домогтой төстэй. Мөн эхний хувилбарт нар, сар, хүнээс өмнө байсан гэж өгүүлдэг бол, удаах хувилбарт туурвигч баатар үхсэний дараагаар түүний баруун, зүүн нүднээс бий болж байна. Үүнээс гадна туурвигч баатрын үхэж буй өгүүлэмж нь эхний домогт нарыг дагаснаас болж халууцан ам нь цангаж, ус хайж яваад үхдэг бол хоёр дахь домогт газар тэнгэрийг зааглан тогтоож, эцэстээ дийлэхээ больж, хүчин мөхөсдөн үхэж байна.

Дараагийн өөр нэгэн хувилбарт *“Эрт цагт Пань Гү хэмээх аварга хүмүүн нойрноос арай ядан сэртэл эргэн тойрныг түнэр харанхуй бүрхсэн байжээ. Өндийн босох гэтэл түүнийг тэнгэр дарсан байв. Газар тэнгэрийн завсар хэвтэж буйгаа ойлгосон тэрбээр тэнгэрийг мөрлөн босож дээш өргөн газар тэнгэр хоёрыг салгажээ. Ингээд энэ аварга хүмүүний ачаар тэнгэр газар салж,*

харин түүний бие нь өнө мөнхөд газар тэнгэртээ ууссан гэдэг. Пань Гү-гийн нэг нүд нь нар, нөгөө нүд нь сар болж хувирсан домогтой. Мөн түүний хөлс нь бороо, амьсгал нь салхи, их бие нь уул болж, тархи нь эрдэнэ болжээ. Пань Гү-тэй хамтран инь янь буюу арга билиг үүдсэн” хэмээжээ. Энэ хувилбар өмнөх хоёр хувилбараасаа нэлээд ялгаатай. Хоёр дахь хувилбарт Пань Гү дөрвөн зүгийн сахиуснаас тусламж авч газар дэлхийг заагласан бол, эл хувилбарт түүнийг аварга хүмүүн хэмээн тэмдэглэж, тэрээр өөрөө өргөн салгаж байгаа бөгөөд өргөгч баатар болж байгаа бөгөөд салгасныхаа дараа өөрөө газар тэнгэртээ уусчихаж байна. Мөн өмнөх хоёр хувилбарт ой мод, амьтад, уул нуруудын үүслийг дурдсан бол энэ домогт байгалийн үзэгдэл салхи шуурга, хур тунадасын үүсэл болон байгалийн баялаг эрдэнэ үүссэн өгүүлэмж бий. Харин хоёр дахь домогт Ин, Янь нь газар болон тэнгэр байсан бөгөөд Пань Гү-гээс өмнө үүсэн бий болсон. Гурав дахь хувилбарт Ин Янь нь Пань Гү-тэй хамтран үүдсэн бөгөөд арга билиг хэмээн өгүүлэгджээ.

Төлөв төрх, дүрслэл: Эдгээр гурван хувилбарын өгүүлэмжээс үзэхэд “Эрт цагт Пань Гү хэмээх аварга хүмүүн нойрноос арай ядан сэртэл эргэн тойрныг түнэр харанхуй бүрхсэн байжээ.”, “Орчлон ертөнц анх ямар ч хэлбэр дүрсгүй, үүл мэт манантай, харанхуй байхад” гэх мэтчилэн хятадын домог зүй, ард түмний сэтгэлгээнд хаос бол ямар ч хэлбэр дүрсгүй, тэнгэр газар нийлсэн, үүл манантай түнэр харанхуй байна.

Сэдэл санаа: Дэлхий дахины домог зүйн өгүүлэмжид түгээмэл байдаг аль нэгэн туурвигч баатарт нь оршин суух газар орон хэрэгтэй болох, эсвэл дээд оршихуйн төлөөлөл хурмаст тэнгэр, эх бурхан зэрэг дунд тивийг бүтээхээр сэддэг өгүүлэмж хятадын домог зүйд байхгүй байна. Харин туурвигч баатар үхэж мөхсөнөөр газар дэлхий үүссэн гэж өгүүлжээ.

Загвар: Домог зүйн загвар нь “...өндгийг дотроос нь хага татан онгойлгож Ин, Яныг зааглан мэндэлжээ. Ин, Ян он жил өнгөрөх тусам Паньгуг хавчин шахахад тэрээр 4 зүгийн сахиус болох цагаан арслан, луу, галт шувуу, яст мэлхий нараас тусалцаа авч тэрхүү заагийг дөрвөн талаас нь татан тогтоон барьдаг байжээ. 18,000 жил өнгөрөхөд Паньгу хүчин мөхөсдөнөөр нас баржээ. Түүнийг нас барахад баруун нүд нь тэнгэрт хөөрөн сар болж, зүүн нүд нь мөн л тэнгэрт хөөрсөөр нар болж, цус нь гол болж, толгой дахь цагаан үс нь хуйларсаар одод болж, хөл болон биеийн үс нь газарт үлдэн ой мод болж, бие дээрх бөөс хуурснууд нь амьтан болж, биеийнх нь бүхий л атираа нь уул болж, тэнгэр газрыг зааглан оришиж дэлхий үүссэн” хэмээн туурвигч баатрын үйл оролцоотойгоор бүрэлдэн тогтсон бүтээл туурвилын загвар, шинжтэй байна.

Дүрийн ангилал: Хятадын домог зүйд туурвигч баатар Паньгугийн дүрслэл нь гурван хувилбарт “нар сарыг дагаж явсаар халууцаж, их ус эрж яваад үхсэнээр”, “гүн нойрноос сэрээд газар, тэнгэрийн зааглан өргөж хүчин мөхөсдсөнөөр”, “газар тэнгэрийг зааглан салгаад өөрөө уусаж” ертөнц бүрэлдэн үүсэх зэргээр ялгаатай өгүүлжээ.

Дээрх хувилбаруудаас үзвэл ихэнхдээ Паньгу өөрөө үрэгдэж, биеийн хэсгүүдээс нь ертөнц бүрэлдэн тогтож буйгаар өгүүлэгдэж байгаа бөгөөд түүнээс өөр сөнөөгч баатар, шумбагч гэх мэт туслах баатар байхгүй байна. Харин хоёр дахь хувилбарт ертөнц үүсэхээс өмнө Ин, Яныг зааглан өргөхөд туслан, хүч нэмж буй дөрвөн зүгийн сахиус цагаан арслан, луу, галт шувуу, яст мэлхий зэрэг туслагч баатрууд байна. Мөн Паньгу нь анхны хүн төрөлхтөн хэдий ч түүний анхны төрх, энэ ертөнцөд төрж, үүсэж буй дүр, үйл бүтээлийг нь дүгнэн үзвэл хагас бурханлаг шинжтэй домгийн баатар юм.

Дөрөв. Японы ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмжийн ангилал

ЗТ 712 онд ордны түшмэл Ясуморогийн бүтээсэн домог үлгэр, түүхийн чанартай Козики хэмээх 3 боть бүхий бүтээл бий. Үүний ихэвчлэн баатарлаг үлгэр домгийг эмхлэн оруулсан эхний ботид ертөнц үүссэн тухай өгүүлдэг. ЗТ 712 онд ордны түшмэл Ясуморогийн бүтээсэн домог үлгэр, түүхийн чанартай Козики хэмээх 3 боть бүхий бүтээл бий. Үүний ихэвчлэн баатарлаг үлгэр домгийг эмхлэн оруулсан эхний ботид ертөнц үүссэн тухай өгүүлдэг. “Эхлээд бүх юм эмх замбараагүй байв.” хэмээн дэлхий дахиний домог зүйн өгүүлэмжийн нэгэн адил хаос оршиж байсан гэдэг. Харин энэ эмх замбараагүйг газар дэлхий болгон биежүүлэн тогтоох зарлигийг Изанами, Изанаги хэмээх ах дүү хоёр тэнгэр хүлээдэг. Ийн “усан дээр тавьсан тэнгэрийн гүүрэн дээр зогсож, усыг жадаараа хатгаад өргөхөд, жадны үзүүрээс тунах дууссан давснаас арал үүсчээ” хэмээн өгүүлдэг.

Домогт “Ах дүү хоёр тэнгэр бүтээсэн арал дээрээ очиж, өндөр багана босгоод өөрсдөдөө орон суурин барьжээ. Тэгээд тэр баганыг тойрч яван уулзахдаа Изанами нь “Яасан сайхан эр вэ?” гэж дуу алдсанд, Изанаги нь “Ямар сайхан хүүхэн бэ?” хэмээн дуугарчээ. Тэгээд тэр хоёр гэрлэн суусанд, төрсөн хүүхдүүд нь дандаа эрэмдэг зэрэмдэг гарах болов.” гэх ураг хоорондоо ханилан сууж, цус ойртсон тухай өгүүлэмж нь манай монгол домог зүйд ч бий. Энэ талаар С.Дулам “Монгол, япон домог зүйн харьцаа” өгүүлэлдээ “Изанаги, Изанами хоёрын үр хүүхдүүд хөлгүй гаргүй, эрэмдэг зэрэмдэг төрсөн өгүүлэмж нь монгол домог зүйд ч гэсэн эрт цагт урагтаа гэрлэдэг байхад хөл гар нь муруй

мэндэлж түүний учрыг Зараа сэцэнээс асуухад “хөл хөл мах, хөхүүр хөхүүр айраг авч харь элгэндээ ураглахын учрыг” зааж өгсөн гэдэг. Энэ бол эртний бүлгээр гэрлэх ёс, овог дотроо гэрлэх ёсны үлдэл газар сайгүй байсны гэрч, эртний домгийн цуурай мөн буй заа.” хэмээн дурджээ. Монгол домогт учрыг эртний домгийн соёлт баатраас асууж байгаа бол япон домогт хурмаст тэнгэрээс асуух бөгөөд хурмаст тэнгэр “*бүсгүй хүн түрүүлж үг өдсөнөөс болсон*” хэмээж буй өгүүлэмж нь японы нийгэм дэх эмэгтэйчүүдийг үзэх үзэл, хандлага, байр суурийг илэрхийлсэн болов уу.

Төлөв төрх, дүрслэл: Ертөнц дахины домог зүйн нэгэн адил анхны хаос нь “*усан дээр тавьсан тэнгэрийн гүүрэн дээр зогсож, усыг жадаараа хатгаад өргөхөд, жадны үзүүрээс тунан дуссан давснаас арал үүсчээ*” хэмээн нэлий далай, усан төлөвтэй оршиж байжээ.

Загвар: Эмх замбараагүй их усан далайг газар дэлхий болгон биежүүлэн тогтоох зарлигийг Изанами, Изанаги хэмээх ах дүү хоёр тэнгэр хүлээдэг. Тийн “*усан дээр тавьсан тэнгэрийн гүүрэн дээр зогсож, усыг жадаараа хатгаад өргөхөд, жадны үзүүрээс тунан дуссан давснаас арал үүсчээ*” хэмээн өгүүлдэг бөгөөд өнөөх эмх замбараагүй усан биеийг алив нэгэн туурвигч баатар бүрэлдүүлэн тогтоож буйгаараа *бүтээл туурвилын домог зүйн загвартай* байгаа юм.

Дүрийн ангилал: Туурвигч баатруудын үйл бүтээл, хоорондын харилцаа, зөрчлийн хувьд ах дүүсээс эр эм болдог япон арлыг бүтээсэн эртний их хуланц Изанаги, Изанами хоёрын домог нь монгол домог зүйн харш зөрүү санаатай ах дүү Бурхан, Чөтгөр хоёрын домогтой төстэй өгүүлэмж бүхий гэж хэлж болно. (Дулам, С. 2018, 494)

Тав. Домгийн өгүүлэмжийн харьцуулал

	Монгол	Энэтхэг	Хятад	Япон
Бурхан, чөтгөр өрсөлдөж бүтээсэн	+			+
Яст мэлхийг харваж, биеэс нь бүтсэн	+			
Алтан өндөгнөөс бүтээгч баатар төрсөн	+	+	+	
Туурвигч баатрын цогцосноос бүтсэн		+	+	
Усан дээр үр тогтоосон		+		

Далайн ёроолоос атга шороо олж ирсэн	+			
Далайн ёроолоос давс олсон				+

Зургаа. Домгийн дүрийн ангилал

	Монгол	Энэтхэг	Хятад	Япон
Бурхан	+	+		+
Шумбагч баатар	+			
Өрсөлдөгч баатар	+			+
Алтан өндөг	+	+	+	
Яст мэлхий	+			
Галбингаа шувуу	+	+		
Тэнгэр, газар	+		+	+
Нар, сар			+	+

ДҮГНЭЛТ

- 1. Анхны хаосын төлөв нь** монгол болон японы домог зүйд их усан биеэр оршиж буйгаар дүрсэлдэг бол энэтхэг болон хятадын домог зүйд түнэр харанхуй, бүрэнхийгээр дүрсэлжээ.
- 2. Домог зүйн загварын хувьд** дорно дахины ард түмний ертөнцийн үүслийн домог нь нийтлэг бүтээл туурвилын загвартай байна.
- 3. Ертөнцийг бүтээхээр зорьж буй санаа сэдэл нь** монгол болон, японы домог зүйд туурвигч баатарт амьдрах орон газар, тулах цэг, сууж амрах газар хэрэгтэй болсны тул ертөнцийг бүтээж байгаа бол энэтхэг, хятадын домог зүйд ямар нэгэн зорилгогүйгээр, санамсаргүй байдлаар туурвигч баатрын биеэс бүтэж байна.
- 4. Домгийн дүрүүд нь** нэг нэгнээсээ өрсөж ертөнц дэлхий, байгалийн юмс үзэгдлийг бүтээж буй, өрсөлдөгч баатрууд монгол болон японы домгийн өгүүлэмжид байна. Харин алтан өндөг, галбингаа шувуу, бурхан, тэнгэр газар нь монгол, энэтхэг, хятадын домгийн өгүүлэмжид нэг ижил байна. Шумбагч баатар нь дан ганц монгол домогт байгаа бол, нар, сар нь дан ганц хятадын домог зүйд дүрслэгджээ.

5. **Харилцан нөлөөлөл нь** монгол, энэтхэг, хятад домог зүйд алтан өндөгний домгийн өгүүлэмж ижил байгаа бол монгол, японы домог зүй нь ураглах хуримлах ёс, соёлт баатрын нэг ижил өгүүлэмжтэй байна. Мөн монголын галавын үлгэр дэх ертөнцийн үүслийн домгийн хувилбар нь монгол домогт энэтхэг домгийн нөлөө туссан, бурхан шашны өгүүлэмж орсон нь харагдаж байна.

A COMPARATIVE STUDY OF EASTERN MYTHOLOGICAL NARRATIVES ON THE ORIGIN OF THE WORLD

The cultures, arts, literature, natural environments, and social phenomena of nations and peoples such as Mongolia, India, China, and Japan—who inhabit the vast lands of Asia—have historically developed in interrelation with one another. Notably, ancient myths and legends that reflect how these civilizations perceived, imagined, and narrated the origin of the world, the sun, moon, stars, and humanity, share remarkable similarities. This study aims to gather and compare multiple versions of such myths from each of these countries, analyzing their narratives and imagery to identify the unique features of their worldviews, imagination, and ways of thinking.

НОМ ЗҮЙ

- Дулам, С. Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа. *Эрдэм шинжилгээний өгүүлийн чуулган II боть*. УБ., 2018
- Дулам, С. *Монгол домог зүйн дүр*. УБ., 2020
- Дулам, С., Нандинбилиг, Г. *Монгол аман зохиолын онол II*. УБ., 2022
- Хөвсгөл, С. *Дорно дахины уран зохиол /түүхэн найрууллууд/*. УБ., 2003
- Хэрлэн, Л. *Домог өгүүлсэн соёлын дурсгалаас. Ер бусын ертөнц I*. УБ., 2020
- Цэрэнсодном, Д. *Монгол ардын домог үлгэр*. 1982



МОНГОЛ АМАН ЗОХИОЛ ДАХЬ УРГАМЛЫГ ОНЬСОГОЛОХ ТОГТМОЛ БОЛОН ӨГҮҮЛЭМЖИЙН ХАРИЛЦАА ХОЛБООГ ШИНЖЛЭХ НЬ

(Хүүрнэн өгүүлэх аман зохиолын жишээн дээр)

Бямба-Эрдэнийн НОМИН

МУИС-ийн Утга зохиол судлал, III түвшин

Удирдагч: И. Даваадорж

МУИС-ийн УЗУСТ-ийн багш

Хураангуй: *Аялгуут бус аман яруу найргийн нэгэн төрөл зүйл болох оньсогын оньсоголох тогтмолд тухайн юм, үзэгдлийн бусад зүйлээс ялгарах гол шинж, онцлог чанарыг товойлгодог. Мөн аман зохиолын төрөл зүйлүүд өөр хоорондоо уусан сүлэлдэж, өгүүлэмж давхацдаг. Энэ нь эртний хүмүүсийн ертөнцийг танин мэдэх гэсэн оролдлогын ул мөр юм. Иймээс оньсоголох тогтмолыг судалснаар тухайн үндэстний хорвоо ертөнцийн талаарх анхны ойлголт, түүнийгээ далдлан илэрхийлсэн сэтгэлгээний загварыг тодруулах ач холбогдолтой. Энэхүү илтгэлд монгол аман зохиолын дотроос ургамлын тухай оньсогыг сонгон, тэдгээрийн голлох шинжийг хэрхэн оньсоголсныг тодруулахын тулд өвс, цэцэг, шилмүүст ургамал, улиасны тухай оньсогыг хүүрнэн өгүүлэх төрөл зүйлтэй холбон шинжиллээ.*

Түлхүүр үг: *ургамлын оньсого, ургамлын өгүүлэмж, оньсоголох тогтмол, домог, үлгэр*

УДИРТГАЛ

Монгол аман зохиолын аялгуут бус аман яруу найргийн төрөл зүйл болох оньсого нь нэгэн юм үзэгдлийн олон зүйл шинж тэмдэг, овор байдал, уг язгуурыг уудлан гаргахыг оролддог¹ онцлогтой. Эртний хүний ертөнцийг танин мэдэх

¹ С. Дулам, Г. Нандинбилиг, *Монгол аман зохиолын онол I* (Улаанбаатар: МУИС Пресс, 2016), 135.

гэсэн оролдлого, туршлагын ул мөр аман зохиолын зүйлсэд хадгалагдан үлдсэн байдаг. Тэрхүү зүйлийн тухай ойлголт, өгүүлэмж оньсого, домог, үлгэр, зүйр цэцэн үг зэрэг аман зохиолын өөр, өөр төрөл зүйлд давхацдаг нь тухайн цаг үеийн сэтгэлгээний илрэл болно. Энэ тухай судлаач Ж. Баянсан уламжлалт оюуны соёлын мөн чанар нь сэтгэлгээний тогтвортой хэв шинж юм. Үнэлэмж бол үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлох хамгийн гол шинж, үндсэн шалгуур бөгөөд үнэлэмж нь хэлний тогтвортой нэгжүүдээр илэрч байдаг² гээд хэлний тогтвортой нэгжид зүйр цэцэн үг, бэсрэг хэллэг, оньсого таавар зэргийг багтаан үзжээ. Эдгээр нь дангаараа байж, харилцааны тодорхой орчин нөхцөлд бэлэн ээлнээрээ хэрэглэгдэж байхаас гадна ардын үлгэр тууль, ерөөл магтаал, дуу шүлэг, домог туулийн дотор ч амьжиж биежсэн байдаг. Ийм учраас эдгээр нь үндэстний сэтгэлгээний хэв маягийн уламжлал шинэчлэлийн онцлог байдлыг таниулах гол хэрэглүүр болно³. Үүнээс үзвэл оньсоголох тогтмол нь монголчуудын уламжлалт сэтгэлгээ, алив юм үзэгдлийг танин мэдэх онцлогийг илрүүлэх нэгэн арга зам болох юм. Байгаль дэлхий, хүний аж амьдралтай салшгүй холбоотой ургамлыг тухайлан судалж, түүний оньсоголох тогтмолыг шинжилснээр ургамлыг хооронд нь ялган таньсан анхны ойлголт, далдлан илэрхийлсэн сэтгэлгээний загварыг тодруулах ач холбогдолтой.

Монгол оньсогыг сурвалжлан цуглуулсан байдлыг авч үзвэл ОХУ-ын эрдэмтэн В. Л. Котвич *Кальмыцкие загадки и пословицы* (1905), Ц. Жамцарано, А. Руднеев нар *Образцы монгольской народной литературы* (1908), Бельгийн эрдэмтэн А. Мостаэрт *Textes oraux Ordos* (1937), ОХУ-ын эрдэмтэн И. Н. Мадасон *Онъһон үгэнүүд, таабаринууд* (1956), Н. О. Шаракшиново *Загадки* (1981), Ц. А. Дугарнимаев *Түмэн таабари* (1981), Ц. Б. Будаев *Онъһон үгэ оноштой* (1988) зэрэг эрдэмтэн анхлан цуглуулж хэвлүүлсэн байна. БНХАУ-ын эрдэмтэн Г. Журамт, Д. Өргөн нар *Онъсогууд* (1958), Ням, Цэцэнгуа нар *Монгол онъсогын түүвэр* (1986), Дэнжав *Онъсогын чуулган* (1989) зэрэг түүвэр хэвлүүлжээ. Монгол улсын эрдэмтэн П. Хорлоо *Монгол ардын зүйр цэцэн үгүүд ба онъсогууд* (1966), Ц. Өлзийхутаг *Түмэн онъсого I-II* (1966, 1989), Ш. Гаадамба, Г. Ловор *Монгол ардын онъсого таавар* (1990) зэрэг бүтээлдээ сурвалжлан цуглуулж, өмнөх үг, тайлбар зүүлт болон газар орны мэдээ, индекстэй хэвлэсэн байна.

Академич П. Хорлоо (1966), Н. О. Шакшинова (1981), Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв (1988), С. Дулам, Г. Нандинбилиг (2005, 2007) нарын эрдэмтэд монгол онъсогын төрөл зүйлийн онцлогийг тодорхойлж, тухайн онцлогийг харгалзан ангилах санал дэвшүүлсэн байна. Мөн эрдэмтэн С. Ловор *Монгол*

² Ж. Баянсан, *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ* (Улаанбаатар: МУИС Пресс, 2016), 37.

³ Мөн тэнд, 37.

оньсогын уран сайхны онцлог, утга учир зүй сэдвээр 2005 онд Хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Судлаач С. Ганцэцэг оньсого бүтэж буй арга, ангиллыг судалж *Монгол оньсогын ангилал, туурвил зүйн онцлог* (2013) хэмээх нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн юм.

Монгол аман зохиол дахь ургамлын дүр, дүрслэл, өгүүлэмжийг тусгайлан судалсан судалгаа ховор. Профессор С. Дулам *Монгол угсаатны утга соёл дахь ургамлын бэлгэдэл* (2018) өгүүлэлдээ оньсого, зүйр цэцэн үг, бөө мөргөлийн яруу найраг, домог зэрэг аман зохиолын төрөл зүйлсэд тулгуурлан зарим ургамлын бэлгэдэлт утгыг тайлан тайлбарлажээ.

Энэхүү илтгэлд өмнөх үеийн эрдэмтдийн сурвалжлан цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан оньсоголох тогтмолыг тухайлсан ургамлын оньсого болоод хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл зүйлс дэх ургамлын өгүүлэмжээс тодруулах юм. Үүний тул задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тайлан тайлбарлах аргыг ашигласан болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Оньсого нь оньсоголох арга болон оньсоголох тогтмолоос бүрддэг. Оньсоголох тогтмол нь уул юм үзэгдэлд зуршмал байдаг, бусад юм үзэгдлээс ялгарах шинжүүд байх нь олонтоо⁴. Өөрөөр хэлбэл оньсоголох тогтмол нь юм үзэгдлийн зуршмал шинжийг тодорхойлсон агуулга, багтаамж бүхий *ойлголт*⁵ бүтээдэг гэж болох юм. Эрт дээр цагт монголчуудын ургамлыг хэрхэн танин мэдсэн, ямар ямар шинжийг голчлон тогтмол болгосныг дараах ургамлын оньсогоор жишээлж, хүүрнэн өгүүлэх аман зохиолын зүйлс болох домог, үлгэр, түүх домог зэрэгт давхцаж буй өгүүлэмжтэй холбон тайлбарлалаа.

Өвсний тухай оньсого, оньсоголох тогтмол

Монгол аман зохиол дахь өвс ургамлын тухай оньсого дотор мод болон үр боловсрох оронт ургамлаас бусад дээд, доод ургамлыг зүйлчлэн ялгаж оньсоголсон нь цөөн, ихэнхдээ ерөнхийлсөн утгаар зүлэг ногоог бүхэлд нь заасан байдаг. Үүний дотор ийм нэг оньсого бий.

Өсдөг үндэстэй

Үрждэг биетэй

⁴ С. Дулам, “Оньсоголох урлагийн учир”, *МУИС-ийн Профессорын өв: Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа-II* (2016): 177.

⁵ Ойлголт бол нэг юм уу, нэг төрлийн бүлэг юмны гол гол шинж байдлыг онцлон, ерөнхийлж илэрхийлдэг сэтгэхүйн хэлбэр (Отгонбаяр, 2016: 13).

*Орчлон ертөнцийн**Онцын хэрэгцээ (Өвс)*⁶

Тус оньсогод өвсний өсөж үрждэг хийгээд орчлон ертөнцөд хэрэгцээтэй талыг онцлон тусгасан байна. Монгол аман зохиолд ертөнцийн болоод хүний үүслийн ихэнх домогт дэлхий бүтэж бүрэлдсэний дараа өвс ургамал дэлгэрч, түүний дараа хүн үүсдэг зүй тогтол ажиглагдаж байна. Жишээлбэл “Монгол ардын домог үлгэр” эмхэтгэлд буй нэгэн домогт *Анхандаа газар байхгүй, гал ус, салхи хольцолдсон юм байжээ. Тэгээд бурхан багш шороо авч ус руу хийгээд газар дэлхий буй болж өвс, ургамал мод ургаж дэлгэрч гэнэ. Дараагаар нь хүн бий болгосон юм байна*⁷ гэсэн бол өөр хувилбарт *Анх нь газар дэлхий гэж үгүй нэлдээ ус далай байсныг Бурхан, тэнгэрээс чимх шороо авч ирж цацаад манай дэлхий бүтэж бүрэлджээ. Тэр дээр нь өвс ургамал, ан амьтан, хүн буй болов*⁸ гэх зэргээр өгүүлсэн. Энэ нь өвс ургамал ургах бол ертөнц бүрэлдэн бий болсны дараах болон хүн үүсэхийн өмнөх хоёрын завсрын зайлшгүй үе шат гэдгийг ойлгон мэдсэн хэрэг болж байна. Хүн яагаад махан хүнстэн болсон тухай эртний домогт⁹ өгүүлэхдээ *Хүн анх эхлээд өвс ногоо иддэг байжээ. Бурхан багш хүнийг аль хэр өвс ногоо иддэг юм, үзье гэж санаад унагатай гүү, хүүхэдтэй хүүхэн хоёрыг нэг нэг өвстэй жалганд ойрхон идээшлүүлж тавьжээ. Үдийн хугас бололгүй эргэж ирээд үзвэл хүүхэдтэй хүүхэн нь өөрийнхөө оноосон жалганы өвсийг идэж эхэлмэгц тэр хоёр муудалцаж Бурхан багшид зарга мэдүүлж гэнэ. Бурхан багш энэ заргыг шүүгээд, “ер нь хүн өвс ногоо идэж зохихгүй юм байна, хүнийг хэмжээтэй мах шүүстэй хоолонд оруулъя” гэж хэргийг шийтгэсэн юм*¹⁰ гэжээ. Энэ домогт хүний өвсөн тэжээлтнээс махан идэштэн болсон шилжилтийг өгүүлэх ба хүн зэр зэвсэг эзэмшин ан гөрөө хийж сурсан үетэй холбогдож байна. *Амьтны аймаг нь өвс ургамлыг идэж, тэр амьтныг бусад араатан болон хүн идэж бие биеэ дараалан золиослох*¹¹ явдлыг ухан ойлгосон туршлага нь ургамал бол идэш тэжээлийн гинжин хэлхээний анхдагч буюу орчлон ертөнцийн онцын хэрэгцээ мөн болохыг баталж байна. Идэш тэжээл ийнхүү өөрчлөгдсөнтэй холбоотой өөр нэгэн домог нь “Галавын үлгэр” юм.

⁶ Ц. Өлзийхутаг, эмх., *Түмэн оньсого I* (Улаанбаатар: Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр, 1989), 47.

⁷ Д. Цэрэнсодном, эмх., *Монгол ардын домог үлгэр* (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989), 38.

⁸ Мөн тэнд, 38-39.

⁹ Энэ домгийг 1981 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ард Магсарын Мишигээс /73 настай, халх/

¹⁰ Г. Нандинбилиг, “Монгол идээ ундааны соёл дахь ариун ба бузрын ойлголт”. *МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг*, Боть 39 (2015): 110.

¹¹ С. Дулам, *Монгол домог зүйн дүр* (Улаанбаатар: Битпресс, 2020), 193.

Галавын үлгэрийн эхэн хэсэгт *Тэр цагт нар гэж ч үгүй, од мичид гэж ч үгүй, тас харанхуй байж. Тэгээд хүүхэд гарахаар нь айсандаа тэр дор нь хаячхаад явчихдаг болж. Хаясан хүүхдийн эхийн хойдхоос жимсний мод ургаж цэцэглээд, модноос нь жимс ургаж боловсрохоор түүнээс нь идэж амиа тэжээдэг байж. Тэр жимсний мод өөрийнх нь хүйсээс холбоотойн учир том болоод тасалж тусгаарладаг байж. Тэгээд хүн болгон тийм жимсний модтой, ганцхан өөр өөрсдийнхийгөө л иддэг, “бусад хүнийхийг хороочихно” гээд иддэггүй байж*¹² гэсэн нь хүн зөвхөн өөрийгөө л авч явах чадалтай үедээ ургамал, үр жимсээр хооллодог байсныг илтгэнэ. Мөн дээрх оньсогын бүтсэн аргыг авч үзвэл ямар нэг дүрслэх ур маяг хэрэглээгүй нь бүтээсэн цаг хугацааны хувьд эртнийх гэдгийг илтгэж буй юм.

Сарьсан багваахайн тухай нэгэн үлгэрт *Эрт урьд цагт араатан, жигүүртэн хоёрын хооронд аймшигт зодоон болж өд сөд, үс ноос нь өвс ургамал мэт дэлхийг бүрхэж байв*¹³ гэж гардаг. Энд тоо томшгүй олон, их гэсэн утгыг газар дэлхийг бүрхэн, дуусашгүй өсөж үрждэг өвстэй зүйрлэн илэрхийлсэн байна. Эдгээрээс харвал өвсний дэлхийд зайлшгүй байх хэрэгцээ ба машид олон, үрждэг зэрэг шинж нь оньсоголох тогтмол болж байна. Домог зүйн утгаар хүн анх ариун байхдаа мах иддэггүй, өвс ургамал иддэг байсан нь орчлон ертөнцийн түгээмэл хэрэгцээ хэмээн оньсоголосонтой нийцэх юм.

Цэцгийн тухай оньсого, оньсоголох тогтмол

*Оньсого бол ард түмний түүх, аж төрөх ёс, ертөнцийг үзэх үзэл, гүн ухаан, ёс зүй, гоо зүйн сэтгэлгээний онцлогийг танин мэдэх бодит хэрэглэгдэхүүн юм*¹⁴. Гоо үзэсгэлэнтэй, сайхан зүйлийг цэцэгтэй зүйрлэх нь түгээмэл. Профессор С. Дулам *Монгол утга соёл, ардын билиг, аман зохиолд цэцэг навч бол байгаль ертөнцийн гоо сайхныг төлөөлөх дүр дүрслэл байдаг*¹⁵ гээд аман зохиолын олон төрөл зүйлд үндэслэн цэцгийг ерөнхий утгаараа үр шим, гоо үзэсгэлэн, цэвэр ариун, залуу нас, мандан бадрахын бэлгэдэл хэмээн үзжээ. Харин цэцгийг ерөнхийлөн шүлэглэсэн оньсого бүрд цэцгийг малгайтай адилтгасан байна. Тухайлбал:

¹² S. Dulam, J. Vacek, *A Mongolian mythological text* (Ulaanbaatar: BitPress, 2013), 15.

¹³ Д. Цэрэнсодном, эмх., *Монгол ардын үлгэр*, ред. А.Лувсандэндэв (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1982), 42.

¹⁴ Г. Ловор, *Монгол оньсогын уран сайхны онцлог, утга, учир зүй* (Улаанбаатар: Урлах эрдэм, 2005), 13.

¹⁵ С. Дулам, “Монгол угсаатны утга соёл дахь ургамлын бэлгэдэл”, *МУИС-ийн Профессорын өв: Бэлгэдэл зүйн судалгаа* (2018): 523.

Газраас гарсан ганиухай

Ганган эрээн тоорцогтой

Алтан саа өнгөтэй

Агар зандангийн үнэртэй (Цэцэг)¹⁶

Шулуун гуа биетэй

Шүхэр тоорцог малгайтай (Цэцэг)¹⁷

Эл оньсоготой холбогдох “Элээ тахиа хоёр” домогт *Нэгэн өдөр тахиа элээг сайн ажиглавал гоо үзэсгэлэн хувцастай толгой дээрээ оюу шүр мэт улаан эрээн цэцгийн засал чимэгтэй учир үнэхээр сайхан харагдаж байв*¹⁸ хэмээдэг. Дээрх оньсого ба домгоос анх цэцгийг ажиглан мэдэхдээ хэлбэрийг онцгойлон голлох шинж болгож, үндэс, иш, навч, дэлбээ гэх цэцгийн гадна бүтцийг төстэй хэлбэр дүрс бүхий малгайтай адилтган оньсоголжээ. Түүнчлэн *ганган эрээн, алтан саа, шулуун гуа, засал чимэг* хэмээн тодотгон дүрсэлсэн нь сайхан гэх утгыг илтгэж байна. Тэгэхээр дээр өгүүлсэн бэлгэдэлт утга байхаас гадна цэцгийг оньсоголох тогтмол нь бүтэц, гадна хэлбэр дүрс болоод харагдах байдал, гадаад дүрслэлтэй холбогдож буй юм.

Шилмүүст ургамлын тухай оньсого, оньсоголох тогтмол

Монгол домогт тодорхой хэдэн ургамлын мөнх ногоон болсон шалтгааныг өгүүлсэн нь олон. Тэдгээр нь нарс, хуш, зээргэнэ, шинэс, гацуур, арц зэрэг ургамал болно. Эдгээр ургамлын тухай зарим оньсогод ийн шүлэглэжээ.

Өвөл зунгүй нэг өнгөтэй

Өвгөн залуугүй нэг дуутай (Нарс, хуш, гацуур, жодоо)¹⁹

Өлгөр басган

Өвөл даардаггүй

Зун халууцдаггүй (Гацуур)²⁰

¹⁶ Ц. Өлзийхутаг, эмх., *Түмэн оньсого II* (Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр, 1966), 38.

¹⁷ Г. Ловор, Ц. Өлзийхутаг, эмх., *Монгол ардын оньсого таавар*, (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1990), 64.

¹⁸ Д. Цэрэнсодном, эмх., *Монгол ардын домог үлгэр* (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989), 132.

¹⁹ Ц. Өлзийхутаг, эмх., *Түмэн оньсого I* (Улаанбаатар: Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр, 1989), 57.

²⁰ Г. Ловор, Ц. Өлзийхутаг, эмх., *Монгол ардын оньсого таавар*, (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1990), 72.

“Нарс, хуш, зээргэнэ мөнх ногоон болсон учир” гэх домогт хараацай хүнд үхэшгүй мөнхийн рашаан уулгахаар явж байхад хэдгэнэ хажуу талаас нь хатгасанд хараацай шувуу өвдөхийн эрхээр дуу алдан ёлсонд аман дахь мөнхийн усаа асгаж гэнэ. Тэр асгарсан рашаан нь нарс, хуш, зээргэнэ гурав дээр дуссан учир энэ гурав мөнх ногоон шилмүүст навчтай болсон ажээ²¹ гэхчлэн мөнхийн рашааныг шалтгаан болгон өгүүлсэн байна. Энэ өгүүлэмж нь хүний үүслийн домгийн нэгэн тасархай²² болно. Мөнхийн амьдралын тухай санааг байгаль дэлхийн хувьсан өөрчлөгдөх жамын дунд басхүү үл хувьсан өөрчлөгдөх нэгэн зүй жам байхыг байгаль дээрх мөнх ногоон ургамлуудаас санаж сэрсэн байж болох бөгөөд түүнийг хүмүүний мөнх бус аж амьдралтай холбон үзээд хүмүүнийг мөнх наслуулах хүслэнгийн илэрхийлэл болгосон нь²³ харагдаж байна.

Дээрх ургамлууд нь шилмүүстийн ангид хамаарна. Усны хязгаарлагдмал хангамж, температурын өргөн хэлбэлзэл, гэрлийн өндөр эрчмээс болоод хуурай бүс нутгийн ургамалд эдгээр нөхцөлийг тэсэх зохилдлогууд хөгжсөн байдаг. Олонх нь навчны гадаргаас доош тусгай хонхорт шигдсэн амсартай, зузаан, арьслаг навчтай болсон нь бүгд ууришлтаар явагдах усны алдагдлыг багасгахад чиглэгдсэн зохилдлого²⁴-ын нэг нь шилмүүс юм. Эртний хүмүүс энэхүү ижил төстэй шинжийг ажиглаж, учир шалтгааныг хийсвэрлэн төсөөлж домоглон, оньсого болгосон байна. Тэгэхээр дээрх ургамлуудыг оньсоголох тогтмол бол навч нь өнгөө сольдоггүй шинж чанар болно.

Улиасны тухай оньсого, оньсоголох тогтмол

Монгол аман зохиолд улиасны тухай цөөн хэдэн оньсого байна. Тэдгээр нь улиасыг дангаар нь бус, бусад нэг ангид хамаарах модтой нь хамт, эсвэл навч нь унах үйл хөдлөлийг онцлон оньсоголсон байдаг. Жишээлбэл:

Зургаан баян айлын гурав нь

Шар, хөх, улаан өнгийн цамц өмсөнө

Гурав нь өмсөж гарсан дээлээ

Өвөл, зундаа ч тайлдаггүй (Хус, нарс, улиас, шинэс, хуш, жодоо)²⁵

²¹ Д. Цэрэнсодном, эмх., *Монгол ардын домог үлгэр* (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989), 80.

²² С. Дулам, *Монгол домог зүйн дүр* (Улаанбаатар: Битпресс, 2020), 197.

²³ Мөн тэнд, 198-199.

²⁴ Ж. Э. Бидлак, Ш.Х.Янский, *Стерний ургамлын биологийн оршил*, ред. Н. Сонинхишиг (Улаанбаатар: МУИС Пресс, 2021), 112.

²⁵ Г. Ловор, Ц.Өлзийхутаг, эмх., *Монгол ардын оньсого таавар*, (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1990), 74.

Далан шаргачин дав хийв

Далхи цагаан азарга гээгдэв (Улиасны навч унах)²⁶

“Алтанмөнгөн аргай” үлгэртаав нь найман настай Чагаа хүүгээ өөрийн оронд мангас эмгэнд өгч, мангас эмгэн морийг нь алаад хүүг хөөхөд *Чагаа хүү явган болж явгаар гүйж нэг талд алтан улиасанд гарлаа. Тэгээд мангас эмгэн алтан улиасны үндсийг цавчина гэж байтал нэг үнэг ирж, “Ээж ээж энэ улиасыг би унагая. Та нэг хэсэг унтаад аваарай” гэж тэр үнэг хэлэв. Мангас эмгэн унтаж байлаа. Тэр цагт нь үнэг түүний нүдийг нь цавуудаж орхиод хүүг модноос буулгаж өгөв²⁷* гэх ба эл үйл явдал бас дахин давтагддаг. “Тал улаан хаан”, “Хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор” зэрэг үлгэрт ч бас үлгэрийн баатрын замд улиас таардаг эсвэл баатар тэрхүү улиас доор хоноглодог. Улиас голцуу голын эргийн чийглэг хөрсөнд ургана. Тэгэхээр улиас доор амсхийн хонож байгаа нь ус, ундтай ойр буудаллах шалтгаантай байж болно. Түүнчлэн улиас нь эвэр мод цэцэгтний багт хустай хамт хамаарах ба *дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст ихэвчлэн тохиолддог маш түргэн өсдөг, нарийн урт дагавар навчтай бөгөөд тэр нь нэлээд эрт гөвөгддөг²⁸*. Энэ онцлогоосоо шалтгаалж бусад модтой харьцуулахад навч нь шар, улаан, бор, хүрэн олон өнгөнд хувирдаггүй, ихэвчлэн шар байдаг байна²⁹. Энэхүү шинж чанарыг ажигласны үндсэнд үлгэрт улиасыг алтан улиас хэмээн өнгийг нь онцолж, оньсогод навчийг нь шаргачин буюу зээрээр, их бие нь цагаан байдаг тул цагаан азаргаар төлөөлүүлжээ. Улиас бусад модтой харьцуулахад хурдан ургаж, навчаа хурдан гөвж, элдэв ургамлын өвчинд өртөн тэгтэл олон жил ургадаггүйг нь үлгэрт улиас ургасан газар үлгэрийн баатар уддаггүй, дамжин өнгөрч байгаагаар дам өгүүлсэн байж болох юм. Тэгэхээр улиасыг оньсоголох тогтмол нь намар цагийн навчных нь шар өнгө хийгээд хурдан ургаж, навчаа хурдан гөвдөг зэрэг чанар болно.

ДҮГНЭЛТ

Эртний хүний ертөнцийг танин мэдэх гэсэн оролдлого, туршлагын ул мөр аман зохиолын зүйлсэд хадгалагдан үлдсэн байдаг. Тэрхүү зүйлийн тухай ойлголт, өгүүлэмж аман зохиолын өөр, өөр төрөл зүйлд давхацдаг нь тухайн цаг үеийн сэтгэлгээний илрэл болдог. Байгаль дэлхий, хүний аж амьдралтай

²⁶ Ц. Өлзийхутаг, эмх., *Түмэн оньсого I* (Улаанбаатар: Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр, 1989), 57.

²⁷ Д. Цэрэнсодном, эмх., *Монгол ардын үлгэр*, ред. А. Лувсандэндэв (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1982), 84.

²⁸ М. Ургамал, Д.Магсар, Б.Сангидорж, *Ургамал судлал* (Улаанбаатар: Жинст харгана, 2003), 165.

²⁹ Ж. Э. Бидлак, Ш.Х.Янский, *Стерний ургамлын биологийн оршил*, ред. Н. Сонинхишиг (Улаанбаатар: МУИС Пресс, 2021).

салшгүй холбоотой ургамлыг тухайлан судалж, түүний оньсоголох тогтмолыг шинжилснээр ургамлыг хооронд нь ялган таньсан анхны ойлголт, далдлан илэрхийлсэн сэтгэлгээний загварыг тодруулах ач холбогдолтой.

Өвсний тухай оньсого нь ертөнцийн ба хүний үүслийн домогтой *газар дэлхий-өвс ургамал-хүн* үүссэн зүй тогтлоор холбогдож байна. Мөн өвс ургамал идэш тэжээлийн гинжин хэлхээний анхдагч нь болох ба хүн зэр зэвсэг эзэмшин ан гөрөө хийж, өвсөн тэжээлтнээс махан идэштэн болж өөрчлөгдсөн өгүүлэмжийг оньсогод товчлон хураажээ. Тийнхүү өвсний дэлхийд зайлшгүй байх хэрэгцээ ба их, олон, үрждэг зэрэг шинж нь өвсийг оньсоголох тогтмол болдог.

Цэцэг нь ерөнхий утгаараа үр шим, гоо үзэсгэлэн, цэвэр ариун, залуу нас, мандан бадрахын бэлгэдэл болох ба цэцгийн тухай оньсого хийгээд *Элээ тахиа хоёр* домгоос үзэхэд үндэс, иш, навч, дэлбээ бүхий гадаад бүтэц хэлбэрийг адил төстэй малгайтай адилтгаж хүншүүлэн дүрсэлж, *ганган эрээн, алтан саа, шулуун гуа, засал чимэг* зэргээр тодорхойлсон байна. Тэгэхээр цэцгийг оньсоголох тогтмол нь хэлбэр дүрс болоод гоё сайхан харагдах байдал байна.

Нарс, хуш, зээргэнэ, шинэс, гацуур, гачуур, арц зэрэг шилмүүст ургамлын мөнх ногоон болсон тухай домог түгээмэл бий. Тэдгээр домогт дээрх ургамал дээр мөнхийн рашаан дуссанаас өвөл зуны алинд ч мөнх ногоон байх тухай өгүүлдэг. Хүн шилмүүст ургамлаас *үл хувьсах* мөн чанарыг ухаарч мөнх наслах хүслэнтэй холбон домогложээ. Ийн шилмүүст ургамлыг оньсоголох тогтмол бол навч нь өнгөө сольдоггүй, үл хувьсан өөрчлөгдөх шинж болно.

Улиас навчаа эрт гөвдөг тул олон өнгөнд хувирдаггүй, шар навчтай байдаг онцлогийг танин мэдсэний үндсэнд үлгэрт улиасыг *алтан* хэмээн өнгийг нь онцолж, оньсогод навчийг нь шаргачин буюу зээрээр, цайвар их биеийг нь цагаан азаргаар төлөөлүүлжээ. Түүнчлэн бусад модтой харьцуулахад хурдан ургаж, навчаа хурдан гөвж, элдэв ургамлын өвчинд өртөн олон жил ургадаггүйг нь үлгэрт улиас ургасан газар үлгэрийн баатар уддаггүй, дамжин өнгөрч байгаагаар дам өгүүлж, оньсогод зээр ба морь зэрэг хурдан амьтнаар илэрхийлэн амьдчилсан байж болно. Иймээс намар цагийн навчных нь шар өнгө хийгээд хурдан ургаж, навчаа хурдан гөвдөг зэрэг онцлог нь улиасыг оньсоголох тогтмол юм.

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

- Ловор, Г., Өлзийхутаг, Ц., эмх. *Монгол ардын оньсого таавар*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1990.
- Өлзийхутаг, Ц., эмх. *Түмэн оньсого I*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр, 1966.
- Өлзийхутаг, Ц., эмх. *Түмэн оньсого II*. Улаанбаатар: Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр, 1989.
- Сампилдэндэв, Х., эмх. *Монгол домог*. Ред. Д.Цэрэнсодном. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1984.
- Цэрэнсодном, Д., эмх. *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989.
- Цэрэнсодном, Д., эмх. *Монгол ардын үлгэр*. Ред. А.Лувсандэндэв. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1982.

Судалгааны бүтээл

- Баянсан, Ж. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар: МУИС Пресс, 2016.
- Бидлак, Ж. Э., Янский, Ш. Х. *Стерний ургамлын биологийн оришил*. Ред. Н.Сонинхишиг. Улаанбаатар: МУИС Пресс, 2021.
- Dulam, S., Vacek, J. *A Mongolian mythological text*. Ulaanbaatar: Bitpress, 2013 [1983].
- Дулам, С. *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Битпресс, 2020 [1989].
- Дулам, С., Нандинбилиг, Г. *Монгол аман зохиолын онол I*. Улаанбаатар: МУИС Пресс, 2016.
- Ловор, Г. *Монгол оньсогоын уран сайхны онцлог, утга, учир зүй*. Улаанбаатар: Урлах эрдэм хэвлэлийн компани, 2005.
- Отгонбаяр, М. *Логик сурах бичиг*. Ред. Ц.Гомбосүрэн. Улаанбаатар: МУИС Пресс, 2016.
- Ургамал, М., Магсар, Д., Сангидорж, Б. *Ургамал судлал*. Улаанбаатар: Жинст харгана, 2003.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

- Дулам, С. “Онсьоголох урлагийн учир.” *МУИС-ийн Профессорын өв: Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа-II* (2016): 169–191.
- Дулам, С. “Монгол утсаатны утга соёл дахь ургамлын бэлгэдэл.” *МУИС-ийн Профессорын өв: Бэлгэдэл зүйн судалгаа* (2018): 522–539.
- Нандинбилиг, Г. “Монгол идээ ундааны соёл дахь ариун ба бузрын ойлголт.” *МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг*, боть 39 (2015): 108–114.

Товчилсон үгийн жагсаалт

МАДҮ – Монгол ардын домог үлгэр

МАОТ – Монгол ардын оньсого таавар

МАҮ – Монгол ардын үлгэр



ШАВЖИЙН СУДАЛГААГ АШИГЛАН ХАДНЫ ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Цэрэндоржийн НАМУУН

*МУИС-ийн НУС, Антропологи, археологийн тэнхимийн Түүх соёлын
дурсгалт зүйлийн сэргээн засварлалт хөтөлбөрийн IV курсийн оюутан*

Удирдагч багш: Д. АЛТАНЧИМЭГ

*ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу, шавж судлалын
лабораторийн ЭША, магистр*

Хамтран удирдагч багш: Б. БАТЧИМЭГ

*Чингис хаан үндэсний музейн Сан хөмрөг, хадгалалт хамгаалалтын
хэлтсийн ахлах сэргээн засварлагч, магистр*

Товч агуулга: Бид 2023 онд малтан судалсан Баянхонгор аймгийн Шинэжсинст сумын нутагт ориих Сарлагтайн хадны оршуулгаас илэрсэн занданисан хүний биеийн хэвлийн хэсгээс олон тооны эртний шавжийн үлдэгдэл олдсоныг цуглуулан авч, ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн шавж судлалын лабораторид авчран, ангилал зүйн боловсруулалтыг хийж гүйцэтгэлээ. Шавж нь хөгжлийн хувьд бүрэн ба бүрэн бус хувиралтай байна. Бүрэн хувиралтай шавж нь өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцсэн, бүрэн бус нь хүүхэлдэйн шатыг дамжин хөгжинө. Лабораторийн боловсруулалтын явцад уг шавжийн үлдэгдэл нь хүүхэлдэйн хоосон хонгио болох нь тогтоогдов. Шавжийн хонгиогоор ангилалзүйн боловсруулалтыг зүйл хүртэл тодорхойлоход тун бэрх хэдий ч бид түүний морфологийн шинж тэмдэгт тулгуурлан, Хос далавчтан (Diptera)-ы багийн Calliphoridae овгийн Calliphora төрөлд хамаарах Calliphora vicina хэмээх зүйл байж болохыг урьдчилан тогтоолоо. Уг шавжийг илрүүлснээр занданисан шарил хэвлийдээ ил шархтай, нас барснаас хойш 3 хоногийн дотор оршуулсан, агуйн температур ойролцоогоор 5-30°C, оршуулах зан үйлийг дулааны улиралд хийсэн болохыг нотолж болох юм. Энэхүү судалгааны үр дүнгээс харвал Монголын Археологийн шинжлэх ухаанд археоэнтомологийн

шинэ, залуу салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Археэнтомологи, занданшсан хүн, эртний шавжийн үлдэгдэл, хос далавчтан, хүүхэлдэй

УДИРТГАЛ

Шавж нь янз бүрийн орчин, цаг уурын нөхцөлд амьдрах чадвартай. Түүний биеийн зарим хэсгүүд (гадна хитин бүрхүүл, хөл, далавч, ам, үржлийн эрхтэн) задрал удаан явагддаг эсвэл огт задардаггүй учир урт хугацаанд хадгалагдан үлддэг. Эдгээр биеийн хэсгүүдээр шавжийн зарим ангилалзүйн нэгж хүртэл боловсруулалт хийх боломжтой. Үүний тулд эртний шавжийг өнөө үед тархан амьдарч буй орчин цагийн шавжтай морфологийн түвшинд харьцуулна. Хэрэв уургийн задрал явагдаагүй шавжийн биеийн хэсгүүд олдвол генетикийн судалгаагаар зүйлийн түвшинд хүртэл тодорхойлж болно. Нэгэнт зүйл хүртэл ангилалзүйн боловсруулалтыг хийж чадвал тухайн шавжийн амьдралын мөчлөг, биологи, экологийн онцлогт тулгуурлан археологид тайлбарлаж чадаагүй нэмэлт мэдээллүүдийг тодруулах боломж үүсэх юм.


Археологийн шинжлэх ухааныг энтомологи (шавж судлал)-той холбон судлахыг АРХЕОЭНТОМОЛОГИ-ийн шинжлэх ухаан (Buckland et al., 2004) гэх бөгөөд шавж судлалын залуу шинэ салбар юм (Gouda, 2023). Эртний шавж нь хүн амьтны шарил (Tuccia et al., 2022), дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл зэргээс олдоно. Түүгээр оршуулга үйлдэгдэх үеийн хугацаа, улирал (Huchet, 2018), оршуулгын зан үйл, бусад (Gaudry, 2009) зэргийг тодруулдаг бол шүүх эмнэлгийн салбарын энтомологичид үхлийн дараах хугацаа /PMI/-г тодорхойлдог (Amendt et al., 2004).

Үүнийг археологийн шинжлэх ухаанд оршуулгын зан үйлтэй холбон түлхүү судалдаг бол заримдаа шавжийг давамгайл судалдаг. Бид энтомологи буюу шавж судлалын салбарын судалгааны арга зүйд тулгуурлан археологийн зарим хэрэгцээт мэдээллүүдийг бүрдүүлэхийг зорив.

Судлагдсан байдал. Археэнтомологийн шинжлэх ухаан нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, илт мэдэгдэхүйц ололт амжилт гарч, олон тооны эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгджээ. Одоогоор Итали, Перу, Англи, Франц, АНУ зэрэг улсууд судалгаагаар тэргүүлж байгаа бол Азийн орнуудад харьцангуй цөөн судлагдаж байна. Судалгааны ерөнхий байдлыг тивээр авч үзвэл Европт (58%) хамгийн их, хойд өмнөд Америкт (тус бүр 19 ба 15%) харьцангуй бага, Африк Азид (тус бүр 4%) бүр ч цөөн тооны судалгаа хийгджээ

(Magni et al., 2023) (Диаграмм 1).

Диаграмм 1. Археознтомологийн судалгаа (Тивээр)



Манай оронд археологийн малтлагаас илэрсэн эртний шавжийг нэг л удаа судалж байжээ. Монгол-Францын хамтарсан хээрийн шинжилгээний анги Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Бургаст хэмээх газарт малтсан 17 дурсгалаас эртний шавжийн үлдэгдэл олдсоныг Францын судлаачид ялааны багийн 6 төрөл, цохны багийн 6 төрөл, үүнээс 2-ыг нь зүйлийн түвшинд тодорхойлжээ (Лепец нар., 2021).

Бид археологийн малтлагаас илэрсэн эртний шавжийг 3 дахь жилдээ судалж байна. Тухайлбал, 2022 оны малтлага судалгааны явцад 8 дугаартай бунхант булшнаас илэрсэн хүн, бугын тархи, амны хөндийгөөс олдсон эртний шавжийн овог, төрлийг (Silphidae, Nicrophorus sp.; Carabidae, Carabus sp.) микроморфологийн түвшний харьцуулалтын аргыг боловсруулан тодорхойлсноор нас барагчийн амьсгал хурааснаас оршуулах хүртэлх хугацаа, оршуулга үйлдсэн улирлыг тогтоов. Үүнээс гадна тухайн бунхан тоногдсоны дараа хүн болоод бугыг ижил цаг хугацаанд тахилын байдлаар оршуулсан болох, нас барагчийн зэрэг дэв, бунхны жинхэнэ эзний талаарх асуудалд таамаглал дэвшүүлэх боломжтой болсон билээ (Намуун, 2023).

Тус дурсгалт газарт 2023 онд явуулсан хээрийн малтлага судалгааны явцад 9 дугаартай бунхант булшны малтлагын явцад илэрсэн эртний шавжийн овог, төрлийг (Scarabaeidae, Gymnopleurus sp.) энтомологийн салбарын арга зүйд тулгуурлан тодорхойлж, оршуулгын зан үйл, бунхан тоногдох үеийн тонуулын ул мөр, тоносон эд барааг бунхны үүдэвчээр адуу оруулж зөөсөн зэргийг

тодорхойлох ажлуудыг тус тус гүйцэтгэв (Намуун, 2024).

Археологийн малтлагаар шавжийн үлдэгдэл их гарч ирдэг ч Монгол улсад судлагдсан байдал хомс, үндэсний боловсон хүчин байхгүй байна. Тиймээс археологийн судалгаанд багахан ч болов хувь нэмэр болох зорилгоор шавжийн үлдэгдэл дээжийг цуглуулах, цэвэрлэх, хадгалах, ангилалзүйн боловсруулалт хийх зэрэг арга зүйг боловсруулах зорилго тавин ажиллаж байна.

Шинэлэг тал. Археологийн судалгаанд биологийн шинжлэх ухааныг хослуулан ашиглаж, судалгаа шинжилгээ хийн бодит үр дүнд хүрсээр багагүй хугацаа өнгөрсөн ч энтомологийн салбарын судалгааны арга зүйг археологийн ухаанд хавсарган ашиглаж буй нь бидний судалгааны шинэлэг тал болно. Мөн археоэнтомологийн судалгааны үр дүнд амьсгал хураахаас оршуулах хүртэлх хугацааг хоног, цагаар, оршуулга үйлдсэн улирлыг улирал, сараар, тухайн үеийн цаг уурын байдлыг температураар тодруулахаас гадна оршуулгын зан үйл, нас барагчийн зэрэг дэв, бунхны жинхэнэ эзний асуудал, тонуулын ул мөр, үхлийн шалтгаан зэрэг багагүй асуудлыг тайлбарлах боломжтой юм.

Судалгааны үр дүн

Дурсгалын тодорхойлолт. Дурсгалын талаар биологийн ухааны доктор Л.Жаргалсайхан өөрийн нутгийн дүү Шинэжинст сумын иргэн Ц.Гансүх, түүний гэргий Н.Мөнхтуяа нараас сонсож, анхлан мэдээлжээ. Үүний дагуу ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн Археологи-Угсаатны судалгааны ангийн археологич доктор, профессор Ю.Болдбаатар болон доктор С.Бат-Эрдэнэ тэргүүтэй судалгааны баг нь тус хадны оршуулгын дурсгалд авран хамгаалах малтлагыг гүйцэтгэв. Энэхүү хээрийн судалгааны ажил нь 2023 оны 04-р сарын 12-ны өдрөөс 04-р сарын 18-ны өдрийг хүртэл үргэлжилжээ (Болдбаатар & Бат-Эрдэнэ нар, 2023).

Тус дурсгал нь газарзүйн байршлын хувьд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төвөөс зүүн урагш 17 км зайд, Зараа 1-р багийн Дөрвөлжин хайрхны баруун хойд Сарлагтай хэмээх хадтай уулын зүүн хойд аманд, жалгын баруун талд, өгөршил ихтэй цохионы хөмөгт оршино /N44°60'424" E-99°44'331" Alt-2044/. Агуйн өндөр 0.6 м, урт 2.4 м, өргөн 2.63м болно (Зураг 1). Мөн агуйн амыг гадна талаас нь хавтгай чулуугаар өрж тагласан байдалтайгаар олдсон байна (Болдбаатар & Бат-Эрдэнэ нар, 2023).



Зураг 1. Сарлагтайн хадны оршуулга, агуйн ам

Нас барагчийг хадны жижиг хөмөг дотор баруун урагш хандуулан тэнэгэр байдалтай тавьжээ (Зураг 2). Биеийн хадгалалтын байдлын хувьд аман хүзүүнээс урагш толгой байхгүй, баруун гар өгөршиж унасан (Зураг 3), зүүн гарын шууны яс салсан, бугалгын яс зүүн хөлийн хажууд тусдаа байдалтай байв. Хөлийн улнаас аман хүзүү хүртэл 159 см, эрэгтэй. Гарын хумс, арьс, үс маш сайн хадгалагдан үлдэж, занданшсан. Арьсан дээлтэй, дотор талдаа битүү захтай тааран цамцтай, хөлдөө ширэн хос гуталтай. Биеийн баруун талаас ширэн саадаг, зүүн талаас ширэн хоромсого, доод талаас нумын тал хэсэг, тодорхойгүй ширэн эдлэлийн хэсэг, ногоон тааран даавууны хэсэг, хөл орчмоос нумын хөвч, нумын ясан наалтууд, бүтэн болон хугархай нумын сумны хэсгүүд, сумны зэв, саадгийн төмөр чимэглэл, эсгий эдлэлийн үлдэгдэл, бод малын шагай (Болдбаатар & Бат-Эрдэнэ нар, 2023) зэрэг олджээ.



Зураг 2. Нас барагчийн бие анхны байрлалаараа Зураг 3. Нас барагчийн баруун гар

Судалгааны эх хэрэглэхүүн. Авран хамгаалах малтлагын дараа хадны оршуулгаас илэрсэн занданшсан хүн, эд өлгийн зүйлсийг СӨҮТ-ийн Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын сэргээн засварлалтын лабораторид тээвэрлэн авчирч, хүлээлгэн өгчээ. Хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын явцад (Зураг-4) занданшсан хүний биеийн хэвлийн хэсгээс, өмссөн байсан дээлийн хормой хэсгийн дотор талаас олон тооны шавжийн үлдэгдэл (Зураг-5) олдсоныг цуглуулан авчээ.



Зураг 4. Сэргээн засварлалын явц




Зураг 5. Эртний шавжийн үлдэгдэл

Лабораторийн боловсруулалт. Бид эртний шавжийн үлдэгдлийг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу, шавж судлалын лабораторид тээвэрлэн авчирч, лабораторийн боловсруулалтыг гүйцэтгэлээ. Нийт 73 ширхэг шавжийн хүүхэлдэй байв. Нэн түрүүнд шавжийг дээжлэн авч (Зураг 6-7), нэрмэл ус (*Distilled water-H₂O*) ашиглан 3 удаагийн давтамжтайгаар гадаргуун бохирдлыг цэвэрлэв (Зураг 8-10). Үүний дараа цаашид гэмтэлгүй хадгалах зорилгоор глицерин (*Glycerin-C₃H₈O₃*)-д хийж стандарт саванд хадгаллаа (Зураг 11-13).



Зураг 6-7. Дээж бэлтгэл



Зураг 8-10. Цэвэрлэгээ



Зураг 11-13. Хадгалах


Ангилалзүйн боловсруулалт. Ангилалзүйн боловсруулалтыг хийхдээ MOTIC ES-18BZL маркийн бинокуляр, **холбогдох тодорхойлох бичгүүдийг** ашиглан бие бүтцийн шинж тэмдгүүд (хэлбэр, хэмжээ, өнгө, ялгаатай байдал)-ийг тодорхойлов (Хүснэгт 1-хавсаргав). Шавжийн хүүхэлдэй нь толгой буюу 3 сегментийн заагаар задарч бие гүйцсэн шавж нь гарч хоосон хонгио үлдсэн байв. Үүнд:

Шинж тэмдэг салалт 1. Толгойн хэсэгт хэлбэр ялгагдахуйц 3 сегмент, их биеийн 8 сегмент гэсэн нийт 11 сегменттэй. Биеийн нэг сегментийн эхний хагас нь өргөс хэлбэрийн төвгөр цэгжилт, сүүлийн хагас нь утасны ширхэглэг мэт харагдах гөлгөр гадаргуутай. Он цагийн элэгдлээс үүдсэн өнгөний ялгаа ажиглагдана (Зураг 14).

Шинж тэмдэг салалт 2. Морфологи ижил ч биеийн сегментүүд долгион хээтэй, өнгө мэдэгдэхүйц бараан. Ижил зүйлийн ялааны эрэгчин, эмэгчин байх магадлалтай (Зураг 15).



Зураг 14. Ангилал 1 (65 ширхэг)



Зураг 15. Ангилал 2 (8 ширхэг)

Хонгионы хэлбэр, хэмжээ, өнгө, (Цэндсүрэн, 1987), судал, шан, цэг (Намхайдорж нар., 2008), хэвлийн төгсгөл, амьсгалын сүв (Galassi et al., 2009) түүний биеийн бүтцээр Хос далавчтан(Diptera)-ы багийн Каллифорид (Calliphoridae) овгийн ялааны хүүхэлдэй болохыг тогтоолоо.

Баг, овгийн түвшинд шавжийн хүүхэлдэйн хонгионууд өөр хоорондоо ялгарах шинж тэмдэг багатай байна. Иймд энтомологичид хүүхэлдэйн хөгжлийг үргэлжлүүлэн бойжуулж бие гүйцсэн шавжийг гарган авснаар ангилалзүйн боловсруулалтыг хийдэг. Гэвч археологийн нөхцөлд олдож буй эртний шавжийн хувьд биеийн хөгжил хэдийн бүрэн зогсолтод орсон байна (Amendt et al., 2007). Хүүхэлдэй цоороогүй байсан ч хонгио доторх ялаа нь уургийн задралд орно. Тиймээс хоосон хүүхэлдэйн хонгионд тулгуурлан ангилалзүйг тодорхойлохын тулд хүүхэлдэйн эталон цуглуулгатай харьцуулна (Kenward, 2009). Гадаад бүтэц танигдахааргүй, зүйлийн түвшинд тодорхойлох түлхүүр шинжийг агуулах биеийн хэсэг хадгалагдан үлдээгүй тохиолдолд DNA-д тулгуурлан тодорхойлох боломжийг эрж хайна (Vanin et al., 2024).

Хүүхэлдэйн хонгионд тулгуурлан ангилалзүйг боловсруулахад Piophilidae (Giordani et al., 2023) овгийн ялааны хувьд биеийн урд байрлах амьсгалын сүвний морфологи, Calliphoridae (Szpila, 2010) овог болоод Hydrotaea (Giordani et al., 2018) төрлийн ялааны хувьд биеийн төгсгөлд байрлах амьсгалын сүвний морфологи түлхүүр шинж болно. Бид хадны оршуулгаас олдсон хүүхэлдэйн хонгионы биеийн төгсгөлийн амьсгалын сүв, түүний онцлог гадаад бүтцэд тулгуурлан ангилалзүйн боловсруулалтыг хийж *Calliphora vicina* (blue bottle fly) зүйл байж болохыг тодорхойлов. Тус ялаа нь амьтны аймаг (Animalia)-ийн, үет хөлтний хүрээ (Arthropoda)-ий, шавжийн анги (Insecta)-ийн, ялааны баг (Diptera)-ийн, Calliphoridae овгийн, *Calliphora* төрлийн *C. vicina* зүйлд

хамаарах юм.

***Calliphoridae* овгийн ялааны идэш тэжээлийн онцлог.** Ихэвчлэн ялзарсан органик бүтээгдэхүүн, сэг зэмээр хооллодог. Үржил явуулж, үр төлөө хооллохын тулд сэг зэмийг идэвхтэй хайдаг инстинкттэй юм. Тус овгийн эмэгчин ялаа өндөглөхөд уураглаг идэш тэжээл заавал шаардагддаг (Wheeler, 1996) байна. Биеийн нүх сүв, ил шарх сорви зэрэг шим тэжээл бүхий нойтон гадаргууд өндөглөдөг (Williams et al., 2006). Сэг зэм дотроо авгалдайн хөгжил нь явагдаж, битүү орчноосоо цоолон гарч гадна орчинд хүүхэлдэйдэг онцлогтой. Авгалдайн шатандаа сэгч юм уу холимог идэштний шинжийг агуулж, бие гүйцэхээрээ сахар (ургамал цэцэг, боловсорсон жимсэнд агуулагдах чихэрлэг шингэн, сахрын агууламж ихтэй хүнсний бүтээгдэхүүн г.м) болон уураг (амьтны сэг зэм г.м)-ийн агууламжаар хооллоно (Rozkošný et al., 1993).

Ил байгаа цогцос дээр 8 хүртэлх дарааллаар шавж цугларч, хооллодог. (Smith, 1986). Нэн түрүүнд хэд хэдэн овгийн ялаа ирнэ (Smith, 1988) (Ibrahim et al., 2013). Үүний төлөөлөл болох *Calliphoridae* (Byrd & Castner, 2012) нь амьсгал хурааснаас 1 цагийн дотор ирж өндөглөнө (Krikken & Huijbregts, 2001). Хүн, амьтны биеийн задрал шинэ шат (fresh)-д байх үед *Calliphoridae* (Salimi et al., 2018), *Sarcophagidae* овгийн ялаа, хөөлтийн шат (bloated)-д байх үед *Fanniidae*, *Sarcophagidae* (давхацна), *Muscidae*, *Phoridae* овгийн ялаа цугларна (Grassberger, 2003).

***Calliphora vicina* ялааны хөгжлийн мөчлөг.** Хүүхэлдэй нь бүрэн хувиралт шавжийн 3 дахь хувирал (Намхайдорж нар., 1989) юм. Өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцсэн (Чогсомжав нар., 1967) гэсэн хөгжлийн 4 үеийг дамждаг. **Хөгжлийн үе шат нь ойролцоогоор 1 сар явагдана.**

Бие гүйцсэн эрэгчин эмэгчин ялаа үржилд орсноор үр тогтоно. Тус зүйлийн эмэгчин ялаа нэг өндөглөхдөө 150-300, амьдралынхаа турш 2000 гаруй өндөг (Rognes, 1991) гаргадаг байна. *C. vicina* ялааны өндөглөх температур 10-35°C-ийн хооронд хязгаарлагдана (Ody et al., 2017).

1. **Өндөг.** Цагаан өнгөтэй, гулууз хэлбэртэй, 1.25 мм орчим (Olsson et al., 2020).
2. **Авгалдай.** Цайвар өнгөтэй, өт хэлбэртэй. 3 удаа гуужна.
3. **Хүүхэлдэй.** Хүүхэлдэйн шатанд хөдлөх, хооллох процессоо зогсоож, идэвхгүй байдалд орно.
4. **Бие гүйцсэн.** Цээж, хэвлийг бүрхсэн тод гялгар, ногоон цэнхэрдүү өнгөтэй. 10-14 мм (Stevens et al., 2001).

Ялааны хөгжлийн мөчлөг температураас шууд хамааран харилцан адилгүй

хугацаанд үргэлжилнэ (Winkler et al., 2020). Дундаж температурт 3 долоо хоног зарцуулагдана (Krikken & Huijbregts, 2001). Тухайлбал, *C. vicina* ялааны хөгжлийн мөчлөг 12°C-ийн дулаанд 43 хоног, 14°C-д 34 хоног, 16°C-д 29 хоног, 18°C-д 24 хоног тус тус үргэлжилж, температур 6°C-ээр өөрчлөгдөхөд (ихсэх, багасах) хөгжлийн мөчлөгт 19 хоногийн зөрүү гарчээ (Salanitro et al., 2022). Мөн 20°C-д 18 хоног (Bharti, 2009), 24°C-д 16 хоног (Sanei-Dehkordi et al., 2014), 25°C-д 15 хоног тус тус зарцуулсан (Bharti, 2009) болох нь лабораторийн судалгаагаар тогтоогдсон байна. Харин орчны температур хэт халуун буюу 30°C-ээс дээш байхад тус зүйлийн ялаа авгалдайн шатандаа харьцангуй хурдан томордог болох нь ажиглагдсан ч хүүхэлдэй үүсэхээс өмнө хөгжил зогсдог (Bharti, 2009) байна.

C. vicina ялааны идэвхтэй үе нь 13-16 °C-ээс эхэлдэг (Manea et al., 2022). Ер нь орчны температур 12°C-ээс доош, 35°C-ээс дээш байх нь тус зүйлийн ялааны хөгжлийг хязгаарлах буюу идэвхгүй байна (Priscilla, 1961) (Niederegger & Pastuszek, 2010) (Defilippo et al., 2013) (Matuszewski et al., 2013).

ДҮГНЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Бидний эх хэрэглэхүүн болох ялааны хүүхэлдэй нь нас барагчийн хэвлийн хөндийгөөс түлхүү олдсон нь тус хэсэгт ил шархтай байсныг шууд бусаар илтгэнэ. Энэ нь боломжит үхлийн шалтгаан байх магадлалтай юм. Мөн Calliphoridae овгийн ялааны амьдрах, өндөглөх, үржих температурт тулгуурлан үзэхэд нас барагч дулааны улиралд амьсгал хурааж, оршуулагджээ.

Хүн амьсгал хураасны дараа биеийн дулаан нь цаг тутамд 1°C орчим хөрдөг. *C. vicina* ялаа нь 10-35°C-д өндөглөх боломжтой бөгөөд түүний хөгжлийн мөчлөг, температурын хамааралд тулгуурлан нас барагч нартай амьсгал хураасан тохиолдолд 2 цагийн дараа, харанхуйд амьсгал хураасан тохиолдолд 8 цагийн дараа өндөглөсөн болохыг тодорхойлж болохоор байна.

Тус зүйлийн ялаа нь задралын шинэ шатанд цугларч, өндөглөдөг. Энэ нь нас барагчийн бие хөөлтийн шатанд орохоос өмнө буюу 3 хоногоос ихгүй хугацаанд оршуулагдсаныг илтгэнэ. Цагийн нарийвчлалыг урьдчилсан байдлаар хэлэхэд бэрх ч боловч цаашид тодруулах боломжтой. Үүний тулд тус зүйлийн ялааны өндгийг хэд хэдэн ялгаатай температурт бойжуулж, хөгжлийн мөчлөг, түүний онцлогийг тодорхойлох шаардлагатай болно.

Идэвхтэй ялзрал (active decay)-ын шатанд цугларах цохны зүйлүүд нь булчин, шөрмөсийг арьснаас салгах үүрэгтэй. Нас барагчийн бие занданшсан байдалтай, арьс, хумс, булчин шөрмөс анхны байрлалаараа байгаа нь нас барагч

амьсгал хураагаад удаагүй байхдаа оршуулагдсан, хадны хөмөг битүүмж сайтай байсныг гэрчилнэ.

Өндөг нь бие гүйцэх хүртлээ 15-43 хоногийг зарцуулна. Тэдгээр нь нас барагчийг оршуулагдсаны дараа буюу хадны хөмөг дотор байхдаа амьдралын хөгжлөө гүйцээжээ. Бие гүйцсэн ялаа нь нас барагч дээр ахин өндөглөх боломжгүй нь түүний бие цогцос хэдийн хөрсөнтэй холбоотой. Мөн ялааны хөгжил, түүнд хамаарах температурт үндэслэн хадны хөмөг доторх температурыг 5-30°C хэмээн тодорхойлох боломжтой байна.

Талархал

Энэхүү судалгааг эхлүүлэх, эх хэрэглэхүүнийг бий болгосон хамтрагч тал ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн Археологи-Угсаатны судалгааны ангийн археологич доктор, профессор Ю.Болдбаатар болон доктор С.Бат-Эрдэнэ тэргүүтэй судалгааны багийн хамт олон болоод хамтрагч тал Соёлын өвийн үндэсний төвийн Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга, доктор М.Оюунтулга, тус газрын хамт олонд талархал илэрхийлье. Судалгааны ажилд гар бие хамтран оролцохын зэрэгцээ мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, багаж хэрэгслээр хангасан удирдагч багш ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн ЭША, магистр Д.Алтанчимэг танаа гүнээ талархлаа.

Мөн тус судалгааны ажил эхлэх эх үндсийг тавьж, анхны эх хэрэглэхүүнийг бий болгосон МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор Т.Идэрхангай тэргүүтэй судалгааны баг хамт олон болон тус судалгааг анхлан санаачилж, хэрэгжүүлсэн Чингис хаан үндэсний музейн Хадгалалт хамгаалалт, Сан хөмрөгийн хэлтсийн ахлах сэргээн засварлагч Б.Батчимэг танаа талархлаа.

НОМ ЗҮЙ

Монгол ном

- Лепец, С. (2021). *Монгол Алтайн эртний хүн ам ба хоригууд: Бургаст ба Их хатуугийн голын археологийн дурсгалууд /НТӨ 1100-НТ 1100/35*. Франц: 0-361.
- Намхайдорж, Б., Нансалмаа, Б., Пунцагдулам, Ж. (1989). БНМАУ-ын шавж тодорхойлох бичиг-II боть. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Намхайдорж, Б., Мягмарсүрэн, Д., & Пунцагдулам, Ж. (2008). Монголын шавж тодорхойлох товч бичиг II ботийн 2-р хэсэг. Улаанбаатар.
- Цэндсүрэн, А. (1987). *Бүгд найрамдах Монгол ард улсын амьтны аймаг-I боть. Шавжийн анги*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Чогсомжав, Л. *Хөдөө аж ахуйн энтомологи ба Фитопатологи*. Улаанбаатар: 1967.

Монгол өгүүлэл

- Ю. Болдбаатар., & С. Бат-Эрдэнэ. (2023). *Баянхонгор аймгийн Шинэжсинст сумын Сарлагтай хэмээх газарт хийсэн хадны оршуулгын судалгаа*.
- Ц. Намуун. (2023). Бунхант булшнаас илэрсэн шавжийн үлдэгдэл Монголын археологийн судалгаанд шинэ мэдээллийг бий болгох нь. *Эрдмийн хэлхээ 2023*.
- Ц. Намуун. (2024). Археоэнтомологийн судалгааны арга зүйг нэвтрүүлэх нь. *Эрдмийн хэлхээ 2024*.

Гадаад ном

- Buckland, S. T., Anderson, D. R., Burnham, K. P., Laake, J. L., Borchers, D. L., & Thomas, L. (2004). *Advanced distance sampling: Estimating abundance of biological populations*. Oxford University Press.
- Byrd, J. H., & Castner, J. L. (2012). *Forensic entomology: The utility of arthropods in legal investigations* (2nd ed.). CRC press.
- Gaudry, E. (2009). *The insects colonization of buried remains*. Current concepts in forensic entomology. https://doi.org/10.1007/978-1-4020-9684-6_13
- Goff, M. L. (2009). *Early Postmortem Changes and Stages of Decomposition*. Current Concepts in Forensic Entomology.
- Kenward, H. (2009). *Northern Regional Review of Environmental Archaeology: Invertebrates in Archaeology in the North of England: Environmental Studies Report*. English Heritage Research Department, Fort Cumberland.
- Rognes, K. (1991). *Blowflies (Diptera, Calliphoridae) of Fennoscandia and Denmark*. Brill.
- Smith, K. G. V. (1986). *A manual of forensic entomology* (1st ed.). Cornell University Press.

Гадаад өгүүлэл

- Amendt, J., Campobasso, C. P., Gaudry, E., Reiter, C., Leblanc, H. N., & Hall, M. J. (2007). Best practice in forensic entomology-standards and guidelines. *International Journal of Legal Medicine*, 121, 90–104.
- Amendt, J., Krettek, R., & Zehner, R. (2004). Forensic entomology. *Naturwissenschaften*, 91(2), 51–65.
- Bharti, M. (2009). Studies on life cycles of forensically important flies, *Calliphora vicina* and *Musca domestica* at different temperatures. *J. ent. Res.*, 33(3), 273–275.
- Defilippo, F., Bonilauri, M. S. P., & Dottori, M. (2013). Effect of temperature on six different developmental landmarks within the pupal stage of the forensically important blowfly *Calliphora vicina* (Robineau-Devoidy) (Diptera: Calliphoridae). *Forensic Science International*, 58, 1554–1557.
- Galassi, A., Cattaneo, C., Turchetto, M., & Vanin, S. (2009). Forensic entomology and the archaeology of war. *Journal of Conflict Archaeology*, 5(1), 127.
- Giordani, G., Grzywacz, A., & Vanin, S. (2018). Characterization and identification of puparia of *Hydrotaea* Robineau-Desvoidy, 1830 (Diptera: Muscidae) from forensic and archaeological contexts. *Journal of Medical Entomology*, 56, 45–54.
- Giordani, G., Tuccia, F., Martín-Vega, D., Angell, C. S., Pradelli, J., & Vanin, S. (2023). Morphological and molecular characterization of puparia of *Piophilidae* species of forensic relevance. *Medical and Veterinary Entomology*, 37, 339–358.
- Gouda, M. N. R. (2022). Forensic Entomology: Past, Present and Future. *Agri Atricles*, 2(1), 25.
- Grassberger, M., Reiter, C., Frank, C., & Amendt, J. (2003). The use of larval development data in forensic entomology. *Forensic Science International*, 135(1), 45–50.
- Huchet, J. (2018). Archaeoentomological study of the insects remains found within the mummy of Namenkhet Amon, San Lazzaro Armenian Monastery, Venice/Italy). *Research Gate*.
- Ibrahim, A. A., Galal, F. H., Seufi, A. M., & Elhefnawy, A. A. (2013). Insect succession associated with corpse's decomposition of the guinea pig *Cavia porcellus* in Benha city, Egypt. *Egypt. Acad. J. Biol.*, 5, 1–20.
- Krikken, J., & Huijbregts, J. (2001). Insects as forensic informants: The Dutch experience and procedure.
- Manea (Amariei), C., Sandu, I., Iliescu, D. B., Forna, N. C., Vasilache, V., & Sîrbu, V. (2022). Preliminary study on the larval development of *Calliphora vicina* (Diptera: Calliphoridae) on different types of substrates used as reference in forensic entomology. *Applied Sciences*, 12(21), 10907. <https://doi.org/10.3390/>

app122110907

- Magni, P. A., Harvey, A. D., & Guareschi, E. E. (2023). Insects associated with ancient human remains: How archaeoentomology can provide additional information in archaeological studies. *Heritage*, 6, 437.
- Matuszewski, S., Szafałowicz, M., & Grzywacz, A. (2013). Temperature-dependent appearance of forensically useful flies on carcasses. *International Journal of Legal Medicine*, 128, 1013–1020.
- Niederegger, S., & Pastuszek, J. G. (2010). Preliminary studies of the influence of fluctuating temperatures on the development of various forensically relevant flies. *Forensic Science International*, 199, 72–78.
- Ody, H., Bulling, M. T., & Barnes, K. M. (2017). Effects of environmental temperature on oviposition behavior in three blow fly species of forensic importance. *Forensic Science International*, 275, 138–143.
- Olsson, F., Buckland, P., & Buckland, P. (2020). Paleoentomology: Insects and other arthropods in environmental archaeology. *Encyclopedia of Global Archaeology*, 8291–8312.
- Priscilla, H. S. (1961). The spectral sensitivity of *Calliphora* maggots. *Journal of Experimental Biology*, 38, 237–248.
- Rozkošný, R., & Vaňhara, J. (1993). Diptera Brachycera of a forest steppe near Brno (Hády Hill). *Acta Scientiarum Naturalium Brno*, 27(2-3), 1-76.
- Salanitro, L. B., Massaccesi, A. C., Urbisaglia, S., Pería, M. E., Centeno, N. D., & Chirino, M. G. (2022). *Calliphora vicina* (Diptera: Calliphoridae): Growth rates, body length differences, and implications for the minimum post-mortem interval estimation. *Revista de la Sociedad Entomológica Argentina*, 81(2).
- Salimi, M., Rassi, Y., Oshaghi, M. A., Chatrabgoun, O., Limoe, M., & Rafizadeh, S. (2018). Temperature requirements for the growth of immature stages of blowflies species, *Chrysomya albiceps* and *Calliphora vicina*, (Diptera: Calliphoridae) under laboratory conditions. *Egyptian Journal of Forensic Sciences*, 8(1), 28.
- Sanei-Dehkordi, A., Khamesipour, A., Akbarzadeh, K., & Akhavan, A. A. (2014). Experimental colonization and Life Table of the *Calliphora vicina* (Robineau-Desvoidy) (Diptera: Calliphoridae). *JOURNAL OF ENTOMOLOGY AND ZOOLOGY STUDIES*, 2(6), 45-48.
- Stevens, J., & Wall, R. (2001). Genetic relationships between blowflies (Calliphoridae) of forensic importance. *Forensic Science International*, 120(1), 116-123.
- Szpila, K. (2010). Key for the identification of third instars of European blowflies (Diptera: Calliphoridae) of forensic importance. In J. Amendt, M.L. Goff, P.C. Campobasso, & M. Grassberger (Eds.), *Current concepts in forensic entomology*. 43-56.

- Tuccia, F., Giordani, G., & Vanin, S. (2022). State of the art of the funerary archaeoentomological investigations in Italy. *Archaeological and Anthropological Sciences*, 14(70). <https://doi.org/10.1007/s12520-022-01524-3>
- Wheeler, D. (1996). The role of nourishment in oogenesis. *Annual Review of Entomology*, 41(1), 407-431.
- Williams, K. A., & Villet, M. H. (2006). A new and earlier record of *Chrysomya megacephala* in South Africa, with notes on another exotic species, *Calliphora vicina* (Diptera: Calliphoridae.). *African Invertebrates*, 47, 347–350.
- Winkler, A., Jung, J., Kleinhenz, B., & Racca, P. (2020). A review on temperature and humidity effects on *Drosophila suzukii* population dynamics. *Agricultural and Forest Entomology*, 22(3), 179-192.
- Vanin, S., Tuccia, F., Pradelli, J., Carta, G., & Giordani, G. (2024). Identification of Diptera Puparia in Forensic and Archeo-Funerary Contexts. *Insects*, 15(8), 599.

DISCOVERING FUNERARY PRACTICES OF CAVE BURIAL THROUGH THE STUDY OF INSECTS

Abstract. Numerous ancient insect remains were found from the abdominal area of a mummified human body discovered in the Sarlagtai cave burial in Shinejinst sum, Bayankhongor province in 2023. The collected specimens were brought to the Entomology research laboratory of the Institute of Biology, Mongolian academy of sciences for taxonomic processing. Insects undergo either complete or incomplete metamorphosis in terms of development. Insects with complete metamorphosis develop through egg, larva, pupa, and adult stages, while those with incomplete metamorphosis develop without a pupal stage. During the laboratory analysis, it was determined that the insect remains were empty pupal cases. Although taxonomic processing based on insect pupal cases to the species level is very challenging, we preliminarily identified them as belonging to the *Calliphora* genus of the Calliphoridae family (Diptera), possibly *Calliphora vicina*, based on its morphological characteristics. The discovery of this insect suggests that the mummified body had a possible open wound in the abdominal area, was buried within 3 days of death, the temperature of the cave was approximately 5-30°C, and the burial took place during warm seasons. The results of this study highlight the need to develop archaeoentomological study which is a new branch of science, in Mongolian archaeological research.

Keywords: *Archaeoentomology, mummified body, ancient insect remains, Diptera, fly pupae*

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Хүүхэлдэйн хонгионы биеийн бүтэц

Д/д	Хэлбэр	Хэмжээ	Өнгө	Тайлбар
1	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
2	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
3	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.88 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
4	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1 см	Хар хүрэн	Толгойн хэсэг бүтэн боловч гэмтлээс үүдэн урагдал үүссэн, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
5	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
6	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.95 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
7	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1.15 см	Хар хүрэн	Бүтэн. Бие гүйцсэн ялаа хүүхэлдэйн дотроо байх магадлалтай. Хадгалалтын гэмтлээс үүдэн зарим хэсгээр хонхойлт үүссэн байна.
8	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
9	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

10	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
11	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.95 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
12	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1.15 см	Хүрэн	Бүтэн. Хэвлийн төгсгөл хэсгийн нэг амьсгалын сүв цоорсон байна.
13	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
14	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Бүтэн. Бие гүйцсэн ялаа хүүхэлдэйн дотроо байх магадлалтай.
15	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
16	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг бүтэн буюу бие гүйцсэн ялаа гарч амжаагүй байсан байна. Биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн цоорсон байна.
17	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1 см	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
18	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
19	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.93 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

20	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
21	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
22	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
23	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.5 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
24	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.5 мм	Хүрэн	Толгойн хэсэг бүтэн буюу бие гүйцсэн ялаа гарч амжаагүй байсан байна. Биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн цоорсон байна.
25	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.45 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
26	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
27	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1.1 см	Хүрэн	Бүтэн. Бие гүйцсэн ялаа хүүхэлдэйн дотроо байх магадлалтай.
28	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
29	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1.2 см	Хар хүрэн	Бүтэн. Бие гүйцсэн ялаа хүүхэлдэйн дотроо байх магадлалтай.

30	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
31	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
32	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
33	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
34	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
35	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1 см	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
36	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.65 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
37	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
38	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
39	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 см	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

40	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
41	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
42	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
43	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
44	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.6 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
45	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
46	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
47	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
48	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1 см	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
49	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1.1 см	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

50	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.6 мм	Хар хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
51	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.2 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
52	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.75 мм	Хүрэн	Биеийн ихэнх хэсэг үрэгдэж, биеийн төгсгөл хэсэг л үлдсэн байна.
53	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.3 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
54	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
55	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.4 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
56	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.6 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
57	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.95 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
58	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.4 мм	Хүрэн	Толгойн хэсэг бүтэн буюу бие гүйцсэн ялаа гарч амжаагүй байсан байна. Биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн цоорсон байна.
59	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.8 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

60	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Биеийн төгсгөл хэсэг байхгүй, ихэнх хэсгээр цоорсон байна.
61	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг бүтэн буюу бие гүйцсэн ялаа гарч амжаагүй байсан байна. Биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн цоорсон байна.
62	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
63	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
64	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
65	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.4 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
66	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
67	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.55 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
68	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	1 см	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн үрэгдэж, биеийн дунд хэсэг л үлдсэн байна.
69	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.

70	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.7 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.
71	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.6 мм	Хүрэн	Толгойн хэсэг бүтэн буюу бие гүйцсэн ялаа гарч амжаагүй байсан байна. Биеийн төгсгөл хэсэг гэмтлээс үүдэн цоорсон байна.
72	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.9 мм	Хүрэн	Бүтэн. Бие гүйцсэн ялаа хүүхэлдэйн дотроо байх магадлалтай.
73	Толгой, хэвлийн төгсгөл илт мэдэгдэхүйц, өндгөрхүү зууван	0.85 мм	Хүрэн	Толгойн хэсэг цоорсон, хэвлийн төгсгөлд үржлийн эрхтнүүдийн бүтцийг илтгэх шинж тэмдгүүд бинокулярт тодорхой харагдана.



МОНГОЛ ОХИДЫН САРЫН ТЭМДЭГ АНХ ИРЭХ НАС МЕНАРХИ БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ (Улаанбаатар хотод амьдарч буй охидын жишээн дээр)

Болорчулууны МӨНХЖИН

МУИС-ийн Археологи, Антропологийн тэнхим

Удирдагч багш: М. Эрдэнэ

PhD, МУИС-ийн Археологи, Антропологийн тэнхимийн профессор

Хураангуй: Менаρχе буюу охидын биеийн юм анх ирэх нас нь охидын нөхөн үржихүйн чадавхи, бие махбодийн төлөвшилийг илтгэх гол үзүүлэлт юм. Тус судалгаагаар монгол охидын менаρχе нас сүүлийн 70 жилийн хугацаанд мэдэгдэхүйц эршиж буйг илрүүлсэн бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжил, хотжилт, хоол тэжээл, амьдралын хэв маягтай нягт холбоотой гэж үзэж байна. Судалгаанд хамрагдсан охидын анхны сарын тэмдэг ирэх дундаж нас 12.4 байсан нь өмнөх үеийн судалгаануудтай харьцуулахад бараг 3 жилээр урагшилсан үзүүлэлт юм. Судалгаагаар биологийн хүчин зүйлс (БЖИ, хоол тэжээл), орчны нөхцөл (стресс, шилжилт хөдөлгөөн), сэтгэлзүйн бэлтгэл, мэдээлэлтэй байдал зэрэг нь менаρχетэй холбоотойгоор охидын мэдрэмж, сэтгэхүйд нөлөөлж буй ажиглагдсан. Энэхүү бичвэрт анхны сарын тэмдэг ирэх насны өөрчлөлт нь зөвхөн тоон үзүүлэлт бус охидын амьдралын чанар, эрх, боловсрол, эрүүл мэнд, бие даах чадварт нөлөөлөх өргөн цар хүрээтэй үзэгдэл болох талаар судлахыг зорилоо.

Түлхүүр үг: Охидын сарын тэмдэг анх ирэх нас (менаρχе нас), нийгэм-соёлын нөлөө, биологийн нөлөө

УДИРТГАЛ

Шинжлэх ухааны ойлголтоор *menarche* гэдэг нэр томьёо нь сарын тэмдэг (биеийн юм) анх ирэхийг илэрхийлдэг бөгөөд хүн биологийн зүйл амьтны хувьд нас бие гүйцэж үржилд орох нөхцөл бүрдсэнийг илтгэнэ. Сарын тэмдэг анх харилцан адилгүй насанд эхэлдгийг эрдэмтэд тухайн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, байгаль, газарзүйн байршил, тухайн үндэстний ёс заншил, удамшил, сэтгэл зүйн байдал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, хоол хүнс гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалдаг болохыг тогтоосон бөгөөд хамгийн тэргүүлэх хүчин зүйл бол нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал (тухайн эмэгтэйн амьдарч буй амьдралын түвшин, гэр бүлийн боловсролын түвшин, зарим тохиолдолд тухайн гэр бүлийн хүүхдийн тоо, хот ба хөдөө амьдардаг гэх мэт) байгаль, газар зүйн байршил нөлөөлдөг байна. Сарын тэмдэг анх ирэх нас удамших нөлөөг судалгаа байгаа хэдий ч эрдэмтдийн дунд маргаантай сэдэв хэвээр байна. Тухайлбал, И. Ковальскагийн 1963 онд ахлан хийсэн сарын тэмдэг анх ирэх нас хоорондоо тодорхой холбоогүйг нотолсон бол, Ковальска 1966 онд өөрийн бие даасан судалгаагаар холбоотой хэмээн дүгнэжээ.

Менарх буюу анхны сарын тэмдэг нь эмэгтэй хүүхдийн хөгжилд чухал түүхэн үеийг тэмдэглэдэг бөгөөд бага наснаас өсвөр нас руу шилжих шилжилтийг илэрхийлдэг. Менархийн үе нь зөвхөн биеийн өөрчлөлтөд ч бус, сэтгэл зүйн болон нийгэмд эзлэх байр сууринд ч нөлөөлдөг. Иймд менархийн насны хувьсал нь эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм (Yoo, 2016).

Сүүлийн жилүүдэд охидын биений юм ирэх насны хувьсал нь дэлхий даяар ажиглагдаж байна. Энэхүү хувьсал нь биологийн, байгаль орчны, нийгэм-эдийн засгийн олон хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогддог. Жишээлбэл, илүүдэл жин, таргалалттай охидын биений юм эрт мэдэрдэг болохыг олон судалгаагаар тогтоожээ. Мөн хоол тэжээл, амьдралын хэв маяг, стресс зэрэг хүчин зүйлс ч биений юм ирэх насанд насанд нөлөөлдөг. Монгол охидын хувьд менархийн насны тухай судалгааг 1958 оноос хийж эхэлсэн байдаг ба хамгийн сүүлийн нэгдсэн датасан бүхий судалгааг 2009 онд хийсэн байна. Тус судалгаанд оролцогчид 1990 оноос өмнө төрж өссөн хүмүүс байсан ба монголын чөлөөт эдийн засгийн шилжилтийн үеийн болон түүний дараа төрж өссөн охидын менархийн насны судалгаа хомс байна.

Энэхүү судалгаа нь менархийн насанд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг судлах зорилготой юм. Судалгааны үр дүн нь менархийн насны хувьсалд нөлөөлөх хүчин зүйлсийг

ойлгох, холбогдох эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэхэд, охидын биологийн болон нийгмийн мэдрэмжийг ойлгоход чухал ач холбогдолтой.

Судлагдсан байдал

Сарын тэмдэг нь гипоталамус-гипофиз-өндгөвчний (НРО) боловсорч гүйцсэн тэнхлэгт тохиолддог. Энэ нь дараах үйл явц дээр тулгуурладаг: гипоталамусын болон гипофиз булчирхайн хэвийн үйл ажиллагаа, эмэгтэйн нөхөн үржихүйн хэвийн анатоми, хэвийн хоол тэжээл, бусад архаг өвчин эмгэггүй байх. Энэ нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл мэндийн хэвийн байдлын үзүүлэлт юм. Анхан шатны сарын тэмдэг нь хэвийн өсөлт, хоёрдогч бэлгийн хөгжилд 15 нас хүртлээ сарын тэмдэг ирэхгүй байх, эсвэл 13 нас хүртэл хэвийн өсөлт, хоёрдогч бэлгийн хөгжил байхгүй үед сарын тэмдэг ирэхгүй байхыг хэлнэ. Сарын тэмдэг хэтэрхий эрт, оройтсон эсвэл огт тохиолдохгүй үед онцгой анхаарал хандуулдаг, учир нь эдгээр хувилбарууд нь ирээдүйд сөрөг үр дагавартай байдаг. Сарын тэмдэг 10-аас доош настай бол эрт, 15-аас доош настай бол хожуу гэж үзнэ (De Sanctis et al., 2019).

Дэлхийн улсуудад хийгдсэн олон судалгаагаар сарын тэмдгийн дундаж нас өнгөрсөн зуунд буурсан болохыг харуулж байна. 20-р зууны эхэн үед барууны орнуудад сарын тэмдгийн дундаж нас ойролцоогоор 16-17 жил байсан ба нийгэм- 12-13 жил байна (Parent et al., 2003). Судалгаанаас үзэхэд, сарын тэмдгийн нас нь газар зүй, эдийн засгийн хөгжил, үндэс угсаа зэргээс хамаарч өөр өөр байдаг. Жишээлбэл, Африк гаралтай Америк, Испани охидын сарын тэмдэг нь Кавказ, Ази охидтой харьцуулахад эрт ирдэг (Chumlea et al., 2003). Бүс нутгийн судалгаагаар янз бүрийн популяцид сарын тэмдгийн насны өөрчлөлтийг илрүүлсэн бөгөөд энэ нь ихэвчлэн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хүчин зүйлээс шалтгаалдаг. Монголд хийсэн судалгаагаар монгол охидын сарын тэмдэг нь Хан үндэстний охидтой харьцуулахад өндөр, өндөр, BMI зэрэг антропометрийн хэмжилтийн хувьд ялгаатай байдгийг харуулсан (Chinese Journal of Preventive Medicine, 2015). Нэмж дурдахад Казахстаны хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс хожуу насанд хүрдэг бөгөөд үүнд хүрээлэн буй орчны хүчин зүйлс ихээхэн үүрэг гүйцэтгэдэг (Annals of Human Biology, 2008).

Биологийн болон хүрээлэн буй орчны хэд хэдэн хүчин зүйл нь сарын тэмдгийн насны өөрчлөлтөд нөлөөлдөг. Гэр бүлийн стресс, бага насны хүүхдийн хүчирхийлэл зэрэг сэтгэлзүйн нийгмийн хүчин зүйлүүд нь сарын тэмдгийн эхэн үетэй холбоотой байдаг. 2003 онд хийсэн судалгаагаар бага насны нийгэм-эдийн засгийн байдал, гэр бүлийн зөрчилдөөн зэрэг нь сарын тэмдгийн эхэн үеийг урьдчилан таамаглах хүчин зүйл болдог (Psychological Medicine, 2003).

Цаашилбал, түүхийн тоо баримтаас харахад сарын тэмдгийн нас нь цаг хугацааны явцад хэлбэлзэж, аж үйлдвэрийн хувьсгал зэрэг амьдралын ядуу нөхцөлд ихээхэн удаашрал ажиглагдаж, улмаар 20-р зуунд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал сайжирсантай холбоотойгоор буурсан байна (Journal of Pediatric and Adolescent Gynecology, 2016).

Монгол охидод болон дэлхийн зарим улс орны хүн амд эмэгтэйчүүдийн биеийн юм анх ирэх үеийн насыг өмнө нь Монголын болон гадаадын эрдэмтэд судалж байсан. Vlcek-ийн 1958 онд монгол охидын дунд явуулсан судалгаагаар охидын сарын тэмдэг анх ирэх дундаж насыг 15 нас 10 сар (Цит. Г. Грим.1967) гэж тодорхойлжээ. Х. Лхагважавын (1972) Улаанбаатар хотод амьдардаг охидын дунд явуулсан судалгаагаар охидын сарын тэмдэг анх ирэх нас дунджаар 14 нас 1 сартайд ирдэг гэсэн үр дүн гарчээ. 1958-1961 онд явуулсан Ч. Чүлтэмдорж (1962,1967) явуулсан судалгаагаар 14 насанд биеийн юм ирсэн охид нийт судалгаанд оролцсон охидын 45,3% эзэлж байсан бол 1981 онд Д. Батчулуун (1981) судалгаагаар 14 насанд сарын тэмдэг ирсэн охид 96% болж өссөнийг судлаач тэмдэглээд сүүлийн 50 жилд охидын сарын тэмдэг ирэх нас бараг 2 жилээр урагшилсан гэж дүгнэжээ.

П. Цэндсүрэнгийн (1977) Улаанбаатар хотын охидын дунд хийсэн судалгаагаар анхны сарын тэмдэг охидод дунджаар $13,48 \pm 1,02$ насанд, Монголын говийн бүсийн нутагт амьдардаг охидод дунджаар $13,52 \pm 1,09$, хангайн уулархаг нутагт амьдардаг охидод $13,64 \pm 1,04$ насанд тус тус ирдэг гэж тодорхойлжээ. Улаанбаатар хот болон 6 аймгийн төвд амьдардаг 2804 өсвөр насны охидыг (нийгмийн байдлаар өөр өөр) хамруулан судалсан Ж. Дэмбэрэлсүрэн нарын судалгаагаар анхны сарын тэмдэг ирэх үеийн дундаж насыг 12,8 гэж тодорхойлжээ. Д. Түмэн (1996) судалгаагаар охидын анхны сарын тэмдэг хот, хөдөөгийн охидод харилцан адилгүй насанд үзэгддэг гээд анхны сарын тэмдэг хотод амьдардаг охидод 13,2 насанд, аймгийн төвийн охидод 13,3 насанд, суманд амьдардаг охидод 14,0-14,6 насанд ирж байна гэж дүгнэжээ.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд нийт 11–45 насны 112 эмэгтэйг хамруулан асуумжийн аргаар өгөгдөл цуглуулсан бөгөөд цуглуулсан мэдээлэлд SPSS болон Python программын тусламжтайгаар статистик боловсруулалт хийсэн. Судалгааны чанарын хэсэгт 11–18, 17–28, 28-аас дээш гэсэн гурван өөр насны ангиллаар нийт 9 эмэгтэйг сонгон авч, тус бүрээс гурван эмэгтэйгээс антропологийн этнографийн ярилцлага хийсэн. Эдгээр ярилцлагын хүрээнд анхны сарын тэмдэг ирэх үеийн сэтгэл хөдлөл, мэдрэмж, нийгмийн орчин дахь үүрэг,

хариуцлагын талаарх ойлголт, өөрийн биеийн талаарх ухамсрын өөрчлөлт зэрэг асуудлыг онцлон авч үзэж, анализ хийсэн.

Түүнчлэн, 58-р сургууль болон Шинэ Монгол сургуулийн 6-р ангийн охидын дунд оролцон ажиглалт хийж, тухайн орчны хандлага, сурагч охидын зан төлөв, мэдлэгийн түвшинг ажиглалтын аргаар үнэлсэн. Үүнээс гадна дээрх сургуулиудын сургуулийн эмч нартай тусгай ярилцлага хийж, охидын анхны сарын тэмдэг ирэх насны хандлагын талаарх мэргэжлийн ойлголт, туршлага, ажиглалтыг тодруулсан. Мөн охид, өсвөр насны хүүхдүүдтэй ажилладаг эмчээс ярилцлага авч, анхны сарын тэмдэг ирэх үеийн бие махбод түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх нарийвчилсан мэдээллийг багтаасан болно.

Холимог арга зүйд суурилсан энэхүү судалгаа нь тоон ба чанарын аргуудыг хослуулан хэрэглэж, анхны сарын тэмдэг ирэхтэй холбоотой биологийн болон нийгэм-соёлын хүчин зүйлсийг цогц байдлаар ойлгохыг зорьсон юм.


Охидын сарын тэмдэг анх ирэх насанд нөлөөлөх хүчин зүйлс

Анхны сарын тэмдэг нь өсвөр насны эмэгтэй хүүхдэд анх удаа сарын тэмдэг ирэх үеийг тодорхойлогддог. Сарын тэмдэг нь ихэвчлэн 10-16 насны хооронд тохиолддог ба дундаж нас нь 12.4 жил байдаг. Сарын тэмдгийн насыг тодорхойлох хүчин зүйлсийг одоог хүртэл тодорхойлон судалсаар байна; Нийгэм, эдийн засгийн нөхцөл, генетик, ерөнхий эрүүл мэнд, хоол тэжээлийн байдал, дасгал хөдөлгөөн, улирлын шинж чанар, ам бүлын тоо чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Сарын тэмдэг нь өвдөлтгүй, сэрэмжлүүлэггүйгээр тохиолддог. Эхний мөчлөгүүд нь ихэвчлэн янз бүрийн урт, урсгалтай ановуляци байдаг. Сарын тэмдэг нь нөхөн үржихүйн чадварын эхлэлийг илтгэдэг бөгөөд хоёрдогч бэлгийн шинж чанаруудын байнгын хөгжилтэй нягт холбоотой байдаг (Lacroix et al., 2023).

Сарын тэмдэг буюу сарын тэмдгийн эхний үе нь эмэгтэй хүний нөхөн үржихүйн чадавхийг илтгэж, биологийн төлөвшлийн гол үзүүлэлт юм. Сарын тэмдэг ирэх хугацаа нь хүн амын дунд харилцан адилгүй бөгөөд генетик, хүрээлэн буй орчин, нийгэм соёлын хүчин зүйлсээс шалтгаалан цаг хугацааны явцад өөрчлөгддөг.

Менархий нас нь биологийн, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн олон хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогддог. Биеийн жин ба хоол тэжээл чухал үүрэг гүйцэтгэдэг ч бүс нутгийн ялгаа, сэтгэл зүйн хүчин зүйлс ч мөн нөлөө үзүүлдэг (Ramamani et al., 2020). Олон судалгаагаар охидын анхны сарын тэмдэг ирэх насанд нөлөөлж буй томоохон хүчин зүйлийг нийгэм-эдийн засгийн байдал хэмээн тодорхойлсон байдаг. Энэхүү судалгаандаа

нийгэм-эдийн засгийн байдлын үзүүлэлтийг дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) үзүүлэлтээр төлөөлүүлэн авч үзэв. 1961, 1972,1977,1981,1996 болон 2024 онд хийгдсэн охидын сарын тэмдэг анх ирэх насны тухай судалгаануудыг тухайн үеийн ДНБ-ийн өсөлтийн хувь хоорондын хамаарлыг тооцон үзэхэд хамааралгүй буюу нийгэм-эдийн засгийн өсөлт болон охидын анхны сарын тэмдэг ирэх нас хоорондоо статистик хамааралгүй гарч байна.



Correlations			
		ДНБ_ өсөлт	Дундаж_ нас
ДНБ_өсөлт	Pearson	1	-.263
	Correlation		
	Sig. (2-tailed)		.614
	N		6
Дундаж_нас	Pearson	-.263	1
	Correlation		
	Sig. (2-tailed)	.614	
	N	6	

Дүрслэл 1. Нийгэм-эдийн засгийн өсөлт (ДНБ-ийн өсөлт) болон охидын сарын тэмдэг анх ирэх насны хамаарал


Биологийн нөлөөлөл

Хэд хэдэн судалгаагаар сарын тэмдэг ирэх насыг тодорхойлоход биеийн жин, хоол тэжээлийн үүрэг чухал болохыг онцолсон байдаг. Судалгаанаас үзэхэд илүүдэл жинтэй эсвэл таргалалттай охидууд үе тэнгийнхнээсээ эрт сарын тэмдэг ирэх хандлагатай байдаг. Жишээлбэл, 9-16 насны 2127 эрүүл охидыг хамруулсан судалгаагаар сарын тэмдэг эрт ирэх нь биеийн жин, өндөр, БЖИ ихэсдэг, охидын 25% нь 11.98 нас хүрэхээс өмнө сарын тэмдэгтэй байсан нь тогтоогджээ (Journal of Pediatric Endocrinology and Metabolism, 2012). Үүний нэгэн адил 1996 оны судалгаагаар долоон насандаа илүү жинтэй охидын сарын тэмдэг эрт ирдэг бол төрөхдөө илүү жинтэй охидууд сарын тэмдэг нь хожуу тохиолддог болохыг ажигласан (An International Journal of Obstetrics and Gynaecology, 1996).

Хэт боловсруулсан хоол хүнс, ялангуяа илчлэг, уургийн хэрэглээг нэмэгдүүлэх нь сарын тэмдэг эрт ирэхтэй холбоотой байдаг (Eveleth & Tanner, 1990). Биеийн өөхний өндөр хувь ба БЖИ (BMI) нь гипоталамик-гипофиз-гонададь тэнхлэгт нөлөөлдөг лептины түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор сарын тэмдэг эрт эхлэхтэй холбоотой байдаг (Frisch & Revelle, 1970). Хоол тэжээлийн хэрэглээ, ялангуяа амьтны гаралтай уургийн өндөр хэрэглээ нь сарын тэмдэг эрт ирэхтэй холбоотой байдаг. 2014 оны системчилсэн тойм нь жирэмсний өмнөх болон бага насны хүүхдийн өсөлт нь бэлгийн төлөвшилд ихээхэн нөлөөлдөг бөгөөд биеийн жин, хоолны дэглэм чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолсон (Biomed Research International, 2014). Гэсэн хэдий ч 1989 онд хийсэн өөр нэг судалгаагаар сайн хооллодог популяцид удамшлын хүчин зүйл нь сарын тэмдгийн насыг тодорхойлоход хоол тэжээлээс илүү нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна (Archives of Disease in Childhood, 1989).

Монгол улсын хувьд сүүлийн 30 жилийн хугацаанд хүн амын дундах таргалалт нь нийгмийн анхаарал татсан чухал асуудлуудын нэг болж хувирсан. Энэхүү үзэгдэл нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдац, хотжилт, амьдралын хэв маягийн өөрчлөлттэй шууд холбоотой гэж сүүлийн үеийн судалгаанууд харуулж байна. 1990-ээд оны үед Монгол Улс нийгэм, эдийн засгийн шилжилт болж үүний дараагаас буюу 2000-аад оноос эхлэн эдийн засгийн өсөлт, хотжилт хурдацтай явагдаж, энэ нь хүмүүсийн амьдралын хэв маягт ихээхэн нөлөөлжээ (Монгол улсын хүн амын хүнс тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017 он).

Улаанбаатар хотод амьдарч буй 2000 оноос хойш төрсөн 112 эмэгтэйтэйгээс авсан судалгаагаар биеийн жин болон сарын тэмдэг анх ирэх дундаж насыг харьцуулан хамаарлыг судалхад дараах үр дүн гарч ирсэн ба охидын сарын тэмдэг анх ирэх нас болон жин нь бага зэргийн хамааралтай гарлаа.



$R = -0.03603808087$


$P > 0.5$

Дүрслэл 2. Охидын жин болон анхны сарын тэмдэг ирэх насны хамаарал

Анх монгол охидын анх сарын тэмдэг ирэх насны тухай 1961 онд Vlcek (1958) судалгаагаар дундаж нас 15 нас 10 сар байсан бол дараа дараагийн судалгаагаар энэ нас бага багаар буурсан. Х. Лхагважав (1972) 14 нас 1 сар, Ч. Чүлтэмдорж (1962, 1967) 14 настай охид 45.3% байсныг, харин Д. Батчулуун (1981) 14 настай охид 96% болсон гэж тэмдэглэсэн. П. Цэндсүрэн (1977) судалгаагаар дундаж нас 13.5 орчим байж, газар нутгийн онцлогоос шалтгаалан бага зэрэг ялгаатай байжээ. Ж. Дэмбэрэлсүрэн нар (он тодорхойгүй) 2804 охины дундаж насыг 12.8 гэж тогтоосон бол Д. Түмэн (1996) хот, хөдөөгийн ялгаа байгааг харуулж, хотын охидод 13.2, аймгийн төвийнхөнд 13.3, сумын охидод 14.0–14.6 насанд ирдэг гэж дүгнэжээ. Монгол охидын сарын тэмдэг ирэх нас сүүлийн хэдэн арван жилд ойролцоогоор 2 жилээр урагшилсан байна.

2000 оноос хойш төрсөн охидын анхны сарын тэмдэгийн судалгаа байгаагүй тул 2000 оноос хойш төрсөн охидоос судалгаа авсан бөгөөд ихэвчлэн 12-13 насанд ирэх хандлага ажиглагдаж байсан. 1950-аад онд монгол охидын сарын тэмдэг анх ирэх нас 15 нас орчим байсан бол 1980 он гэхэд энэ нас дунджаар 14 нас, 1990-ээд он гэхэд 13 нас хүртэл буурсан байна. Зарим бүс нутгийн судалгаагаар хотын охидын дундаж нас 12.8 болсон нь дэлхийн дундажтай

(12.5–13.0) бараг адилхан түвшинд хүрч байгааг харуулж байна. Энэ нь Монгол дахь охидын сарын тэмдэг анх ирэх нас сүүлийн 50–60 жилийн хугацаанд 2–3 жилээр урагшилсан болохыг тодорхой харуулж байна.



Дүрслэл 3. Монгол охидын менархе насны өөрчлөлт

Монголд сарын тэмдгийн чиг хандлагын судалгаа сүүлийн үеүдэд хийсэн судалгаа хязгаарлагдмал байна. Гэсэн хэдий ч Төв Азийн ижил төстэй популяциас хийсэн судалгаагаар хоол тэжээлийн шилжилт, хотжилт нь сарын тэмдгийн нас буурахад нөлөөлж байгааг харуулж байна.

Нийгэм дэх охидын сарын тэмдгийн тухай ойлголтууд

Менархе буюу охидын биеийн юм анх ирэх нь зөвхөн биологийн үйл явц биш бөгөөд тухайн нийгэм, соёлын хэв маяг, зан үйл, итгэл үнэмшилтэй салшгүй холбоотой байдаг. Дэлхийн олон улс оронд менархегийн насны хэлбэлзэл нь зөвхөн хоол тэжээл, эрүүл мэнд, амьдралын хэв маягтай төдийгүй тухайн нийгмийн ойлголт, ёс заншил, итгэл үнэмшлээр тодорхойлогддог. Тухайлбал, Энэтхэгийн өмнөд хэсгийн Тамил Наду мужид охины биеийн юм анх ирэхэд “Ritu Kala Samskara” хэмээх ёслолын арга хэмжээ зохион байгуулж, түүнийг эмэгтэй хүн болж нас биед хүрснийг баяр хөөртэйгөөр тэмдэглэдэг. Харин зарим орны уламжлалт нийгэмд, тухайлбал Непалд, чхаупади нэртэй зан үйлээр охидыг менархе ирэхэд сүм хийд, гэр бүлийн орчноос тусгаарлаж, ариун бус хэмээн үздэг байна. Үүнтэй адил, уламжлалт шашны нөлөө бүхий орнуудад менархетэй холбоотой хорио цээр, бэлгийн боловсролын дутагдал зэргээр илэрдэг сөрөг ойлголт элбэг байдаг. Мөн Англосаксчууд сарын

тэмдгийг the curse буюу “хараал” гэж нэрлэдэг ба сарын тэмдгийн мөчлөг үнэндээ ямар ч индивидуаль зорилгогүй байдаг. Аристотелийн үед хэрэв үр тогтсон бол хүүхдийн мах цусыг бүрдүүлэх байсан цус сар бүр гадагшилдаг гэж үздэг байжээ(Бовуар, 2010).

Өмнө нь менархи нас нь охин хүүхэд гэх шатнаас эмэгтэй хүн болж буй өсвөр насны эхлэл гэж тооцогддог байсан бол өнөө үед тус шилжилтийн үе шатыг охид нухацтайгаар хүлээн авч мэдрэхгүй байгаа ажиглагдсан. Arnold van Gennep-ийн The Rites of Passage (1909) хэмээх сонгодог антропологийн бүтээл нь хүний амьдралын үе шатны шилжилт (төрөх, нас бие гүйцэх, гэрлэх, үхэх гэх мэт)-ийг янз бүрийн соёлд хэрхэн ёслол, зан үйлийн хэлбэрээр тэмдэглэдэгийг судалсан ба охидын анхны сарын тэмдэг буюу менархе (menarche) -г амьдралын чухал “шилжилтийн үе” буюу rites of passage-ийн нэг хэлбэр гэж үздэг. Тэрээр янз бүрийн соёлд охины анхны сарын тэмдгийг нийтээр тэмдэглэх, тусгаарлах (isolation), цэвэршүүлэх (purification) зэрэг зан үйлийн хамт хүлээн авдаг болохыг дурдсан байдаг.

Монгол охидын дунд сүүлийн 70 жилийн хугацаанд сарын тэмдэг анх ирэх нас бараг 3 жилээр эртшсэн үзүүлэлт нь үүний тод жишээ юм. Энэ нь хоол тэжээл, хотжилт, боловсрол зэрэг нийгэм-биологийн хүчин зүйлсийн өөрчлөлтийн нөлөөг харуулж байна. Орчин үед менархегийн нас хурдацтайгаар эртшиж байгаа бөгөөд энэ нь охид биологийн хувьд үр тогтоох чадвартай болж байгааг илтгэж байгаа хэдий ч нийгмийн хувьд хараахан бэлэн биш байна. Мөн судалгаанд оролцсон охидын ихэнхи нь анх сарын тэмдэг ирэх үед бэлтгэлгүй байсан ба сарын тэмдэг ямар учраас ирдэг талаар мэдлэг тутмаг байсан. Оролцон ажиглалт болон ярилцлагын явцад нас насны эмэгтэйчүүдээс ярилцлага авах явцад анхны сарын тэмдэг нас хожуу байх тусам тухайн эмэгтэй илүү бэлтгэлтэй, мөн “том хүн болсон”, “эмэгтэй хүн болсон” мэт мэдрэмж илүү авч байсан талаар дурдав.

“Анх миний сарын тэмдэг 15 нас нээх удахгүй ирсэн тэгэхэд нэг л том хүн болсон юм шиг мэдрэмж төрж байсан, давуугаа аваад л кармандаа нуугаад л найзуудаараа нойл орохоор нэг тийм эмэгтэй хүн болчихсон ч юм шиг”...

45 настай эмэгтэйн ярилцлагын хэсгээс

...“Миний биений юм бас эрт ирж байсан санагдаж байна 5 дугаар ангид байхад, би өөрөө мэдэхгүй гэнэт цус гараад, анх хараад аймар айгаад эгчдээ хэлсэн чинь манай эгч нойлоос гараад Э эмэгтэй хүн болчихсон байна гээд орилож байсан”...

23 настай эмэгтэйн ярилцлагын хэсгээс

“Сонин мэдрэмж байсан, би уг нь ер нь болмооргүй л байсан л даа, тухгүй санагдсан, одоо л дасаж эхлэж байна, анх ирэхээс нь өмнө сарын тэмдэг гэж эмэгтэй хүн болгон сар бүр цус гардаг юм байна гэдгийг мэдэж байсан”...

12 настай охины ярилцлагын хэсгээс

10-45 насны эмэгтэйчүүдээс менархи насны талаар ярилцлага хийж байх явцад анх сарын тэмдэг ирж байх үе таагүй тухгүй, хэцүү санагдаж байсан тухайгаа хуваалцсан ба эхэн үедээ тодорхой хэмжээнд тух алдагдуулдаг хэмээн хэлж байсан. Асуулгын үр дүнд анхны сарын тэмдэг нь эрт ирсэн охид сарын тэмдэгтэй сөрөг сэтгэгдэлтэй, орой ирсэн охид эрт ирсэн охидоос илүү бага таагүй мэдрэмж авч буй хандлага ажиглагдсан.

...“Охидын сарын тэмдэг, ариун цэврийн хэрэглэлийн тухай ойлголт сайн байгаа хэдий ч сарын тэмдгийн тухай ярих болоход хажууд нь хүн байвал бүгд харцаа буруулан, шивнэж ярьж байсан. Хөвгүүд нь охидуудтай нь тусгайлан уулзаж байх үед орж ирээд сарын тэмдгийн тухай ярилцаж байгааг мэдээд бүгд нүдээ томруулаах, жуумалзаад ангиас гарж байв. Сарын тэмдэг ирснээр нөхөн үржихүйн насанд хүрсэн гэдгээ тэр бүр ухамсарлахгүй байгаа бололтой, сарын тэмдэгийг эмэгтэй хүнд сар болгон тохиолддог цус гардаг л зүйл гэж бодох хандлага их байна.”...

(2025.4.15 хээрийн тэмдэглэлийн хэсгээс)

Орчин цагт менархегийн нас эртшиж буй нь нийгмийн олон асуудлыг давхар хөндөж байна. Тухайлбал, сэтгэл зүйн хувьд бэлтгэлгүй охид өөрсдийгөө “насанд хүрсэн мэт” мэдрэх боловч бодит байдал дээр хүүхдийн орчинд, хүүхдийн эрх зүйн хүрээнд амьдарсаар байна. Иймд анхны сарын тэмдэг ирэх насны өөрчлөлт нь зөвхөн тоон үзүүлэлт биш, харин охидын амьдралын чанар, эрх, боловсрол, эрүүл мэнд, бие даах чадварт нөлөөлөх өргөн цар хүрээтэй үзэгдэл гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монгол охидын сарын тэмдэг анх ирэх насны хэлбэлзэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг биологийн болон нийгэм-соёлын хүрээнээс авч үзлээ. Судалгаанд оролцсон 112 охидын дундаж анхны сарын тэмдэг ирэх нас 12.4 байна. Үүнийг 1961 оны судалгаатай (Чүлтэмдорж, 1961) дундажтай харьцуулахад ойролцоогоор 3 жилээр урагшилсан байна. Үүнд хотжилт, амьдралын хэв маягийн өөрчлөлт, хоол тэжээлийн бүтэц, нийгэм-эдийн засгийн өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байж болно.

30-аад жилийн өмнө сарын тэмдэг анх ирэх үед хувь хүнд өөр үе шатад очиж буй мэт мэдрэмж илүү төрдөг байсан бол өнөө үед сарын тэмдэг ирэх нас урагшилсантай холбоотойгоор энэхүү мэдрэмж нь бага болж байна. Магадгүй энэ нь сарын тэмдэг ирэх нас урагшласантай холбоотой ч байж болно.

Охидод анхны сарын тэмдэг ирэх нь биологийн хувьд нөхөн үржихүйн чадвартай болж нас бие гүйцэж байгааг илтгэх хэдий ч нийгмийн хувьд бэлэн бус сарын тэмдэг эрт ирж буй охид нөхөн үржихүйн боломжтой болсон гэх ойлголтыг авахгүй байгаа хандлагатай байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх материал

- Ганболд, С. (1999). Монголын хүн ам дахь генетик процессийн онцлог, Биологийн докторын зэрэг горилсон бүтээл
- Эрдэнэ, М. (1998). Монголын байгаль газар зүйн янз бүрийн бүсийн хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн онцлог, Биологийн докторын зэрэг горилсон бүтээл

Гадаад хэлээрх материал

- Bayanjargal, O., Namsrai, Z., & Sievert, L. L. (2022). The menopausal transition in Mongolia. *Menopause*, 29(1), 96–100. <https://doi.org/10.1097/GME.0000000000001877>
- Christian, P., Shaikh, S., Shamim, A. A., Mehra, S., Wu, L., Mitra, M., Ali, H., Merrill, R. D., Labrique, A. B., & West, K. P. (2022). Influence of vitamin D supplementation on growth, body composition, and pubertal development among school-aged children in an area with a high prevalence of vitamin D deficiency: A randomized clinical trial. *JAMA Pediatrics*, 176(12), e223123. <https://doi.org/10.1001/jamapediatrics.2022.3123>
- Cooper, C., Kuh, D., Egger, P., Wadsworth, M., & Barker, D. (1996). Childhood growth and age at menarche. *BJOG: An International Journal of Obstetrics & Gynaecology*, 103(8), 814–817. <https://doi.org/10.1111/j.1471-0528.1996.tb09879.x>
- Kozieł, S., & Jankowska, E. A. (2012). Association of early menarche age and overweight/obesity. *Journal of Pediatric Endocrinology and Metabolism*, 25(1–2), 57–62. <https://doi.org/10.1515/jpem-2011-0277>
- Li, X., Zhang, Y., & Liu, Y. (2024). The relationship between age at menarche and metabolic syndrome in Chinese women. *Chinese Journal of School Health*, 45(1), 45–48. <https://doi.org/10.16835/j.cnki.1000-9817.2024137>

- Sievert, L. L., Obermeyer, C. M., & Saliba, M. (2013). Symptom clusters at midlife: A four-country comparison of checklist and qualitative responses. *International Health*, 5(4), 244–252. <https://doi.org/10.1093/inthealth/ihl026>
- Sioka, C., Fotopoulos, A., Georgiou, A., Xourgia, X., Papadopoulos, A., & Kalef-Ezra, J. A. (2010). Age at menarche, age at menopause and duration of fertility as risk factors for osteoporosis. *Climacteric*, 13(1), 63–71. <https://doi.org/10.3109/13697130903075337>
- van Noord, P. A. H., Kaaks, R., van der Schouw, Y. T., & Peeters, P. H. M. (1990). Age at menarche, age at menopause, height and obesity as risk factors for breast cancer: A prospective study. *International Journal of Cancer*, 46(5), 817–820. <https://doi.org/10.1002/ijc.2910460508>
- Wang, Y., Wang, H., & Wang, X. (2015). Association between age at menarche and risk of metabolic syndrome in Chinese women. *European Journal of Clinical Nutrition*, 69(5), 564–568. <https://doi.org/10.1038/ejcn.2014.265>
- Wang, Y., Wang, H., & Wang, X. (2017). Association between age at menarche and risk of metabolic syndrome in Chinese women. *International Journal of Women's Health*, 9, 1–8. <https://doi.org/10.2147/IJWH.S131701>
- Wilson, D. C., & Sutherland, I. (1949). The age of the menarche. *British Medical Journal*, 2(4619), 130–132. <https://doi.org/10.1136/bmj.2.4619.130>
- Yanjmaa, E., Ogawa, S., Tsogbadrakh, B., Khurelbaatar, T., Khuyagbaatar, E., Nasanjargal, T., Hayashi, K., Takeda, T., Oidov, B., & Shinozaki, H. (2022). Prevalence of premenstrual syndrome and premenstrual dysphoric disorder among Mongolian college students. *Kita Kanto Medical Journal*, 72(1), 43–48. <https://doi.org/10.2974/kmj.72.43>
- Yermachenko, A., & Dvornyk, V. (2014). Nongenetic determinants of age at menarche: A systematic review. *BioMed Research International*, 2014, Article 371583. <https://doi.org/10.1155/2014/371583>
- Zhang, Y., Li, Y., & Wang, X. (2014). Association between age at menarche and risk of metabolic syndrome in Chinese women. *Chinese Journal of Public Health*, 30(10), 1234–1237.
- Savinetsky, A. B., & Kiseleva, N. K. (2021). Paleopathological analysis of human remains from the Neolithic site of Ust-Kyakhta-3 (Transbaikalia). *Archaeology, Ethnology & Anthropology of Eurasia*, 49(1), 89–97. <https://doi.org/10.17746/1563-0110.2021.49.1.089-097>

ХАВСРАЛТ 1

Асуулга

Хүн ам зүйн мэдээлэл

1. Нас: _____

Үндэс угсаа:

Оршин суугаа хаяг: _____

Сарын тэмдэг анх ирэх үед оршин сууж байсан газар:

- ☐ Хот
- ☐ Хөдөө
- ☐ Ямар аймаг.....

Боловсролын байдал:

- ☐ Бага
- ☐ дунд
- ☐ Ахлах
- ☐ Баклавр
- ☐ Мастер
- ☐ Доктор

Өрхийн дундаж орлого

- ☐ 500,000 доош
- ☐ 500,000-1,500,000
- ☐ 1,500,000-2,500,000
- ☐ 2,500,000-3,500,000
- ☐ 3,500,000-с дээш

Таны ажил ямар хөдөлмөрийн онцлогтой вэ?

- ☐ Ихэвчлэн суугаа ажил (өдөрт 6 хүртэлх цаг суудаг)
- ☐ Хөдөлгөөнтэй ажил (өдөрт 6 хүртэлх цаг зогсоо ажил хийдэг бол)
- ☐ Хосолсон ажил (өдөрт 3-4 цаг суугаа, 4-5 цаг зогсоо ажил хийдэг бол)
- ☐ Сурагч
- ☐ Оюутан

2-р хэсэг: Сарын тэмдгийн хугацаа ба биологийн хүчин зүйлс

Таны анхны сарын тэмдэг хэдэн настайд тань ирж байсан бэ?

.....

Таны гэр бүлийн эмэгтэйчүүдэд анхны сарын тэмдэг эрт эсвэл орой анхны сарын тэмдэг ирж байсан тохиолдол байгаа юу?

- ☐ Тийм, сарын тэмдэг эрт ирж байсан
- ☐ Тийм, сарын тэмдэг хожуу
- ☐ Онцлох зүйл байхгүй
- ☐ Мэдэхгүй байна

Таны гэр бүлд хэдэн эмэгтэй хүн амьдардаг вэ? (таныг оролцуулахгүйгээр)

.....

Анхны сарын тэмдэг ирэх үед таны жин, өндөр ойролцоогоор хэд байсан бэ?

Жин: _____ кг

Өндөр: _____ см

Таны анхны сарын тэмдэг ирэхээс өмнө эрүүл мэндийн ямар нэгэн ноцтой нөхцөл байдал үүссэн үү?

- ☐ Тийм : _____
- ☐ Үгүй

Таны анхны сарын тэмдэг ирсэн үед энгийн үеийнхээсээ өөр хоолны зуршилтай болж байсан уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Одоо сарын тэмдэг ирсэн үед энгийн үеийнхээсээ өөр хоолны зуршилтай болдог уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Анх сарын тэмдэг ирж байх үед таны сэтгэл зүйд ямар нэгэн өөр зүйл мэдрэгдсэн үү?

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Анх сарын тэмдэг ирэх үед өвдөлт байсах эсэх

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Одоо сарын тэмдэг ирэхэд өвддөг эсэх

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Сарын тэмдэг ирэх өвдөлтөд өвчин намдаах эм уудаг эсэх

- ☐ Тийм
- ☐ Үгүй

3-р хэсэг: Нийгэм-соёл, хүрээлэн буй орчны нөлөөлөл

Анхны сарын тэмдэг ирэхээс өмнө та ямар хоолны дэглэмтэй байсан бэ?

- ☐ Уламжлалт гэрийн хоол
- ☐ Боловсруулсан/түргэн хоол-хүнд хоолны дэглэм
- ☐ Аль аль нь

Та сарын тэмдэг ирэхээс өмнө хүрээлэн буй орчны томоохон стресст өртсөн үү (гэр бүлийн асуудал, шилжилт хөдөлгөөн, эдийн засгийн хүндрэл гэх мэт)?

- ☐ Тийм: _____
- ☐ Үгүй

Таны эргэн тойронд сарын тэмдгийн талаар ямар нэгэн тодорхой уламжлал, хориотой зүйл байсан уу?

- ☐ Тийм : _____
- ☐ Үгүй

Эхний сарын тэмдэг ирэхдээ хэр бэлтгэлтэй байсан бэ?

- ☐ Маш сайн бэлдсэн
- ☐ Бага зэрэг бэлдсэн
- ☐ Огт бэлтгэлгүй

Сарын тэмдгийн талаарх мэдээллийг хэн өгсөн бэ?

- ☐ Гэр бүлийн эмэгтэй гишүүнээс
- ☐ Гэр бүлийн эрэгтэй гишүүнээс

- ☐ Найзууд
- ☐ Сургууль/багш нар
- ☐ Ном/Интернет
- ☐ Хэн ч биш

4-р хэсэг: Сарын тэмдгийн үеийн сэтгэл зүй, нийгэмээс үзүүлэх нөлөө

Анх сарын тэмдэг ирэхэд ямар мэдрэмж төрж байсан бэ?

- ☐ Сэтгэл хөдөлсөн
- ☐ Хайхрамжгүй
- ☐ Ичиж байна
- ☐ Айсан
- ☐ Бусад (тодорхойлно уу): _____

Та сарын тэмдэгтэй холбоотой ямар нэгэн байдлаар шоолуулж, гутаан доромжлуулж байсан уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй

Сарын тэмдэг таны нийгмийн амьдрал эсвэл сургуулийн туршлагад хэрхэн нөлөөлсөн бэ?

- ☐ Ямар ч нөлөө үзүүлэхгүй
- ☐ Зарим нөлөө (жишээ нь: тав тухгүй байдал, сургуулиа орхих, дооглох)
- ☐ Их хэмжээний нөлөөлөл (тусгаарлах, дээрэлхэх, нөөцийн хомсдол гэх мэт)

Сарын тэмдэг ирэх нь таны өөрийгөө үнэлэх үнэлэмж, биеийн дүр төрхөд тодорхой хугацаанд нөлөөлсөн гэж та бодож байна уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Сайн мэдэхгүй байна

Асуулга авсан google form link: <https://forms.gle/Jyxzz6Bhu7EGSNds8>

ХАВСРАЛТ 2

Судлагдсан байдалын тоймлол хийсэн хүснэгт:

<https://docs.google.com/spreadsheets/d/16zkVHDRi9yjZvmf7w6dj5TrVHwukRcDlByKLMc34AQg/edit?usp=sharing>



МОНГОЛЫН МАЛЧДЫН МАХНЫ ХУДАЛДАА ДАХЬ ЁС СУРТАХУУНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ОЙЛГОЛТ

Цацралмаагийн МӨНХЗАЯА

МУИС. Антропологи хөтөлбөрийн IV түвшиний оюутан

Удирдагч багш: И. Бямбабаатар (PhD)

МУИС. Монгол судлалын хүрээлэн

СЭДВИЙН ҮНДЭСЛЭЛ

Манай улсад хотын оршин суугчид болон махны худалдаа эрхлэгчдийн хооронд махны үнэ ханш их байгаа талаар маргаан байнга үүсдэг. Махны нэмүү өртгийн сүлжээг багасгаж, үнийг тогтворжуулах зорилгоор төсвийн мөнгөөр нөөцийн мах авч зардаг ч төдийлөн махны үнэ буурдаггүй. Тухайлбал, 60 сая гаруй толгой малтай Монгол улс яагаад ердөө 3.5-хан сая иргэнээ тогтвортой, хямд үнэтэй махаар хангаж чадахгүй байна вэ? гэсэн асуулт олон нийтийн дунд байнга яригдаж, малчдыг махны үнээ нэмэгдүүлж байна гэж буруутгадаг. Гэвч малчид ихэнхдээ малаа дундын зуучлагчид (middleman) буюу ченжүүдэд хямд үнээр зарах эсвэл мах худалдан авч буй мал нядалгааны цехүүдэд худалдах сонголт хийдэг. Харин ямар ч тохиолдолд малчид ченжүүдэд малаа хямд үнээр өгөх нь ашиггүй бөгөөд эдүгээ малчин бүр суудлын болон Солонгосын Портер зэрэг ачааны машинтай болсон энэ үед яагаад малаа хот руу оруулж ирж зарахгүй, өөрсдийн дургүй мал нядалгааны газар өгөх болов гэдэг анхаарал татаж байна. Тиймээс малчид мал зарах, мах нийлүүлэх сонголтын цаана өөр ямар шалтгаан байгаа талаар нийгэм, соёлын антропологийн үүднээс этнографын судалгаа хийх шаардлагатай гэж үзэв.

Монголын нийгэмд 1990 оноос хойш өрнөсөн улс төр, эдийн засгийн тогтолцооны шилжилтийн үр дүнд зах зээл, чөлөөт худалдааны зарчим бий болж хувьчлалын үр дүнд малчид нэгдлээс үл хамаарах бие даасан шийдвэр гаргах болсон. Нэгдлийн үйл ажиллагаа татан буугдсанаас хойш махны борлуултыг таслахгүйн тулд “ченжүүд” бий болсон. Ингэснээр нэгдлийн гүйцэтгэдэг байсан тээвэрлэлтийг тэдгээр хүмүүс гүйцэтгэх болжээ. Үүний улмаас олон

нийтийн дунд малчдыг илүүтэй худалдаанд оролцож ашигт байдлыг тооцох, орлогоо нэмэгдүүлэх оролдлого хийдэг гэж бодох хандлага бий болсон байдаг. Тиймээс энэхүү судалгаагаараа зах зээлийн харилцаанд дарагдаж үлдсэн ёс суртахууны асуудлыг хөндөхийг хичээлээ. Үүний тулд 1) малчдын хувьд уламжлалт маллагаа, мал гаргах аргыг тодруулах, 2) малыг олноор нь нядалдаг малын бойг малчид хэрхэн тодорхойлж байгаа, 3) малчидын шийдвэр гаргалтад нөлөөлж буй нийгмийн болон зах зээлийн хүчин зүйлс 4) малчид малаа бойнд өгсөнөөрөө өөрсдийн хувьд үнэт зүйлээ хэрхэн хамгаалахыг оролдож байгаа талаар тодруулах зорилтыг дэвшүүлсэн. Ингэснээр ёс суртахууны эдийн засгийн ойлголтоор малчид зөвхөн материаллаг ашиг сонирхол бус орон нутгийн мэдлэг, нийгмийн сүлжээн дэх итгэлцлийг авч үлдэхийг зорьж байна гэж үзэж болох юм.

Судлагдсан байдал

Эдгээр дэвшүүлж буй санааг ёс суртахууны эдийн засаг хэмээх онолын дагуу авч үзсэн билээ. Энэ нь зах зээлийн харилцаа, эдийн засгийн тогтолцоонд хүмүүс ёс суртахуун, шударга ёсны ойлголт, хүлээлтээрээ ёс зүйн хүрээнд эдийн засгийг явуулдаг тогтолцоо юм (Thompson; 1971). Энэ нь олон нийтийн амь зуулгыг ашиг олох, орлогоо нэмэгдүүлэхэд ашиглахын эсрэг бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа зөвхөн ашгийн төлөө байх албагүй, харин тухайн нийгмийн дотор нийтээрээ амьжиргаагаа хангах боломжийг эвдэхгүй байх, шударга ёсны талаарх нийтлэг ойлголт, хэвшиж тогтсон зан заншлаа дагах зэрэг дээр тулгуурлах ёстой гэсэн санааг гаргасан онол юм. Харин Скотт (1977) ёс суртахууны эдийн засаг гэдгийг шударга байдлын тэнцвэр алдагдахад, амьжиргаагаа хамгаалахын тулд хүмүүс ашигтай сонголтын эсрэг шийдвэр гаргах хандлага хэмээн тодорхойлжээ. Тэрээр судалгаагаа тариачдын дунд хийж, тэд хүн бүрийн амьжиргааг хүндэтгэх, баячуудын туслалцаа, хоорондын хамтын ажиллагаа зэрэг нь эдийн засгийн тогтолцооны үндэс байв. Гэвч колоничлолын дараа энэ уламжлалт тогтолцоо задран, ашиг хөөсөн зах зээлийн хандлага давамгайлснаар нийтээрээ амьжиргаагаа залгуулах баталгаа алдагдаж, ёс суртахууны төлөө хийдэг байсан үйлдлүүд байхгүй болсон тул үүнийг тариачид эсэргүүцэж бослого гаргасан тухай тайлбарладаг.

Түүнчлэн ёс суртахууны эдийн засгийг зөвхөн “уламжлалт” хэмээн тодорхойлохоос гадна янз бүрийн нөхцөл, орчин үеийн нийгэмд хамрах түгээмэл ойлголт гэж үзэх нь зүйтэй хэмээн Гётц (2015) дурьдсан. Түүний дэвшүүлж буй шинэ санаа нь орчин үеийн нийгэмд ёс суртахууны эдийн засаг нь эдийн засгийн нэгэн сонголт болсон ажээ. Энэ нь ёс суртахууны эдийн засгийг тайлбарлахдаа заавал бослого тэмцэл, хоёр талын зөрчил мэтээр

харуулах албагүй юм. Вейгратц нар (2016) неолиберал бодлого давамгайлсан Зүүн Африкт хувь хүмүүс амьжиргаагаа залгуулахын тулд нийгмийн эв нэгдэл, хамтын үнэ цэнээс илүүтэй ашиг сонирхлыг урьтал болгох болсон хандлагыг шүүмжилсэн. Тэд “мөнгөний ёс суртахууны эдийн засгийн хүч” (the moral economic power of money) хэмээх ойлголтоор дамжуулан ашгийн сэдэл уламжлалт ёс суртахууны үзэл баримтлалыг дарангуйлж, өрсөлдөөн, хомсдолд тулгуурласан амьдрах стратеги давамгайлж байгааг хэлэлцсэн. Ийнхүү ёс суртахууны эдийн засаг хэмээх ойлголт амьжиргаа, хоол хүнс, уламжлал ба зах зээл хоорондын зөрчил зэргээр тайлбарлагдаж иржээ.

Тэгвэл антропологийн бүтээлүүдэд мах болон мал нядалгааны талаар судалгаанууд цөөнгүй хэвлэгдсэн. Монголын нөхцөлд мах нь зөвхөн хүнсний хэрэгцээ бус, харилцаа, ураг төрлийн холбоо, нутгийн мэдрэмжтэй салшгүй холбоотой. Фокс (2021) махыг ураг төрлийн холбоог хадгалагч, орон нутгийн мэдрэмжийг сэргээх хэрэгсэл хэмээн тайлбарлажээ. Хөдөөнөөс мах, идэш авснаар хотын хүмүүс ураг төрлөө санагалзах, нутгаасаа холбоо тасраагүй мэдрэмжийг авч байхад, эсрэгээрээ идэшгүй байгаа нь холбоо тасарсныг илэрхийлж байдаг аж.

Зөвхөн махнаас гадна нядалгааны тал дээр судлаачид, хэрэглэгчид маш олон шүүмж өгдөг бөгөөд нядалгаа буюу бой нь амьтныг ёс суртахуунгүй нядалдаг, харгис хэмээн үздэг. Үүнээс улбаалан “аз жаргалтай мах” ойлголтоор дамжуулан амьтныг эрх чөлөөтэй, байгалийн орчинд өсгөж, стрессгүйгээр нядлах нь хэрэглэгчдийг ёс зүйтэй сонголт хийж байгаа мэт итгүүлж байгаа. Гэсэн хэдий ч энэ нь ёс суртахууны үзэл баримтлалын нэр дор ашиг хонжоо хайсан маркетинг болж хувирч байгааг шүүмжилжээ (Cole; 2011). Үүнтэй ижил санааг Рийд (2014) ч мөн онцолсон бөгөөд орчин үеийн махны үйлдвэрлэл нь нядалгааг хувь хүний ёс суртахууны хариуцлагаас салгаж, механик үйл явц болгон хувиргаж, амьтны амийг бараа бүтээгдэхүүн болгож үнэгүйдүүлж байгааг шүүмжилжээ. Смит (2002) мал нядлах автомат төхөөрөмжүүдийг хэрэглэж байгааг амьтныг хурдан, хүндрэл багатай хөнөөдөг гэдэг үүднээс “хүмүүнлэг” арга хэмээн мах нийлүүлэгчид үздэг. Гэвч энэ нь хүмүүсийг амьтны үхэл, зовлонгоос холдуулж, зөвхөн “мах”, “гахайн мах” гэх мэт нэршлээр төлөөлүүлэн, амьд амьтан байсан гэдгийг мартаж байна гэжээ.

Эдгээрээс харахад ихэнх судалгаанууд нядалгаа буюу бойны үйл ажиллагааг ёс суртахуунгүй, харгис үйлдэл хэмээн шүүмжилж байна. Харин энэхүү судалгаанд монголын бойны газруудын мал нядлах арга техникийг малчид харгис арга хэмээн тодорхойлж байгаа хэрнээ бой нь ёс суртахууны эдийн засгийг авч үлдэх нэгэн арга болоод буй юм. Тухайлбал бойгоор малаа

нядлуулах нь малчинг тэрхүү нядалгаанд оролцуулахгүй байгаагийн хувьд уламжлалт үнэт зүйлээ хадгалах хэрэгсэл болон хувирч байгааг тодруулснаараа шинэлэг билээ. Өөрөөр хэлбэл, малчид малаа өөрсдөө төхөөрч, зах зээлд шууд хүргэх замаар илүү ашиг олох боломжтой байсан ч бой, ченжид малаа өгөхийг илүүд үзэж байгаа нь ёс суртахууны эдийн засгийн хүрээнд ашигтай байх, орлогоо нэмэгдүүлэх үйлдлийг зориуд үл тоомсорлосон сонголт юм.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө бид судалгааны сэдвээ тодорхойлон сонгож, хээрийн ажлын зорилго, аргачлалаа төлөвлөн, ярилцлагын асуултуудыг боловсруулсан. Мөн судалгаа хийхээр төлөвлөсөн аймаг, сумдын тухай ерөнхий мэдээлэл, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, мал аж ахуйн бүтэц, зан үйлтэй холбогдох суурь судалгаануудыг урьдчилан судалж, бэлтгэл ажлаа хангаж ажилласан. Хээрийн судалгааг Хэнтий болон Дорнод аймагт хийсэн бөгөөд уг ажлын хүрээнд бид малчин айлууд, сумын иргэдтэй гүнзгийрүүлсэн чанарын ярилцлагуудыг хийж, мөн оролцон ажиглалтын аргаар мэдээлэл цуглуулсан. Оролцон ажиглалтын хувьд малчдын гэрт амьдарч, ахуйн ажилд нь туслан, тэдний өдөр тутмын амьдралын хэв маягтай танилцаж ажиглалт хийсэн. Түүнчлэн өөрийн судалгааны сэдвийн хүрээнд мал зарах үйл явцад биечлэн оролцож, аймаг, сумын нядалгааны цэгүүдээр очиж ченжүүд болон бойны ажилчидтай ярилцлага хийж, амьдарч буй айлынхаа махыг хамт зарах зэргээр судалгааг өргөн хүрээнд гүйцэтгэв. Хээрийн ажлын дараа цуглуулсан чанарын өгөгдлүүдийг боловсруулан, ярилцлагын аудио бичлэгүүдийг бүрэн шивж, хээрийн тэмдэглэлүүдийг нэгтгэсэн. Үүний дараа бүх мэдээллийг дэдүүс (dedoose) программ ашиглан кодчилж, ангилан ялган, агуулгын шинжилгээ хийж, судалгааны арга зүйг гүнзгийрүүлэн боловсруулав.

Махны худалдаа

Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний экспорт нь уул уурхай, ноолуурын дараа орох экспортын гол нэрийн бүтээгдэхүүн бөгөөд “2023 онд 80.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортод гаргасан. 2024 онд 71.1 мянган тонн, 2025 он гарсаар 9.0 тонн мах, махан бүтээгдэхүүнийг тус тус экспортлоод байна. Жилдээ 300 орчим сая ам.долларын экспортын арилжааг махнаас хийгдсэн” (ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д. Довчинсүрэн)¹. Үүнээс харахад мах махан бүтээгдэхүүний экспорт ДНБ-ны 2%-ийг эзэлж байна. Ийнхүү мах, махан бүтээгдэхүүнийг

¹ newszindaa.mn-сайтаас татаж авав.

гадаадад экспортлохоос гадна улсын хэмжээнд махаар хангаж буй юм. Үүний цаана малчдын малд зориулж буй хөдөлмөр, зохион байгуулалт байгаа бөгөөд малчдын орлогын эх үүсвэр, гол хөрөнгө нь тэдний мал. Санхүүгийн хэрэгцээ гарсан үед малаасаа зараад асуудал нь шийдэгдэнэ.

Малчдын хувьд малаа мах болгон зарах хэд хэдэн арга буй. Тухайлбал хамгийн ашигтай арга нь малаа Улаанбаатар хотод авчирч дундын зуучлагч, ченжүүдээр дамжуулалгүй борлуулах юм. Энэ нь зардал, хүн хүч, цаг зав, мал эмнэлэгийн бичиг зэрэг олон зүйл шаарддаг. Ихэнх малчдад энэ арга явдал чирэгдэл ихтэй ч зарим малчид илүү их ашгийн төлөө илүү хөдөлмөр гаргаж энэ аргаар малаа худалддаг. Үүнтэй адилаар хамаатан садан, танилаараа дамжуулах, нийгмийн сүлжээгээр (фейсбүүк) зар тавих зэргээр цөөн хэдэн махыг зарах тохиолдол байна. Харин зарим нутагт маш олон малтай зах зээлжсэн малчид байх бөгөөд тэд махны үйлдвэрүүдтэй гэрээ хийдэг. Дорнод аймаг хээрийн судалгаанд 10,000 малтай малчин байсан бөгөөд 1990 оноос хувьчлал гарснаас хойш ийнхүү үйлдвэртэй хамтарч бизнес хийж эхэлжээ. Сүүлийн арга бол хамгийн хямд үнээр ченжид өгөх, эсвэл өөрт ойр бойнд өгөх. Бойнд өгнө нь гэдэг нь мөн ченжид борлуулж буй гэсэн үг бөгөөд ченж нар бойг ажиллуулж буй юм.

Миний хээрийн судалгаа хийсэн аймгийн нэг болох Хэнтий аймгийн малчид аймгийн ченж нарын бойнд малаа өгөөд, тэд хүчит шонхор зах дээр хотын ченж нарт зарж, цаашаа бөөний махны дэлгүүрт очиж, хүнсний захууд тэднээс авч эцэст иргэд түүнээс хүнсний хэрэглээндээ мах худалдан авна. Ийнхүү үе шат бүрд 200-2000 төгрөгийг килограмм бүрд нэмж зардаг байна. Харин сум, баг бүрд бусад малчдаасаа хавь илүү олон малтай малчид байх бөгөөд тэдний мах дээрх шиг олон дамжлага давалгүй шууд үйлдвэрүүдэд махаа худалддаг. Энэ нь нөөцийн мах, үйлдвэрүүдийн мах болон хувирдаг.

Тэгвэл малчдын хамгийн их үйлчлүүлдэг бойны газар яаж явагддагийг хуваалцвал, олон ченж нар нийлж нэг бой ажиллуулж малчин аль ченжид өгөхөө шийддэг, эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай бойны газар байх бөгөөд тэнд махыг гадаад руу экспортлоход бэлэн болтол нь хэд хэдэн шат дамжлагат ажиллах хүчтэй байдаг. Хүйтний улиралд цаг агаараас шалтгаалан бой ажиллахгүй ч малчдын хотонд очиж, захиалгаар бой хийж өгдөг. Би очсон бойнууд дээрээс бог малыг төхөөрөх гурван аргыг харсан ба хоньны толгой дээр сүхээр цохих, хоолойг нь хэрчих, ямааны толгойн орой дээр хайч зоох гэх мэт. Амьдарч байсан айлын маань эгчийн хэлснээр тогонд цохиулах, бог малыг амьдаар нь гуяыг нь цоолж дэгээнд гүйлгэдэг зэрэг сонсохоос эвгүйцэм аргуудыг бойны газар ашигладаг ажээ. Харин нөгөө талаас малчид бойнд дээр

малыг төхөөрч буй арга технологит дургүй, шүүмжлэлтэй ханддаг хэдий ч тэдний ажлыг хөнгөвчилж байгаа, махны хөргүүртэй тул эрүүл ахуйн шаарлага хангаж байгаа зэрэг эерэг талуудтай. Тэгвэл бойнд малаа өгч уламжлалт бус, харгис технологиор малаа нядлуулж байгаагийн хувьд малчид харин ч ёс суртахуунгүй юм биш үү? хэмээх асуулт бидэнд гарч байна. Дараагийн хэсэгт хамгийн харгис аргаар малаа нядлуулах нь яагаад ёс суртахууны эдийн засгийн шийдвэр болж буй талаар хэлэлцлээ.

Малчин малдаа ээнэгшин дасах нь

Эдийн засгийн антропологийн салбарт “ашигтай сонголт” (rational choice) буюу өгөгдсөн хувилбаруудаас хамгийн оновчтой хувилбарыг нөхцөл байдалтайгаа харьцуулан үнэлээд, өөрт ирэх үр өгөөжийг нэмэгдүүлэх сонголт хийх хэмээн тодорхойлж (Бямбабаатар нар, 2023), энэхүү ойлголтыг шүүмжилж ёс суртахууны эдийн засгийн онол гарч ирсэн билээ. Учир нь хөрөнгө хуримтлуулахаас илүү амь зуулгаа нийтээрээ тэгш хангах, хамгийн бага хэмжээнд орлого олж амьдралаа залуулах ёс зүй нь илүү чухал гэж үздэг (мөн тэнд, 2023). Өөрөөр хэлбэл, эдийн засгийн шийдвэр гаргалтад зөвхөн ашгийн тооцоо бус, ёс суртахуун, шударга ёсны тухай ойлголтууд нөлөөлдөг гэж үздэг. Энэ хэсэгт мал болон малчны хоорондын гүн холбоо ээнэгшил, дасал болон малчдын өөрсдийн өсгөсөн малаа олноор нядалж, борлуулах үйл явцыг хэрхэн өөрөөсөө холдуулж байгаа тухай авч үзнэ.

Уламжлалт мал төхөөрөх аргын хувьд бог малын амийг өрлөх аргаар, бод малыг нугасалж амийг нь тасалдаг. Нугаслахдаа дагз-аман хүзүүний үеэр хутганы үзүүр оруулан нугасыг тасална, өрлөх арга нь “аймхай мөгөөрсний ар дор 8-10 см зайд өөхний цагаан шугамыг огтолж цоройг цоолоод, цоорхойгоор гараа оруулж өрц гүзээний хооронд улаан хоолой байх ба үүний цаана өрцөнд хүрнэ. Сээрний нугаламд тулахад гол судас лугшиж мэдрэгдэнэ. Энэ судсыг хуруугаараа гогодож нуруунаас хөндийрүүлэн татаж огцом тасална” (Авдай, 2003; 61). Малыг хүндэтгэн төхөөрөх ёс нь XIII зууны *Их засаг* хуульд чухал байр суурь эзэлж байсан бөгөөд энэхүү хуульд малын цусыг газар асгахыг хориглож, нядалгааг зохих ёсоор гүйцэтгэхийг шаардсан байдаг.

Харин монголчуудын энэхүү “цус гаргахгүй, цэвэрхэн, тайван мал гаргах”-ийн эсрэг талд Исламын шашны халал нядалгааны арга гэж малчид үздэг. Халал нядалгааны үед Аллах бурхны өмнөөс, тодорхой ёс суртахуун, ариун байдлын шаардлагын дагуу нядлах ба халал нядалгаанд амьтныг бүрэн ухаантай, эрүүл байхад нь хүзүүний урд хэсгээс огтолдог. Ингэснээр амьтны

зүрх бүрэн цохилж буй тул цус бүхэлдээ гадагш урсдаг².

Сүүлийн жилүүдэд Исламын шашинтай Иран улсад мах экспортлох зорилгоор Монголд халал нядалгааны стандартууд нэвтэрч, Хэнтий аймагт Ираны халал нядалгааны аргаар хонины мах бэлтгэж, шууд экспортод гаргаж байгаа билээ. Харин бусад монгол ченж нар ч мал төхөөрөх халал аргыг хурдан, хялбар гээд Ираны мах бэлтгээгүй байсан ч бойны газруудад нэвтэрсэн шилдэг мал нядлах арга болж байгаа нь арилжааны зориулалтаар уламжлалт аргаас татгалзаж буй хэлбэр юм.

Мал нь зөвхөн эдийн засгийн өмч төдий бус, малчин хүнд хувь хүнтэй адил нандин харилцаа бүхий амьд оршихуй байдаг. Миний уулзсан малчид мянга мянган малтай хэр нь мал бүрийнхээ зүсийг таньж, аль гэмтэж доголсон малыг ажиглах, шинжих зэргээр малтайгаа байнгын холбоотой байдаг. Ийм харилцааны улмаас зарим малчид өөрсдөө малаа олноор нь нядалж чаддаггүй. Тухайлбал Сандаг, Жамаадорж гэх мэт настай малчид, мөн бидний уулзсан залуу, идэр насны малчдын олонх нь Ираны бой болон монгол бой ямар харгис хэрцгий байгааг байнга дурсаж байв. “Өөрсдөө малаа муулж байснаас тэр бойнд нь өгчихвөл амархан юм даа. Ямар бид гаргаж байгаа биш, амьдаар нь худалдаж байгаа хойно” гэж ярьж байв. Тиймээс бойны газар руу өгч, биечлэн оролцохгүйгээр “амь таслах” үйлдлээс өөрийгөө холдуулж байгааг ёс суртахууны эдийн засгийн үүднээс тайлбарлах боломжтой. Малчид хониныхоо хоолой хэрчихийг харахаас зайлсхийх, малаа бойны хашаа руу оруулаад хурдан холдох зэргээр олон жил, бараг сар бүр энд ирж малаа өгдөг ч харийн мал төхөөрөх аргад одоо ч дасаагүй хэвээр.

Мал бол хүний амьдралын багаж хэрэгсэл, идэвхгүй, ухамсаргүй объект биш харин тэд мэдэрдэг, өөрсдийн зан чанартай, бие даасан оролцогчид учраас өдөр бүр тэдэнтэй ажилладаг малчин малтайгаа сэтгэл хөдлөлийн хувьд нэг нэгнээ гүнзгий мэдэрдэг талаар судалгаа олон байна (Ingold, 2021; Bumochir, 2020; Küçüküstel, 2021). Түүхэн талаасаа ч мал нь зарж борлуулах эд хөрөнгө гэхээс илүү өсгөн үржүүлж, бусдад бэлэг болгож өгөөмөр сэтгэл, зочломтгой чанарыг харуулдаг байсан. 1990-ээд онд мал сүргээ өсгөж үржүүлэхийг хичээдэг байсан тул зөвхөн хурим, найр, оршуулгын үед нийтийг хүнс хоолоор хангахдаа л их хэмжээний малыг уламжлалт аргаар нядалдаг байв (Finke, 2003). Харин социализмын он жилүүдэд малчид өөрт оноогдсон төлөвлөгөөг биелүүлэхийн тулд зөвхөн малаа өсгөх ба мал бэлтгэлийн үе болонгуут мах комбинатууд ирээд малаа авчихдаг, мөн нэгдлийн зүгээс мах комбинатууд руу

2 ANF Halal Standards - American Halal Foundation

туувар зохион байгуулдаг тул нядалгаанд оролцдоггүй байжээ.

Гэр бүл, хот айл зэрэг сүлжээнүүдийн хувьд мах гэдэг нь чухал биш харин амьд мал тэдний харилцаанд илүү чухал байдаг (Fox, 2021; 287). Тэгэхээр тэрхүү мал зөвхөн мах болдог зүйл бус хүмүүс хоорондын нийгмийн, сайн сайхан холбоог бий болгох хэрэгсэл юм.

“Малын буян гэдэг чинь мал хүн хоёр хоорондоо хоёр биеийнхээ зан заншлыг авах л байх гэж бодоод байгаа юм. Одоо хөөрхий минь намайг [мотоциклээр] туухаар ердөөсөө явахгүй. хүн харахаараа нохой харсан юм шиг л давхичихдаг юм. Тэгэхээр намайг таньдаг л юм даа. Ерөөсөө явахгүй гишгүүлчих гээд л. Мал хүн хоёр хоорондоо тэгж л дасдаг ижилсдэг” (Ярилцлага, Жамаадорж, 2024, 8 сарын 3).

Дээрх ярилцлагад мал нь ухамсаргүй амьтан боловч олон жил малласан эзнээ таньдаг, түүнд хариу үйлдэл үзүүлдэг хэмээн дурдаж байна. Малчин хүний хувьд мал бол зөвхөн эд хөрөнгө биш, харин тухайн айлын буян заяаг илэрхийлэгч, эцэг эхийн өв залгамжлал, хамт амьдардаг амьд амьтан гэдэг ойлголт, хандлагыг илэрхийлж байна. Ийнхүү мал, малчин хоёр нэг нэгнээ мэдэж, бие биеэ таньж, малтайгаа хамтдаа амьдарч, дотно харилцаатай байгаа утгыг агуулж байгаа. Энэхүү харилцаа нь зөвхөн аж ахуйн холбоо бус, харин ёс суртахууны мэдрэмж, соёлын уялдаа болж илэрч байна. Тиймээс энэхүү мэдрэмжийг “мал, хүн хоёр бие биедээ ээнэгшин дасна” гэх ойлголтоор илэрхийлж болох юм.

Малтайгаа “ээнэгших”, “таних”, “ойлголцох” гэх сэтгэл зүйн харилцаа нь нядалгаа хийх үед бэрхшээлтэй мэдрэмж, сэтгэл зовнил, бурхан шашны итгэл үнэмшил, ёс заншлын баримтлалтай холилдон гарч ирдэг. Иймд малчид малаа өөрсдөө нядлан зах зээлд арилжиж ашиг орлогыг нэмэгдүүлэх боломж байсаар атал түүний оронд бой, ченжид хамгийн хямд үнээр өгөхийг илүү түгээмэл сонгож байгааг гаднаас нь хараад цаг хэмнэж, хүн хүчний дутагдлыг нөхөж байна, ариун цэврийн шаардлага хангасан гэх мэт зүйлсээр ойлгуулан далдалж байна. Харин нөгөө талаараа энэхүү «ашиггүй» шийдвэр нь зөвхөн хөдөлмөрийн хөнгөвчлөл бус, ээнэгшин дассан малынхаа амийг олноор нь хөнөөгөөд ашиг хөөсөн наймаачин болохгүй гэсэн ёс суртахууны шийдвэр гаргалт болдог.

Миний ярилцсан малчид “...цахилгаан бойнд малаа өгчхөөд хурдан гараад явахгүй бол харахын эцэсгүй хөөрхий” (Ярилцлага, Дүүдээ, 2024, 8 сарын 10) гэж сэтгэл зовнин ярьж байв. Үүнээс харахад Дүүдээ гуай малаа зах зээлийн логигоор бус, ёс суртахууны үнэлэмжээр харж буй нь тодорхой байна. Ийнхүү малчин нядлагч, яргачин болж хувирмааргүй байгаа тул ёс суртахууны

эдийн засгийн ойлголтоор бол нүглийг өөрөөсөө холдуулж байгаа хэрэг юм. Гэсэн ч малчдын бойг сонгож байгааг эрүүл ахуйг хангасан, малчдын ажлыг хөнгөвчилж, цаг хэмнэх хэмээх гадна талын зүйлстэй нь холбоод цаана нь буй малдаа ээнэгшин дасах, малаа хайрладаг зэрэг ёс суртахууны шинжүүдийг үл тоож байна.

Дараагийн хэсэгт бойны газарт малаа нядлууллаа гээд үнэхээр ёс суртахуунаа авч үлдэх хэрэгсэл нь бол чадах уу, мөн дундын зуучлагч буюу ченжийн тухай хэвшиж тогтсон ойлголтыг сөргүүлэн харуулах юм.

Нүглийг холдуулах нь

Өмнөх хэсэгт бой буюу нядалгааны тусламжтайгаар ёс суртахууныг авч үлдэх тухай дурдсан. Энд бой, ченж хоёулаа малчдын нүгэлд өртөх хариуцлагыг үүрч өгч байна хэмээн үзсэн юм.

Тэгвэл зарим судлаачид үүнийг хариуд амьтныг зовоон алахгүйгээр “ургуулсан мах” (cultured meat) гэх шинэ технологийг танилцуулж эхэлжээ (Behera, 2023). Энэ нь амьтны булчингийн эсээс багахан дээж авч, лабораторийн нөхцөлд өсгөх замаар мал нядлахгүйгээр мах гарган авах юм. Энэ мэтээр амьтныг хүнсний хэрэглээний зориулалтаар алах явц нь ёс суртахууны асуудлыг хөндсөн олон бүтээлүүдэд гарч байна.

Харин энэ судалгаанд Монголчууд мэдээж мал нядалж буй шинэ технологийг харгис, ёс суртахуунгүй хэмээн хүлээн зөвшөөрч байгаа боловч малчин өөрөө арилжаа, орлогын төлөө малаа өөрөө нядлах бүр ч илүү ёс суртахуунгүй гэж үзээд нядалгааны газарт өгч байгаагаар өөрийгөө нүглээс хамгаалж байгаа юм.

Малчид өөрсдөө махаа төхөөрч борлуулбал илүү ашигтай байх бөгөөд ийм сонирхол ч байдаг. Гэхдээ өмнөх хэсэгт эдийн засгийн үр ашгаас илүүтэйгээр хамгийн хямд үнээр ченж, бойд өгч байгааг дурдсан билээ. Тэгвэл үүнийг бид гаднаас нь малчдын ажлыг хөнгөвчилдөг, эрүүл ахуйг хангасан, мөн энэнээс өөр сонголт байхгүй мэтээр дүгнэдэг. Харин үүний цаана ээнэгшин дассан малаа бойнд амьдаар нь өгөөд, бойны хашаанд оруулах үед мал нь тухайн малчны өмч биш болж, бойны харгис технологийн үр нь малчинд бус бойнд ажиллаж буй хүнд очно хэмээн нүглийг өөрөөсөө түлхэж, мөн санхүүгийн хэрэгцээ гарах бүрд малчин өөрөө малаа нядлах бус, бусдаар нядлуулж ёс суртахууны үүднээс нүглийн хариуцлагыг өөрөөсөө холдуулж байгаа юм. Тухайлбал олон амьтны амь тасаллаа гэж санаа зовохгүй болж, ёс суртахуунаа авч үлдэх хэрэгсэл нь бой болж байна.

Амьдарч байсан гэр бүлийн эгчтэй Нараагийн бой дээр очсон бөгөөд эгч маань малаа нядлуулж буй дүр зургийг харж чадахгүй байсан:

“Сонор эгч бид 2 өөрсдийнхөө малыг яаж үхэж байгааг харах гээд ойртоход жижиг цонхоор харагдах ба Одгэрэл эгч тэр зүгт харахгүй гээд над руу эргэж хараад малаа нядлуулж байгааг харахаас айжээ. Гэвч тэр зүг рүү харахгүй байсан ч сүхээр толгойг цохиж буй чимээ заалаар дүүрэн. Хонины толгой нь ширхэглэн бяцарч буй чимээ маш тод сонсогдож байв. Сонор эгч хонийг сүхээр цохиж буй дүрсийг нүдээрээ харахгүй байгаа ч хонинуудын толгойг бяцлах сүхний чимээ бүрд цочиж байлаа. Тэд хонийг нэг цохилтоор унагаахын тулд маш чангаар цохино. Угсруулаад ардаас нь бусад айлын малуудыг 5 секундийн дотор зайтай хурдан цохиж алсан” (Хээрийн тэмдэглэл, 2024, 8 сарын 7).

Хэдийгээр малаа бойнд оруулах нь махны зах зээлийн эрэлт хэрэгцээ, амьдралын шаардлагаар хийгдэж байгаа ч хүмүүсийн ухамсар, мэдрэмжид **зөрчилдөөн, эмзэглэл, зовнил** үлдээж байгааг харуулж байна. Гэсэн ч малчид өөрсдөө малаа төхөөрөхгүйн тулд ашгаа багасгаад бойнд малаа өгч байгаа юм.

Баянхутаг сумынхан малчид бойнд ажилладаг хүмүүсийг уламжлалт бус аргаар нядалгаа хийдэг болохоор “яргачин” гэж нэрлэдэг.

“Аав тэгээд байдаг юм, ярга хийж байгаа хүмүүсийг дээшээ явж байхыг ерөөсөө харж байгаагүй гээд. Нүгэл л байдаг байх. Манай сумын Бооёо³ гээд сайхан ах байсан байхгүй юу, тэгээд насаараа ярга хийгээд л, тэгээд нэг самарт явж байгаад хачигт өрөөсөн хөлөө хазуулаад, тэр хачиг нь хорттой байж таараад, өрөөсөн хөл нь цүлхийтэл хавдаад олгойнд хийсэн цус шиг болчихсон. Тэгээд гуяныхаа махыг шулуулаад, яс, арьс шөрмөс 3 нь л үлдчихсэн. Тэгээд л одоо өрөөсөн хөлтэй доголлон, одоо ч гэсэн бойгоо хийгээд л явж байгаа. Эхнэр нь хаяад явчихсан нэг хүүхэдтэйгээ амьдардаг. Бас архи ууна, архичин, бойчин, яргачин” (Ярилцлага, Ш. Ундрах-Эрдэнэ, 2025, 4 сарын 21).

Уламжлалт аргаар малаа хүндэтгэлтэйгээр төхөөрөх нь нүгэл авчрахгүй харин бойны харгис технологи нь нүгэлтэй гэж үздэг байна. Тиймд малчид илүү ашигтай байхын төлөө өөрөө малаа нядлах, борлуулах үйл ажиллагааг зохион байгуулахаас илүү ёс суртахууны дарамтаас зайлсхийхийн тулд бойны газар, ченжээр дамжуулан малаа өгдөг нь хэчнээн хямд, үр ашиггүй байсан ч ёс суртахууныг өөрсдийн гол шийдвэрийн нэг болгож байгаа юм.

³ Нэрийг нууцлаж, солив.

Ченжийг бид “шулаач”, “малчны махыг хямд авдаг” гэдэг хандлагаар хардаг бол энэ судалгаанд ченж нар малчдын ёс суртахууны үүднээс олон амьтны амийг тасалсан гэх шийтгэлийн хариуцлагийг малчдын өмнөөс үүрдэг үе шат нь болж байгаа юм. Малыг нядлах, ашгийн төлөө зарж борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа гэсэн шалтгаанаар монголчуудын уламжлалт үйлийн үр хэмээн сэтгэдэг зүйл нь ченжид хуримтлагдан ирнэ гэж үзэх ажээ. Тухайлбал, монголчууд уламжлалт бурхны шашин болон бөө мөргөлийн итгэл үнэмшлээр дамжуулан өөрсдийгөө болон өрх гэрээ муу үйл, сөрөг үр дагавраас хамгаалдаг (Bristley, 2025). Энэ нь зөвхөн эрсдэлээс зугтах хэрэгсэл бус, харин ирээдүйн сайн сайхныг хангах зорилготой гэсэн байдаг гэсэнтэй адил малчин өөрийн малаа бойны хүмүүст өгч байгаа нь нүглээс өөрийгөө холдуулах нэг хэлбэр болж байгаа юм.

Иймээс маш хямд ч гэсэн малчид ченжид махаа өгсөөр байгаа юм. Урьд нь ченж, бой байхгүй байхад өөрсдөө нядлаад ачаад төв газар борлуулдаг байсан ба энэ үед ашигтай боловч өөрсдөө өсгөчхөөд нядалж борлуулахыг зохион байгуулах нь ёс суртахууныг нь алдагдуулдаг байжээ. Тиймээс малчид энэхүү нүглийг ченжид шилжүүлээд бойд малаа өгөх нь арай дээр шийдвэр болж, ёс суртахууны үүднээс өөрсдийгөө хэлтрүүлэх хэрэгсэл болж байна.

Монгол Улсын хэмжээнд мах бол гол хүнсний бүтээгдэхүүн бөгөөд нэг хүнд ногдох жилийн хэрэглээ хөдөө орон нутагт 92,6 кг, Улаанбаатар хотод 88,8 кг байна (Ichinkhorloo, 2015; 6). Хотынхон малчдыг махаа үнэтэй зардаг, байгалийн гамшиг тохиосон ч засгийн газраас тусламж их авдаг гэдэг шалтгаанаар тэднийг “залхуу”, “эрх дархтай” хэмээн хочилдог. Үүний цаана хэрэглэгчдийн хүнсний хүртээмжтэй байдал, аюулгүй байдлын талаар төрөөс бодлого хэрэгжүүлэхгүй зөвхөн малчдыг халамжлаад байна гэсэн шүүмж хотын хэрэглэгчдийн дунд байсан (Ichinkhorloo, 2015). Тэд махны үнэ бага байх ёстой, үнийг тогтвортой барих ёстой (улирлын чанартай махны үнийн хэлбэлзэл ихтэй) зэргээр боддог. Гэтэл Бямбабаатар нарын (2015) үзэж байгаагаар хотод буй хүмүүсийн цалин, орлого нь махны үнэтэй харьцуулахад илүү өсөж байгаа тул хүмүүс зүгээр л махыг үнэтэй гэж төсөөлж, боддог гэж үзжээ. Харин миний хувьд хотын хэрэглэгчдээс мах үнэтэй байна хэмээх шүүмж одоо ч хэвээр явж байгаа гэж үзэж байна. Малчин ч махаа маш хямд үнээр борлуулж байна. Тэгвэл малчин болон хэрэглэгч хоёрын дунд явж буй нэмүү өртгийн сүлжээ нь малчдын ёс суртахууныг хадгалах, хамгаалахад нэг талаар нэмэр болж, нөгөө талаар малчид мал, махаа хотын хэрэглэгчдэд шууд хямдаар заръя гээд ч боломжгүй байгаа юм.

Нүглийг үүрч ашиг хийж байгаа ченжүүд, бой зэргийг тэвчин мал, махаа

нийлүүлсээр байгаа малчдын хандлага нь өөрсдийгөө нүглээс хэлтрүүлэх хэрэгсэл, ёс суртахууны эдийн засгийн харилцаа болж байна. Харин хотын иргэд гадна талаас дүгнэхдээ малчдыг малаа шууд хотод авчраад зар, ченж нар малчдын мах, түүхий эдийг хэтэрхий доогуур үнэлж байна зэргээр дүгнэдэг. Гэвч малчдад бүгдэд нь ээнэгшин дассан малаа нядлаад харгис нядлагч болж хувирмааргүй байгаа нэгдмэл ашиг сонирхол байгаа бөгөөд энэ нь ёс суртахууны шийдвэр болж байгаа. Харин энэ ёс суртахууны хариуцлагаа авч үлдэхийн тулд бойны хүмүүсээр малаа нядлуулж нүглээс зайлсхийж буй юм.

ДҮГНЭЛТ

Малчдын хувьд малаа эдийн засгийн өмч гэхээсээ илүүтэй амьд амьтан, буян, дотно оршихуй гэж үздэг тул өөрсдөө олноор нь нядлах нь ёс суртахууны зөрчил үүсгэдэг. Иймд бойд малаа өгөх нь зөвхөн ажил хөнгөвчлөх арга биш, харин өөрийнхөө олон малыг арилжааны төлөө нядалмааргүй байгаа тул бой, ченж нарт худалдах гол шалтгаануудын нэг болжээ. Үүний цаана мал гаргах, төхөөрөх, нядлах нүглийг өөрөөсөө холдуулж, тэжээж өсгөсөн малаа амьдаар нь худалдсан хэмээн өөрсдийгөө нүглээс хэлтрүүлж, тайтгаруулж байна. Өөрсдийн идэш, хүнсний хэрэгцээг хангахдаа гэртээ зул барьж, залбирдаг малчид, орчин цагийн өөрчлөлт, арилжааны шинэ хэлбэрүүдтэй дасан зохицож байна гэж дүгнэж болох юм. Хэдийгээр малчдын цагийг хэмнэж, ажлыг түргэвчилж байгаа ч үнэ хямд гээд бой болон ченжийг үргэлжлүүлэн шүүмжлэхийн хажуугаар хамтран ажилласаар байна. Иймээс малчид махаа өөрсдөө нядалж, шууд борлуулах нь эдийн засгийн хувьд илүү ашигтай хэдий ч, бой болон ченжид малаа амьдаар өгөх шийдвэрийн нэг гол шалтгаанаар ёс суртахууныг нэрлэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

Авдай Ч, Төмөржав С, Сонгино Ч, Дорж Б, Цэвэгсүрэн Ж, Нацагдорж Н., 2003, Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи, УБ, Бемби сан
Бямбабаатар И, Г. Мөнх-Эрдэнэ, П. Чулуунбат, 2023, Эдийн засгийн антропологи: зах зээлийн бус эдийн засаг, УБ, МУИС Пресс

Гадаад хэлээр:

Behera, R., & Adhikary, L. (2023). Review on cultured meat: ethical alternative to animal industrial farming. *Food Res*, 7(2), 42-51.

- Bristley, J. (2025). Risk and its others: Toward an anthropology of “protection” in rural Mongolia. *American Anthropologist*, 127(1), 69-79.
- Bumochir, D., Ichinkhorloo, B., & Ahearn, A. (2020). Herd agency: Rethinking herd–herder relations in Mongolia and Qinghai, China. *Inner Asia*, 22(2), 183-198.
- Cole, M. (2011). From “animal machines” to “happy meat”? Foucault’s ideas of disciplinary and pastoral power applied to ‘animal-centred’ welfare discourse. *Animals*, 1(1), 83-101.
- Finke, P. (2003). Does privatisation mean commoditisation? Market exchange, barter, and gift giving in post-socialist Mongolia. In *Anthropological perspectives on economic development and integration* (pp. 199-223). Emerald Group Publishing Limited.
- Fox, E. (2021). Flesh and Blood: Rotting and Relating in the ‘Age of the Market’. *Inner Asia*, 23(2), 285-303.
- Götz, N. (2015). ‘Moral economy’: its conceptual history and analytical prospects. *Journal of Global Ethics*, 11(2), 147-162.
- Ichinkhorloo, B., & Thrift, E. D. (2015). Who eats quality meat?. *Health*, 1, 1-15.
- Ingold, T. (2021). *The perception of the environment: essays on livelihood, dwelling and skill*. routledge.
- Küçüküstel, S. (2021). *Embracing Landscape: Living with Reindeer and Hunting among Spirits in South Siberia* (1st ed., Vol. 3). Berghahn Books.<https://doi.org/10.2307/j.ctv2tsxjv9>
- Miyamoto, M., Magnusson, J., & Korom, F. J. (2021). Animal slaughter and religious nationalism
- Reed, A. Y. (2014). From sacrifice to the slaughterhouse: Ancient and modern approaches to meat, animals, and civilization. *Method & Theory in the Study of Religion*, 26(2), 111-158.
- Scott, J. C. (1977). *The moral economy of the peasant: Rebellion and subsistence in Southeast Asia*. Yale University Press.
- Smith, M. (2002). The ‘ethical’ space of the abattoir: On the (in) human (e) slaughter of other animals. *Human Ecology Review*, 49-58.
- Thompson, E. P. (1971). The moral economy of the English crowd in the eighteenth century. *Past & present*, 50(1), 76-136.
- Wiegatz, J., & Cesnulyte, E. (2016). Money talks: Moral economies of earning a living in neoliberal East Africa. *New Political Economy*, 21(1), 1-25.

**ОЮУТАН СУДЛААЧ ХӨТӨЛБӨРТ
ХОЛБОГДОХ ЗУРГУУД**

Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
“ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.



На. СҮХБААТАР

МУБИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор,
түүхийн ухааны доктор



СУДАЛГААНЫ АЖЛЫН АНХАН ШАТ, АРГА ЗҮЙН АСУУДЛУУД



2024 оны 11 дүгээр сарын 20-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг



Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд



Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
“ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.



Б.БАТЧИМЭГ

Чингис хаан үндэсний музейн
Сан хөмрөг хадгалалт хамгаалалтын хэлтсийн
Ахлах сэргээн засварлагч


МОНГОЛ ДАХЬ СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ШИНЖЛЭХ УХААН БА ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА



2024 оны 11 дүгээр сарын 27-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг



Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд



Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
“ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.



Г. ЭНХБАЯР

МУИС-ийн нүүдэлчдийн археологийн хүрээлэнгийн
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

“ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН УНАЛГЫН АДУУНЫ ТОНОГ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА”

өгүүллийн бүтэц ба бичлэгийн задлан шинжилгээ



2025 оны 2 дугаар сарын 12-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг



Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд





Эрхэм хүндэт Та бүхнийг
 Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
 “ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
 уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
 хүрэлцэн ирэхийг урьж байна.

И. ДАВААДОРЖ
 МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын УТГА Зохиол, Урлаг Судлалын тэнхимийн багш

**"МОНГОЛ ҮЛГЭР, ТУУЛЬ ДАХЬ
 ХАТДЫН ЗҮҮДНИЙ ӨГҮҮЛЭМЖИЙГ
 ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ"**
 өгүүллийн бүтэц, бичлэгийн задлан шинжлэл






2025 оны 2 дугаар сарын 26-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг



Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд







АМТ-ийн эрдэм шинжилгээний зөвлөх Г. Цэцэгдарь (МУБИС)





"Оюутан судлаач" хөтөлбөрийн зохицуулагч Т. Батбямба (ШУА. ХЗХ)






С. Цэлмүүн



*Удирдагч багш
Р. Сарангэрэл (МУБИС)*





Г. Энхжин



*Удирдагч багш
Р. Сарангэрэл (МУБИС)*






З. Хишигбаяр



*Удирдагч багш
Д. Уртнасан (ШУА, ХЗХ)*





Y. Солонго



*Удирдагч багш
P. Сарангэрэл (МУБИС)*





З. Анужин



*Удирдагч багш
Ж. Ганбаатар (МУИС)*






Ц. Сувд-Эрдэнэ



*Удирдагч багш
Р. Сарангэрэл (МУБИС)*





Ч. Өнөрзаяа



*Удирдагч багш
М. Жавхлан (МУИС)*





С. Чулуунцэцэг



*Удирдагч багш
Г. Цэцэгдарь (МУБИС)*





Ц. Төгсбаатар



*Удирдагч багш
Г. Нандинбилиг (МУИС)*





Э. Будсүрэн



*Удирдагч багш
П. Яньдий (МУБИС)*





Б. Золбоо



*Удирдагч багш
И. Даваадорж (МУИС)*





М. Адьяасүрэн



*Удирдагч багш
С. Даашдэжид (МУИС)*





Б. Номин



*Удирдагч багш
И. Даваадорж (МУИС)*





Ц. Намуун



*Удирдагч багш
Б. Батчимэг (Чингис хаан музей)*






Б. Мөнхжин



*Удирдагч багш
М. Эрдэнэ (МУИС)*





Ц. Мөнхзаяа



*Удирдагч багш
И. Бямбабаатар (МУИС)*



ЭРДМИЙН ХЭЛХЭЭ

Эрдэм шинжилгээний бичиг
2025 (14)

Цаасны хэмжээ: B5
Хэвлэлийн хуудас: 22
Хэвлэсэн тоо: 100

"АРВАЙБАРХАН" ХХК-д эхийг
бэлтгэж хэвлэв.